

# МОНГОЛЫН ХҮҮХДҮҮДИЙН ТӨЛӨӨ

**25 ЖИЛ – 25 ДЭВШИЛ**

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь  
үйл ажиллагааны тойм (1994 - 2019)

Улаанбаатар хот  
2020 он

Эмхэтгэсэн: О.Энхжавхлан

Хянасан: Л.Баян-Алтай

Г.Цолмон

М.Хулан

А.Дэлгэрмаа

Хэвлэлийн эхийг: Х.Балдандорж

# АГУУЛГА

Хүүхдийн төлөөх 100 жил . . . . .	6
НҮБ-ЫН Хүүхдийн Эрхийн тухай Конвенц . . . . .	10
Өмнөх үг . . . . .	12
Товчилсон үгийн тайлбар . . . . .	14
Хүүхдийг Ивээх Сан Монголд . . . . .	15
<b>ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗАСАГЛАЛ . . . . .</b>	<b>24</b>
1. ЭРХЗҮЙН САЛБАРЫН ӨӨРЧЛӨЛТ . . . . .	26
• 1994 оноос: ХИС ба Монгол Улсын Засгийн газрын хамтын ажиллагаа . . . . .	26
• 2005 - 2006 он: “Хүүхдийн эрх ба боловсрол” эвсэл . . . . .	30
• 2008 он: “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийн төсөл . . . . .	31
• 2013 - 2014 он: “Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийг хөгжүүлэхэд баримтлах чиглэл”. . . . .	31
• 2016 - 2018 он: ХИС-гийн санал зөвлөмж өгч ажилласан хууль, журмын төслүүд . . . . .	31
2. ХАМТЫН АЖИЛЛАГАА . . . . .	32
• 1995 он: Нийгмийн Хөгжлийн Төв . . . . .	32
• 2002 он: Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхийн Холбоо . . . . .	33
• 2004 он: Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн “Мандах” холбоо . . . . .	33
• 2014 он: Монголын Багш, Эцэг Эхийн Холбоо . . . . .	33
• 1998 - 2019 он: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хамгаалал, үйлчилгээний талбарт олсон амжилтууд . . . . .	34
3. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ . . . . .	40
• 2004 он: НҮБ-ын ХЭК-ийн хэрэгжилтийн Засгийн газрын I тайлан . . . . .	40
• 2006 он: НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд илгээсэн Монголын ТББ-уудын “Хөндлөнгийн тайлан”-1 . . . . .	41
• 2009 он: НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд илгээсэн Монголын ТББ-уудын “Хөндлөнгийн тайлан”-2 . . . . .	41
• 2009 он: НҮБ-ын Хүүхдийн Эрхийн хороонд илгээсэн монгол хүүхдийн I илтгэл . . . . .	42
• 2014 - 2016 он: НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн газрын V тайлан илтгэлтэй холбогдуулан төрийн бус байгууллагын сүлжээнээс илгээсэн нэмэлт илтгэл . . . . .	43
• 2015 он: “Бүх хүүхдийн эрхийн төлөө” НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээсэн монгол хүүхдийн II илтгэл . . . . .	44
• 2010, 2017 он: НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсад ирүүлсэн зөвлөмж . . . . .	45
4. ХҮҮХДИЙН ОРОЛЦОО . . . . .	46
• 2008 он: “Хамгаалал” хүүхдийн клуб . . . . .	47
• 2008 он: Хүүхдүүд- Хүүхдийн эрхийн сургагч багш . . . . .	47
• 2008 он: “Хүүхэд хүүхдийн төлөө” . . . . .	48
• 2013 оноос хойш: “Өсвөр үеийнхний дуу хоолой (Young Voices)” хүүхдийн эрхийн бүлэг . . . . .	50
5. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗАСАГЛАЛ ХӨТӨЛБӨР . . . . .	51
• Хүүхдийн эрхийн хяналт, үнэлгээний хүрээнд хийсэн ажлууд . . . . .	51
- 2008 он: Хүүхэд хамгааллын нөхцөл байдлын суурь судалгаа . . . . .	51
- 2015 он: Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ . . . . .	52
- 2018 он: Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ . . . . .	53

- Хүүхдэд ээлтэй сайн засаглалыг бэхжүүлэх хүрээнд хийсэн ажлууд . . . . . 54
  - 2012 - 2013 он: “Сайн засаглалд хүүхдийн оролцоо амин чухал” төсөл . . . . . 54
  - 2013 - 2014 он: “Хүүхдийн төлөө төсөв” . . . . . 56
  - 2014 - 2015 он: “Өсвөр үеийнхний эерэг хөгжил оролцоо” . . . . . 57
  - 2017 он: “Өсвөр үеийнхний дуу хоолой-1” . . . . . 58
  - 2018 он: “Өсвөр үеийнхний дуу хоолой-2” . . . . . 59
  - 2018 - 2019 он: “Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төсөл . . . . . 62
- Хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн ажлууд . . . . . 63

## **ХҮҮХЭД ХАМГААЛАЛ . . . . . 64**

- 1994 - 1996 он: “Хүүхэд төвтэй хөгжил” сургалтын хөтөлбөр . . . . . 68
- 1997 - 2002 он: Нийгмийн ажлын сургалт, судалгааны аргагүйн төв . . . . . 68
- 2003 оноос хойш: Хүүхэд хамгааллын Хамтарсан баг . . . . . 71
- 2010 он: “Хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх нь” төсөл . . . . . 74
- 2003 - 2015 он: Улаанбаатар хот дахь “Хүүхэд төв” . . . . . 76
- 2015 оноос хойш: Хүүхэд хамгааллын аргагүйн төв . . . . . 78
- 2015 - 2018 он: “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төсөл . . . . . 80
- 2006 оноос хойш: “Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоохыг уриалах олон улсын өдөр” . 82
- 1996 - 2000 он: “Хот айл” төвүүд . . . . . 84
- 1996 - 1999 он: “Хөдөлмөр эрхлэгч хүүхэд” хөтөлбөр . . . . . 86
- 1999 оноос хойш: “Нийгэмшүүлэх цирк” төсөл . . . . . 88
- 2005 - 2009 он: “Хүүхэд ба дуран” гэрэл зургийн хөтөлбөр . . . . . 91
- 2009 - 2014 он: Гэр бүлд түшиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээ . . . . . 92
- 2017 - 2018 он: Хурдан морь унаач хүүхдийн эрхийн хамгаалал . . . . . 94

## **БОЛОВСРОЛ . . . . . 96**

### **1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ . . . . . 98**

- 1994 - 2000 он: “Сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр-1” . . . . . 98
- 2000 - 2005 он: Сургуулийн өмнөх боловсролын төвүүд . . . . . 100
- 2000 - 2010 он: Хувилбарт сургалт . . . . . 100
- 2011 - 2014 он: “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” . . . . . 100
- 2012 - 2017 он: “Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх хөтөлбөр” . . . . . 102

### **2. БАГА БОЛОВСРОЛ . . . . . 106**

- 2003 - 2006 он: “Малчин хүүхдийн боловсрол” төсөл . . . . . 106
- 2006 - 2009 он: “Сургуулийн өмнөх ба бага боловсролын чанарыг сайжруулах нь” төсөл . . . 106
- 2012 - 2017 он: “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төсөл . . . . . 108
- 2015 - 2018 он: “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” төсөл . . . . . 112

### **3. СУУРЬ БОЛОВСРОЛ . . . . . 114**

- Тэгш хамруулан сургах боловсрол . . . . . 114
  - 2002 - 2008 он: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Нөхөн сэргээх төвүүд . . . . . 116
  - 2018 - 2021 он: “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төсөл . . . . . 117
- Үндэстний цөөнхийн хүүхдийн боловсрол . . . . . 118

### **4. ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ БОЛОВСРОЛЫН ОРЧИН . . . . . 120**

- 2008 - 2011 он: “Боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг дэмжих, удирдлага хяналтын тогтолцоог сайжруулах нь” төсөл . . . . . 120
- 2008 - 2011 он: Хүмүүжлийн эерэг арга . . . . . 122

5. БОЛОВСРОЛ ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО . . . . .	124
• “Эцэг эхтэй харилцах дэвтэр” . . . . .	124
• Олон Нийтийн Боловсролын Зөвлөл . . . . .	126

## **ХҮҮХДИЙН ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ . . . . . 128**

• 1996 - 2000 он: “Ядуурлыг бууруулах Үндэсний хөтөлбөр” . . . . .	129
• 2015 - 2017 он: Өсвөр үеийнхэнд бизнесийн боловсрол, энтрепренер ур чадвар олгох BEST төсөл . . . . .	130
- 2015 - 2016 он: Орон нутагт амьдарч буй өсвөр үеийнхэнд бизнес болон энтрепренер ур чадвар олгох боловсролын хэрэгцээг тодруулах судалгаа . . . . .	130
- 2017 он: Өсвөрийн энтрепренерүүдийн анхдугаар уралдаан . . . . .	130
- 2018 он: Өсвөрийн энтрепренерүүдийн хоёрдугаар уралдаан . . . . .	130
- 2018 он: “Монгол Энтерпрайзинг Эрэл” . . . . .	131
- 2019 он: Өсвөрийн энтрепренерүүдийн гуравдугаар уралдаан . . . . .	131

## **ЭРҮҮЛ МЭНД . . . . . 132**

• 2008 он: 50,000 нярайд 50,000 дулаан малгай . . . . .	134
• 2010 он: “Хүүхэд хамгаалал” хичээлийн хөтөлбөр . . . . .	134
• 2011 он: Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад зориулсан мэргэшүүлэх сургалт . . . . .	134
• 2011 - 2014 он: “Хүүхэд ээлтэй ариун цэврийн өрөө” . . . . .	135
• 2013 он: “Эсэн мэнд амьдрахуйн төлөө” өдөрлөг, гүйлт . . . . .	137
• 2012 оноос хойш: Денан төсөл . . . . .	138

## **ХҮМҮҮНЛЭГИЙН ХӨТӨЛБӨР . . . . . 142**

1. ХҮМҮҮНЛЭГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД . . . . .	144
• 1999 - 2001 оны зуд . . . . .	144
• 2001 оны гар, хөл амны өвчний дэгдэлт . . . . .	145
• 2003 оны зуд . . . . .	145
• 2009 - 2010 оны зуд . . . . .	145
• 2011 оны Япон улсад болсон газар хөдлөлтийн тусламж . . . . .	146
• 2012 - 2013 оны өвөл . . . . .	146
• 2015 - 2016 оны зуд . . . . .	147
• 2016 - 2017 оны зуд . . . . .	148
• 2018 оны үер . . . . .	150
• 2018 - 2019 оны өвөлжилтийн бэлтгэл . . . . .	150
• 2011 - 2019 он: ХИС - Хүмүүнлэгийн багийн гишүүн . . . . .	151
2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ БУЙ АЖЛУУД . . . . .	152
• 2011 - 2016 он: “Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал, хүүхэд төвтэй бэлэн байдлыг бэхжүүлэх нь” . . . . .	153
• 2016 - 2019 он: Сургуулийн орчны гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа . . . . .	154
• 2016 - 2019 он: Хүүхэд үзүүлэх сэтгэлзүйн анхны тусламж . . . . .	155
• 2017 он: ЕБС-ийн цогц аюулгүй байдлын суурь судалгаа . . . . .	155
• 2018 он: Гамшгийн Эрсдэлийг Бууруулах Азийн Сайд нарын Бага хурал . . . . .	156
• 2018 - 2019 он: Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилт . . . . .	156
• 2007 - 2019 он: Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр гаргасан сурталчилгааны материалууд . . . . .	157
• 2019 он: Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн тойм судалгаа . . . . .	158
ХИС-гийн Монгол дахь хөтөлбөрийн хандивлагчид: . . . . .	159
Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн хандивлагчдын санхүүжилт, зарцуулалтын нэгдсэн мэдээлэл (1994-2019). . . . .	160

# ХҮҮХДИЙН ТӨЛӨӨХ ЗУУН ЖИЛ

Хүүхдийг Ивээх Сан зуун жилийн туршид хүүхдийн хамгаалуулах, эсэн мэнд амьдрах эрхийг хангахын төлөө тэмцэж, хүүхэд өөрийн боломж бололцоог бүрэн дүүрэн ашиглахад дэмжлэг үзүүлж ирсэн. Бид хүүхдийн оролцоог хангаж, амьдралд нь нөлөөлөх шийдвэр гаргахад хүүхдийн үзэл бодлыг тусгадаг хариуцлагатай нийгмийг цогцлоохын төлөө ажилладаг.

1919



- Дэлхийн нэгдүгээр дайны улмаас маш олон хүүхэд өлсгөлөнд нэрвэгдэж, хямралд өртсөнийг харсан Эглантин Жебб гэгч энгийн нэгэн эмэгтэй тэдэнд туслахаар сэтгэл шулуудаж, Хүүхдийг Ивээх Санг байгуулжээ.

- 1930-аад онд хандивлагчдын тусламж дэмжлэгээр үйл ажиллагаагаа өргөжүүлж, Ази, Африк тивүүдэд хүүхдийн эрхийг хамгаалах Хүүхэд хамгааллын зөвлөл байгуулав.



1920

1930

- 1924 онд Үндэстнүүдийн холбоо Эглантин Жеббийн анхлан боловсруулсан Хүүхдийн эрхийн тунхгийг хүлээн авч баталсан нь өдгөө дэлхий даяар хүүхдийн эрхийг хангах эрхзүйн үндсэн баримт бичиг болох НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн суурь болжээ.

- 1921 онд Орос улс дэлхийн түүхэнд бичигдсэн их өлсгөлөнд нэрвэгдэх үед Хүүхдийг Ивээх Сан анхны томоохон тусламжаа үзүүлжээ. Тэр жилийн зун Саратов хотын ойр орчимд 600 тонн хоол хүнс хүргэж, 1400 явуулын хоолны газар ажиллуулан, нийт 300,000 хүүхэд, 350,000 насанд хүрэгсдийг хоол тэжээлээр хангасан байдаг.





- Малай буюу одоогийн Малайз улсад Серенда төслийг хэрэгжүүлж, эцэг эхээсээ өнчирсөн хөвгүүдэд боловсрол эзэмших, эрүүл аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэв. 1950-иад оны сүүлч гэхэд Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтийн дийлэнх нь Ази дахь үйл ажиллагаанд зориулагдах болжээ.



- 1950 онд Солонгосын дайн эхэлснээр олон мянган хүүхэд гудамжинд гарч, хараа хяналтгүй болов. Хүүхдийг Ивээх Сангийн баг 1952 онд Солонгосыг зорьж, тэндээ 20 гаруй жил ажилласан байдаг. 1954 онд Пусан хот дахь дүрвэгсдийн томоохон хуаранд эмнэлэг, хүүхэд хөхүүлэх орон зай, тоглоомын талбай байгуулав



- 1930-аад оны эхээр Этиоп улсын Аддис Абаба хотод хүүхдийн асрамж, халамжийн төв байгуулж, Африк дахь анхны хөтөлбөрөө эхлүүлсэн. 1935 онд Италийн арми тус улсыг эзлэн авсны дараа Хүүхдийг Ивээх Сан Британийн Сомалиланд (одоогийн Сомали улсын хэсэг) дахь дүрвэгсдэд тусламж үзүүлж ажилласан.

1940

1950

- 1945 онд дэлхийн хоёрдугаар дайн дуусгавар болсны дараа Франц, Грек, Польш, Югослав дахь дайны хөлд сүйдсэн орон нутагт иргэд, дүрвэгсэд, хорих лагериас амьд үлдсэн хүмүүст дэмжлэг үзүүлж эхэлсэн.



- 1940 онд Хүүхдийг Ивээх Сан дэлхийн хоёрдугаар дайны хөлд нэрвэгдсэн хүүхдүүдэд туслах уриалга гаргав. Английн томоохон хотуудын агаарын довтолгооны нуувч газруудад түшиглэн байгуулсан хүүхдэд ээлтэй орон зай өнөөг хүртэл хүүхдийг хамгаалж хөгжүүлэх зорилгоор ашиглагдаж байна.



- 1967 онд Нигерийн иргэний дайны улмаас өлсгөлөнд нэрвэгдсэн Биафра дахь хүүхдүүдийн цочирдом дүр зураг ил болов. Хоёр жил гаруй хугацаанд үргэлжилсэн зөрчил мөргөлдөөний үеэр Хүүхдийн Ивээх Сангийн эмнэлгүүд өдөрт 400 гаруй өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлж байжээ.




- 1980-аад онд Хүүхдийг Ивээх Сан эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах дэлхий нийтийг хамарсан аянд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж эхлэв. Түүнчлэн ХДХВ/ДОХ-ын тархалт, өвчлөлтийн талаарх ташаа ойлголтыг залруулах, ялгаварлан гадуурхах явдлыг эцэс болгоход чухал нөлөө үзүүлсэн.

1960

- 1960 он гэхэд Хүүхдийг Ивээх Сан 17 улсад эрүүл мэндийн иж бүрэн үйлчилгээ, халамж үзүүлэх багтай болж, Европ, Ази, Африк, Карибын бүсийн 26 улсад ажиллан, гэр бүл, хүүхдэд тусламж үзүүлж байлаа.

1970

- 1970 оны төгсгөлд Хүүхдийг Ивээх Сан зургаан тивийн 120 гаруй улсад үйл ажиллагаа явуулах болов.



1980

- 1975 онд Хүүхдийг Ивээх Сан Вьетнамын дайны дараа тус улсад дахин үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан анхны олон улсын хүмүүнлэгийн байгууллага болжээ.





- 1984 онд Этиоп улсад тохиосон өлсгөлөнгийн хор хөнөөлийг ил гаргаж, дэлхий нийтийн анхааралд татан авчирлаа. Хүүхдийг Ивээх Сан үр тариа, хуурай сүү, элсэн чихэр, тос зэргийг салбар төвүүдээрээ дамжуулан түгээж, тус оны 9 дүгээр сар гэхэд тэжээлийн дутагдалд орсон 7000 хүүхдийг өдөр бүр хоол тэжээлээр хангаж байлаа.

- Хандивлагчдын дэмжлэгээр гамшгийн үед өргөн хүрээтэй хүмүүнлэгийн тусламж үзүүлэх чадамжтай боллоо. 2004 онд Ази тивд учирсан цунамигийн хохирлыг арилгах таван жилийн хөтөлбөр хэрэгжүүлж, нэг сая орчим хүнд хүрч үйлчилсэн. Мөн 2005 оны Пакистанд болсон газар хөдлөлт, 2003 онд Суданы Дарфур дахь мөргөлдөөний үед дүрвэгсдэд дэмжлэг үзүүлж халуун цэг дээр нь ажиллав.



- 2006-2009 онд “Ирээдүйгээ дахин тодорхойлъё” аяны хүрээнд зэвсэгт мөргөлдөөн, хямралд өртсөн улсуудын 1.4 сая хүүхдийг сургуульд суралцахад дэмжлэг үзүүлэв.

- 2016 онд бид 125 улсын нийт 175 сая хүүхдэд хүрч ажиллалаа.

1990

2000

2010

- 1994 онд Монгол Улсад салбараа нээв.



- 2014 онд үхлийн аюулт Эбола вирусийн тархалтын үеэр Сьерра Леон, Гвиней, Либери улсад 4.6 сая хүнд хүрч үйлчилснээс 2 сая гаруй нь хүүхэд байв. 2000 гаруй эмч, эмнэлгийн ажилтныг сургаж, эмчилгээний төвүүдийг ажиллуулан вирусийн халдвар авсан өвчтөнүүдийг эмчлэх орны хүрэлцээг 20 хувиар нэмэгдүүлсэн.



# 2019 ОНД НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ БАТЛАГДСАНЫ 30 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

## НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ (ХЯЛБАРШУУЛСАН ХУВИЛБАР)

### 1-р зүйл

18 нас хүрээгүй хүн бүр энэ Конвенцод заасан бүх эрхийг эдэлнэ.

### 2-р зүйл

Тус Конвенц нь яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэг, чадвар, үзэл бодол, үг яриа, гарал үүслийг үл харгалзан хүн бүрт хамааралтай.

### 3-р зүйл

Хүүхдийн холбогдолтой бүх байгууллагууд хүүхэд нэг бүрийн дээд эрх ашгийг эрхэмлэнэ.

### 4-р зүйл

Эдгээр эрхийг хүүхдэд эдлүүлэх үүргийг төр хүлээнэ.

### 5-р зүйл

Гэр бүлийн зүгээс хүүхдээ удирдан чиглүүлэх, өсөн торнихын хэрээр эрхээ зохистой эдлэхэд сургах эрх, үүрэг, хариуцлагыг оролцогч улсууд хүндэтгэнэ.

### 6-р зүйл

Хүүхэд амьдралыг бүрэн эдлэх эрхтэй. Оролцогч улсууд хүүхдийн эсэн мэнд амьдрах, эрүүл саруул хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана.

### 7-р зүйл

Хүүхэд бүр нэр авах, иргэний харьяалалтай байх эрхтэй. Түүнчлэн эцэг эхээ мэдэх, хайр халамжийг нь боломжийн хэрээр хүртэх эрхийг эдэлнэ.

### 8-р зүйл

Иргэний харьяалалтай байх, нэр авах, гэр бүлийн холбоогоо хадгалах хүүхдийн эрхийг хүндэтгэх үүргийг оролцогч улсууд хүлээнэ.

### 9-р зүйл

Хүүхдийн сайн сайхан байдлыг хангах шаардлагатай үеэс жишээ нь, эцэг эхийн зүгээс хүүхдэд хэрцгийгээр харьцах, анхаарал, халамжгүй орхих зэргээс өөр бусад тохиолдолд хүүхдийг эцэг эхээс нь хагацаах ёсгүй. Эцэг эх нь салангид байх нөхцөлд хүүхдэд хор учирхааргүй бол хүүхэд эцэг, эхийнхээ аль алинтай харилцаа холбоотой байх эрхтэй.

### 10-р зүйл

Өөр өөр улс оронд амьдарч буй эцэг эх, хүүхэд хоорондоо шууд харилцаатай байх эсхүл гэр бүлдээ эргэж нэгдэхийн үүднээс тэдгээр улс орны дунд зорчих эрхэд оролцогч улсууд хүндэтгэлтэй хандана.

### 11-р зүйл

Оролцогч улсууд хүүхдийг хууль бусаар шилжүүлэх буюу гадаад улсаас эх оронд нь буцаахгүй байхтай тэмцэх арга хэмжээ авна.

### 12-р зүйл

Хүүхэд өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, идэвхтэй оролцох эрхтэй бөгөөд оролцогч улсууд хүүхдийн үзэл бодолд зохих ач холбогдол өгнө.

### 13-р зүйл

Хүүхэд бүр мэдээлэл олж авах болон дамжуулах эрхтэй ба гагцхүү тэр мэдээлэл өөрт нь болон бусдад сөргөөр нөлөөлөхгүй байх учиртай.

### 14-р зүйл

Хүүхэд бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, сүсэглэх эрхтэй. Гагцхүү энэ эрх нь бусдын үндсэн эрхийг хязгаарлахгүй байх ёстой ба үүнд эцэг эх удирдан чиглүүлэх үүрэгтэй.

### 15-р зүйл

Хүүхэд бүр бусад хүүхэд, залуусын хамт хуран цуглах, эвсэл холбоо байгуулан эвлэлдэн нэгдэх эрхтэй. Гагцхүү энэ эрх нь бусдын эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй байх ёстой.

### 16-р зүйл

Хүүхэд бүр хувийн халдашгүй байдлаа хадгалах эрхтэй. Хүүхдийн амьдрал, нэр хүнд, түүний гэр бүл, орон гэр хөндлөнгийн халдлагаас хуулиар хамгаалагдсан байх ёстой.

### 17-р зүйл

Хүүхэд бүр төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл олж авах эрхтэй. Телевиз, радио, сонин зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь хүүхдэд ойлгомжтой, тэдний сайн сайхан байдалд хохирол үл учруулах мэдээлэл хүргэвэл зохино.

### 18-р зүйл

Хүүхдээ өсгөн бойжуулахад эцэг эх хоёулаа адил тэгш үүрэг, хариуцлага хүлээх ба хүүхэд нэг бүрийн сайн сайхны төлөө хүчин чармайлт тавина. Ялангуяа, эцэг эх хоёулаа ажилладаг нөхцөлд төр нь үйлчилгээ үзүүлэх замаар туслаж дэмжих үүрэгтэй.

### 19-р зүйл

Хүүхэд бүрт зохистой халамж хүртээх, мөн эцэг эх болон хүүхдийг асран халамжилж буй хэн боловч хүүхдэд хүчирхийлэл, дарамт, үл хайхрах явдал гаргахгүй байхыг оролцогч улсууд батлан даана.

### 20-р зүйл

Төрсөн гэртээ халамжлуулах бололцоогүй хүүхэд зохих ёсны асаргаа халамжийг өөрийн шашин болон соёлын хамаарал, төрөлх хэлийг нь хүндлэн үзэгч хүмүүсээс эдлэх эрхтэй.

1989 оны 11 сарын 20-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассемблей хүүхдийн эрхийг тунхагласан Хүүхдийн эрхийн тухай конвенцийг баталсан юм. Тус конвенц нь хамгийн олон орон нэгдэн орсон, дэлхийн даяар хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн баримт юм. Монгол Улс тус конвенцид 1990 оны 7 дугаар сарын 5-нд нэгдэн орсон бөгөөд тус конвенцийн гурван нэмэлт протокол болох а. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протоколыг 2003 онд, б. Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг нэмэлт протоколыг 2004 онд, в. Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протоколыг 2015 онд тус тус соёрхон баталжээ.

**21-р зүйл**

Үрчлэлтэд хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина. Энэхүү хэм хэмжээг хүүхдийг эх оронд нь, эсхүл өөр оронд үрчлүүлэх аль аль тохиолдолд адил баримтална.

**22-р зүйл**

Дүрвэгчийн хувиар ирсэн хүүхэд тухайн орны уугуул хүүхэдтэй адил тэгш эрхийг эдэлнэ.

**23-р зүйл**

Хөгжлийн аливаа бэрхшээлтэй хүүхэд тусгай халамж, дэмжлэгийг авч бүрэн дүүрэн, идэвхтэй амьдрах эрхтэй.

**24-р зүйл**

Хүүхэд бүр эрүүл байхын үүднээс мэндийн чанартай үйлчилгээ, ундны цэвэр ус, тэжээллэг хоол хүнсээр хангагдах эрхтэй. Хөгжингүй орнууд үүнд хөгжиж буй орнуудад туслалцаа дэмжлэг үзүүлвэл зохино.

**25-р зүйл**

Хүүхэд бүр өөрийн эмчилгээ, сувилгаа төдийгүй эцэг эхийн асаргааг тогтмол үнэлж дүгнүүлэх эрхийг эдэлнэ.

**26-р зүйл**

Төр нь хүүхдийн зориулалтаар гэр бүлд нэмэлт тэтгэмж олгоно.

**27-р зүйл**

Хүүхэд бүр өөрийн бие бялдар, оюун ухааны хөгжлийг хангахуйц түвшинд амьдрах эрхтэй. Үүнийг гүйцэлдүүлэх бололцоогүй гэр бүлүүдэд төрөөс туслалцаа дэмжлэг үзүүлвэл зохино.

**28-р зүйл**

Хүүхэд бүр сурч боловсрох эрхтэй. Сургуулийн дэг журам нь хүүхдийн нэр төрийг хүндэтгэдэг байх шаардлагатай. Суурь боловсрол үнэ төлбөргүй байвал зохино. Эдгээр зорилгын үүднээс хөгжингүй улс орнууд нь хөгжиж буй орнуудад туслалцаа дэмжлэг үзүүлэх нь зохистой.

**29-р зүйл**

Боловсрол нь хүүхэд бүрийг бие хүнийх нь хувьд төлөвшүүлэх, авьяас чадварыг нь бүрэн төгс хөгжүүлэх үүрэгтэй. Мөн боловсрол нь хүүхдийг эцэг эхээ хүндлэх, эх орныхоо болон бусад улс орны соёлыг хүндэтгэх үзэлд дуудан дагуулдаг байх ёстой.

**30-р зүйл**

Хүүхэд өөрийн гэр бүлийн ёс заншлыг дагах, төрөлх хэлээрээ ярих эрхтэй. Үүнд тухайн орны дийлэнх хүн ам хэрэглэдэг эсэх үл шалтгаалах ба зөвхөн бусдад саад учруулахгүй байхыг эрхэмлэнэ.

**31-р зүйл**

Хүүхэд бүр амрах, тоглож наадах, соёлын болон уран бүтээлийн төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцон чөлөөт цагаа өнгөрүүлэх эрхтэй.

**32-р зүйл**

Хүүхдийн эрүүл мэнд, боловсролд сөргөөр нөлөөлөхүйц болон осол аюултай хөдөлмөр эрхлэх явдлаас хүүхдийг хамгаалах үүргийг төр хүлээнэ.

**33-р зүйл**

Төр нь хүүхдийг аюултай, мансууруулах бодис хэрэглэхээс хамгаалах үүрэгтэй.

**34-р зүйл**

Оролцогч улсууд хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ.

**35-р зүйл**

Хүүхдийг хулгайлах, худалдах явдлаас хамгаалах үүргийг төр хүлээнэ.

**36-р зүйл**

Хүүхдийн хөгжилд хохирол учруулах аливаа үйлдлээс хүүхэд хамгаалагдсан байх ёстой.

**37-р зүйл**

Хууль зөрчсөн хүүхдэд хэрцгий, хүнлэг бусаар харьцахыг цээрлэнэ. Эрх чөлөөгөө хасуулсан хүүхдийг насанд хүрэгчдээс тусгаарлах ба гэр бүлтэйгээ харилцаатай байх боломжоор хангана.

**38-р зүйл**

Оролцогч улсууд 15 насанд хүрээгүй хүүхдийг зэвсэгт хүчинд алба хаалгахаас татгалзана. Зэвсэг мөргөлдөөний үед хүүхдүүдийг тусгайлан хамгаална.

**39-р зүйл**

Үл хайхрах байдалд өртсөн эсхүл гутаан доромжлогдсон хүүхдэд бие бялдар, сэтгэл зүйн нөхөн сэргээх тусгай тусламжийг үзүүлнэ.

**40-р зүйл**

Хууль зөрчсөн тохиолдолд хүүхэд бүр хууль эрх зүйн туслалцаа авах эрхтэй. Хүүхдийн хувьд хорих ялыг хамгийн ноцтой хэрэгт хэрэглэнэ.

**41-р зүйл**

Тухайн орны хууль тогтоомж хүүхдийг илүүтэйгээр хамгаалж чадаж байгаа нөхцөлд тэдгээр хууль тогтоомжийг Конвенцийн заалтаас илүүтэйд үзнэ.

**42-р зүйл**

Оролцогч улсууд Конвенцийн зарчим, заалтуудыг насанд хүрэгчид болон хүүхдүүдэд таниулан сурталчлах үүрэг хүлээнэ.

**43-54-р зүйл**

Хүүхдийн эрхийн тухай Конвенц нь нийт 54 зүйлтэй ба 43-54 зүйлүүд нь хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд насанд хүрэгчид болон улс орнууд хэрхэн хамтран ажиллах тухай заасан байдаг болно.

## ӨМНӨХ ҮГ

### ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТРАН ЗҮТГЭГЧИД ЭЭ,



**Мицуаки Тоёода,**  
Монгол дахь Хүүхдийг  
Ивээх Сангийн захирал



**Л.Баян-Алтай,**  
Хүүхдийг Ивээх Сангийн  
Монгол дахь Менежер,  
Суурин төлөөлөгч

Олон улсын Хүүхдийг Ивээх Сан байгуулагдсаны 100 жил, Монгол Улсад үйл ажиллагаагаа 1994 оноос хэрэгжүүлж эхэлсний 25 жилийн ойд зориулж энэхүү номыг хүүхдийн эрхийн төлөө зүтгэгч таны гарт хүргүүлж байна.

Дэлхийд хүүхдийн эрхийн чиглэлээр ажиллаж эхэлсэн хамгийн ууган байгууллага болох Хүүхдийг Ивээх Санг үүсгэн байгуулагч, хатагтай Еглантин Жебб хүүхдийн эрхийн асуудлыг хүн төрөлхтний өмнө анх дэвшүүлэн тавьж, хүүхдийн эрхийн тунхгийг боловсруулсан билээ. Энэхүү тунхгийг 1924 онд Үндэстнүүдийн Лиг<sup>1</sup> баталж, 1989 оны 11-р сарын 20-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас “Хүүхдийн эрхийн тухай конвенц” болгон баталсан нь өнөөдөр хамгийн олон улс орон нэгдсэн хүний эрхийн баримт бичиг болоод байна. Дэлхийн 196 улс албан ёсоор хүлээн зөвшөөрсөн уг конвенцод Монгол Улс 1990 оны 7-р сарын 5-нд нэгдэн орсноор хүүхдийн эрхийг дээдлэхээ илэрхийлсэн анхдагчдын нэг болсон юм. Хүүхдийн эрхийн конвенцод нэгдсэн нь Монгол Улсын хүүхдийн эрхийн засаглал, хамгаалал, хөгжлийн тогтолцоог шинэчлэхэд үндсэн эргэлтийг авчирсан билээ.

Хүүхдийг Ивээх Сан 1994 оны 2-р сард нийгмийн шилжилтийн хямралд өртөж, эдийн засгийн хүнд нөхцөлд байсан Монгол Улсад хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлжээ. Бид Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхдийн эрхэд суурилсан хандлагыг таниулахаас ажлын гараагаа эхэлж, ажилгүйдэл, ядуурлын улмаас гудамжинд гараад байсан Монголын эмзэг бүлгийн болон хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдэд нэн түрүүнд тусламжийн гараа сунгасан юм. Хүүхдийг Ивээх Сан нь нийгэм, улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлт, онцгой байдлын үеэс урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад хүүхдийг хамгаалж, хүүхдийн эрхийг цогцоор нь хангахыг дэмжин ажилласаар 25 жилийн нүүрийг үзэж байна. Бид хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой өөрчлөлтийг бий болгох зарчмыг баримтлан, тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдлийг олох аргагүйг эрхэмлэн ажилладаг.

Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө зүтгэсэн 25 жилийн нөр их хөдөлмөр, хуримтлуулсан арвин туршлага, бахархам ололт амжилт, нийгэмд авчирсан ололт дэвшлийн төлөө хамтран зүтгэсэн түнш байгууллага, хандивлагч нартаа гүн талархал илэрхийлье.

<sup>1</sup> Дэлхий дахины “энхтайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, олон улсын харилцааг дэмжих” зорилгоор байгуулагдсан Үндэстнүүдийн Лиг (1919-1946) нь өнөөгийн НҮБ-ын үндсийг тавьжээ.

## ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН АЛСЫН ХАРАА:

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг дэлхий ертөнцийг цогцлоохыг бид эрмэлзэнэ.

## ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО:

Хүүхдэд чиглэсэн дэлхий нийтийн хандлагад эргэлт хийж, хүүхдийн амьдралд урт хугацааны тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө бид хүчин зүтгэнэ.

Хүүхдийг Ивээх Сан Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхдийн эрхэд суурилсан хандлагыг таниулахаас ажлын гараагаа эхэлж, ажилгүйдэл, ядуурлын улмаас гудамжинд гараад байсан Монголын эмзэг бүлгийн болон хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдэд нэн түрүүнд тусламжийн гараа сунгасан юм.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөр хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой өөрчлөлтийг бий болгох зарчмыг баримтлан тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдэл олохыг эрхэмлэн ажилладаг.

## 2030 он хүртэл хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой өөрчлөлтийг бий болгох БОДИТ ДЭВШИЛ ДАРААХ ГУРВАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД хийгдэнэ:



### 1. ЭСЭН МЭНД АМЬДРАХ

Тав хүртэлх насны хүүхдийн урьдчилан сэргийлж болохуйц эндэгдлийг таслан зогсооно.



### 2. СУРАХ

Бүх хүүхэд чанартай суурь боловсрол эзэмшиж чаддаг болсон байна.



### 3. ХАМГААЛУУЛАХ

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийгмээрээ үл тэвчдэг болсон байна.

Хүүхдийг Ивээх Сангийн Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө зүтгэсэн 25 жилийн нөр их хөдөлмөр, хуримтлуулсан арвин туршлага, бахархам ололт амжилт, нийгэмд авчирсан ололт дэвшлийг энэхүү номд нэгтгэн уншигч танд хүргэж байна.

## БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС



### ХАРИУЦЛАГА

Бид хүүхдүүд, дэмжигч, хамтрагчдынхаа өмнө ил тод, хариуцлагатай байж, нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан, хэмжигдэхүйц үр дүнд хүрэх үүргийг хүлээнэ.



### ТЭМҮҮЛЭЛ

Бид өөрсдөдөө болон хамтрагчдадаа чанд шаардлага тавьж, алсын хараатай зорилго дэвшүүлэн, хүүхдийн төлөөх үйл ажиллагааныхаа чанарыг ямагт сайжруулахад тэмүүлнэ.



### ХАМТЫН АЖИЛЛАГАА

Бид хамтрагчдаа хүндэлж, ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрч, хамтдаа өсөн дэвжиж, хүүхдийн амьдралд эерэг өөрчлөлт бий болгохын төлөө ажиллана.



### БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ

Бид шинэ санаа, санаачилгад нээлттэй, өөрчлөлтөд бэлэн, эрсдэлд ухаалаг, зоримог байж, хүүхдийн төлөөх тогтвортой шийдлийг хүүхдүүдтэй хамт эрэлхийлнэ.



### ШУДАРГА БАЙДАЛ

Бид үнэнч шударга байдал, ёс зүйн өндөр хэм хэмжээг сахина. Бид үргэлж нэр төрөө эрхэмлэн ямагт хүүхдийн язгуур эрх ашгийг дээдлэн ажиллана.



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн Хөгжлийн Банк
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
ГБХЗХГ	Гэр Бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар
ЖАЙКА	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МУЗН	Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НХТ	Нийгмийн Хөгжлийн Төв
НХХЯ	Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам
ОБЕГ	Онцгой Байдлын Ерөнхий Газар
ОНБЗ	Олон Нийтийн Боловсролын Зөвлөл
ОУБ	Олон улсын байгууллага
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХБХЭЭХ	Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг, Эхийн Холбоо
ХИС	Хүүхдийг Ивээх Сан
ХТҮТ	Хүүхдийн Төлөө Үндэсний Төв
ХТҮГ	Хүүхдийн Төлөө Үндэсний Газар
ХЭА	Хүмүүжлийн эерэг арга
ХЭК	Хүүхдийн эрхийн тухай конвенц
ХЭҮТ	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв
ЯБҮХ	Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөр

# ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН МОНГОЛД



■ Зүүн гар талаас ХИС-гийн хөтөлбөрийн захирал Жон Буклер, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монголд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жон Дурам, БСШУ-ны сайд Ч.Лхагважав нар ЯБҮХ-ийн Орон Нутгийн Хөгжлийн Сангийн дор СӨБ-ын дэд сан бий болгон байршуулах гэрээнд 1997 оны 7 дугаар сарын 7-нд гарын үсэг зурлаа.

1992 оны 1-р сарын 13-нд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаар Монгол Улс хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлсэн, хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхээ тунхаглан зарлалаа.

1993 оны 8-р сард Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын эрхэмсэг гүнж Анна Монгол Улсад албан ёсоор айлчилж, айлчлалын дүнд Монгол Улсын Засгийн газар, Хүүхдийг Ивээх Сан хамтын ажиллагааны гэрээг үзэглэжээ. Энэхүү үйл явдал Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь үйл ажиллагааны эх үндсийг тавьсан юм.

1990-ээд оны дунд үед<sup>1</sup> Монгол Улс төлөвлөгөөт эдийн засгийн системээс зах зээлийн системд шилжиж, нийгэм, эдийн засгийн туйлын хүнд нөхцөлд байсан билээ. Шилжилтийн эхэн үед Монголын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж, тус улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний гуравны нэгтэй тэнцэж байсан ЭЗХТЗ<sup>2</sup> болон ЗХУ<sup>3</sup>-ын тусламж, санхүүгийн дэмжлэг зогссон нь нийгмийн амьдралд цохилт болсон юм. Эдийн засгийн үзүүлэлтүүд жил дараалан доошилж, 1992-1993 онд хүн амын бодит орлого хоёр дахин, 1993 онд дахин гуравны нэгээр буураад байлаа.

<sup>1</sup> ХИС-гийн Монгол дахь хөтөлбөрийн стратегийг (1995- 2000 он) боловсруулах ажлын хүрээнд хийсэн "Нөхцөл байдлын судалгаа", 1994

<sup>2</sup> Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл (1949-1991)

<sup>3</sup> ЗХУ- Зөвлөлт Холбоот Улс (1922-1991)

Энэ үед Монгол Улсын Засгийн газар бүтцийн өөрчлөлт хийж, төрийн өмчийг хувьчлах, зах зээлийн чөлөөт үнэд шилжих, төрийн үйлчилгээний татаасыг бууруулах зэрэг ажлыг шат дараалан хэрэгжүүлсэн бөгөөд улс орны нийгмийн бодлогыг тухайн үеийн санхүүгийн эх үүсвэрийн хомс байдалд зохицуулахаас өөр аргагүйд хүрчээ.

Бүтцийн өөрчлөлтөөс үүдэн ажилгүйдэл, ядуурал нийгмийн хурц асуудал болж, 1995 он гэхэд хүн амын 36,3% нь ядуу амьдралтай байлаа.<sup>1</sup> Ажилгүйдэл ихэсч, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын хөрөнгө оруулалт, үйлчилгээ эрс хумигдсанаар Монгол Улсын нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүд огцом буурсан юм.

Хөдөөд эрүүл мэндийн тогтолцоо хямарч, 1991-1993 онд эхийн эндэгдэл хоёр дахин нэмэгдэв. Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг төрөөс даахаа больсноор 1989-1992 онд дотуур байранд амьдардаг хүүхдийн тоо 2 дахин буурч, сургууль завсардалт эрс нэмэгдэв. 1990 онд ажиллаж байсан 909 цэцэрлэг 1995 он гэхэд 660 болтлоо цөөрч, сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-д хамрагдалтын хувьд 27,9%-аас 18,8% хүртэл буурлаа.<sup>2</sup> Өмнөх тогтолцооны үед байсан хүүхдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээ үндсэндээ үгүй боллоо.

1 Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр, Монгол Улсын Статистикийн Үндэсний Газраас хийсэн “Амьжиргааны түвшин тогтоох судалгаа”, 1995

2 “Бүх Нийтийн Боловсрол” үнэлгээ, 2000

■ Улаанбаатар хотын хар зах дээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд, Хүүхдийг Ивээх Сангийн гэрэл зургийн архиваас



Яг энэ үед буюу 1994 оны 2-р сард Хүүхдийг Ивээх Сан (ХИС)-гийн Монгол дахь Хөтөлбөр үүдээ нээж, захирал Жон Буклер, орчуулагч, туслах ажилтан, жолооч гэсэн дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

ХИС-гийн Монгол дахь Хөтөлбөр үйл ажиллагаандаа баримтлах стратегиа 1993 онд ХИС-гийн бүсийн салбараас Дэлхийн Банкны захиалгаар хийж гүйцэтгэсэн “Монголын эмзэг бүлгийн хүмүүсийн нөхцөл байдлын үнэлгээ”, 1994 онд хийсэн бусад судалгаа, баримтад үндэслэн:

- 1 Шилжилтийн үеийн хүндрэлүүдэд хамгийн их өртөж, эрх нь ноцтой зөрчигдөж байгаа Эмзэг бүлгийн хүүхдүүдэд онцгой анхаарах;
- 2 Эмзэг бүлгийн хүүхдүүдийн өмнө тулгарч байгаа асуудлыг байгаа нөөц, боломжийнхоо хүрээнд шийдвэрлэхийн тулд өрхийн түвшин дэх Ядуурлыг бууруулахад туслах;
- 3 Боловсрол, нийгмийн тусламжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөлд байгаа (хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч) хүүхдүүдийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд нийгэмд Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, Хүүхэд төвтэй үйлчилгээг хөгжүүлэх;
- 4 Бүхлээрээ хямарсан боловсрол, нийгмийн халамжийн тогтолцоог олон улсын жишигт хүргэх, оролцоонд тулгуурласан хөгжлийн шинэ хандлагыг нэвтрүүлэхийн тулд Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих хэмээн тодорхойлж, бүх хөтөлбөр, үйл ажиллагаагаа эдгээрт чиглүүлжээ.

ХИС эцэг эх, асран хамгаалагчийн асрамж, хараа хяналтаас гарсан, “гудамжны” гэж нэрлэгдэх эмзэг бүлгийн хүүхдүүдэд нэн тэргүүнд онцгой анхаарч, тэднийг орон байр, хоол хүнсээр хангаж нийгэмшүүлэн хөгжүүлэх “Хот айл” төвүүдийг байгуулсан юм. “Хот айл” төвүүд бол өнчин хүүхдийн асрах газрын оронд бий болгосон үйлчилгээний шинэ хувилбар байв. Энэхүү үйл ажиллагаагаа амь зуухын эрхээр ажил хийж, ар гэрээ тэжээж яваа хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн эрхийг хамгаалах, тэднийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нөхөн сэргээх гэх мэт тал бүрийн үйлчилгээгээр өргөжүүлсэн юм.

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдэн орсон боловч ХИС-г хөтөлбөрөө нээх үед хүүхэдтэй харилцахдаа “хүн биш хүүхэд байна” гэж үл тоомсорлох хандлага Монголын нийгэмд түгээмэл байлаа. Хүүхэдтэй харилцах олон нийтийн хандлагыг өөрчлөхийн тулд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан хүүхдийн эрхийн тухай үндсэн ойлголтыг түгээх, хүүхэд хамгааллын бодлогыг амьдралд хэрэгжүүлэхэд онцгой үүрэгтэй нийгмийн ажлын үйлчилгээг Монгол Улсад хөгжүүлж, хүний нөөцийг чадавхжуулах нь нэн чухал шаардлагатай байв.



1994-2000 онд ХИС хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог хөгжүүлэх ажлыг санаачлан эхлүүлэхдээ хүүхэдтэй ажилладаг шат шатны төрийн болон төрийн бус байгууллагууд, боловсролын салбарын мэргэжилтнүүд, бүх шатны боловсролын байгууллагын багш нарт хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын аргазүйн сургалтыг тасралтгүй явуулсан. Түүнчлэн Монгол Улсын багш бэлтгэх тогтолцоонд агуулга, чанарын өөрчлөлт хийж, “нийгмийн ажилтан” хэмээх цоо шинэ мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн билээ.

Хүний хөгжил төлөвшилд бага насны үеийн хөгжил нэн чухал нөлөөтэйг харгалзан ХИС СӨБ-ын салбарт хөрөнгө оруулах, сонирхогч талуудтай хамтран ажиллах стратегийн шийдвэрийг гаргасан. 1994 онд ХИС нь СӨБ-ын хувьд Монгол Улс дахь цорын ганц олон улсын хандивлагч байж, энэ салбарыг шилжилтийн үеийн хямралаас хамгаалж үлдэхийг зорьсон юм.

2000 он гэхэд Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал сайжирч, шилжилтийн үеийн хямралт байдлаас гарав. Ядуурлын түвшин буураагүй ч 1999 он гэхэд Монгол Улсын хүний хөгжлийн үзүүлэлтүүд сайжирч, 1990 оны түвшнээс давсан байлаа. СӨБ бүрэн сэргэж, “Сургуулийн өмнөх Боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр-2” хэрэгжиж эхэллээ. СӨБ-ын салбарт олон улсын бусад байгууллагууд, хандивлагчид ч анхаарлаа хандуулах болов.

Энэ үеэс эхлэн ХИС Боловсролын хөтөлбөрийнхөө цар хүрээг өргөжүүлж, Боловсролын салбарын эрхзүйн шинэчлэл; Тэгш хамруулах боловсрол, Хүүхдийн эрхэд суурилсан боловсролын тогтолцоог бэхжүүлэх; Боловсрол дахь эцэг эх, олон нийтийн оролцоо зэрэг олон чиглэлээр тэлсэн юм.

■ Хүүхдийг Ивээх Сангийн Нийгэмшүүлэх Цирк хөтөлбөрийн суралцагчид Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох олон улсын өдрийг угтан парад зохион байгуулж байна. Улаанбаатар хот, 2014 он







■ Хүүхдийг Ивээх Сангийн санаачилсан алслагдсан хөдөөгийн хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг хүргэх шинэлэг арга хэлбэрүүдийг улсын хэмжээнд туршиж, нэвтрүүлжээ. Гэр цэцэрлэгийн үйл ажиллагаа. Говь-Алтай аймаг, 2003-2004 он

ХИС бусад улс орнуудад хуримтлуулсан сайн туршлагаасаа Монголд түгээж, нэг ч хүүхдийг боловсролын гадна үлдээлгүй тэгш хамруулах загвар бий болгохын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд анхаарлаа хандуулсан юм. 1998 онд ХИС хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн цэцэрлэгт хамруулах туршилт төслүүдээ эхлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй монголчуудын амсдаг ялгаварлал, хүчирхийллийн асуудлыг илүү тодоор харж эхэлсэн билээ. Олон нийтийн тэрхүү сөрөг хандлагыг өөрчлөхийн тулд ХИС бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгч талуудтай эрхзүйн талбарт бүтээлчээр ажиллаж, хүний эрхийн төлөөх иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжиж ажиллав.

Өнөөдөр Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн цэцэрлэгт болон ЕБС-д хамрагдах боломжтой болсон төдийгүй үзэл бодлоо илэрхийлэх, оролцох, хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих боломжтой болсон нь ХИС-гийн 25 жилийн уйгагүй зүтгэлийн үр дүн юм.

2000 оноос хойш ХИС-гийн шинэ стратеги батлагдаж, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийнхөө хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхийн тулд сонгосон аймаг, орон нутагт төвлөрч, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын салбарт нөлөөллийн ажлууд идэвхтэй явуулж эхэлсэн байна.

ХИС-гийн Монголын нийгэм рүү хандсан бодлогын өөрчлөлт НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтэд иргэний нийгэм болоод хүүхдүүд хяналт тавих; үндэстний цөөнхийн хүүхдүүд эх хэлээрээ боловсрол эзэмших; гамшиг, онцгой байдал дахь хүүхэд хамгаалал; алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдийн боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах; гэр бүлд түшиглэсэн, олон нийтийн оролцоотой сургалтын хувилбарууд гэсэн шинэ чиглэлүүд рүү хандаж байв.

2004 оноос ХИС НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн тайлан бичихэд нь иргэний нийгмийн байгууллагууд, хүүхдүүдэд дэмжлэг үзүүлж эхэлсэн нь Монгол Улс дахь Хүүхдийн эрхийн нөхцөл байдлыг бодитойгоор үнэлэх, хянах, улмаар сайжруулахад дэвшил авчирсан юм.

2005-2009 онд ХИС-гийн явуулсан бодлогын алхмууд, нөлөөллийн ажлууд хүүхэд хамгаалах үндэсний тогтолцоог бий болгон хөгжүүлэхийн зэрэгцээ иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах, хүүхдийн эрхийн хяналт, үнэлгээнд хүүхдүүдийг оролцуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

■ *Хүүхдийг Ивээх Сангийн тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл хэрэгжиж байгаа 67 дугаар сургуулийн хоёрдугаар ангийн сурагч Т (зургийн голд буй сурагч охин) арав хүртэл тоолж чаддаг, үсэглэж уншдаг, ангийнхантай тоглох, цагийг хамт өнгөрөөх дуртай болжээ. Улаанбаатар хот, 2020 он*







■ Японы Хүүхдийг Ивээх Сангийн захирал, ноён Кунио Сенга “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төслийг хамтран хэрэгжүүлэгч 70 дугаар цэцэрлэгт зочилж байгаа нь. Улаанбаатар хот, 2013 оны 10 дугаар сар

Гэвч тухайн үед дэлхийн олон улс гүрнийг хамарсан эдийн засгийн хямралаас үүдэн Их Британийн ХИС олон улсад хэрэгжүүлж байсан хөтөлбөрүүдээ эргэн нягталж, санхүүжилтээ багасгахдаа Монгол Улсад нээсэн салбараа хаахаар шийдвэрлэсэн билээ. Тэр үед Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, 2009 оны байдлаар Монгол Улс нийт төсвийнхөө 19,1%-ийг боловсролд зарцуулж байсан нь “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүргэх санаачилга”-аас (одоогийн Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл) зөвлөсөн жишигт нийцэж байв. Энэ нь улсын нийт ДНБ-ний 7,5%-тай тэнцэхүйц хөрөнгийг боловсролд хуваарилдаг гэсэн үг бөгөөд Ази, Номхон далайн улс орнуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм<sup>1</sup>.

Их Британийн ХИС Монгол дахь хөтөлбөрөө хаахдаа Монгол Улсын хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын салбарт хүрсэн түвшин, бодлогын өөрчлөлт, олсон амжилтыг харгалзан Японы Хүүхдийг Ивээх Санд шилжүүлсэн билээ. Ийнхүү ХИС-гийн Монгол Улс дахь хөтөлбөрийн хөгжлийн шинэ үе эхлэв.

2009 оноос хойш ХИС хүүхдэд ээлтэй сайн засаглалыг бэхжүүлэх, Монголын Сургуулийн өмнөх боловсрол, бага боловсрол, хүүхэд хамгаалал, тэр дундаа гамшиг, онцгой байдал дахь хүүхэд хамгаалал; хүүхдийн оролцооны хөтөлбөрүүдэд түлхүү анхаарч байна.

<sup>1</sup> Г.Стайнер-Хамси, А.Гэрэлмаа. Монголын боловсролын чанар ба тэгш байдал, 2009



■ Хүүхдийг Ивээх Сан байгууллагын үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн тухай мэдээллийг олон нийтэд түгээж байна. Сүхбаатарын талбай, Улаанбаатар хот, 2008 оны 10 дугаар сар

Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэхдээ ХИС нь хүүхэд, хүний эрхийн төлөө иргэний байгууллага, төрийн байгууллага, олон нийт, хэвлэл мэдээлэл гээд олон талын оролцогчдыг татан оролцуулж, байр суурийг нь тусгадаг. Ялангуяа иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах, бэхжүүлэх, олон нийтэд хүүхдийн эрх, хамгааллын талаарх мэдлэг, мэдээллийг хүргэхэд ХИС анхнаасаа санаачилгатай хандаж, чиглүүлж ирэв.

Монголын хүүхдүүдийн амьдралыг сайн мэддэг, тэдний үзэл бодлыг ойлгодог, хүсэл мөрөөдлийг нь дэмждэг байгууллагын хувьд Хүүхдийг Ивээх Сан өнгөрсөн 25 жилд Монголын хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр үндэсний хэмжээний өөрчлөлт хийж, олон амжилт дэвшлийг бүтээсэн билээ.

Өнөөдөр Хүүхдийг Ивээх Сан Монголын хүүхдүүдийн амьдралд урт хугацааны, тогтвортой өөрчлөлтийг бий болгохын тулд тэдний өмнө тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдлийг олохыг эрхэмлэн ажиллаж байна.

Тиймээс хүүхдийн хөгжлийг дэмжих, оролцооны эрхийг баталгаажуулахад чиглэсэн “Хүүхдийн эрхийн засаглал”, “Хүүхэд хамгаалал”, “Боловсрол”, “Хүүхдийн ядуурлыг бууруулах” хөтөлбөрүүдээ өргөжүүлэн, Монгол Улсад хүний эрхийг дээдэлсэн, ардчилсан, хүмүүнлэг нийгэм, хүүхдэд ээлтэй сайн засаглалыг байгуулах үйлсэд хувь нэмрээ оруулж байна.



Анх 1997 оны сүүлээр ХИС гэх энэхүү олон улсын нэр хүндтэй байгууллагад орж ажилласандаа маш их баяртай, бас байнга талархаж байдаг. Учир нь тэнд би олон сайхан хүмүүстэй хамтран ажиллаж, цугтаа олон ажлын ард амжилттай гарч, хамт сурч хөгжиж ирсэн ба тэднээрээ болон ийм бололцоо бүрдүүлж олгож ирсэн байгууллагаараа байнга бахархаж явдаг.

1994 оны дундуур ХИС Монгол Улсад ажиллаж эхлэх үедээ дэлхийн олон арван улсад 70 гаруй жил ажилласан арвин туршлага, янз бүрийн нөхцөлд хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр ажиллаж хуримтлуулсан мэдлэг, өндөр ур чадвартай боловсон хүчинтэй болсон байсан.

ХИС ийм олон улсад зэрэг үйл ажиллагаа явуулахдаа нэгдсэн журам, заавар болон байгууллагын хөгжлийн хамгийн сүүлийн үеийн мэдлэг мэдээллээр тэдгээр улс дахь хөтөлбөрүүдээ хангаж байсан нь тухайн ажиллаж байгаа улсынхаа хуульд нийцүүлэн, байгууллага байнга хөгжин өөрийн соёл, ёс зүйн хэм хэмжээг тогтоон ажиллахад нь их хувь нэмэр болж байсан гэж боддог.

ХИС-гийн өнөөг хүртэл тогтвортой, амжилттай ажиллахад гол үүрэг гүйцэтгэсэн зүйл бол тэнд ажиллаж байсан, ажилласаар байгаа ажилтнууд билээ. ХИС ажилтнуудаа дотоод журмынхаа дагуу олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар зарлан сонгон шалгаруулалтаа явуулж мэдлэг боловсролтой хүмүүсээр багаа бүрдүүлдэг. Анх 1990-ээд онд ХИС Монгол Улсад хөтөлбөрөө эхлүүлэхдээ боловсролтой, мэргэжил ур чадвар өндөр, ажилдаа сэтгэл зүрхнээсээ хандаж чаддаг, зөв хүмүүсийг сонгон авч ажиллуулан сууриа маш сайн тавьсан явдалд ХИС-гийн Монгол дахь хөтөлбөрийн анхны захирал Жон Буклер онцгой гавьяатай юм. Түүний дараа дараагийн захирлууд ч энэхүү суурийг улам бэхжүүлж, ажилтнуудаа сонгон шалгаруулахдаа анхаарч, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд их ач холбогдол өгч ирсэн.

Намайг ажиллаж байх үед ХИС-гийн Монгол дахь төлөөлөгчийн газар ИБХИС-ийн Тайландын Бангкок хотод байрлах Зүүн Өмнөд Ази Номхон Далайн бүсийн төвд хамаарч, тус төвөөс зохион байгуулдаг сургалт, семинарт ажилтнуудаа байнга хамруулахын зэрэгцээ аль нэг хөтөлбөрийн хүрээнд нэвтрүүлэх гэж буй шинэ арга зүй, чиг хандлагыг оруулж ирэхдээ гаднын болон дотоодын зөвлөхүүдийг урьж ажиллуулах, сургалт явуулах зэргээр ажилтнуудаа хөгжүүлж ирсэн. Мөн ажилтнуудынхаа нийгмийн асуудалд анхаарсан хүний нөөцийн бодлого, хангамж, байгууллагын дотоод тааламжтай уур амьсгал нь хүмүүс сэтгэлээсээ, урам зоригтой, тогтвортой ажиллах хөшүүрэг болж байсан.

Олон төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн ажилтнуудын ард хүний нөөц, санхүү, захиргааны ажилтнуудын үүрэг маш чухал байсан. Тэд ч энэ үүргээ байнга сайн биелүүлж, байгууллага үйл ажиллагаагаа хэвийн, тогтвортой явуулахад шаардлагатай дотоод дүрэм журмыг боловсруулж, түүнийгээ сахин мөрдөх, аюулгүй ажиллагаа, худалдан авалт, төв оффисоос болон гадаадын санхүүжүүлэгч байгууллагаас тавьж буй шаардлагад нийцүүлэн ажиллах гээд бүхий л зүйл дээр найдвартай ар тал нь байсаар ирснийг дурдах нь зүйтэй юм.

Анх 6-7 хүнтэй байсан ХИС-гийн Монгол дахь хөтөлбөр 2000 он гарахад 80 гаруй ажилтантай, хөдөө орон нутагт салбар төвтэй болж өргөжин 150-170 хүүхдэд шууд үйлчилгээ үзүүлж байхад ч тэд хөтөлбөрийнхнийг байнга найдвартай ажиллагаагаар хангаж, итгэлтэй ар тал туслагч нь байж ажиллаж ирсэн. Захиргаа, санхүүгийн ийм чадварлаг хамт олонтой хамтран ажиллаж байсандаа талархаж, тэднээр бахархаж явдаг билээ.

Эргээд бодоход, Монголын хүүхдийн төлөө нэг байгууллагын хэмжээнд биш салбарын хэмжээнд, үндэсний хэмжээнд бодлогын өөрчлөлт гаргаж, шинэ шинэ үзэл баримтлалын анхдагч нь болон ажилласан чадварлаг хамт олонтой ажиллаж байжээ. Тэд одоо ч хүүхдийн сайн сайхны төлөө олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудад манлайлан ажиллаж байгаад бахархдаг.

ХИС-д ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа нийт ажилтнуудын хүүхдийн төлөөх ариун үйлсэд нь улам их амжилт хүсье.

Л.Дулмаа, ХИС-гийн Захиргаа, Хүний нөөцийн менежер (1997- 2010)



# ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗАСАГЛАЛ

ХИС хүүхдийн үгийг сонсдог, амьдралд нь нөлөөлөх шийдвэр гаргахад хүүхдийг оролцуулдаг, үзэл бодлыг нь тусгадаг хариуцлагатай нийгмийг цогцлоохын төлөө зорин ажилладаг. Тиймээс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтэд онцгой анхаарал тавьдаг юм.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох зэрэг үндсэн эрхийг баталгаажуулдаг олон улсын хүний эрхийн суурь гэрээ билээ. Уг конвенцод нэгдсэн улс орнууд өөрсдийн нутаг дэвсгэрт амьдарч буй бүх хүүхдэд эдгээр эрхийг эдлүүлэх үүрэг хүлээдэг. Түүний тулд зайлшгүй шаардлагатай зүйлийн нэг бол “хүүхдийн төлөө сайн засаглал” бөгөөд энэ нь төрөөс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын зарчим, хэм хэмжээг хэрэгжүүлэхийн төлөө хүлээсэн үүрэг хариуцлага юм.<sup>1</sup>

Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1990 онд нэгдэн орсон. Энэ нь ХИС-г Монгол Улсад үйл ажиллагаа явуулах, хүүхдийн эрхийн төлөөх хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэх эрхзүйн үндсийг тавьсан юм.

<sup>1</sup> A global strategy for achieving our Child Rights Governance Goals 2013-2015, Save the Children

## ХИС-гийн Монгол Улс дахь хөтөлбөр улс орны хөгжлийн түвшин, үндэсний онцлогийг харгалзан:



Хүүхдийн эрхийн тухай суурь ойлголт, зөв мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээх, сурталчлах;



Монгол Улсын хүүхдийн эрхийн нөхцөл байдлыг шинжлэх, хяналт тавих;



Нөлөөллийн аргаар холбогдох хууль эрхзүйн баримтуудад хүүхдийн эрхийг хамгаалах үзэл санааг тусгах;



Монголын төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хүүхдийн эрхэд суурилсан чиг хандлагыг нэвтрүүлэх;



Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийг хөгжүүлэх, дэмжих бүтцийг бий болгоход удирдлага, санхүү, аргазүйн болон бусад төрлийн дэмжлэг үзүүлэх;



Хүүхдийн эрхийн төлөө иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах;



Хүүхдүүдийн оролцоог аргазүйгээр дэмжиж хөгжүүлэх зэрэг олон чиглэлээр өргөн хүрээтэй ажлыг шат дараалан хэрэгжүүлсэн билээ.



■ “Өсвөр үеийнхний дуу хоолой бүлэг”-ийн хүүхдүүд “Сайн засаглалд өсвөр үеийнхний оролцоо амин чухал” төслийн нэгэн хэлэлцүүлгийн үеэр. Улаанбаатар хот, 2013 он

**25 дэвшил: №1**

**Монгол Улсад  
хүүхдийн эрхийн  
тухай үндсэн  
ойлголтыг  
түгээж, хүүхдийн  
эрхэд суурилсан  
чиг хандлагыг  
нэвтрүүлэв.**



■ “Сайн засаглалд өсвөр үеийнхний оролцоо амин чухал” төслийн арга хэмжээ. Улаанбаатар хот, 2013 он

Хүрсэн түвшин, ирээдүйн стратегийн зорилтоос шалтгаалан ХИС-гийн Монгол Улс дахь хөтөлбөрийн газар нь хүүхдийн эрхийн чиглэлээрх үйл ажиллагаагаа 2012 оноос “Хүүхдийн эрхийн засаглал” бие даасан хөтөлбөртэй болгосон юм. ХИС-гийн “Хүүхдийн эрхийн засаглал” хөтөлбөр нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцоор баталгаажсан хүүхдийн салшгүй бүх эрхийг бодитойгоор хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тогтолцоог дэмжихүйц “хүүхдийн төлөө сайн засаглал”-ыг бий болгохын тулд эрх эдлэгч хүүхдүүд болон иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна.



## 1. ЭРХЗҮЙН САЛБАРЫН ӨӨРЧЛӨЛТ

### 1994 ОНООС: ХИС БА МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХИС нь Монголд хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн цагаасаа Монгол Улсын Засгийн газар, тэр дундаа БСШУСЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Хүүхдийн төлөө Үндэсний төв (өнөөгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар)-тэй хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр нягт хамтран ажиллаж байна.

2003-2004 онд тухайн үеийн Хүүхдийн төлөө үндэсний газрын стратегид хүүхдийн эрхийг хамгаалах, сурталчлах ажил үүргийг онцгойлон тусгахад ХИС-гаас дэмжлэг үзүүлсэн нь одоо ч тус байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл хэвээр байгаа юм.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (1996- 2000)”, “Сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр-1 (1995-2000)”, “Сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр-2 (2001- 2007)”, “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002-2010)”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөр”, “Үндэстний цөөнхийн

25 дэвшил: №2

**Хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох эрхзүйн салбарын өөрчлөлтийн үйл явцад ХИС манлайлан ажиллав.**



боловсролыг дэмжих хөтөлбөр (2008-2012)”, “Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх 2010-2015 оны үндэсний стратеги”, “Боловсрол үндэсний хөтөлбөр (2010-2021)”, “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр” (2011) гээд үндэсний хэмжээнд хэрэгжсэн олон хөтөлбөрт ХИС-гийн хамт олны хүчин зүтгэл орсон.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд заасан тулгуур зарчмын дагуу Монгол Улс эрхзүйн салбараа шинэчилж эхлээд 30-аад жил болж байна.

ХИС тус улсад ажиллаж эхэлсэн цагаасаа Монгол Улсын хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг батлуулахад чиглэсэн нөлөөллийн ажлын тэргүүлэгчдийн нэг байж, эдгээр хуулиуд болон олон улсын хүний эрхийн баримт бичгүүдийг таниулах, түгээх сургалтыг нийслэл болон орон нутгийн, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлд зориулан тасралтгүй зохион байгуулж ирлээ.

Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүүхдийн Сангаас 2014 онд хийсэн Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар “Монгол Улсын 1-14 насны хүүхдүүдийн 46 хувь нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн” гэж гарсан нь нийгэмд хүүхдийг хүмүүжүүлэх нэрээр бие махбодын болон сэтгэл санааны шийтгэл хэрэглэх нь түгээмэл байгааг илтгэж байна.

Тийм ч учраас ХИС Монгол Улсын нөхцөл байдалд нийцсэн хүмүүжлийн эерэг аргазүйг түгээх замаар хүүхдийг гэр бүл, боловсролын орчинд бие махбодын болон сэтгэл санааны шийтгэлээс ангид өсгөн хүмүүжүүлэх, улмаар хүүхдийн эсрэг чиглэсэн бүх төрлийн хүчирхийллийг халахын төлөө ажиллаж ирлээ<sup>1</sup>.



■ Хүүхдийг Ивээх Сангаас “Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох олон улсын өдөр”-ийг тэмдэглэж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулав. Улаанбаатар хот, 2006 он

<sup>1</sup> Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөрийн стратеги бодлого (2012-2016)

УИХ 2016 онд “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай” багц хуулийн төслийг хэлэлцэх үед ХИС тус улсад хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудын “Хүүхдийн эрхийн бүлэг” эвслийг тэргүүлж байлаа. “Хүүхдийн эрхийн тухай” болон “Хүүхэд хамгааллын тухай” хуулиудын Техникийн Ажлын Хэсгийг дэмжин ажиллаж, төсөлд зарчмын санал, зөвлөмж боловсруулж ажиллахдаа ХИС олон улсад хүүхдийн эрхийг хамгаалах хууль эрхзүйн баримт бичигт тусгадаг үндсэн зарчмуудыг “Хүүхэд хамгааллын тухай” хуульд тусгуулж чадсан юм. Тухайлбал:



1 Хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэл (гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөг) -ийг нийгмийн бүх орчинд хориглох хууль эрхзүйн орчныг бүрдүүлж чадсан.



2 Хүүхдийн эрхийг хүүхдийн амьдралын орчин бүрд (гэр бүлийн орчин, боловсролын орчин, эрүүл мэндийн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл цахим орчин, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны хүрээнд) хамгаалах төрөлжүүлсэн зохицуулалтыг санаачлан оруулав.



3 Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд Хүүхэд Хамгааллын Хамтарсан Багийн үйл ажиллагааг хуульчлах санаачилгыг тус тус гаргаж ажилласан билээ.

■ Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг хамтарсан багаар шийдвэрлэх арга барилыг Хүүхдийг Ивээх Сан 2003 оноос нэвтрүүлж Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран хэрэгжүүлж ирсэн юм. “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн ойлголт ба өнөөгийн байдал” Судалгааны тайлан танилцуулах уулзалт. Улаанбаатар хот, 2010 он








2016 оны 2-р сард Монгол Улсын Их Хурал “Хүүхэд хамгааллын тухай хуулийг” баталж, мөн оны 9-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлснээр Монгол Улс хүүхдийг зодож шийтгэхийг нийгмийн бүхий л орчинд хуульчлан хориглосон дэлхийн 49 дэх улс болсон юм.

2018 оны 5-р сарын байдлаар Монгол Улс олон улсын хүний эрхийн нийт 36 гэрээнд нэгдэн орсон. Харин 2015 оноос хойш хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн олон улсын гэрээнд нэгдэн ороогүй байна.

“Хүүхэд хамгааллын тухай хууль” батлагдсан нь Монгол Улсын хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын салбарт 25 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан ХИС-гийн үе үеийн ажилтнуудын хичээл зүтгэлийн үр дүн байлаа.



■ Архангай аймгийн эцэг эхчүүд хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг аянд нэгдэж байна. Цэцэрлэг хот, 2014 он

## Хүүхдийн эрхэд суурилсан боловсролын тогтолцоог бэхжүүлэхэд нөлөөлөв.

### 2005 - 2006 ОН: “ХҮҮХДИЙН ЭРХ БА БОЛОВСРОЛ” ЭВСЭЛ

ХИС 2005 онд Боловсролын салбарын стратегийн төлөвлөлтийн суурь мэдээлэл цуглуулах зорилгоор “Шилжих хөдөлгөөн хүүхдийн амьдралд: Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ба боловсролын хүртээмж” судалгааг хийсэн юм.

Судалгааны хүрээнд Монгол Улсын Боловсролын тухай хуульд хүүхдийн эрхийн үүднээс дүн шинжилгээ хийсний үндсэн дээр уг хуульд хүүхдийн эрхийн чиглэлээр нэмэлт өөрчлөлтүүд оруулах нөлөөллийн кампанит ажлыг орон даяар эхлүүлсэн билээ. Энэхүү кампанит ажлыг эрчимжүүлэх зорилгоор иргэний нийгмийн бүлгүүдийг нэгтгэн “Хүүхдийн эрх ба боловсрол” эвслийг байгуулж, УИХ дахь “Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих бүлэг”, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, эцэг эхчүүд, хүүхдүүдтэй хамтран ажилласан билээ. Тус нөлөөллийн аяны үр дүнд 2006 онд Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, багш нь суралцагчийн бие махбодод халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг задруулах, хууль бус төлбөр хураамж авахыг хориглосон юм.

Мөн энэ ажлын хүрээнд албан бус сургалт болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хувьсах зардлыг нэмэгдүүлж чадсан нь том амжилт болсон билээ.

■ Хүүхдийг Ивээх Сан Монгол Улсын Боловсролын тухай хуульд хүүхдийн эрхийн чиглэлээр нэмэлт өөрчлөлтүүд оруулах нөлөөллийн кампанит ажлыг санаачилж, орон даяар зохион байгууллаа. 2006 он







## **2008 ОН: “СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛ**

ХИС 2008 онд УИХ-аас баталсан “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийн төсөл боловсруулах Ажлын Хэсгийн гишүүнээр идэвхтэй ажиллан бүх хүүхэд сургуулийн өмнөх, чанартай боловсролд тэгш хамрагдах эрх зүйн бие даасан орчинг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсан юм.



## **2013 - 2014 ОН: “ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЦЭЦЭРЛЭГИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ”**

2013 онд БШУЯ “Хүүхэд бүрд ээлтэй цэцэрлэгийг хөгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг батлан гаргасан ба Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанарт анхаарсан энэхүү бодлогын баримт бичиг нь бага насны хүүхдийн хөгжил, хамгааллын талаарх ХИС-гийн үзэл баримтлал, үйл ажиллагааны сайн туршлага дээр үндэслэсэн болохыг онцлон дурдахад таатай байна.



Мөн 2014 оны 4-р сарын 10-ны өдөр БШУЯ-ны сайдын тушаалаар батлагдсан “Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийг хөгжүүлэхэд баримтлах чиглэл” бодлогын баримт бичиг нь ХИС-гийн боловсруулсан загвар, үзэл санааг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх эрхзүйн орчинг бүрдүүлж байна.

■ Боловсролын тухай хуульд оруулах өөрчлөлтийн талаарх Хүүхдийг Ивээх Сангийн саналыг Монгол Улсын Шадар Сайдад танилцуулах уулзалт. Төрийн Ордон, 2006 он

Баруун гар талаас Шадар сайд М.Энхсайхан, Шадар сайдын зөвлөх Б.Жавзанхүү, (зүүн гар талаас) Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн захирал Ч.Тунгалаг, хөтөлбөрийн ажилтан Д.Амараа, хуульч Х.Тэмүүжин

## **2016 - 2018 ОН: ХИС-ИЙН САНАЛ ЗӨВЛӨМЖ ӨГЧ АЖИЛЛАСАН ХУУЛЬ, ЖУРМЫН ТӨСЛҮҮД**

“Боловсролын тухай”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Гэр бүлийн тухай” хууль, тэдгээрийг дагаж гарах журам, төлөвлөгөөний төсөл, Боловсролын салбарын мастер төлөвлөгөө гэх мэтчилэн хүүхдийн эрх, хүүхэд хамгаалалтай шууд холбоотой эрхзүйн баримт бичгүүдэд ХИС санал, зөвлөмжөө өгч ажилласан.

## 2. ХАМТЫН АЖИЛЛАГАА

**25 дэвшил: №4**

### **Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэв.**

ХИС урт хугацааны тогтвортой түншлэлийг хөгжүүлж, Хүүхдийн эрхийн олон улсын механизмыг хэрэглэх чиглэлээр иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх, нийгмийн эгэх хариуцлагын хамтын ажиллагааг сайжруулахад ТББ-уудыг дэмжин ажиллаж байна.

Түүний тулд 2004 оноос НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаар хөндлөнгийн тайлан, нэмэлт илтгэл бичихэд нь хүүхдүүд болон иргэний нийгмийн байгууллагуудад аргазүй, санхүүгийн дэмжлэг үзүүлж ирлээ. Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн ахиц дэвшилд хяналт үнэлгээ хийх, тайлан гаргах нь хүүхдийн эрхийн төлөөх хариуцлагыг бий болгох үйл явцын чухал хэсэг мөн.

2008 онд ХИС хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын “Хүүхэд хамгааллын эвсэл”-ийг манлайлан ажиллаж, УИХ-ын сонгуульд оролцогч улс төрийн намуудаас хүүхэд хамгааллын чиглэлд анхааран ажиллах амлалтыг авч баталгаажуулж чадсан.

### **ХИС-ГИЙН АРГАЗҮЙ, САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР БАЙГУУЛАГДСАН ТББ-УУДААС ДУРДВАЛ:**

#### **НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ (1995 ОН)**

Иргэний нийгмийн салбар дахь ХИС-гийн анхны хамтрагчдын нэг “Нийгмийн хөгжлийн төв” (НХТ) төрийн бус судалгааны байгууллагыг тухайн үеийн Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт (одоогийн Удирдлагын академи)-ийн залуу судлаач багш нар байгуулжээ. ХИС, Монгол Улс дахь ИБУИНВУ-ын ЭСЯ-ны дэмжлэгтэйгээр НХТ-д үйл ажиллагаагаа эрхлэх гарааны санхүүжилтийг олгосон нь алсын хараатай шийдвэр байлаа.

НХТ нийгмийн судалгааны чиглэлээр мэргэшин ажиллаж, Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (ЯБҮХ)-ийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг амжилттай гүйцэтгэсэн байдаг. ХИС нь НХТ-тэй хамтран улсын хэмжээнд чадавх бэхжүүлэх сургалтууд зохион байгуулсан нь ЯБҮХ-ийн хэрэгжилтийг олон нийтэд түшиглэх нөхцөлийг хангаж, хөтөлбөрийн хэрэгжилт, шийдвэр гаргалтад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн билээ. Орон нутгийн иргэдийн оролцоонд суурилсан хөгжлийн энэ хандлага тухайн үедээ Монгол Улсад шинэ ойлголт байсан юм.

2006 онд тус төвөөс оролцооны аргаар хийсэн ядуурлын судалгаа нь Монголын хүүхэд залуучууд, тэдний эцэг эхчүүд өөрсдийн нөхцөл байдлын талаар ямар бодол саналтай явдаг дүр зургийг тодорхой гаргаж чадсан билээ.





■ *Нийгмийн Хөгжлийн Төвийн судлаач Р.Гантөмөр орон нутгийн иргэдтэй зөвлөлдөж байна. Архангай аймаг, 1996 он*

## **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХИЙН ХОЛБОО (ХБХЭЭХ) (2002 ОН)**

2002 онд ХИС хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хүүхдийнхээ эрхийн төлөө эвлэлдэн нэгдэх санаачилгыг аргазүй, санхүүгийн хувьд дэмжсэнээр ХБХЭЭХ байгуулагдсан юм.

ХИС 2003 онд Европын Холбооны ТАСИС хөтөлбөрийн 133 мянган еврогийн санхүүжилттэй “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны чадавхыг бэхжүүлэх нь” 18 сарын хугацаатай төслийг хэрэгжүүлсэн.

2006-2009 онд Европын Холбоо болон Их Британийн ХИС-гийн 1,3 сая еврогийн санхүүжилттэй “Сургуулийн өмнөх болон бага боловсролын үр дүнг сайжруулах нь” багц төслийн 3 дахь төсөл дээр тус холбоог дэмжиж, чадавхжуулах зорилгоор хамтран ажилласны үр дүнд ХБХЭЭХ нь Улаанбаатар хот болон хөдөө, орон нутагт салбараа байгуулан, үндэсний хэмжээний төрийн бус байгууллага болтлоо өргөжсөн юм. Одоо тус ТББ 17 аймагт салбараа байгуулан чадавхаа бэхжүүлэн ажиллаж байна.

## **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ХҮҮХДҮҮДИЙН “МАНДАХ” ХОЛБОО (2004 ОН)**

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн үүсгэл санаачилга, ХИС-гийн аргазүй, санхүүгийн дэмжлэгээр байгуулагдсан “Мандах холбоо” нь хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд хүрч ажиллах, тэдэнд боловсролын болон хөгжлийн шинэ боломжуудыг нээж өгөх, хөдөлмөр эрхэлж байгаа болон хараа хяналтгүй хүүхдүүдийг амьдрах ухааны арга барилд сургахад ХИС-гийн гол хамтрагч байлаа.

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдэд зориулсан ХИС-гийн хөрөнгө оруулалт нь тэдгээр хүүхдүүдэд орлогоо нэмэгдүүлэх, гудамжны амьдралаас хөндийрч орон гэртээ амьдрахад нь ихээхэн үүрэг гүйцэтгэсэн билээ.



■ *“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх олон нийтийн эерэг хандлагыг төлөвшүүлэх нь” нөлөөллийн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан Сургагч багш бэлтгэх семинар, 2007 оны 11 дүгээр сар*

## **МОНГОЛЫН БАГШ, ЭЦЭГ ЭХИЙН ХОЛБОО (2014 ОН)**

2011-2014 онд Япон Улсын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төслийн хүрээнд 2014 онд өмнө нь ХИС-д ажиллаж байсан хүмүүс болон 19 цэцэрлэгийн Эцэг эхийн зөвлөл нийлж “Монголын багш, эцэг эхийн холбоо” ТББ байгуулсан нь цэцэрлэг, сургуулийн Эцэг эхийн зөвлөлүүдийн хамтын ажиллагааны суурь болон ажиллаж, СӨБ-ын салбарт хүмүүжлийн эерэг аргыг түгээн сурталчилж байна. Тус байгууллага нь эцэг эх, олон нийтийн хүч оролцоог дайчлах, дуу хоолойг нь нэгтгэх замаар төрөөс хүүхдүүдэд чанартай боловсрол олгоход дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилладаг.

**25 дэвшил: №5**

**Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах, тэднийг боловсролд хамруулах болон нөхөн сэргээх, хөгжүүлэх үйлчилгээнд хандлага, үйл ажиллагаа, бодлогын эргэлт хийв.**

## **1998 - 2019 ОН: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛБАРТ ОЛСОН АМЖИЛТУУД**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хамгаалал, үйлчилгээний талбарт ХИС эргэлт гаргаж, өөрийн гэсэн нийгмийн үйлчилгээний брэндийг бүтээсэн юм. Энэхүү брэндийг бүтээхэд алсын хараатай бодлого, тогтвортой үйл ажиллагаа, салбар хоорондын хамтын ажиллагаа, хандивлагчдын дэмжлэг нэн чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

1990-ээд онд эцэг эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ нийгэмшүүлэх, зохих боловсролд хамруулах, тэднийг хөгжүүлэх нь байтугай гэрээсээ гаргахгүй нуудаг, бусдаас ичдэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар олон нийт буруу ойлголттой, ялгаварлан гадуурхдаг, цэцэрлэг болон сургуулийн багш нарын мэдлэг, мэдээлэл хангалтгүй байлаа. Яг ийм үед ХИС хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн талаар анх дуугарч, 1998 онд Архангай, Булган аймаг, Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн цэцэрлэгт хамруулах туршилтын төслийг санаачлан эхлүүлсэн.

■ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөр”-ийн үр шимийг 8,000 орчим хүүхэд шууд хүртжээ. Хөтөлбөрийн зорилтот сургууль, 2008 он





Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангахын тулд ХИС хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандсан төсөл хөтөлбөрүүддээ тухайн хүүхдийн боловсрол эзэмших боломжийг бий болгох, хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэх зорилгоор үе шаттай арга хэмжээг авсан.

Тухайн үедээ БСШУЯ-тай харилцан зөвшилцсөний үндсэн дээр 2003 онд тус яамны дэргэд “Тэгш хамруулах боловсролын нэгж” байгуулан, уг нэгжийн ажилтнуудын цалин хөлс, үйл ажиллагааны зардал зэргийг санхүүжүүлэн, аргазүй, санхүүгийн дэмжлэгийг үзүүлсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн сургууль болон цэцэрлэгт үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох баримт бичигт тусгах, Засгийн газрын бодлогод нөлөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

2003 онд тус нэгжээс Монгол Улсад анх удаа “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөр”-ийг боловсруулан Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөр, Эрүүл Мэнд болон Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын тушаалаар батлуулсан нь 2008 он хүртэл амжилттай хэрэгжиж, 8,000 орчим хүүхэд уг хөтөлбөрийн үр шимийг шууд хүртсэн байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сонсголын аппарат, бусад туслах хэрэгслээр хангах гэх мэт үр дүн нь богино хугацаанд харагдах шууд үйлчилгээ үзүүлснээс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх, засан сайжруулах төвийг Монголдоо анх удаа орон нутагт байгуулсан юм.

2003 онд ХИС-гийн салбар ажиллаж байсан Дорнод аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамгийн анхны Нөхөн сэргээх төвийг Дорнод аймгийн Бүсийн оношилгооны төвийг түшиглэн, ХБХЭЭХ-той түншлүүлэн байгуулжээ. Энэхүү загвараар Ховд, Баянхонгор, Баян-Өлгий аймгуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Нөхөн сэргээх төвтэй болсон. (Нөхөн сэргээх төвүүдийн үйл ажиллагааны тухай мэдээллийг “Боловсрол” бүлгээс авна уу).





■ “Өсвөр үеийнхний дуу хоолой-1: Хүүхдийн эрхийн тулгамдсан асуудлууд” судалгаанд оролцсон сурагч сэтгүүлчдэд яриа өгч байна. Улаанбаатар хот, 2017 оны 5 дугаар сар

Дээрх ажлын хүрээнд эцэг эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг мэргэжилтнүүдийг сургах, чадавхжуулах хэрэгцээ үүсэж, ХИС-гаас эцэг эх, багш нарт зориулсан сургалт зохион байгуулан, шаардлагатай ном, гарын авлагыг орчуулан хэвлэж түгээжээ.

ХИС өөрийн хэрэгжүүлж байсан бүх төсөл хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг анхааран тусгаж байсан бөгөөд СӨБ болон бага боловсрол олгоход нэвтрүүлж байсан хувилбарт сургалт, гэр бүлд түшиглэсэн хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 36 ном, 34 тоглоом бүхий сургалтын багц хэрэглэгдэхүүнийг бэлтгэсэн юм.

2015 онд “Бүх хүүхдийн эрхийн төлөө” НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээсэн монгол хүүхдийн илтгэлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд анх удаа оролцож, өөрийн үзэл бодлыг илэрхийлсэн нь том дэвшил байлаа.

2017 онд нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд “Өсвөр үеийнхний дуу хоолой-1: Хүүхдийн эрхийн тулгамдсан асуудлууд” судалгаанд оролцож, эрхийнхээ нөхцөл байдалд үнэлгээ хийж шийдвэр гаргагчдад илгээсэн юм.





*“Сургууль намайг бусад хүүхэдтэй адил хүлээн авсанд би эхлээд баярласан. Тэргэнцэртэйгээ сургууль руу орох гарах амаргүй байдаг. Өглөө унд уухаас жаахан зовно, учир нь сургуульд намайг бие засуулах хүн байхгүй шүү дээ. Би тэргэнцэр дээрээ ангийн хамгийн хойно суудаг. Миний сурлагыг багш нар шударгаар дүгнэдэггүй, миний ойлгоогүй зүйлийг тайлбарлаж өгдөггүй. Би өрөвдүүлэх бус бусад хүүхэдтэй адил суралцахыг, үнэлүүлэхийг, бас оролцохыг хүсэж байна”.*

*12 настай А охины ярианаас  
НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээх  
Хүүхдийн илтгэл - Монгол Улс, 2015*



Хүүхдийн эрхийн зөрчилтэй асуудлыг цаашид нарийвчлан судлан, 2018 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд “Өсвөр үеийнхний дуу хоолой-2: Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” судалгаанд оролцож, шударга ёс, авлигын байдалд үнэлгээ хийсэн.

ХИС 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх НҮБ-ын тусгай төлөөлөгчийн асуулгад Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг илтгэсэн билээ.

ХИС-гийн санаачилга, оролцоотойгоор 2019 оны 5-р сарын 14-нд БСШУС-ын сайд А/292 тушаал гаргаж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам”-ыг баталсан нь Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн эрхийг хангасан нэгэн дэвшил боллоо.





*“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах төсөл” дээр мэргэжлийн хүн авах зарын дагуу шалгалт өгч тэнцээд 2002 оны 3-р сард төслийн ажилтнаар орох үед ХИС-гийн Монгол дахь хөтөлбөрийн захирлаар Канадын иргэн Марк Лапорт ажиллаж байв. Энэ эрхэм Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үндэстний цөөнхийн хүүхдийн боловсролд их санаа тавьдаг, тэдний төлөө ихийг хийсэн, алсын хараатай хүн байсан.*

*Энэ хүн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийг дэмжих ажлыг өөрөө санаачлан эхлүүлсэн ба Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоог бодлогоор дэмжиж, ажлын байраар хангаж, гүйцэтгэх захирлын цалин болон байрны түрээсийг хүртэл санхүүжүүлдэг байсан. Түүнчлэн М.Лапорт захирал мэргэжлийн зөвлөх авч ажиллуулан, Европын Холбооны ТАСИС хөтөлбөрт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны чадавхыг бэхжүүлэх нь” гэсэн төсөл бичсэн юм. Тэр төсөл нь батлагдсанаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо (ХБХЭЭХ)-г үүсгэн байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үндэсний хэмжээнд хийгдсэн үйл ажиллагаануудын эхлэлийг тавьсан юм.*

*18 сарын хугацаатай энэ төслийн хүрээнд ХБХЭЭХ-ны чадавх бэхжиж, хөдөө орон нутагт салбаруудаа амжилттай байгуулсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Нөхөн сэргээх төвийн загварыг гаргаж, 4 аймагт байгуулсан. Тэрхүү загвараар Нөхөн сэргээх төв орон нутгийн эмнэлгийг түшиглэн, үйл ажиллагаа явуулах ба түүнд эцэг эхчүүд голлох үүрэгтэй оролцоно. Нөхөн сэргээх төвийн 1 өрөөг ХИС-гаас тоноглоод, орон нутаг нь байр болон эмч, сувилагчаар хангаж, ХБХЭЭХ-ны салбарыг үнэгүй байрлуулдаг байсан. Нөхөн сэргээх төвүүдийн дэргэд эцэг эхийн холбоо үйл ажиллагаа явуулах нь Монголын нөхцөлд тун тохирсон загвар байсан. Одоо ч тэдгээр Нөхөн сэргээх төвүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Зарим нь улам өргөжиж, тухайлбал Баянхонгор аймгийн салбар ХИС болон орон нутгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр өөрийн тусдаа байртай болсон. Хожим 2008 онд Марк Лапорт захирлыг Монголд ирэхэд бид ХБХЭЭХ дээрээ аваачиж, санаачилсан ажлынх нь үр дүнг харуулахад маш их баярлаж, сэтгэл нь их хөдөлж билээ.*

2000 оны эхээр Монголын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, тэднийг хөгжүүлэх мэдлэг, мэдээлэл байгаагүй. Тиймээс төслөөс маш их сургалт хийдэг, эцэг эхчүүд, багш нарт зориулсан ном, гарын авлагыг орчуулан тараадаг байлаа.

Энэ төсөл амжилттай хэрэгжсэний бас нэг үндэс бол салбарынхаа яамтай маш нягт уялдаатай ажиллаж, БСШУЯ дээр Тэгш хамруулах боловсролын нэгжийг байгуулсан явдал юм. Тухайн үед БСШУЯ-нд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлыг харууцаж байсан мэргэжилтэн Ж.Мягмар Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хамгаалал дээр хийсэн эрхзүйн өөрчлөлтөд их үүрэг гүйцэтгэсэн гэж боддог.

Тэгш хамруулах боловсролын нэгжээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор цэцэрлэг, сургуулийн үнэлгээний журмын шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулсан. Жишээлбэл цэцэрлэг, сургуулийн жилийн ажлыг дүгнэх журамд нь хамран сургах тойргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс хэд нь хамрагдсан гэдэг үзүүлэлтийг нэг шалгуур болгож өгсөн. Ингэснээр цэцэрлэг, сургууль тодорхой хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулах ёстойг бодлогоор тусгаж оруулсан. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үндэстний цөөнх хүүхдийн хувьсах зардлыг энгийн хүүхдээс илүү байхаар санал оруулсан боловч хэрэгжилтийн явцад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо болон санхүүжилтээс шалтгаалан хүндрэл гарсан юм.

Өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах эцэг эх, сургууль, цэцэрлэгийн хандлага өөрчлөгдсөн.

Миний хувьд ХИС-д ажиллах хугацаандаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, сургуулийн өмнөх болон бага боловсролын чиглэлээр боловсролын салбарт томоохон брэнд ажлуудыг хамт олныхоо дэмжлэг тусалцаатайгаар амжилттай эхлүүлсэн гэж боддог юм.

2006- 2009 онд Европын Холбоо болон Их Британийн Хүүхдийг Ивээх Сангийн 1,3 сая еврогийн санхүүжилттэй “Сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах нь” гэсэн 12 дэд төсөлтэй багц төслийг удирдаж ажиллан, төр болон төрийн бус байгууллагуудтай хамтран цаг хугацаанд нь амжилттай хэрэгжүүлсэн. Энэ үндэсний төслийн хүрээнд сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах чиглэлээр олон талт үйл ажиллагаа явуулсны нэг нь зорилтот 3 аймаг, 2 дүүрэг тус бүрд 75 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг барьж ашиглалтад оруулсан. Тухайн үед төсөл батлагдаж, хэрэгжүүлж эхлэхэд барилгын материалын үнэ өссөн тул цэцэрлэгийн барилгын санхүүжилт хүрэлцэхгүй байсан тэр үед БСШУЯ болон орон нутгийн засаг захиргаатай хамтран ажилласны ачаар улсаас 350,0 сая төгрөг, орон нутгаас 110,0 сая төгрөгийн дэмжлэг авч, 5 цэцэрлэгийн барилгаа гүйцээж билээ.

2009 онд Их Британийн ХИС-гийн Монгол дахь хөтөлбөр хаагдах үед дээрх төсөл дуусаж, удалгүй би БСШУЯ-ны хэрэгжүүлж байсан АХБ-ны 10 сая ам долларын санхүүжилттэй “Боловсролын салбарын шинэчлэл” төсөлд хяналт үнэлгээний мэргэжилтэн болон дэд захирлаар ажиллаж байгаад ХИС-гийн захирлын урилгаар 2012 оны 6-р сарын 1-нээс ХИС-даа буцаж ирсэн.

Энэ үед Боловсролын хөтөлбөрийн менежерээр ажиллахын сацуу Дэлхийн Банкны 2,5 сая ам долларын санхүүжилттэй “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийг удирдан, менежерээр ажилласан.

Эргээд харахад ХИС-гийн Монгол дахь хөтөлбөрийн түүхэнд үлдсэн хамгийн том хоёр төслийг амжилттай хэрэгжүүлсэндээ маш их бахархаж явдаг. Энэ бол ХИС-гийн маань цомхон атлаа чадварлаг хамт олон, түншлэгч байгууллагууд, хамтрагчдын маань хамтын амжилт юм.

ХИС-гийн Боловсролын Хөтөлбөрийн мэргэжилтнээр (2002-2009 онуудад) болон менежерээр (2012-2018 онуудад) ажиллаж байсан Ц.Гэрэлтуяагийн дурсамжаас



### 3. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

**25 дэвшил: №6**

**Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдалд хүүхдүүд, иргэний нийгмийн байгууллагууд хөндлөнгөөс хяналт, үнэлгээ хийдэг боллоо.**

#### **2004 ОН: НҮБ-ЫН ХЭК-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН I ТАЙЛАН**

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаар НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд тайлан илтгэл бичих ХИС-гийн санаачилгыг Монгол Улсын Засгийн газар дэмжин, 2004 онд анхдугаар тайлангаа бичсэн юм.

ХИС-гийн Хүүхдийн эрхийн хяналт, үнэлгээний гол зорилго бол НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод дурдсан хүүхдийн эрхийн талаар Засгийн газар болон бусад голлох тоглогчдын авсан амлалт, хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд хариуцлага тооцох явдлыг сайжруулахад оршино.

ХИС НҮБ-ын Хүүхдийн Эрхийн конвенцын хэрэгжилтийн тайлан бичихийг санаачилсны хувьд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн хороонд Монголын иргэний нийгмийн байгууллагуудаас илгээсэн 3 удаагийн илтгэл, хүүхдүүдийн 2 удаагийн бие даасан илтгэлийг 2004- 2006, 2007-2009, 2014-2016 онуудад тус тус бэлтгэхэд нь хүүхдүүдэд болон хүүхдийн эрхийн төлөөх ТББ-уудад аргазүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

■ Засаглал дахь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хүүхдүүд хорооны удирдлагууд, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж байгаа нь. Нийслэлийн төр захиргааны Хангарьд ордон, Улаанбаатар хот, 2013 он





## **2006 ОН: НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХОРООНД ИЛГЭЭСЭН МОНГОЛЫН ТББ-УУДЫН “ХӨНДЛӨНГИЙН ТАЙЛАН”-1**

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн талаар Засгийн газрын тайланд иргэний нийгмийн байгууллагууд, хүүхдүүд “Хөндлөнгийн илтгэл” бичдэг.

Иргэний нийгмийн байгууллагууд Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаар “Хөндлөнгийн тайлан” бичсэнээрээ Засгийн газрын тайланд нэмэлт мэдээлэл өгөхөөс гадна бие даасан, хараат бус байр сууринаас үзэл бодлоо илэрхийлдэг. Тиймээс ХИС хөндлөнгийн тайланд хүүхдүүд, иргэний нийгмийн үзэл бодлыг тусгах явдлыг нэн чухалчилж, НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаанд оролцох ТББ-ууд, түүний дотор хүүхдийн бүлгүүдийн ажлыг дэмжсээр ирсэн билээ.

2005-2006 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээх Монгол Улсын ТББ-уудын анхны “Хөндлөнгийн тайлан”-г ХИС удирдаж ажилласан юм. Уг тайланд үндэстний цөөнх хүүхдийн боловсролын асуудлыг хөндөж, хос хэлний боловсролыг дэмжих санал дэвшүүлсэн юм. Энэ нь Монгол Улсад шинэлэг зүйл байлаа.

## **2009 ОН: НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХОРООНД ИЛГЭЭСЭН МОНГОЛЫН ТББ-УУДЫН “ХӨНДЛӨНГИЙН ТАЙЛАН”-2**

2007-2009 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн хороонд Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн 2 дахь нэмэлт тайланг бичихдээ, Монгол Улсын ТББ-ууд болон ХИС-гийн зүгээс Монгол Улсад нэн шаардлагатай байгаа хүүхэд хамгааллын тулгамдсан асуудал, хүүхэд хамгааллын үйлчилгээ, тогтолцооны талаар хөндсөн билээ.



■ ТББ болон хүүхдүүдийн төлөөлөл Монгол Улс дах Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын талаарх хөндлөнгийн илтгэлийг НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд танилцуулж буй байдал. Женев хот, 2009 оны 10 дугаар сар

Тайлангийн гол дүгнэлтэд Монгол Улсад хүүхэд хамгаалах үндэсний тогтолцоо хэрэгтэй ба хүүхэд хамгааллын талаар төрөөс явуулах бодлогыг тодорхойлж, хууль эрхзүйн орчныг сайжруулах шаардлагатайг дурдсан байдаг. Мөн хүүхэд хамгааллын талаар төрийн болон орон нутгийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох, хүүхдийн эрхийн зөрчлөөс сэргийлэх шаардлагатай арга хэрэгслийг бий болгох, эрх нь зөрчигдсөн, хаягдсан хүүхдүүдэд үзүүлэх нөхөн сэргээх үйлчилгээг бий болгох, хүүхдийн эрхийн хамгааллын салбарт ажиллах боловсон хүчнийг бэлтгэх зайлшгүй шаардлага тулгараад байгааг дурдсан юм.

## **2009 ОН: НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХОРООНД ИЛГЭЭСЭН МОНГОЛ ХҮҮХДИЙН I ИЛТГЭЛ**

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдэн орсноос хойш анх удаа 2008-2009 онд Австралийн Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Монголын хүүхдүүд бие даан хөндлөнгийн тайлан бичиж, НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээсэн юм. Энэхүү тайлан нь засаглал дахь хүүхдийн оролцооны томоохон амжилт байсан бөгөөд хүүхдүүд Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдалд үнэлгээ хийх бүрэн чадвартайгаа харуулсан тод жишээ болсон юм.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд илгээсэн энэхүү тайланг бэлтгэхийн тулд 12-17 насны 27 хүүхэд өөрсдөө удирдан судалгаа хийж, нийгмийн гарал, оршин суугаа газраараа ялгаатай 8-18 насны 180 хүүхдээс судалгаа авч, тоо баримт цуглуулжээ. Хөндлөнгийн илтгэлдээ тэд янз бүрийн салбар дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлыг үнэлсэн төдийгүй төрийн зүгээс нэн тэргүүнд анхаарч ажиллах шаардлагатай гол асуудлуудыг тодорхойлсон.

2009 онд Тайландын Бангкок хотод болсон Хүүхэд хамгааллын Азийн форумаас Монголын хүүхдүүдийн бичсэн хөндлөнгийн тайланг Азийн бусад орнуудын хувьд загвар болохуйц амжилттай ажил болсныг хүлээн зөвшөөрсөн юм.



■ Хөндлөнгийн илтгэл бичсэн хүүхдүүдийн багийн ахлагч Б. Цоггэрэл НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооны уулзалтад оролцож буй нь, Женев хот, 2009 он

## **2014 - 2016 ОН: НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН V ТАЙЛАН ИЛТГЭЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН СҮЛЖЭЭНЭЭС ИЛГЭЭСЭН НЭМЭЛТ ИЛТГЭЛ**

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн 5 дахь удаагийн тайлангаа 2015 оны 4-р сард Хүүхдийн Эрхийн Хороонд илгээсэн билээ.

Хүүхдийн эрхийн конвенцод заасны дагуу Монгол Улсад хүүхдийн эрх байдал ямар байгаа талаар хөндлөнгөөс тайлагнах нэмэлт илтгэлийг Японы ХИС удирдан чиглүүлж, “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын санхүүжүүлснээр хүүхдийн асуудлаар ажилладаг үндэсний 54 ТББ-ын төлөөлөл болох “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвсэл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Хүүхдийн оролцооны байгууллагуудын сүлжээ, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах сүлжээ, ЭКПАТ Монгол гэсэн 5 сүлжээ хамтран бичсэн юм.

Үндэсний ТББ-уудын сүлжээд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн 3, 4-р тайланг хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд “хангалтгүй” гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог цогцоор бүрдүүлэх асуудал тулгамдсан хэвээр байгааг” цохон дурдсан байна.



“...Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог цогцоор бүрдүүлэх асуудал тулгамдсан хэвээр байна. Бүх түвшинд хийсэн ярилцлага, хэлэлцүүлгийн үеэр хүүхдийн амьдралд байнга тулгамдаж ил болон нууц хэлбэрээр амь бөхтэй оршиж буй ялгаварлал, үл хайхрал, хүчирхийлэл, түүний дотор гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөөр байгаа нь Засгийн газраас нэн яаралтай арга хэмжээ авч, хүүхэд хамгааллын тогтолцоог бий болгож, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэн ажиллахыг шаардаж байна...”

*НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаар Монгол Улсын V тайлан илтгэлтэй холбогдуулан төрийн бус байгууллагын сүлжээнээс илгээсэн нэмэлт илтгэл, Монгол Улс, 2015 он*

■ НҮБ-ын Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар тайлан илтгэлтэй холбогдуулан төрийн бус байгууллагуудын сүлжээдээс НҮБ-ын хүүхдийн эрхийн хороонд илгээх илтгэл, 2015 он



■ НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенцын хэрэгжилтийн талаар Монгол Улсын тавдугаар тайлан илтгэлтэй холбогдуулан хүүхдүүд болон төрийн бус байгууллагын сүлжээдээс НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээх илтгэлүүдийг танилцуулах уулзалт. Улаанбаатар хот, 2015 он

## 2015 ОН: “БҮХ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТӨЛӨӨ” НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХОРООНД ИЛГЭЭСЭН МОНГОЛ ХҮҮХДИЙН II ИЛТГЭЛ

ХИС-гийн “Хүүхдийн эрх засаглал” хөтөлбөрийн аргазүй, санхүүгийн дэмжлэгээр 2015 онд монгол хүүхдүүд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд хоёр дахь илтгэлээ явуулав. Илтгэлийг бичихэд 11- 18 насны 108 хүүхэд оролцож, боловсрол, соёл, чөлөөт цаг, эрүүл мэнд, нийгмийн халамж, гэр бүлийн орчин, асран хамгаалал, иргэний эрх, эрх чөлөө, хүүхдийн хөдөлмөр зэрэг асуудлын хүрээнд хэлэлцүүлэг хийж, гарц шийдлийг ярилцан боловсруулсан байна.

Илтгэлийг бэлтгэх явцад Улаанбаатар, Эрдэнэт хот, Ховд, Дорнод, Өвөрхангай, Дундговь, Баян-Өлгий, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн 3285 хүүхдээс асуумж судалгаа авч, гэр бүл, дотуур байр, асрамж халамжийн төв, эмнэлэг, сүм хийд, сургуулийн орчинд хүүхдийн эрх хэрхэн хангагдаж байгааг тодруулсан юм.

Хүүхдийн эрхийн илтгэл, судалгаанд хот суурин, хөдөө орон нутгийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, сүм хийдэд шавилан суугаа хүүхдүүд, хүнд өвчтэй удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдүүд, сургууль завсардсан хүүхдүүд, ял эдэлж байгаа хүүхдүүд гээд хүүхдүүдийг өргөн хүрээтэй оролцуулсан нь Монголд шинэлэг, дэвшилттэй зүйл болсон билээ.

Хөндлөнгийн тайлан бичсэн хүүхдүүд болон ТББ-ын сүлжээдийн төлөөлөл ХИС, Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын дэмжлэгээр 2016 оны 10-р сард Швейцар улсын Женев хотноо НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд тус тайланг амжилттай хэлэлцүүлээ.



*“Сургууль дээр хүүхэд хүүхдээ дээрэлхдэг, бас сурах бичиг хүрэлцэхгүйгээс даалгавраа хийхгүй ирээд, дээр нь ар гэрийн асуудлаас цэвэрлэгээний мөнгө хураалгаж чадахгүй үед багшид загнуулахаас маш их айдаг. Ном хүрэлцэхгүйгээс болоод би нэг удаа тооны хичээлийн даалгавраа хийгээгүй юм. Тэр ном манай ангид наймхан ширхэг байдаг. Гэрийн даалгавар хийгээгүйн улмаас багш намайг тооны сонгоноос гаргана гэсэн. Энэ нь надад маш хүнд туссан, тиймээс багшийгаа харахаар айдас төрдөг. Багшаа хүндлэх өөр хэрэг, айдас бол ондоо шүү дээ. Зарим багшаас их айдаг”.*

14 настай Б хүүгийн ярианаас



*“Би аавыгаа ерөөсөө хараагүй. Ээж маань гадаадад хүнтэй гэрлээд амьдардаг. Би Улаанбаатарт өвөөтэйгөө амьдарч байна. Ээж надад мөнгө, хувцас явуулдаг ч би ээжээсээ хол 6 жил тусдаа амьдарч байгаа болохоор их санадаг”.*

14 настай А хүүгийн ярианаас



*“Хүүхдийн эрхийг Монгол Улсад бодитой хамгаалан хангахын тулд, нийгмийн бүхий л орчинд, эрхзүйн бүх харилцаанд, бизнесийн бүх салбарт хүүхдийн дээд эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явагдаж байхыг НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг мөрдлөг болгон хуульчлахдаа, хууль эрхзүйн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх төсөвтэй нь баталдаг байх шаардлагатай гэж бид үзэж байна.*

*Манай улсад хүн бүр хуулиараа дамжуулан хүүхдийн өмнө ямар үүрэг харцуцлага хүлээдгээ мэдэж, хууль нь хэрэглэгдэж, төр хэрэгжилтэд нь хяналт тавьж чаддаг болчихвол хүүхдийн эрхийг хангаж чадна гэдэгт итгэж байна.”*

*“Бүх хүүхдийн эрхийн төлөө”  
НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээх  
Хүүхдийн илтгэл - Монгол Улс, 2015*





■ “Өсвөр үеийнхний дуу хоолой” бүлгийн гишүүд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээсэн “Бүх Хүүхдийн Эрхийн Төлөө” Хүүхдийн илтгэлийн үр дүн, зөвлөмжийг танилцуулж байна. Улаанбаатар хот, 2015 оны 9 дүгээр сар



■ НҮБ-ын Хүүхдийн Эрхийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар тайлан илтгэлтэй холбогдуулан “НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээсэн Бүх хүүхдийн эрхийн төлөө” Хүүхдийн илтгэл, 2015 он

## 2010, 2017 ОН: НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХОРООНООС МОНГОЛ УЛСАД ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖ

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороо Монгол Улсын Засгийн газрын ХЭК-ийн хэрэгжилтийн тухай гурав, дөрөв ба тавдугаар тайланг хүлээн авч, ТББ-ууд болон хүүхдүүдээс хөндөж тавьсан хүүхэд хамгаалал, хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх, хөгжих, оролцох эрхийг хангах зэрэг хүүхдийн эрхийн асуудлуудыг Монгол Улсын Засгийн газарт хууль эрхзүй, бодлогын түвшинд анхаарч үзэх зөвлөмж, шаардлага ирүүлсэн юм.

НҮБ-ын ХЭХ-ны санал зөвлөмжид ХИС-гаас иргэний нийгмийн байгууллагууд, хүүхдүүдтэй хамтран боловсруулсан зөвлөмжүүд тусаж чадсанд ХИС сэтгэл ханамжтай байна.



“Хөвгүүд, охидын аль аль нь хүйсээр ялгаварлуулж, цаашлаад угсаа гарал, хөгжлийн бэрхшээл, хүүхдийн гэр бүлийн амьдралын түвшин, амьдарч буй газраас хамааран ялгавартай байдал үүсгэж байгаад харамсаж байна. Энэ талаар арга хэмжээ авахыг Гишүүн оронд зөвлөж байна”.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж, 2010 он



“Засаг дарга хүүхдийн төлөөлөлтэй уулзана гээд манай сургуулиас намайг сонгож, би тус үйл ажиллагаанд оролцсон юм. Хүүхдүүдээс тулгамдсан асуудал юу байна гэхээр нь шийдвэрлэх гэж байгаа юм байна гэж бодсон.

Бид золбин нохойноос айгаад сургууль руугаа явахдаа тойруу замаар яваад заримдаа хичээлээсээ хоцордог, бас өвөл айлуудын хөлдүү угаадас дээр халтирч уначих гээд хэцүү байдаг тухайгаа, гэр хороололд маань гэрэлтүүлэг байхгүйгээс их айдаг тухайгаа хэлж байсан.

Түүнээс хойш 2 жил өнгөрсөн. Бидэнтэй ярилцаад юу ч шийдээгүй, томчууд зүгээр л сонсоод өнгөрдөг юм байна лээ.”

12 настай бага сургуулийн сурагч охин О-гийн ярианаас

“Бүх хүүхдийн эрхийн төлөө” НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээх Хүүхдийн илтгэл - Монгол Улс, 2015

■ НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос тавдугаар тайлан илтгэлтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газарт өгсөн дүгнэлт зөвлөмжийг танилцуулах уулзалт. Улаанбаатар хот, 2017 оны 11 дүгээр сарын 20





■ Сургуулийн багш ангийнхаа гурван сурагчийг зодож шийтгэсэн асуудал гарсантай холбогдуулан хүүхдүүд өөрсдийн санаачилгаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсоохыг хүссэн уриалга гаргасан юм. Тэд 600 гаруй хүүхдийн гарын үсэг цуглуулан энэхүү уриалгаа өдөр тутмын сонинд нийтлүүлсэн төдийгүй энэ хэргийн мөрөөр Монголд анх удаа бие даан хэвлэлийн бага хурал зарлан хийсэн юм. Улаанбаатар хот, 2007 оны 11 дүгээр сарын 6

■ 2008 онд, Хүүхдийг Ивээх Сангийн олон нийтэд түшиглэсэн төвүүдээр үйлчлүүлэгч хүүхдүүд болон хүүхдийн оролцооны бусад байгууллагуудын төлөөлөл болсон 27 хүүхэд “Хүүхэд хамгаалал-Өнөөдөр” тайлан бичиж, НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээлээ. Дөрвөн сарын хугацаанд судалгаа хийж, хамтран тайлан бичсэн энэ хүүхдүүд тухайн онд “Хамгаалал” нэртэй хүүхдийн клуб, 2009 онд “Хүүхэд Хүүхдийн Төлөө” ТББ байгуулан хүүхдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулж эхэлжээ.

## 4. ХҮҮХДИЙН ОРОЛЦОО

**25 дэвшил:** №7

**Засаглал дахь хүүхдийн оролцооны загварыг бий болгох санаачилгыг эхлүүлэв.**

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод Хүүхдийн оролцоог “Хүүхдийн суурь эрх” гэж заасан байдаг. Харин хүүхдүүд өөрсдийн эрхийн талаар ойлголт мэдлэгтэй байх нь тэдний утга төгөлдөр оролцооны амин чухал хэсэг юм. Тиймээс ХИС хүүхдийн эрх, Хүүхдийн эрхийн тухай конвенц, үүрэг хүлээгчид гэж хэн болох, ямар үүрэг хариуцлагатай байдаг талаар хүүхдүүдийн мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч ажилладаг.

ХИС-гийн “Хүүхдийн эрхийн засаглал” хөтөлбөр НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 12-р зүйлд тусгасан “Хүүхэд өөртэй нь холбогдолтой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, идэвхтэй оролцох эрхтэй бөгөөд оролцогч улсууд хүүхдийн үзэл бодолд зохих ач холбогдол өгнө” гэсэн заалтыг амьдралд хэрэгжүүлэх талаар идэвхийлэн ажиллаж байна.

Засаглал дахь хүүхдийн оролцооны загварыг бий болгохын тулд ХИС хүүхдийн эрхийн хяналт үнэлгээ, улс орон нутгийн төсөв, орон нутгийн засаглал, бодлого боловсруулах түвшин, хүүхдийн эрхийн боловсрол дахь хүүхдийн оролцооны төслүүдийг хэрэгжүүлсэн.

Түүнчлэн 2013 онд Удирдлагын Академитай хамтран “Засаглал дахь хүүхдийн утга төгөлдөр оролцоо” сургалтын модуль, гарын авлагыг боловсруулсан нь хүүхэдтэй ажилладаг төрийн албан хаагчдад зориулан явуулдаг Удирдлагын Академийн давтан сургалтын хөтөлбөрт багтсан юм.



■ “Өсвөр үеийнхний дуу хоолой I” судалгааг судалгаанд оролцсон хүүхдүүд өөрсдөө Нийслэлийн хүүхдийн төлөө зөвлөлийн хоёрдугаар хуралдаанаар танилцууллаа. Судалгааны дүнд үндэслэн хүүхэд бүрийн дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилгоор Нийслэл, дүүргийн түвшинд “Хүүхдээ сонсох өдөр”-ийг бий болгох тухай тогтоолыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд батлав. Улаанбаатар хот, 2017 он

■ “Хамгаалал” клубийн гишүүн хүүхдүүд “Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох олон улсын өдөр”-ийг гурав дахь жилдээ тэмдэглэж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулав. Улаанбаатар хот, 2009 он

Хүүхдүүдийг насанд хүрэгчидтэй эрх тэгш үзэж, тэдний чадварыг хүлээн зөвшөөрөн, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийг үнэлэхэд оролцуулж, шаардлагатай тохиолдолд чиглүүлэг хийх шинэ практикийг ХИС Монгол Улсад нэвтрүүлсэн билээ.

Хүүхдэд ээлтэй засаглалыг бий болгоход хүүхдийн оролцоо зайлшгүй чухал болохыг нотолсон ХИС-гийн төслүүдийг танилцуулбал:

### **2008 ОН: “ХАМГААЛАЛ” ХҮҮХДИЙН КЛУБ**

2008 оны 6-9 дүгээр сард НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээх хүүхдийн хөндлөнгийн тайланг бичсэн 30 хүүхэд нэгдэж, мөн оныхоо 10-р сард Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтэд хяналт тавих, илтгэлийнхээ мөрөөр ажиллах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн дуу хоолойг хүргэж, хүүхэд хамгааллын нөхцөлийг сайжруулах зорилготой “Хамгаалал” клубийг байгуулжээ.

Клубийн ахлагч Б.Цоггэрэл Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаар хөндлөнгийн илтгэл бичсэн хүүхдүүдийг төлөөлж, 2009 оны 10-р сард НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны хуралд оролцсон юм.

### **2008 ОН: ХҮҮХДҮҮД - ХҮҮХДИЙН ЭРХИЙН СУРГАГЧ БАГШ**

Хүүхдүүд нэг нэгэнтэйгээ ярилцаж, хүүхдийн эрхийн тухай тайлбарлах нь үр дүнтэй гэж үздэг тул ХИС үе тэнгийнхний сургалтыг дэмждэг. Тиймээс





■ “Хүүхэд Хүүхдийн Төлөө” ТББ-ын жилийн тайлангийн уулзалт, Улаанбаатар хот, 2010 он

2008 онд Улаанбаатар хотод олон улсын болон үндэсний зөвлөх багш нарын сургалтыг зохион байгуулж, хүүхдүүдэд хүүхдийн эрхийн талаарх сургалтын техник, заах аргыг эзэмшүүлсэн юм. Нийт 100 гаруй хүүхэд “Үе тэнгийн сургагч багш”-аар бэлтгэгдэж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, хүүхдийн эрхийн талаар насанд хүрэгчид болон хүүхдүүдэд хичээл заах мэдлэг, ур чадвартай болсон. Үе тэнгийн сургагч багшаар бэлтгэгдсэн хүүхдүүд 2009-2010 онд өөрсдийн гэсэн хүүхдэд ээлтэй, хялбар, сонирхолтой аргагүйг боловсруулж, сургалт явуулсан билээ.

Тухайлбал, хүүхдүүдийн амьдралаас сэдэвлэсэн жүжигчилсэн тоглолтоор дамжуулан Улаанбаатар хот, Дорнод аймгийн 16 сургуулийн 240 хүүхдэд хүүхдийн эрхийн талаар сургалт явуулжээ. Үе тэнгийн гурван багш хүүхдийн оролцооны “Залуу аврагч” бүлгийг байгуулж, сургуулийн нийгмийн ажилтны туслалцаатайгаар гамшиг, онцгой байдлын үед хүүхдүүд юу хийх ёстой талаар 200 хүүхдэд сургалт явуулсан байна.

Үе тэнгийн 30 багш 4 бүлгээр ажиллаж дунд сургуулиуд, хүүхдийн халамжийн төвүүдээр сургалт явуулж, 2000 гаруй хүүхэд, 60 гаруй эцэг эхэд хүчирхийлэл, дарамтаас ангид амьдрах хүүхдийн эрхийн талаар танилцуулсан. Хүүхдүүд цахим хуудас ажиллуулж, сонин гаргаж, өөрсдийн дуу хоолойг олон нийтэд хүргэсэн.

## **2008 ОН: ХҮҮХЭД ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ**

ХИС-гийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан “Хамгаалал” хүүхдийн клубийн гишүүдээс 18 насанд хүрсэн хүүхдүүд эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж, “Хүүхэд хүүхдийн төлөө” хэмээх хүүхдийн эрхийн төлөөх ТББ-ыг санаачлан байгуулж, дүү нартаа туслан, “Хамгаалал” хүүхдийн клубийг дэргэдээ ажиллуулах болсон юм.

Эдгээр байгууллага нь хүүхдийн эрхийг тууштай хамгаалагчид болсон ба тэднийг үйл ажиллагаагаа эхлэхэд, чадавхжихад, санал санаачилгаа хэрэгжүүлж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад нь ХИС дэмжлэг үзүүлж ирснээрээ бахархдаг юм.

“Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ 2010 оны 6-р сарын 1-нд Монгол Улсын Ерөнхийлөгчтэй уулзаж, Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоо нэн шаардлагатай байгааг биечлэн сонордуулсан юм. Үүний зэрэгцээ хүүхдүүд гол яамдын сайд, төрийн нарийн бичгийн дарга нарт хүүхдийн эрхийг хамгаалах хууль, бодлогыг амьдралд хэрэгжүүлэх шаардлагыг албан захидлаар хүргүүлж, 500 гаруй хүүхэд УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүдэд ил захидал илгээсэн юм. “Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ-ын хэд хэдэн санаачилгыг Ерөнхийлөгчийн Тамгын Газар дэмжин ажилласан билээ.

2010 оны 6-р сарын 23-нд “Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ ба “Хүүхэд хамгаалал” клубийн төлөөлөл ХЗДХЯ-ны Гэр бүлийн тухай хуулийн төслийн ажлын хэсэгтэй уулзаж, гэр бүлийн орчинд хүүхдийг зодож шийтгэхийг хориглох тал дээр өөрсдийн санал, зөвлөмжийг танилцуулав. Түүнчлэн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2009- 2014 оны дунд хугацааны стратегид хүүхдүүд санал зөвлөмжийг тусгуулсан.

“Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран ХИС-гийн дэмжлэгтэйгээр “Хүүхдийн эрхийн зөрчлийг хаана, хэнд, хэрхэн хандах вэ?” хэмээх товхимлыг боловсруулж, 3000 хувиар хэвлэн, хамгаалал шаардлагатай байгаа хүүхдүүдэд хүргүүлсэн.

Хүүхдийг хүчирхийлэл, дарамтаас хамгаалах тухай “Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ-ын гишүүн хүүхдүүдээс гаргасан зөвлөмжүүд нь 2010 онд Гэр бүлийн тухай хуулийн төсөлд болон Хүүхдийн төлөө үндэсний Зөвлөлийн 2009-2014 оны Хүүхэд хамгааллын дунд хугацааны стратегид туссан юм.

Хүүхдийн эрхийн төлөөх Монголын хүүхэд, залуусын идэвх зүтгэлийг үнэлж, 2010 онд Сан-Марино -Александр Бодини сангаас “Хүүхдийн шагнал”-ыг Монголын “Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ-д 20,000 ам.долларын тэтгэлгийн хамт олгосон билээ.

■ “Хүүхэд Хүүхдийн Төлөө” ТББ-ийн гишүүд “Хүүхдийн оролцоо – Бидний ертөнц” үзэсгэлэн яармагийн үеэр, 2009 он





## 2013 ОНООС ХОЙШ: “ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ (YOUNG VOICES)” ХҮҮХДИЙН ЭРХИЙН БҮЛЭГ

ХИС-гийн Монгол дахь хөтөлбөрийн дэргэд “Өсвөр үеийнхний дуу хоолой” гэдэг хүүхдийн эрхийн бүлэг 2013 оноос хойш ажиллаж байна.

“Өсвөр үеийн дуу хоолой” бүлэг нь 2013 онд “Сайн засаглалд хүүхдийн оролцоо амин чухал” төсөл, 2014 онд “Хүүхдийн төлөөх төсөв” төсөлд оролцож, 2015 онд “Бүх хүүхдийн эрхийн төлөө” илтгэлийг боловсруулан НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээж 2016 оны 10-р сард Швейцар улсын Женев хотноо илтгэлээ амжилттай хэлэлцүүлсэн билээ.

Тус бүлэг нь 2017-2018 онд “Өсвөр үеийнхний дуу хоолой- 1,2” төслийг амжилттай хэрэгжүүлж 2019 онд Хүний Эрхийн хамгаалагчдын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч Мишель Форсттой уулзалт хийж, Монгол Улсын Хүний эрхийн хамгаалагч хүүхдийн нөхцөл байдлыг илтгэсний дээр мөн онд “Хүний эрхийг хамгаалагч хүүхдүүдийн Дэлхийн чуулган”-д төлөөллөө оролцуулсан юм.

2019 оны 11-р сард Засгийн газрын тэргүүнүүдийн уулзалтаар НҮБ-ын ХЭХ, ХЭК-ийн нэмэлт 3-р протоколыг соёрхон батлахад соёрхон батлахын ач холбогдол, баталсны дараа юу хийх талаар саналаа видео мессеж хэлбэрээр илгээсэн нь Монгол Улсын төдийгүй, дэлхийн хүүхдүүдийн төлөөлөл болон танилцуулагдсан байна.

■ “Өсвөр үеийн дуу хоолой” бүлгийн гишүүд Хүүхэд залуучуудын нэгдсэн чуулган дээр үйл ажиллагаагаа сурталчилж байна. “Найрамдал” олон улсын хүүхдийн зуслан, 2018 он





## 5. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗАСАГЛАЛ

### 2012 ОНООС ХОЙШ: “ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗАСАГЛАЛ” ХӨТӨЛБӨР

2012 оноос хэрэгжиж эхэлсэн “Хүүхдийн эрхийн засаглал” хөтөлбөр нь Хүүхдийн эрхийн тухай конвенц, хүүхдэд хамаатай бусад олон улсын гэрээний хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газар хэрхэн ханган ажиллаж байгаад хүүхэд, иргэний нийгмийн байгууллага, эцэг эх, бусад холбогдох байгууллагатай хамтран үнэлгээ хийдэг.

#### 2013 ОНООС ХОЙШ “ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗАСАГЛАЛ” ХӨТӨЛБӨР НЬ:



1 Хүүхдийн эрхийн хяналт, үнэлгээ



2 Хүүхдэд ээлтэй сайн засаглалыг бэхжүүлэх



3 Хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэсэн гурван үндсэн чиглэлээр ажиллаж байна.



### Хүүхдийн эрхийн хяналт, үнэлгээний хүрээнд хийсэн ажлууд

#### 2008 ОН: “ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУУРЬ СУДАЛГАА”

ХИС-гаас Японы Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр 2008 онд явуулсан “Хүүхэд хамгааллын нөхцөл байдлын суурь судалгаа”-нд хамрагдсан хүүхдийн 61% нь “хүчирхийлэл, дарамтад өртдөг” гэж хариулсан байна. Ялангуяа “асрамж, халамжийн байгууллагуудын болон эцэг эхийн хайр халамжаас гадуур гудамжинд амьдарч буй хүүхдүүд, тэр дундаа охид хүчирхийлэл, дарамтад илүү ихээр өртөж байна” гэсэн дүгнэлтийг тус судалгаа гаргажээ.

Эцэг эх, асран хамгаалагчид, насанд хүрэгчдийн архидалт, хүүхдэд тавих асрамж халамж дутмаг байдал нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн гол шалтгаан болдог ба тэдгээр эцэг эх, асран хамгаалагчдын гуравны нэг нь



■ Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөлийн сайд асан эрхэмсэг ноён Уильям Хэйг Улаанбаатар хотноо Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцлаа. Чингэлтэй дүүргийн 15-р хорооны 13 хүүхэд түүнийг төсөл хөтөлбөр хэрэгжиж буй орон нутагт хүлээн авч уулзав. Улаанбаатар хот, 2013 он

хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар огт мэддэггүй, хүүхдийн эрхийн талаар дийлэнх нь анхны ойлголттой боловч шийтгэлийг хүмүүжлийн гол арга болгон хэрэглэдэг байна. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын санхүүжилтээр ХИС-гаас хийсэн өөр нэгэн судалгаагаар<sup>1</sup> сургуулийн 4-11 дүгээр ангийн хүүхдийн 63% нь “бие махбод, сэтгэл санааны шийтгэлд ямар нэгэн байдлаар өртдөг ба анги ахих тутам энэ шийтгэл нэмэгддэг” гэсэн бол багш нарын 93% нь “бие махбод, сэтгэл санааны шийтгэлийн аль алиныг хэрэглэдэг, хэрэглэх тохиолдол байсан” гэж хариулсан байдаг.

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийлэл, дарамтын хүрээ өргөн, тохиолдол буураагүй атал хүүхэд хамгааллын үйлчилгээ орхигдсон, энэхүү үйлчилгээг дийлэнхдээ олон улсын болон зарим төрийн бус байгууллагууд хүргэдэг. Мэргэшсэн нийгмийн ажилтнууд, мөн голдуу эдгээр байгууллагад ажилладаг.<sup>2</sup> Гэр оронгүй хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдтэй тулж ажилладаг төрийн үйлчилгээний гол байгууллага нь цагдаагийн байгууллага байсан бөгөөд асуудлыг гол төлөв эрхзүйн талаас нь шийдвэрлэдэг байв. Мөн хүүхэд хамгааллын ойлголт дутмагаас болж учир шалтгааныг авч үзэхээс илүүтэй үр дагавартай нь ажилладаг арга барил зонхилж байжээ.

Төрийн бусад байгууллагын хувьд ч байдал адил ба тухайн байгууллагын бүтэц, зарим нэгэн удирдлагын буруу ойлголтын улмаас нийгмийн ажилтнуудад үндсэн ажлаас нь өөр ажил үүрэг оногдуулах, нийт хүн амд хамаатай асуудал хариуцуулах эсвэл захиргааны ажил хийлгэх зэргээр хүүхэд хамгааллын асуудлыг ор тас орхидог<sup>3</sup> дүн энэхүү судалгаанаас гарчээ.



## 2015 ОН: ХҮҮХДИЙН ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

2013-2015 онд ХИС хүүхдэд нөлөөлөх бүхий л асуудлаар гэр бүл, сургууль, байгууллага болон олон нийтийн түвшинд, мөн хууль эрхзүй, захиргааны үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог хөхиүлэн дэмжих зорилгоор Монгол Улс дахь ИБУИНВУ-ын ЭСЯ-ны дэмжлэгээр Хараат бус Судалгааны Хүрээлэнтэй хамтран хүүхдийн эрхийн засаглалын өнөөгийн байдлын талаарх судалгааг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод<sup>4</sup> хийсэн.

Уг судалгаанд хамрагдсан таван хүүхэд тутмын хоёр нь тэдэнд нөлөөлж буй асуудалд оролцох эрхийн талаар зохих ойлголтгүй, таван хүүхэд тутмын зөвхөн ганц нь “гэр бүлийн түвшинд шийдвэр гаргахад зохих ёсоор оролцдог” гэжээ. Сургуулийн түвшний шийдвэр гаргалтад судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 13% нь “зохих ёсоор оролцдог” гэж дүгнэсэн бол үлдсэн хувь нь

1 “Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын бие махбодод халдах, хуульд заагаагүй төлбөр хураамж авах, ялгаварлан гадуурхалтын байдал” Суурь судалгааны тайлан, Хүүхдийг Ивээх Сан, 2009 он, Улаанбаатар хот

2 Монгол дахь Хүүхэд хамгааллын тогтолцоо. Үнэлгээний тайлан, Хүүхдийг Ивээх Сан, 2006 он (2008 онд дахин хэвлэсэн)

3 Монгол дахь Хүүхэд хамгааллын тогтолцоо. Үнэлгээний тайлан, ХИС, 2006 он (2008 онд дахин хэвлэсэн)

4 “Засаглал дахь хүүхдийн оролцооны өнөөгийн байдал- нийслэлийн түвшинд”, Хараат бус судалгааны хүрээлэн, Хүүхдийг Ивээх Сан, 2013 он, УБ хот

“дунд зэрэг”, эсвэл “огт оролцдоггүй” гэж хариулсан байна. Харин хорооны түвшинд судалгаанд хамрагдсан 4 хүүхэд тутмын 3 нь “огт оролцдоггүй” гэж хариулжээ. Энэхүү судалгааны нэг чухал үр дүн бол хүүхдүүд өөрсдийнх нь амьдралд нөлөө үзүүлэх асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх хүсэл эрмэлзэлтэй байгаа нь харагдсан явдал юм.

Өмнөх жилүүдэд олсон амжилт хийгээд улс төрийн хүсэл зориг зэргээс харахад “Хүүхдийн эрхийн засаглал” хөтөлбөрөөр дамжуулан хүүхдийн эрхийг хүүхдийн оролцоотойгоор хамгаалах, хөхиүлэн дэмжихийн тулд өнөөгийн тогтолцоо, механизмыг бодитойгоор өөрчлөх боломж байна гэж ХИС үзжээ.



## **2018 ОН: ХҮҮХДИЙН ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

ХИС 2019- 2021 оны стратеги төлөвлөгөөгөө үр дүнтэй боловсруулах зорилгоор Монгол Улс дахь хүүхдийн эрхийн хэрэгжилтийн ерөнхий дүр зургийг тодорхойлох Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээг 2018 оны 1-6 дугаар сард хийж гүйцэтгэжээ. Үнэлгээг хийхдээ 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, хүүхдийн эрхийн засаглал, хүүхэд хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, хүүхдийн ядууралд өртөж буй нөхцөл байдал гэсэн таван сэдвийн хүрээнд бүлгээр ажиллаж, нарийвчилсан дүн шинжилгээг гүйцэтгэсэн.

Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, ОУВС-гийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах болсноор хүүхдэд чиглэсэн аливаа шаардлагатай хөрөнгө оруулалтыг бүрдүүлэхэд бэрхшээл, эрсдэл учруулж байна.

Түүнчлэн, тэнцвэртэй бүсчилсэн хөгжлийг хангаж чадахгүй байгаагаас хот суурин газар хэт төвлөрөл бий болж, харин бусад аймаг, сумын хөгжил зогсонги байдалд орж, улмаар хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурах, хамгаалагдах эрхийг хангахад томоохон сорилт тулгарч байна.

Монгол Улсын хүүхдийн 28,9% нь ядуу өрхөд амьдарч байгаа бөгөөд эдгээр хүүхэд нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа хүмүүсийн 45%-ийг бүрдүүлж байна.<sup>1</sup> Ядуу өрхийн 12- 17 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин 67% буюу маш бага байгаа юм. Гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн орчинд хүүхдийн эрхийг хангах нь тулгамдсан асуудал болжээ. Хүүхдийн эсрэг болон хүүхэд үйлдсэн гэмт хэргийн тоо ихсэж, ялангуяа цахим орчинд хүүхдийг дарамтлах, хуурах, шоглох асуудал нэлээд гарах болсон байна. Гэтэл хүүхдийн эрх зөрчигдвөл хүүхдүүдийн 81,4% нь хаана, хэнд хандахаа мэдэхгүй байгаа юм.

<sup>1</sup> Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, 2017.





## Хүүхдэд ээлтэй сайн засаглалыг бэхжүүлэх хүрээнд хийсэн ажлууд

### 2012 - 2013 ОН: “САЙН ЗАСАГЛАЛД ХҮҮХДИЙН ОРОЛЦОО АМИН ЧУХАЛ” ТӨСӨЛ

ХИС хүүхдийн оролцооны чиглэлээр явуулсан ажлын туршлага, олсон амжилтдаа үндэслэн үндэсний, нийслэл/аймгийн, дүүрэг/сумын, хороо/багийн түвшний засаглалд хүүхдийн системтэй оролцоог хангах тогтолцоо бий болгохыг эрмэлзэж байна.

ИБУИНВУ-ын ЭСЯ-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн энэхүү төслийн эхний шатанд яамд, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар болон хоёр хорооны дунд, дээд шатны нийт 63 албан тушаалтан засаглал дахь хүүхдийн утга төгөлдөр оролцооны талаар ойлголт, мэдлэгтэй болсон.



■ 2012 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны байранд Их Британийн Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр “Сайн засаглалд хүүхдийн оролцоо амин чухал” төслийг хэрэгжүүлэх Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.





2013 оны 3-р сарын 4-нд голлох яам, агентлаг болон төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн салбар дундын ажлын хэсэг “Орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоог хангах” тухай журмын төслийг боловсруулж, Улаанбаатар хотын ИТХ-д өргөн барив.

Шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах туршилтын төслийг нийслэлийн Чингэлтэй дүүргийн хоёр хороон дээр хэрэгжүүлсэн юм. Эдгээр төсөл хорооны түвшинд хүүхдийн оролцоог хангах бүтцийг бий болгохыг зорьсон. Төслийг хэрэгжүүлэгч хороодод 15-20 гишүүнтэй хүүхдийн оролцооны бүлгүүд байгуулсан. ХИС-гийн зүгээс төслийн турш эдгээр бүлгийн хорооны шийдвэр гаргалтад оролцох оролцоог дэмжиж ажилласан ба хорооны ажилтнууд хүүхдийн оролцоонд нээлттэй хандаж, тэднийг мэдээллээр ханган, хорооны түвшний шийдвэр гаргагч нарт санал бодлоо хүргэх боломж бололцоог олгож байлаа.

2013 онд хүүхдүүд Чингэлтэй дүүргийн удирдлагатай уулзаж өөрсдөд нь тулгарч буй асуудлаа танилцуулахад ЧД-ийн ЗДТГ, ИТХ, дүүргийн эрүүл мэнд, боловсролын газрууд, цагдаагийн болон нийгмийн халамжийн хэлтсүүдийн 40 мэргэжилтэн шийдвэр гаргах түвшин дэх хүүхдийн оролцооны ач холбогдлыг таньж мэдсэн.



“Бидний болгоомжтой хандах ёстой нэг зүйл бол “оролцоо” гэсэн нэрээр хүүхдийн эрхийг зөрчих буюу хүүхдүүдийг буруугаар ашиглах явдал юм. Хүүхдүүд эвдрээгүй байдаг учраас тэдний оролцоо нь авлигыг бууруулахад тустай. Тиймээс ч ХИС хүүхдийн оролцоог бүх талаар дэмждэгийг ойлгож байна. Чин үнэнийг хэлэхэд насанд хүрэгчид бид хүүхдийн оролцоонд ор нэр төдий ханддаг. Хорооны хүүхдийн бүлгүүд төсөв гаргаж сурсан гэдгийг бид сонссон. Тиймээс би хүүхдийн оролцоог жинхэнэ утгаар хэрэгжүүлэхийн тулд бүх хороо хүүхдүүдэд шинээр барих хүүхдийн тоглоомын талбайн төсвийг гаргах боломж олгохыг санал болгож байна.”

Чингэлтэй дүүргийн ИТХ-ын төлөөлөгч  
Ч. Дэчингалсан



“Дэлгүүрүүд хүүхдэд архи, тамхи зардаг нь бидний сэтгэлийг зовоодог. Энэ нь хууль зөрчиж байгаа хэрэг хэдий ч ийм зүйл гарсаар л байна. Бид дэлгүүрийн гаднах талбайг цэвэрлээд, хариуд нь хүүхдүүдэд архи, тамхи битгий зараач гэж дэлгүүрийн эзнээс гуйж болох юм. Бас гудамжинд фосфортой, гэрэлтдэг хогийн сав тавих юм бол хүмүүс хогийн савыг шөнө олж харж чаддаг болно...”

...Компьютерын тоглоомд донтсон хөвгүүдэд туслахын тулд интернэт кафенуудад хөндлөнгийн хяналт хийх хэрэгтэй. Бид тэр хүүхдүүдэд компьютерын тоглоомд донтохын хор уршгийг танцуулж, тэднийг өөрсдийн бүлэгт элсүүлж найз нөхөд болцгоож болно...”

Хүүхдүүдийн саналаас

## 2013 - 2014 ОН: “ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ТӨСӨВ”

Аливаа улсын төсөв төлөвлөх, батлах, зарцуулах, тайлагнах тогтолцоо нь тухайн орон засаглалын хувьд хэр нээлттэй, ардчилсан, оролцоотой байгааг илтгэдэг. Төсвийн үйл явцад иргэд оролцсоноор төрийн үйлчилгээ улам боловсронгуй болно гэж үздэг.

Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх үүргийг төр хүлээдэг. Хүүхдийн эрхийг цогцоор нь хэрэгжүүлэх, сайн сайхан ирээдүйд чиглэсэн үйл ажиллагаанд төрөөс төсөв мөнгө төлөвлөж зарцуулдаг билээ. Харин тэрхүү хөрөнгө мөнгийг хэрхэн бүрдүүлж, зарцуулж, тайлагнадаг талаар өсвөр үеийнхэнд ойлгуулж, мэдүүлэх ёстой. Ингэснээр хүүхдүүд Монгол Улс төсвийн мөнгөнөөсөө хэдийг нь өөрсдөд нь зориулж, хэрхэн зарцуулж байгааг үнэлэн, улмаар төсөв хэлэлцэх, зарцуулахад санал бодлоо хэлж, оролцдог болно. Хүүхдүүд улс, орон нутгийн төсвийн тухай мэдлэг, оролцоотой болох нь эрхээ эдэлж, нийгмийн идэвхтэй иргэн болж төлөвших эхлэл юм.

Хүүхдийн эрхийг хангах, хөгжлийн ашиг сонирхлыг дэмжих хөтөлбөрт төсвөөс хангалттай мөнгө хуваарилсан ч хүссэн үр дүндээ хүрэхгүй тохиолдол олон байдаг. Тиймээс хүүхдүүд болон хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн, төрийн бус байгууллагууд хүүхэдтэй холбоотой төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтын талаар мэдлэг, мэдээлэлтэй байж, төсөвт дүн шинжилгээ хийх чадвартай байх нь нэн чухал юм.

Дээрх зорилтод хүрэхийн тулд ХИС 2013 онд ИБУИНВУ-ын ЭСЯ-ны санхүүгийн дэмжлэгээр улсын төсөв, Засгийн газрын төсөвт хэрхэн дүн шинжилгээ хийх тухай тайлбарласан “Хүүхдийн төлөөх төсөв” зурагт номыг бүтээсэн. Уг гарын авлагыг хүүхдүүд болон иргэний нийгмийн байгууллагуудад зориулан боловсруулсан бөгөөд зорилтот бүлгүүдэд уг номын агуулга, нэр томъёог илүү ойлгомжтой байлгах үүднээс номыг бүтээх үйл явцад Улаанбаатар хот, Архангай, Дорнод, Өвөрхангай аймгийн нийт 247 сурагчийг татан оролцуулсан юм.



*“Би төсвийн талаар сургуулийн хөтөлбөрт байдаггүй чухал мэдлэг олж авсан. Төсөв гаргаж сурах нь насан туршдаа ашиглаж болох чухал чадвар юм. Тиймээс ХИС бидэнд ашигтай мэдлэг олгож, санхүүгийн шийдвэр гаргахад хэрэгтэй ур чадварыг зааж байгаа нь үнэхээр чухал. Хамгийн гол нь хүүхдэд зориулж Засгийн газраас хуваарилдаг төсвийн талаар ойлголттой болж, төсвийн шинжилгээ хийж чаддаг болсон нь бид өөрсдийнхөө эрхийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавихад хамгаас чухал юм.”*

*Г.Баянбат, 17 настай*



*“Энэ сургалтаас өмнө төсөв гэдэг маш уйтгартай сэдэв шиг надад санагддаг байлаа. Гэвч ХИС миний бодлыг өөрчилсөн. Төсөл эхлэхээс авхуулаад гарын авлагын агуулга, зураг чимэглэлийн талаар бидний саналыг сонсож байсан, үнэхээр гайхалтай төсөл гэдгийг юуны түрүүнд хэлэхийг хүсэж байна. Бид янз бүрийн түвшинд төсвийн шинжилгээ хийж чадна гэдэгт эхэндээ би итгэлгүй байсан. Гэвч бидэнд гарын авлага, Excel программ, Засгийн газрын цахим хуудсууд болон холбогдох бусад эх сурвалжийг ашиглан дүн шинжилгээ хэрхэн хийхийг маш тодорхой, хялбар байдлаар ойлгуулсан.”*

*Э.Цацрал, 16 настай*





■ Архангай аймгийн сурагчид орон нутгийн төсөвт дүн шинжилгээ хийх сургалтад хамрагдаж буй нь, 2014 он



■ “Хүүхдийн төлөөх төсөв” гарын авлага, 2014

## 2014 - 2015 ОН: “ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЭЭРЭГ ХӨГЖИЛ ОРОЛЦОО”

Орон нутгийн засаглал дахь хүүхдийн оролцоог дэмжих талаар хуримтлуулсан туршлагадаа суурилан ХИС 2015 онд хүүхдийн оролцооны хяналт, үнэлгээг хөгжүүлэх зорилготой “Өсвөр үеийнхний эерэг хөгжил оролцоо” төслийг Хөвсгөл аймаг, Налайх дүүрэгт хэрэгжүүлэв.

Хөвсгөл аймгийн 23 сумын Хүүхдийн зөвлөлийн 96 сурагч, 50 багш, Налайх хотын 50 сурагч, 25 багшид НҮБ-ын Хүүхдийн Сангийн “Хүүхдэд ээлтэй сургууль” хөтөлбөртэй хамтран “Хүүхдийн оролцоо гэж юу вэ?”, “Орон нутгийн засаглал дахь хүүхдийн оролцоо” сэдвээр орон нутагт хүүхдэд ээлтэй засаглалыг бэхжүүлэх чиглэлээр арга зүйн дэмжлэг үзүүлж, цуврал сургалтыг зохион байгуулсан юм.

Уг төслийн зорилго нь эрх эдлэгч өсвөр үеийнхний нийгмийн амьдрал дахь оролцоог нэмэгдүүлж, хандлага, чадвар, мэдлэгийг дээшлүүлснээр ирээдүйн идэвхтэй иргэнийг бэлтгэхэд хувь нэмэр оруулах явдал юм. Хүүхдийн утга учиртай оролцоог дэмжих зорилгоор “Хүүхэд Хөгжлийн Төв”-үүдийн үйл ажиллагааг тэлж, чиглүүлэгч багш нар болон нийгмийн ажилтнуудад хүүхэд-төвтэй оролцооны аргазүйг танилцуулж, хүүхдийн оролцооны стандартуудад суурилсан цуврал сургалтыг зохион байгууллаа.

■ Улсын болон орон нутгийн төсвийг ойлгож, дүн шинжилгээ хийх аргачлал бүхий өсвөр насныханд зориулсан гарын авлагыг танилцуулах арга хэмжээг Монгол Улсын Засгийн газар, УИХ, Их Британийн Элчин сайдын яам болон уг гарын авлагыг бүтээсэн хүүхдүүдийн хамтаар 2014 оны 3 дугаар сарын 14-нд Төрийн ордонд зохион байгуулав.



## 2017 ОН: “ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ - 1”

Шведийн ХИС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Өсвөр үеийнхний дуу хоолой - 1” төслөөр нийслэлийн түвшинд өсвөр насны хүүхдүүдэд өдөр тутам тулгарч байгаа хүүхдийн эрхийн зөрчлийг ХИС-гийн олон улсын эвслийн асуумжаар тодруулж судалсан юм.

Судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн ЕБС-ийн 6, 8, 10-р ангид сурдаг 11-16 настай 1236 хүүхэд оролцжээ. Хүүхдүүдийн 90,8% нь хүүхдийн эрхийн талаар сонссон боловч 87,4% нь шийдвэр гаргагчдад үзэл бодол, саналаа сонгох хомс гэж үзсэн байна.

Хүүхдүүдийн 81,2% “өнгөрсөн 2016 онд ямар нэг зүйлд зориулан сургуульдаа мөнгө хураалгасан”, 55% “тохижилт, цэвэрлэгээнд мөнгө хураалгасан” гэсэн нь “Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон норматив зардлаар санхүүжүүлнэ” гэсэн 2006 онд Боловсролын тухай хуулийн 40.1 дэх заалт амьдралд хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Хүүхдүүдийн 18,9% нь төлбөрөөс болж сургуулийн ямар нэг үйл ажиллагаанд оролцож чадаагүй, 20,9% нь төлбөр хувцас, хэрэгслээс болж чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцож чадаагүй гэж хариулсан нь орлого багатай өрхийн хүүхдүүд сургуулийн зарим үйл ажиллагаанд хамрагдах боломжгүйг илтгэж байгаа бөгөөд энэ хэрээр тэдний хөгжил,



*“Яг үнэндээ томчууд хүүхдийн үзэл бодол зөв байж болно гэдэгт итгэдэггүй. Ядаж бидний асуудлыг бидэнтэй ярилцаж, саналыг минь сонсохгүйгээр өөрийнхөө хүүхэд байсан цаг үеийнхээр шийдэх гээд байдаг. Бид хичээлээс гадуур мэдээлэл авч, амьдралын өөр өөр зүйлийг ч гэсэн ойлгож мэдрээд л явж байгаа. Үнэлэх, дүгнэх, өөртөө хэрэгтэйгээ авах, авахгүй талаар томчуудтай зөвлөх хэрэгцээ байдаг ч тэд үл ойшоодог.*

*Б, 15 настай, эрэгтэй*

■ 2019 оны 5 дугаар сарын 1-нд Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн НҮБ-ын тусгай илтгэгч Мишель Форст “Өсвөр үеийнхний дуу хоолой” бүлгийн гишүүдтэй уулзаж ярилцлаа.







■ *Өсвөр үеийн дуу хоолой бүлгийн гишүүд “Өсвөр үеийнхний дуу хоолой - 1” судалгааны үр дүн, гарсан санал зөвлөмжүүдийг Нийслэлийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хурал дээр танилцуулж байна. Улаанбаатар хот, 2017 он*

оролцоо хязгаарлагдаж байна гэсэн үг юм. Хүүхдүүдийн 86% нь шийдвэр гаргагчид хүүхдийн санал бодлыг сонсох нь чухал гэж үзжээ.

“Өсвөр үеийнхний дуу хоолой - 1” судалгаа нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц амьдралд хэрхэн хэрэгжиж байгааг хүүхдүүд үнэлж чадна гэдгийг баталсан бөгөөд Нийслэлийн ЗДТГ, Нийслэлийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хурал дээр судалгааны үр дүн, гарсан санал зөвлөмжүүдийг танилцуулсан. Түүний дараа Нийслэлийн ЗДТГ-аас “Хүүхдээ сонсох өдөр”-тэй болохоор шийдвэрлэсэн билээ.



*“Үе тэнгийнхний хүчирхийлэл охид, хөвгүүдэд ялгаатай тусдаг. Хөвгүүдийн эсрэг үе тэнгийнхний хүчирхийлэл илт дээрэлхэж зодох, үгэндээ оруулах ч юм уу байдаг бол, охид илүү хорон байдаг. Жишээлбэл, тэр хүүхдийн нэр хүндийг унагаах, сургууль дээр эсрэг фракц үүсгэх, цахим орчинд өөр хүүхдээр дамжуулан доромжлох гэх мэт, байх суух газаргүй болтол “хүчирхийлдэг”, илүү аймаар байдаг. Би тэгээд л өмнөх сургуулиасаа шилжсэн.*

*Ц, 15 настай, эмэгтэй*

*“Өсвөр үеийнхний дуу хоолой-1” судалгаанаас*

## **2018 ОН: “ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ - 2”**

“Өсвөр үеийнхний дуу хоолой-1” төслийг хэрэгжүүлэх үед хүүхдүүдээс гарсан хүүхдийн эрхийн зөрчлийн олон тохиолдлын учир шалтгааныг нягтлах зорилгоор 2018 онд “Өсвөр үеийнхний дуу хоолой - 2” судалгааг “Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” сэдвээр явуулсан билээ.



■ *“Өсвөр үеийнхний дуу хоолой-2: Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” судалгааны үр дүнг танилцууллаа. Улаанбаатар хот, 2018 он*



Судалгааны асуумжийг боловсруулахдаа “Транспаренси интернэшнл” олон улсын байгууллагатай хамтран боловсролын орчин дахь шударга байдал, авлига, ашиг сонирхлын асуудлаар хүүхдийн үзэл бодлыг мэдэх зорилго тавьсан юм. “Өсвөр үеийнхний дуу хоолой-2: Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” судалгаанд нийслэл Улаанбаатар хот болон Архангай, Өвөрхангай, Дорнод, Сэлэнгэ, Төв, Говьсүмбэр аймгийн ЕБС-ийн 6, 8, 10-р ангийн 2,191 сурагч хамрагдсан. Хүүхдүүдийн хувьд шударга байдал гэж худал хэлдэггүй, хууль дүрэм мөрддөг, авлига авч өгөхгүй байхыг ойлгодог бол авлигыг сургууль, цэцэрлэгт орох, сурлагын дүнгээ зохиомлоор өсгөх, анги дэвших, сургууль төгсөхөд боловсролын байгууллага, түүний ажилтан удирдлагад мөнгө өгөх явдал гэж ойлгодог ажээ.

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 95,9% нь авлига, ашиг сонирхлын зөрчил нь буруу зүйл гэж үзсэн байна. Шударга байх нь баян байхаас чухал ч гэсэн үргэлж шударга байх боломжгүй байна гэж хүүхдүүдийн 72,1% үзэж байна. Хэн нэгэн ажил, сургуульд ороход нь шалгалтгүйгээр оруулах болбол хүүхдүүдийн 50,2% нь зөвшөөрнө гэжээ.

Тусгай сургалт тэтгэлэгт хамрагдахын тулд мөнгө, бэлэг өгдөг явдал 5 хүүхэд тутмын 1 (18.3%-д тохиолдож байжээ. Тусгай сургалт, тэтгэлэг гэдгийг судалгаанд оролцогчид тэмцээн уралдаан гэдэг утгаар ойлгосон байж болох бөгөөд ЕБС-д зохион байгуулагдаж байгаа тэмцээн, уралдааны шинж чанартай үйл ажиллагаануудын шударга байдалд хяналт тавих тогтолцоо хэрэгтэй гэдгийг харуулж байгаа юм. Хүүхдүүдийн 44,7% нь анги дэвшиж байгаадаа талархал илэрхийлж, багш, сургалтын менежерт бэлэг эсвэл мөнгө өгч байсан байна.

Авлигыг мэдээлж, авлигатай тэмцэх хүсэл зориг нь мэдээлэгчийг хамгаалдаггүй тул мэдээлснээр өөрт нь ирэх дарамтаас шалтгаалж хэрхэн мэдээлэхээ мэдэхгүй байгаагаа хүүхдүүд илтгэсэн юм.



*“Шударга бай гэж биднээс шаардаж байгаа насанд хүрэгчид өөрсдөө хэрхэн шударга бус байхыг үг болон үйлдлээрээ харуулаад байхаар бид тэгээд шударга байхыг хэнээс сурах вэ?”*

*А, 15 настай, эмэгтэй*





■ Хүүхдийг Ивээх Сан, “Өсвөр үеийнхний дуу хоолой” бүлгийн хүүхэд, залуус болон “Транспаренси Интернэйшнл” байгууллагатай хамтран “Өсвөр үеийнхний дуу хоолой-2: Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” судалгааны үр дүнг танилцууллаа. Улаанбаатар хот, 2018 он



Зарим багш нар хүүхдүүдээс өөрт хэрэгтэй хичээлийн материалыг шаардаж авчруулаад 10 оноо өгнө гэдэг. Нэгдүгээрт, энэ нь мөнгөн бус хахууль, хоёрдугаарт ийм байдлаар дүн нэмэх байсан юм бол хичээж хөдөлмөрлөсөн хүүхэд зүгээр суусан хүүхэд хоёрын хооронд ялгаа гарахгүй. Мөн хүүхдүүдэд багаас нь хахууль өгөхийг зааж байна. Зарим эцэг эхчүүд багш нарт нь бэлэг өгөх, тусдаа уулзах замаар хүүхдүүдийнхээ дүнг нэмүүлдэг.

\*\*\*

Хичээлийн цагт заах ёстой хичээлээ цагтаа багтаан чанартай заагаагүй байж, давтлага өгөхөөр болоод хүүхдүүдээс мөнгө шаарддаг.

Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас “Өсвөр үеийнхний дуу хоолой-2: Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” судалгаа



Гэртээ бусдыг муу хэлэх, дорд үзэх байдал хүүхдийнхээ дэргэд гаргахаар хүүхэд бусад хүүхдийг тэгж ялгаварлан гадуурхдаг болдог. Бас багш ялгаварлан гадуурхаж болохгүй гэх мөртөө өөрөө хүүхдүүдэд ялгаатай ханддаг. Хүүхэд багшаас бас ёс зүйгүй байхыг “сурч байна”.

Н, 15 настай, эрэгтэй

ХИС “Өсвөр үеийнхний дуу хоолой-2: Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” судалгааны үр дүнг АТГ, БСШУСЯ, ГБХЗХГ, ИНБ-ууд, хэвлэл мэдээллийнхэнд танилцуулсан. Тэндээс АТГ, БСШУСЯ боловсролын орчин дахь авлигын асуудлаар цаашид хийх арга хэмжээнийхээ чиглэлийг гаргаж ажилласан болно.

## 2018 - 2019 ОН: “НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ

Дэлхийн Банк, Швейцарын Хөгжлийн агентлагийн санхүүжилтээр ХИС нь 2018 оноос “Монгол Улсад Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн 2-р үе шатын хэрэгжилтийг удирдаж ажиллалаа.

Төр нь хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргийг иргэнийхээ өмнө, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн байдаг. Энэ үүргээ биелүүлэхийн тулд төр иргэдээ сонсох, хийсэн ажлаа тайлагнах, мэдээлэх учиртай. Нөгөөтээгүүр иргэд мэдлэгтэй, мэдээлэлтэй байж, төрийн үйлчилгээнд бүтээлчээр оролцож, хяналт тавьж, хариуцлага нэхэх эрхээ эдлэх учиртай.

Эрүүл мэнд, боловсролын салбарын үйлчилгээний чанар, хүртээмж, ажилтнуудын ёс зүй, харилцаа хандлагад өөрчлөлт хийж, иргэдээ сонсдог, тэдэнтэй хамтран ажилладаг жишиг загвар тогтоохыг эрмэлзэж байгаа энэ төсөл Монгол Улсын 10 аймаг, нийслэл хотод амжилттай хэрэгжсэн.

Төслийн 2-р шатанд ТББ-ууд, орон нутгийн захиргааны байгууллагууд хамтран ажиллаж, эрүүл мэнд, боловсролын чиглэлээр 14 дэд төслийг үндэсний болон аймгийн ТББ-ууд хэрэгжүүлээд байна.



### ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

- “Эх, хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээнд-Иргэдийн оролцоог сайжруулах нь” төслийг Хөвсгөл аймагт,
- “Улсын эмнэлэгт худалдан авч буй эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг олон нийтийн оролцоотойгоор сайжруулах нь” төслийг Увс аймагт,
- “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг сайжруулах нь” төслийг Ховд аймагт,
- Өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжсэн “Залуу нас гэрэлт ирээдүй” төслийг Өвөрхангай аймагт,
- “Эрүүл мэндийн даатгалын ашиглалт, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж” төслийг Дорнод аймагт,
- “Өсвөр үеийнхний шүдний өвчлөлийг бууруулахад олон нийтийн оролцоо” төслийг Сүхбаатар аймагт,
- “Эрүүл зүрх, эрүүл хөдөлгөөн, эрүүл ёс зүй” төслийг Говьсүмбэр аймагт,
- “Өрхийн эрүүл мэндийн төвийн 3 талт гэрээлэх ажиллагаанд олон нийтийн оролцоотой хяналтын механизмыг бүрдүүлэх замаар Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх” төслийг Хэнтий аймагт тус тус хэрэгжүүлээд байна.





### ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР:

- “ЕБС-ийн үйл ажиллагаанд эцэг эх, олон нийтийн оролцоог хангах нь” төслийг Сэлэнгэ аймагт,
- “Олон нийтийн оролцоот сургууль” дэд төслийг Говь-Алтай аймагт тус тус хэрэгжүүлжээ.



### “НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛ- 2020” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжих бодлогын хэрэгжилт
- Сургууль, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлогын үнэлгээг хийжээ.



### “НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНД-2020” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

- Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажлын хэрэгжилт;
- Артерийн даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэвшилтэт арга барилд тулгуурлан, иргэд, олон нийт, салбар хоорондын оролцоог ханган хэрэгжүүлснээр эрт илрүүлгийг нэмэгдүүлж, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бодлогын үнэлгээ хийсэн байна.

Төслийн явцад оролцогчид нийгмийн эгэх хариуцлагын үндсэн ойлголт, аргачлалд суралцан, нийгмийн төлөөллүүд сайн дураар нэгдэн, өөрийн орон нутаг дахь эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамгийн тулгамдаж байгаа зүйлийг тодорхойлж, түүнийгээ шийдвэрлэхээр хамтран ажилласан юм.



## Хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн ажлууд

ХИС 2015-2016 онд Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн техникийн ажлын хэсгийг дэмжин ажиллахдаа Монгол Улс дахь олон улсын байгууллагуудын “Хүүхдийн эрхийн төлөө” бүлгийн хамт хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрхзүйн зохицуулалтыг тусгахад анхаарсан юм.

2017 онд хүүхдийн төлөө төсвийг нэмэгдүүлэх саналаа УИХ-д хүргүүлж, нөлөөллийн ажил хийж ажиллалаа.

2018 оны улсын төсвийг батлахад Хүүхэд хамгааллын төсвийг нэмэгдүүлэх шаардлага, үндэслэлийг бэлтгэн УИХ-ын гишүүдэд илгээсэн.

# ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

“Хүүхэд бүр хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах явдлаас хамгаалагдах эрхтэй. Хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, оролцох эрх бүрэн хангагдсан байх ёстой” гэж ХИС үздэг юм. Хүчирхийлэл нь хүүхдэд асар хор хөнөөлтэй ба хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал, суралцах, нийгэмших чадварт сөргөөр нөлөөлж, улмаар зан үйлийн эрсдэлт байдалд хүргэдэг<sup>1</sup>. Эдгээр сөрөг хор нөлөө насанд хүрсэн хойно нь ч үргэлжилж, өөртөө итгэлтэй, амжилттай, аз жаргалтай амьдрахад саад болдог нь тэдэнд үзүүлж буй хүүхэд хамгааллын үйлчилгээ, тогтолцоо зөв, зохистой байж чадаагүйтэй холбоотой. Харин зохих ёсны хамгаалалд өссөн хүүхэд өөрийн үндсэн эрхүүдээ эдлэн, нийгэмдээ хувь нэмэр оруулах чадвартай иргэн болж төлөвшдөг.

Өдгөө олон оронд хүүхдүүд хүчирхийлэл, дарамт, үл хайхрах нөхцөлд амьдарч байна. Гэр бүл, сургууль, олон нийтийн газар, цахим орчин, гамшиг, онцгой байдал гэх мэт янз бүрийн нөхцөлд хүүхдүүд бүрэн хамгаалагдаж чадахгүйгээс хүчирхийлэлд өртөх, сургууль завсардах, орон гэрээсээ дайжих, бие махбод, сэтгэл санаагаар хохирох нь элбэг байна.

2018 оны Үндэсний Статистикийн хороо, НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын Хүн Амын Сангийн нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар 14 хүртэлх насны хүүхдийн 40%-д сэтгэл зүйн шийтгэл, мөн 28%-д бие махбодын шийтгэлийг эцэг эхчүүд хүүхдээ хүмүүжүүлэх үүднээс хэрэглэсэн байна<sup>2</sup>. Мөн уг судалгаагаар хүүхдүүдийн 49% нь эцэг эх, асран хамгаалагчид ямар нэг хүчирхийллийн арга хэрэглэсэн нь тодорсон бөгөөд энэхүү үзүүлэлт сүүлийн 10 жил буурахгүй өндөр хэвээр байсаар байна.

1 Хүүхэд байх үеийн стрессийн үр дагавар: [http://www.cac.gov/ncipc/publications/pdf/Childhood\\_Stress.pdf](http://www.cac.gov/ncipc/publications/pdf/Childhood_Stress.pdf)

2 ҮСХ, НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын Хүн амын сан, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018









■ “Хүмүүжлийн эерэг арга” сургалтын үеэр “Өдөр тутмын хүмүүжлийн эерэг арга” номын зохиогч хатагтай Жоан Е. Дюррант (зургийн голд) МУБИС-ийн багш, оюутнууд болон Хүүхдийг Ивээх Сангийн ажилтнуудын хамт. МУБИС, Улаанбаатар хот, 2009 он

ХИС-гаас 2017 онд “Өсвөр үеийнхний дуу хоолой- 1” судалгаанд оролцсон хүүхдүүдийн 37.9% нь “өнгөрсөн онд ямар нэг байдлаар дээрэлхүүлж доромжлуулсан” гэж, 40.7% “бусад хүүхдийг зодуулж дээрэлхүүлж байхыг харсан” гэж хариулжээ<sup>1</sup>.

Тиймээс ХИС хүүхэд хамгаалал гэсэн ойлголтыг “хүүхдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх цогц арга хэмжээ, бүтэц” гэж тодорхойлдог. Түүнчлэн хүүхэд хамгааллын хүрээнд “хүүхэд бүр өөрийн гэр бүлд, эсвэл гэр бүлтэй дүйцэх орчин, нөхцөлд амьдрах ёстой” гэсэн зарчмыг баримталдаг юм.

Нийгмийн шилжилтийн хямралаас үүдэж, өмнөх тогтолцооны үед байсан хүүхдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээ үндсэндээ үгүй болж, хүүхдийн төлөөх байгууллагууд санхүүгийн болон аргазүйн хямралд ороод байсан үед ХИС Монголд үүдээ нээхдээ хүүхдийн эрхэд суурилсан хандлагыг таниулах, улмаар хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхээс ажлаа эхэлсэн.

ХИС-гийн Монгол дахь салбарын “Хүүхэд хамгаалал” хөтөлбөр нь хүүхэд, ялангуяа эмзэг байдалд байгаа хүүхдүүдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах явдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх үндэсний хэмжээний хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхийг зорьж ажилладаг билээ.

ХИС “Монгол Улс дахь Хүүхэд хамгааллын тогтолцоо” бодлогын үнэлгээг 2006 онд хийж, хүүхдийг бүх төрлийн хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас хамгаалах тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байгааг нотолсон. Энэхүү үнэлгээг УИХ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Нийгмийн бодлогын Байнгын хороо, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам сайшаан хүлээж авснаар Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцооны үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эхлэл болсон.

<sup>1</sup> ХИС, “Өсвөр үеийнхний дуу хоолой судалгаа”, 2017, 9 дэх тал

## ХИС 2009 оноос хойш “Хүүхэд хамгаалал” хөтөлбөрөө дараах зорилтуудад чиглүүлэн ажиллаж байна. Үүнд:



Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;



Хүүхэд хамгааллын тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх замаар зохих халамж, хамгаалал дутагдсан хүүхдүүдэд чиглэсэн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж, үр өгөөжийг нэмэгдүүлэх;



Орон нутгийн түвшинд зохион байгуулалттай хүүхэд хамгаалах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэх;



Хүүхдийн эрхэд суурилсан хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйг дэлгэрүүлэх замаар хүүхэд хамгаалалд оролцож буй бүх шатны төрийн албан хаагчдад зориулсан тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах;



Хүмүүжлийн эерэг арга зүйг түгээн дэлгэрүүлэх замаар хүүхдийн эсрэг бие махбод, сэтгэл санааны шийтгэлийг гэр бүлийн орчинд халахад хувь нэмэр оруулах;



Хүүхдийн байгууллага, мэргэжилтнүүдийн хүүхэд хамгааллын чиглэлээрх чадавхыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх зэрэг болно.



■ 2017 оны 6 дугаар сард “Хүмүүжлийн эерэг арга” сургалтын сургагч багшаар 25 хүнийг бэлтгэлээ. Энэ сургалтыг Канад Улсын Манитоба Их Сургуулийн мастер багш Эшли Стюарт-Туфеску болон Японы Хүүхдийг Ивээх Сангийн мастер багш Икүко Мори нар удирдаж заасан юм.

## **Нийгмийн ажлын үйлчилгээг Монгол Улсад шинэ мэргэжил болгон нэвтрүүлэв.**

### **1994 - 1996 ОН: “ХҮҮХЭД ТӨВТЭЙ ХӨГЖИЛ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Нийгмийн ажлын мэргэжил огт хөгжөөгүй, иргэний нийгмийн байгууллагууд төлөвшөөгүй байсан 1990-ээд оны дундуур Монгол Улсад шилжилтийн үеийн нийгмийн асуудлууд, түүний дотор ядуурал, хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэх хүмүүс нь хүүхдийн ажилтнууд байлаа. Тэдэнд хүүхэдтэй ажиллах шинэ арга барил, ур чадвар ихээхэн дутагдаж байв. Иймээс ХИС-гаас “Хүүхэд төвтэй хөгжил” сургалтын хөтөлбөрийг боловсруулж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг таниулах, орон нутгийн хөгжлийн талаарх оролцооны аргад суурилсан сургалтуудыг орон даяар явуулж эхэлсэн юм. Улмаар хэрэгжүүлсэн төслүүдийнхээ туршлагаар сургалтын хөтөлбөрийг баяжуулж, 1994-1996 онд хүүхдийн болон нийгмийн бодлогын ажилтан, ЕБС-ийн аргазүйч 500 хүнийг сургасан юм.

### **1997 - 2002 ОН: НИЙГМИЙН АЖЛЫН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ АРГАЗҮЙН ТӨВ**

Хүүхдийн өмнө тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх мэргэжлийн хүний нөөцийг системтэй, тогтвортой бэлтгэх нийгмийн эрэлт хэрэгцээг харгалзан ХИС 1996-1997 онд нийгмийн ажлын үйлчилгээний хэрэгцээ, нийгмийн ажилтан бэлтгэх сургалтын хувилбаруудыг судалсан юм. Судалгааны дүнг орон нутгийн болон олон улсын эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүдээр хэлэлцүүлж, Монгол Улсад хөгжүүлэх нийгмийн ажлын чиг хандлагыг тодорхойлохоор 1996-1997 онд ХИС-гаас үндэсний болон олон улсын зөвлөлдөх семинаруудыг зохион байгуулав. Мэргэжилтнүүд хэлэлцээд “Монгол Улсад хөгжүүлэх нийгмийн ажил нь хөгжилд чиглэсэн хандлагатай байх ёстой” гэж дүгнэжээ. Үүний дагуу ХИС-гаас удирдлага, аргазүй, санхүүгийн дэмжлэг үзүүлж, 1997 онд Улсын Багшийн Их Сургууль (өнөөгийн МУБИС) дээр Нийгмийн



■ “Хүүхэд төвтэй хөгжил” орон нутгийн сургалт, Ховд аймаг, 1995 он





■ МУБИС-ийн Нийгмийн Ажлын Тэнхимийн ахлах багш Х.Өлзийтунгалаг (зургийн голд) Хүүхдийг Ивээх Сангаас зохион байгуулсан “Гэр бүлтэй ажиллах онол арга зүй” сургалтын үеэр. 2000 он

ажлын сургалт, судалгааны арга зүйн төвийг байгуулжээ. Хожим тэнхим болж өргөжсөн энэхүү төв Монгол Улсад шинээр бий болсон “нийгмийн ажилтан” хэмээх мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулж, хүний нөөцийг бэлтгэх түшиц газар болсон юм.

Мөн онд ХИС-гаас Монголын Хүүхдийн Эрхийн Төвтэй хамтран хот болон хөдөө орон нутагт сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх зорилготой ЕБС-ийн нийгмийн ажлын туршилтын төслүүдийг Улаанбаатар хот, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв аймагт хэрэгжүүлж эхэллээ.

1998 онд БСШУЯ-нд Сургуулийн нийгмийн ажлын нэгж байгуулагдлаа.

2000 онд БСШУЯ төрийн өмчийн ЕБС-иудад ажиллуулах нийгмийн ажилтны орон тоог батлав.

2001 онд “Нийгмийн ажилтан” мэргэжлийн анхны төгсөлт болж, анхны төгсөгчид ХИС-гийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан УБДС-ийн Дорнод аймаг дахь Багшийн коллеж, МУИС-ийн Ховд аймаг дахь салбарын Нийгмийн ажлын сургалт, судалгааны төвүүдэд уригдан ажиллав.



“ХИС бидний оролцоо, санаачилгыг ямагт дэмжиж, бидний бага багаар олсон амжилтыг хөхиүлэн ажилладаг байсан юм. ХИС-гийн тусламжтайгаар бид олон улсын зөвлөлтэй бүтэн жилийн хугацаанд хамтран ажилласан төдийгүй АНУ, Англи, Орос, Энэтхэг, Япон, Хонконг зэрэг улсуудын нийгмийн ажлын боловсролын хөгжилтэй биечлэн танилцах, суралцах боломжийг ХИС бидэнд олгосон юм.

Нийгмийн ажлыг хөгжүүлсэн гадны туршлагаас ийнхүү суралцсан нь үнэхээр бидний “нүдийг нээж”, нийгмийн ажлыг өөрийн орны онцлогт тохируулан хөгжүүлэх ёстой гэдгийг бүрэн ойлгоход ихээхэн тус болсон юм.

Нийгмийн ажлын сургалт зохион байгуулахын хажуугаар ХИС-гийн олон нийтийн төслүүд дээр ажиллах боломжтой байсан нь бидний хувьд практик туршлага хуримтлуулах чухал ач холбогдолтой байснаас гадна нийгмийн ажлын үйлчилгээний талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд түлхэц болсон нь гарцаагүй.

Монгол Улсад нийгмийн ажлын мэргэжлийг анх үүсгэн, өнөөдрийн түвшинд хүртэл хөгжүүлэхэд ХИС-гийн гүйцэтгэсэн үүргийг үнэлж баршгүй. Хамтын оролцоон дээр тулгуурлан ажилладаг ХИС-гийн арга барилаас суралцаж, сургалт болон нийгмийн үйлчилгээний бүхий л чиглэлийн үйл ажиллагаандаа оролцоог эрхэмлэн ажиллаж чаддаг болсондоо бид баяртай байдаг билээ”.

МУБИС-ийн Нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч  
Т.Цэндсүрэн, ахлах багш Х.Өлзийтунгалаг

Нийгмийн ажилтан хэмээх шинэ мэргэжлийн үүрэг өдгөө Монголд хэдийн танигдаж, боловсрол, хүүхэд хамгаалал, халамж болон нийгмийн үйлчилгээний бусад салбар дахь нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ хуульчлагдан батлагдаад байна.

Хүүхдийн ажилтнуудыг сургах богино хугацааны сургалтаар эхэлсэн ХИС-гийн энэхүү хүчин чармайлт Монгол Улсад нэн хэрэгцээтэй байсан мэргэжлийн нийгмийн ажилтан бэлтгэх дээд боловсролын хөтөлбөр болон өргөжсөн нь үнэхээр бахархалтай үйлс байлаа.

2002 онд хийсэн ХИС-гийн нийгмийн ажлын төслийн бие даасан үнэлгээнд нийгмийн ажлын шинэ мэргэжлийг Монгол Улсад хөгжүүлэх ХИС болон түүний хамтрагч байгууллагуудын хүчин чармайлт онцгой үр дүнтэй болсныг тэмдэглээд бусад улс оронд энэ туршлагыг түгээн дэлгэрүүлэхийг зөвлөмж болгосон байдаг.

2009 оноос ХИС хүүхэд хамгааллын асуудалд чухал үүрэгтэй нийгмийн ажлын үйлчилгээг чанарын өндөр түвшинд гаргахад анхаарал хандуулан, МУБИС-ийн Нийгмийн ажлын тэнхимтэй хамтран Хүүхэд хамгааллын анхан болон гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж БСШУЯ-аар батлуулав.

2010 онд Эрүүл мэндийн яам, АХБ-наас хэрэгжүүлсэн “Улаанбаатарын эмзэг бүлгүүдийн эрүүл мэндийн үйлчилгээг нэмэгдүүлэх нь” төсөлд ХИС нь МУБИС-ийн Нийгмийн ажлын тэнхимтэй хамтран оролцож, хөгжлийн нийгмийн ажилтны үндсэн болон давтан сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Уг хөтөлбөр нь мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхээс гадна орон нутгийн нөхцөл байдлыг үнэлж ажиллах аргазүйг нийгмийн ажилтнуудад хүргэж, байгууллагын болон макро түвшинд нийгмийн бодлогын нөлөөллийн ажил явуулах чадавхыг нэмэгдүүлсэн юм.

2010 онд ХИС хөгжлийн нийгмийн ажилтны ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт, ажлын үнэлгээний шалгуур үзүүлэлт, гарын авлага зэргийг орон нутгийн хэрэгцээ шаардлага, нөхцөлд уялдуулан боловсруулахдаа гэр бүлд тулгардаг асуудлуудыг шийдвэрлэх арга, аргачлалд ихээхэн анхаарсан билээ.

■ *Сургуулийн анхны нийгмийн ажилтнууд (дунд нь ХИС-гийн хөтөлбөрийн ажилтан А.Батхишиг) Улаанбаатар, 1997 он*







■ “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төсөл хэрэгжиж буй Чингэлтэй дүүргийн 9 хорооны хамтарсан багийн гишүүд, 2018 он

**25 дэвшил:** №9

## Хүүхэд хамгаалалд “Хамтарсан баг”- аар ажиллах аргачлалыг нэвтрүүлэв

### 2003 ОНООС ХОЙШ: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ

Хүүхэд бие бялдар, оюун ухааны хөгжил, төлөвшилтийн хувьд насанд хүрэгчдээс ялгаатай тул *“төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж хамгаалал, түүний дотор эрхзүйн зохих хамгаалалт шаардлагатай”* гэж НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод дурджээ. Иймээс хамгаалуулах эрх нь хүүхдийн эрхийн нэгэн онцлог юм.

Хүүхдийн хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэх гол үүргийг хүлээдэг төр нь хүүхэд хамгааллын үндэсний болон олон нийтэд суурилсан тогтолцоо бий болгох, үүндээ цогц зохион байгуулалттай аргачлал хэрэглэх, олон салбар, оролцогч талуудын хувь нэмэр, чармайлтыг нэгтгэн зангидах шаардлагатай юм.

Хүүхэд хамгааллын энэхүү тогтолцоо нь хууль ба мэдлэгийг (хүний эрхийн стандартад нийцсэн) хослуулж, өндөр түвшинд мэргэшсэн хүний нөөц, хүүхдийн оролцоо, хүүхэд хамгааллын мөн чанар болон хүүхэд хамгааллын асуудлаар авах арга хэмжээний мэдээлэл, сурталчилгаанд суурилсан байх учиртай.



Иймээс ХИС 2003 оноос Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв (ХЭҮТ)-тэй хамтран орон нутгийн түвшинд Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх үндсэн салбаруудыг татан оролцуулж, Хамтарсан багаар ажиллах санаачилгыг туршсан юм.

Монгол Улсад суугаа ИБУИНВУ-ын ЭСЯ-наас санхүүжүүлсэн энэхүү төслөөр Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, Дорнод аймгийн Хэрлэн сумын нийт 21 хамтарсан багт кэйс менежмент, хүүхдийн эрхэд суурилсан аргагүйг сайжруулахад мэргэжил, аргагүйн туслалцаа үзүүлж, төслийн үр дүнд 10000 гаруй иргэн, олон нийт хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хамтарсан багийн тухай ойлголттой болсон.

2007 оны 4-р сарын 9-нд Улаанбаатар хотын захирагч захирамж гаргаж, нийслэлийн 9 дүүргийн хороо тус бүрд хүүхэд хамгааллын Хамтарсан баг байгуулагдсан юм. Үүний дараа 16 аймгийн Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр тэдгээр аймгийн сум, баг бүрд Хамтарсан багийг байгуулсан юм. Энэ үед ХИС-гаас Хамтарсан багуудыг чадавхжуулах ном, гарын авлагуудыг боловсруулан гаргасан юм.

ХИС 2010 онд ХЭҮТ-тэй хамтран “Хүүхэд хамгааллын Хамтарсан багийн өнөөгийн байдал”-д судалгаа хийж, Хамтарсан багийн үйлчилгээг хөгжүүлэхдээ дараах 3 чиглэлээр ажиллахаар шийдвэрлэсэн. Үүнд:



### **ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ҮЙЛ**

**АЖИЛЛАГАА:** 2010-2011 онд ХИС нь хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй дарамт, хүчирхийлэл, түүнийг орон нутгийн түвшинд Хамтарсан багаар шийдвэрлэх боломж бололцоог олон нийт, бодлого боловсруулагчдад таниулах, ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор өргөн хүрээний хэвлэл мэдээллийн кампанит аян өрнүүлсэн юм. Мэргэжлийн уран бүтээлчидтэй хамтран шторк, баримтат кино, богино хэмжээний олон ангит кино бүтээж, үндэсний хэмжээнд цацагддаг 10 телевизийн сувгаар олон нийтэд хүргэв. Мөн радио нэвтрүүлгүүд бэлтгэн, асуудал хөндсөн өгүүллүүдийг өдөр тутмын сонинуудад нийтлэв. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Дорнод аймгийн Хэрлэн сумын ЗДТГ-тай хамтран олон нийтийг хамарсан арга хэмжээнүүд зохион байгуулснаас гадна дунд болон дээд шатны төрийн албан хаагчидтай цуврал хэлэлцүүлэг хийж, тэдний дэмжлэг туслалцааг авч чадсан юм.



### **ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГИЙН АРГАЗҮЙГ ХӨГЖҮҮЛЭХ**

**ҮЙЛ АЖИЛЛАГАА:** 2011 онд “Хүүхэд хамгааллын үйлчилгээг Хамтарсан багаар үзүүлэх аргагүй”-г боловсруулан гарын авлага болгон хэвлүүллээ. Ийнхүү боловсруулахдаа ХИС нь олон улсад хүүхэд хамгааллын Хамтарсан багийг дэмжиж ирсэн баялаг туршлагадаа тулгуурласны зэрэгцээ Монгол дахь хүүхэд хамгааллын Хамтарсан багийн гишүүдтэй зөвлөлдөж, хүүхдийн эрхийн мэргэжилтнүүдийн саналыг авч, төрийн албан тушаалтнуудтай хэлэлцсэн билээ. Уг арга зүйг хүүхдийн эрхийн ажилтнууд, мэргэжилтнүүд “Монголын нөхцөлд тохирсон Хамтарсан багийн анхны аргагүй мөн” гэж үнэлсэн юм.

2010-2011 онд энэхүү аргазүйгээр үндэсний 58 сургагч багшийг бэлтгэсэн бөгөөд Улаанбаатар хот, Дорнод аймагт хүүхэд хамгааллын Хамтарсан багийн гишүүд болох цагдаа, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн ажилтан, хороо, багийн ажилтнууд, төрийн бус байгууллагын төлөөлөл болох 700 гаруй мэргэжилтнийг сургалтад хамруулсан.

2010 оноос ХИС ИБУИНВУ-ын ЭСЯ-ны дэмжлэгтэйгээр хүүхэд хамгааллын асуудлыг эрүүл мэндийн салбарт уялдуулах ажлыг эхлүүлж, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдэд зориулсан хичээлийн хөтөлбөр, гарын авлагыг боловсруулсан. *(Дэлгэрэнгүй мэдээллийг “Эрүүл мэнд” бүлгээс үзнэ үү).*

2015 оноос хойш Хамтарсан багийн үйл ажиллагаа хуульчлагдсантай холбогдуулан ХИС нь ХНХЯ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ХЗДХЯ-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ын санхүүгийн дэмжлэгээр “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Хамтарсан багуудыг чадавхжуулах, хамтарсан багийн үйл ажиллагаанд хэрэглэх аргазүй, гарын авлагыг боловсруулан түгээх зэрэг ажлыг хийсэн юм.



**ХАМТАРСАН БАГИЙН МЕХАНИЗМ:** Өнгөрсөн хугацаанд ХИС хүүхэд хамгааллын асуудалд салбар хоорондын уялдаа холбоог хангасан Хамтарсан багийн механизмыг хөгжүүлэх үйл явцыг манлайлж ирлээ. Энэ механизмыг үе шаттай, нухацтай хэлэлцэн бүрдүүлж, Хамтарсан багийн гишүүд, Хүүхдийн төлөө үндэсний газар, 21 аймгийн Хүүхэд хөгжлийн хэлтэс, дүүргийн салбар зөвлөлүүд болон холбогдох газрууд эдгээр хэлэлцүүлэгт оролцсон юм. Хэлэлцүүлгийн үр дүнд орон



■ “Хүүхэд хамгааллын үйлчилгээг Хамтарсан багаар үзүүлэх аргазүй”-г Хүүхдийг Ивээх Сан Монгол Улсад анх боловсруулж, анхны 58 сургагч багшийг бэлтгэжээ. Улаанбаатар хот, 2011 он

нутгийн түвшинд ажиллах Хамтарсан багийн дүрэм, үйл ажиллагааны журмыг стандартчилан боловсруулав. Ингэхдээ Хамтарсан багийн арга зүйг орон нутгийн төрийн үйлчилгээний өнөөгийн бүтцэд тохируулан сайжруулсан юм. Хамтарсан багийн журамд гишүүн бүрийн ажлын байрны тодорхойлолт, хоорондын уялдаа холбоог нарийвчлан тусгаж өгснөөр орон нутгийн түвшинд тохирсон хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн билээ. 2013 онд орон нутгийн түвшинд ажиллах, нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод “Хамтарсан багийн үндсэн гишүүн байх” үүрэг, хариуцлагыг нэмж тусгав.

2016 онд батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай” хуулиар хүүхэд хамгаалалд Хамтарсан багаар ажиллах аргачлал албажиж, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, хохирогчийн гэр бүлийн бусад гишүүдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцооны нэг хэсэг, үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтын хэлбэр болж хуульчлагдав.

Ийнхүү ХИС-гийн санаачилга, хүчин чармайлтаар хүүхэд хамгааллын Хамтарсан багийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх суурь бат тавигдсан билээ.

## **2010 ОН: “ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ**

2010 онд ХИС ба Хүүхдийн Төлөө Үндэсний Газар (ХТҮГ)-аас үйл ажиллагааны хамтарсан төлөвлөгөөний дагуу хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх төрөл бүрийн сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулав. Түүнчлэн, ХТҮГ-ын бүх салбар, хэлтсийн Хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, хүүхдийн эрхэд суурилсан чиг хандлагын сургалтуудыг явуулав.

2010 онд ХТҮГ-ын хүсэлтээр 2010-2015 оны Хүүхэд хамгааллын дунд хугацааны стратегийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн.

2010-2011 онд ХИС, ХТҮГ хамтран бүх аймаг, дүүргийн хэлтсийн дарга нарт хүүхэд хамгаалал, эрхэд суурилсан чиг хандлагын сургалтууд явуулж, Нийслэлийн Хүүхдийн төлөө газартай хамтран Улаанбаатар хотын 8 дүүргийн бүх хорооны 437 төрийн албан хаагч (цагдаа, эмч, нийгмийн ажилтан)-д Хүүхэд хамгааллын үзэл баримтлал, Хамтарсан багийн арга зүйгээр сургалт явуулав.

2011 онд ХИС-гийн санаачилгаар НХХЯ-ны дэргэдэх Хүүхэд хамгаалал, хөгжил төв, Нийслэлийн Цагдаагийн Газрын харьяа Хүүхэд хамгаалал, Хаяг тогтоох төв, Нийслэлийн Хүүхдийн төлөө газар, Нийслэлийн ЗДТГ-ын дэргэдэх Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв зэрэг байгууллагууд хамтарч хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нийтлэг журам боловсруулахаар зөвшилцсөн юм.



2011 онд ХТҮГ анх аймаг, дүүрэг дэх өөрийн бүх хэлтэс, харьяа байгууллагууд болох халамжийн болон хүүхэд хамгааллын төвүүд, хүүхдийн зуслан, Хүүхдийн ордон, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулиудад хэрэгжүүлэх Байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын загвар баримт бичгийг боловсруулж батлав.

ХИС нь эцэг эхийн халамж, хамгаалал дутагдсан хүүхдүүдийн хамгаалалд хууль хэрэгжүүлэгч байгууллагын оролцоог багасгаж, нийгмийн халамжийн үйлчилгээг түлхүү оруулах загварыг дэмжиж ирсэн тул НЦГ-тай хамтарч 2011 онд хэлэлцүүлэг зохион байгуулж, хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдэд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний загварыг танилцуулсан юм. Үүний зэрэгцээ Хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төвийн ажилтнуудад эмзэг бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн хүүхэд хамгааллын үзэл баримтлал, аргагүйг танилцуулсан үйл ажиллагаа зохион байгуулав. Эцэг эхийн халамж, хамгаалал дутагдсан хүүхдүүдтэй ажилладаг төрийн байгууллагууд хамтран Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх нийтлэг журам боловсруулав.



## 2003 - 2015 ОН: УЛААНБААТАР ХОТ ДАХЬ “ХҮҮХЭД ТӨВ”

ХИС-гийн санаачилгаар байгуулагдсан “Хүүхэд төв” нь 2003 оноос 2015 он хүртэл эцэг эхийн халамж, хамгаалал дутагдсан хүүхдүүдэд суурь болон нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж, үйлчлүүлэгч хүүхдүүдийг төрөл бүрийн хөгжлийн үйл ажиллагаанд хамруулан, хүүхдийн эрүүл аюулгүй орчинд өсөж хөгжих эрхийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан.

Энэ төв хүүхдийг гэр бүлдээ эргэн нэгдэхэд нь туслах, эцэг эхийн зан үйл, хандлагад эерэг өөрчлөлт оруулахыг эрмэлздэг. Үүнд эцэг эхэд ганцаарчилсан зөвлөгөө өгөх, дэмжих бүлгийн ажилд татан оролцуулах, хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамруулах, эцэг эх хүүхдүүдийн харилцан ойлголцлыг сайжруулах гэр бүлийн хурал, уулзалтыг зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа багтана.

Мөн “Хүүхэд төв” нь хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн албан хаагчдын (хорооны Засаг дарга, цагдаа, өрхийн эмч, нийгмийн ажилтан) чадавхыг бэхжүүлэх, энэ чиглэлээр ажилладаг үйлчилгээний байгууллагуудын ажилтнуудын сүлжээг байгуулах, хамтарсан багаар кэйс дээр ажиллах мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх олон ажлыг хийдэг.



■ Хүүхэд Төв дээр хүүхдийг хөгжүүлэх олон төрлийн арга хэмжээг зохион байгуулдаг байв. Улаанбаатар хот, 2010 он





■ Хүүхдийг Ивээх Сангийн нийгмийн ажилтан гэр бүлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж буй нь. Хүүхэд төв, Улаанбаатар хот, 2007 он

2003-2015 онд Хүүхэд төвийн суурь үйлчилгээнд давхардсан тоогоор 1,667 хүүхэд хамрагдсанаас 101 хүүхэд гэр бүлдээ эргэн нэгдэж, давхардсан тоогоор 770 хүүхэд албан бус болон мэргэжлийн сургалтад хамрагджээ. Давхардсан тоогоор 465 хүүхэд, 274 эцэг эх ганцаарчилсан зөвлөгөө авч, 49 хүүхдийг халамжийн хувилбарт үйлчилгээнд зуучилж, 138 кэйсийг амжилттай шийдвэрлэж, 120 эцэг эхийг Хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамруулав.

Нийслэлийн 5 дүүргийн 16 хорооны Хамтарсан багт мэргэжил, аргагүйн дэмжлэг үзүүлж ажилласнаар хүүхэд хамгааллын үйлчилгээний үр нөлөөг жилд дунджаар 52,100 хүүхэд шууд бусаар хүртэх боломжтой болов.



Манай гэр бүлээс охин хүү хоёр маань циркийн сургалтад оролцдог. Манай хүү сургууль завсардсан байсан, одоо харин сургуульдаа эргэн суралцаж эхэлсэн. Манай охины хувьд одоогоос 2 жилийн өмнө хүчирхийлэлд өртөж, тэрнээс болж бидэнтэй ярих дургүй болсон байсан. Харин “Хүүхэд” төвөөр үйлчлүүлж, Нийгэмшүүлэх циркийн сургалтад оролцсоноосоо хойш охин маань бидэнтэй дотно харилцаж, өдөр бүр юу хийсэн, юу хийж чадахгүй байгаагаа ярьдаг болсон. Миний охин өнөөдөр ээжээ би ийм тоглоом сурсан гэж нүд дүүрэн инээж хэлдэг болсон болохоор би баяртай байна. Охинд маань тусалсан “Хүүхэд” төвийнхөнд баярлалаа.

Тунгалаг /ээж/



## 2015 ОНООС ХОЙШ: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН АРГАЗҮЙН ТӨВ

ХИС 2015 оноос “Хүүхэд төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, “Хүүхэд хамгааллын аргазүйн төв” болгон өөрчилж, стратеги төлөвлөгөөг нь шинэчилсэн юм. Ингэснээр “Хүүхэд хамгааллын аргазүйн төв” нь судалгаа, сургалт, мэдээлэл, зөвлөгөө, нөлөөлөл гэсэн таван чиглэлээр хүүхдийн эрхэд суурилсан хамгааллын тогтолцоог хөгжүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулах болов.

### ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН АРГА ЗҮЙН ТӨВӨӨС ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАЖ БАЙГАА БҮХ САЛБАРЫН НИЙГМИЙН АЖИЛТНУУД, БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУД, ТББ-ЫН МЭРГЭЖИЛТНУУД БОЛОН ОЮУТНУУДАД САНАЛ БОЛГОЖ БАЙГАА СУРГАЛТ:



Хүүхдийн эрх, хамгааллын талаарх орчин үеийн чиг хандлага



Хүүхдийн оролцоог хэрхэн ханган ажиллах



Хамтарсан багаар ажиллах арга зүй



Кэйс менежментийн үйлчилгээ үзүүлэх аргазүй

### ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГООР:



Стресс менежмент



Харилцааны техник

### ОЛОН НИЙТ, ГЭР БҮЛТЭЙ АЖИЛЛАДАГ АЖИЛТНУУД БОЛОН ГЭР БҮЛҮҮДЭД:



Гэр бүлийн харилцаа



Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын сургалтыг төлбөртэй болон төлбөргүй хэлбэрээр явуулж байна.



“Хүүхэд хамгааллын аргазүйн төв”-өөс салбартаа ажиллаж байгаа ажилтнуудад харилцан туршлагаа хуваалцах, ажлын байран дээрээ өсөж, хөгжих боломж олгож байгаа ажлуудаас дурдвал гадаад, дотоодын тэргүүлэх мэргэжилтнүүдийг урьж, үнэ төлбөргүй нээлттэй семинар зохион байгуулах; ажилтан тус бүрийн ажлын байран дээр тулгамдаад байгаа асуудал дээр ганцаарчилсан зөвлөгөө өгөх... гэх мэт болно. Түүнчлэн фейсбүүк хуудас болон номын сан ажиллуулах замаар мэргэжилтнүүдийн хүүхэд хамгааллын мэдлэгийг байнга дээшлүүлэн ажилладаг. Тус аргазүйн төв жилд дунджаар 15000 орчим хүнд шууд бусаар хүрч үйлчилж байна.

“Хүүхэд хамгааллын аргазүйн төв” НҮБ-ын Хүн Амын Сангийн Залуучуудын төслийн хүрээнд ГБХЗХГ-ын захиалгаар Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудад мэргэжлийн чадавхыг нь дэмжин сайжруулах зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Уг үйлчилгээний хүрээнд Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны явцыг харуулсан “Хөгжлийн хөтөч” гарын авлага боловсруулж, 72 цагийн аргазүйн зөвлөгөөг зайнаас бүлэглэсэн, зайнаас ганцаарчилсан, ажлын байранд гэсэн гурван хэлбэрээр өгөв.



*Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын аргазүйн төв нийгмийн ажилтнуудад зориулсан олон хэлбэрийн үйл ажиллагаа явуулж байгаад таатай байна. Би өнөөдрийн семинарт хамрагдаж, хүүхдийн иргэний эрхийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсандаа баяртай байна. Өмнө нь тэр бүр анзаарч хардаггүй байсан зүйлээ эргэн харж байна. Цаашид танайхаас зохион байгуулсан олон семинарт суух бас хамтрах сонирхолтой байна.*

*Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгийн тэргүүн Б.Мөнхжаргал*



*Өнөөдөр би танайхаас зохион байгуулсан “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэлзүй ба тархины хөгжил” сэдэвт семинарт суулаа. Хүчирхийлэлд өртөж гэмтсэн хүүхдийн тархины хөгжилтэй холбоотой онолын нарийн мэдээллийг авлаа. Тархины хөгжлийг маш сайхан энгийнээр тайлбарлаж ойлгуулсанд баярлалаа. Уг нь миний үндсэн мэргэжил биологийн багш, гэхдээ би хэзээ ч тархины талаар ингэж энгийнээр тайлбарлуулж байгаагүй.*

*“Логарифм” дунд сургуулийн нийгмийн ажилтан Г.Наранцацрал*





■ “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хоёрдугаар шатыг хэрэгжүүлэх санамж бичигт зүүн гар талаас Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн захирал Мицуаки Тоёода, Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газрын дарга О.Алтансүх, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-гийн Монгол дахь Суурин Төлөөлөгч Мицүми Сато нар гарын үсэг зурлаа. 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдөр.

## 2015 - 2018 ОН: “МОНГОЛ УЛСАД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ

“Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийг ЖАЙКА-гийн санхүүжилтээр Монгол Улсын Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хүүхдийн төлөө үндэсний газар, ХИС хамтран хэрэгжүүлсэн билээ.

Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, 0-18 насны хүүхдийн хүчирхийлэл дарамтаас хамгаалуулах эрхийг бүрдүүлэх зорилготой уг төсөлд Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23, 27-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 2, 10-р хороо, Чингэлтэй дүүргийн 9, 10-р хороо, Архангай аймгийн Хайрхан, Батцэнгэл, Эрдэнэбулган сумын 4-р баг хамрагдсан.

Төслийн хүрээнд Улаанбаатар болон Архангай аймгийг хамруулсан “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал” суурь болон төгсгөлийн судалгааг хийв. Төслийн үр шимийг хамрагдсан 9 сум, баг, хорооны 82,704 хүн амын 19,715 өрхийн 28,637 хүүхэд хүртлээ. Төсөл хэрэгжсэн 3 жилийн хугацаанд 9 нэгжийн Хамтарсан багуудыг чадавхжуулж, төслийн хүрээнд боловсруулсан гарын авлага, маягыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэн, олон нийтэд хүүхэд хамгааллын, хүмүүжлийн эерэг аргын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд ахиц гарсан билээ. Ялангуяа хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх сургалтад хамруулснаар Хамтарсан багийн гишүүд нэгдсэн мэдлэг, ойлголттой болж, хүүхэд гэр бүлд үйлчилгээ үзүүлж байна.

- Төсөл дуусах үед авсан судалгаагаар хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадвар 80 гаруй хувиар нэмэгдсэн байна.
- Төслийн хүрээнд боловсруулсан үйлчилгээний маягт нь салбарын сайдын тушаалаар албажиж, Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх Хамтарсан баг хамгааллын үйлчилгээнд нэгдсэн маягт ашиглаж эхэллээ. Ингэснээр нөхцөл байдлын үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ нь шүүхэд нотлох баримтын түвшинд очих боломж бүрдсэн.
- Олон нийтийн дунд хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхийн тулд хүмүүжлийн эерэг аргын цуврал сургалтуудыг зохион байгуулж, нийтдээ 324 эцэг, эх, асран хамгаалагчийг хамруулав.
- Төсөл хэрэгжсэн 9 сум, баг, хорооны хамтарсан баг нь гурван жилийн хугацаанд 176 кэйсийг илрүүлж, 33 кэйсийг холбон зуучилж, 13-ыг шилжүүлж, 48 кэйсийг амжилттай шийдвэрлэж, 204 хүүхэд, гэр бүлд хамгааллын зөвлөгөө өгсөн байна.



ХИС энэхүү төслийн 2-р үе шатыг 2018 оны 9-р сараас эхлэн 4 жилийн хугацаатай хэрэгжүүлж эхлээд байна. Энэ шатанд ХИС нь ГБХЗХГ болон Хамтарсан багийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албатай хамтран, Улаанбаатар хот, Архангай, Дорнод аймгийн нийтдээ 16 анхан шатны нэгжид хүрч ажиллаж байна.

2018-2019 онд төслийн гарааны суурь судалгааг хийснээс гадна хамтарсан багийн гишүүдэд зориулсан 4 чиглэлийн гарын авлага боловсруулж гаргаад байна. Үүнд олон нийтэд чиглэсэн нөлөөлөл, сурталчилгааны ажил зохион байгуулах, Хамтарсан багийн гишүүдийн болон үйлчлүүлэгчдийн аюулгүй байдал, Хамтарсан багийн гишүүдэд зориулсан төсвийн менежмент, Хамтарсан багийн хөтлөх маягт, түүнийг бөглөх удирдамж, гарын авлагууд багтаж байна. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах чиглэлээр дахин 24 сургагч багшийг бэлтгэж зорилтот хороо, сум, багийн Хамтарсан багийн нийт 123 гишүүнд сургалт зохион байгуулав. Боловсруулан гаргасан сургалтын багц дээр үндэслэн ГБХЗХГ болон “Дэлхийн Зөн Монгол” ОУБ хамтран уг сургалтыг төслийн бус Хамтарсан багуудад түгээн дэлгэрүүлэх ажлыг хийж байна. 2019 оны байдлаар үндэсний сургагч багшаар 45 хүн, бүсийн сургагч багшаар 200 сургагч бэлтгэгдсэнээр, 609 хамтарсан багуудын 3,000 гишүүнд сургалт явуулах чадамжтай болоод байна.

Хамтарсан багийн нийгмийн ажилтнуудад зайлшгүй хэрэгтэй кэйстэй ажиллах ур чадвар, кэйс менежмент чухал аргагүйг төслийн хүрээнд нэвтрүүлж, дэлгэрүүлж ажиллаж байна. ХИС-ын олон улсын эвслийн боловсруулсан хамгааллын алхмууд аргагүйг үндэслэн, кэйс менежментийн сургалтын хөтөлбөр боловсруулж, нийт 20 сургагч багшийг бэлтгэлээ. Мөн кэйс менежментийн гарын авлагыг ГБХЗХГ -тай хамтран боловсрууллаа. Үүнд бэлтгэгдсэн сургагч багш нар болон зорилтот орон нутгийн хамтарсан багийн гишүүд хамрагдсан юм.

Хамтарсан баг, хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор хэвлэмэл материал, мэдээллийн самбар зэргийг боловсруулсан.



**ХИС-гийн санаачилга, олон жилийн идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд Монгол Улс хүүхдийг зодож шийтгэхийг нийгмийн бүхий л орчинд хуульчлан хориглосон 49 дэх улс болов.**

**2006 ОНООС ХОЙШ: “ХҮҮХДИЙГ ЗОДОЖ ШИЙТГЭХИЙГ ТАСЛАН ЗОГСООХЫГ УРИАЛАХ ОЛОН УЛСЫН ӨДӨР”**

ХИС нь Монгол Улсад хүүхдийн бие махбод болон сэтгэл санааны шийтгэлийг халах асуудлыг хөндөж тавьсан, хориглохын төлөө хүчин зүтгэсэн анхны олон улсын хүүхдийн байгууллага юм.

Монгол Улс 2006 онд Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, боловсролын орчинд хүүхдийн бие махбод болон сэтгэл санааны шийтгэлийг хуулиар хориглосон билээ. Энэ нь хүүхэд хамгааллын салбарт гарсан маш том ахиц, дэвшил мөн боловч эцэг эх, багш, асран хамгаалагч нарт хүүхдийг хүчирхийллийн бус эерэг аргаар хүмүүжүүлэх дадал, мэдлэг, арга барил дутмаг байсаар байна. Монгол Улсын хувьд бусад олон орны нэгэн адил хүүхдийг шийтгэх нь нийгмийн хэм хэмжээ, соёлоос үүдэлтэй.<sup>1</sup>

ХИС 2006 онд хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэхийг эцэг эх, асран хамгаалагчдад уриалж, “Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоохыг уриалах олон улсын өдөр”-ийг Монгол Улсад тэмдэглэж эхэлсэн. Түүнээс хойш жил бүрийн 4-р сарын 30-нд үндэсний ТББ-ууд хүүхдийн эрхийн төлөө тэмцэлд дуу хоолойгоо өргөн, хүүхдийг зодож шийтгэхээс татгалзах нөлөөллийн ажил, төрөл бүрийн аян өрнүүлж, өнөөг хүртэл тасралтгүй зохион байгуулж ирлээ.

<sup>1</sup> Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын олон улсын стратеги (2013-2015)

■ Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох олон улсын өдрийг тохиолдуулан Хүүхдийг Ивээх Сангийн Гэр Бүл, Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газар, МУИС, МУБИС-ийн Нийгмийн ажлын тэнхимтэй хамтран зохион байгуулсан арга хэмжээ. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, 2016 оны 4 дүгээр сарын 30







■ 2009-2014 онд Улаанбаатар хот, Дорнод аймагт 4,000 гаруй эцэг эх сургуулиудаар дамжуулсан сургалтад хамрагдаж хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүмүүжлийн эерэг аргын талаар мэдээлэлтэй болов.

зүйн туршлага, гэр бүлийн орчинд байгаа шийтгэлийн талаарх судалгааны тайлан зэрэг баримтуудыг хуулийн Ажлын хэсэг болон холбогдох байгууллагуудад танилцуулсан билээ.

2015 онд ХИС энэ өдрийг “Гэр бүлийн орчинд хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг хүчирхийллийг хуулиар хориглоё”, “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэе” уриан дор тэмдэглэсэн. Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг энэ аянд 21 аймгийн орон нутгийн телевизүүд, нийслэлийн 9 дүүрэг, төрийн болон төрийн бус байгууллагууд нэгдэж, хүүхдийг зодож шийтгэхийг хориглох, эерэг аргаар үлгэрлэн хүмүүжүүлэх сэдэвт шторкуудыг цацаж, 140 оюутан оролцсон флаш моб зохион байгуулсан. Түүнчлэн төрийн болон төрийн бус байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан мэдээлэл өгөх, олон нийтийн цахим сүлжээ, үндэсний мэдээллийн портал, ТВ, радиогийн нэвтрүүлгээр хүүхдийг зодож шийтгэлгүй эерэг аргаар, үлгэрлэн хүмүүжүүлэх талаар зөвлөгөө мэдээлэл цацаж, 280,000 хүнд хүргэжээ.



■ Хүүхэд Хамгааллын тухай болон Хүүхдийн Эрхийн тухай хуулиуд батлагдахаас өмнө Хүүхдийг Ивээх Сангийн төлөөлөл УИХ-ын эмэгтэй гишүүд болон Хоган Лоуэльс олон улсын хуулийн фирмтэй лобби уулзалт хийж байна. 2015 оны 12 дугаар сар

“Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийнхөө хүрээнд зорилтот 16 орон нутагт хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг 1 сарын аяныг хүүхэд, эцэг эх, олон нийтийн оролцоотойгоор явуулсан болно.

Хүүхэд хамгааллын салбарт дэвшил авчирсан “Хүүхэд хамгааллын тухай хууль” бол Монголын хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын салбарт 25 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан ХИС-гийн үе үеийн ажилтнуудын хичээл зүтгэлийн үр дүн мөн.

ХИС-гаас энэ өдрийг тэмдэглэхдээ бие махбод болон гутаан доромжлох шийтгэлийн тухай, түүний хор хөнөөл, хүүхдэд хэрхэн тусдаг тухай хүүхдийн дуу хоолойг хүүхдүүдийн зурсан зураг, ярилцлага, дуу, тараах хуудас зэрэг арга хэрэгслээр эцэг эхчүүдэд хүргэдэг.

ХИС 2009 оноос “Гоу Хелп” байгууллагын дэмжлэгтэйгээр Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран аливаа хүчирхийллээс ангид байх хүүхдийн эрхийг тусгасан хуулийн заалтуудыг “Гэр бүлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулахаар ажиллахдаа гэр бүлийн орчинд шийтгэлийг хориглосон олон улсын эрх

2016 онд ХИС хүүхдийн эсрэг хүчирхийлэл, тэр дундаа бие махбодын болон сэтгэл санааны шийтгэлийг таслан зогсоохоор хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжин ажиллав.

2016 оны 2-р сард Монгол Улсын Их Хурал “Хүүхэд хамгааллын тухай” хуулийг баталж, мөн оны 9 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлснээр Монгол Улс хүүхдийг зодож шийтгэхийг нийгмийн бүхий л орчинд хуульчлан хориглосон дэлхийн 49 дэх улс болсон. Уг хуулийг амьдралд хэрэгжүүлж, олон нийтэд сурталчлан таниулахын тулд ХИС 2017- 2019 онд хэрэгжүүлсэн





■ Зах дээр хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд. Улаанбаатар хот, 1996 он

**25 дэвшил: №11**

**Хараа хяналтгүй  
болон хөдөлмөр  
эрхлэгч  
хүүхдүүдэд  
чиглэсэн  
үйлчилгээний  
загварыг бий  
болгов.**

### **1996 - 2000 ОН: “ХОТ АЙЛ” ТӨВҮҮД**

1996 онд Монгол Улсын эмзэг бүлгийн хүүхдийн тоо ХИС-гийн тооцоолсноор 30000, НҮБ-ын Хүүхдийн Сангийн тооцоолсноор 60000-д хүрээд байв. Тэр дундаа 1990-ээд оны шилжилтийн үеийн хямралын шууд тусгал болсон ажилгүйдэл, ядуурал, архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салалтын уршгаар хүүхдүүд гэрээсээ дайжин, өнчин болон хаягдмал, хараа хяналт сул “гудамжны хүүхдийн” тоо 1990-ээд оны дунд үе гэхэд 1500-4000 орчимд хүрчээ.

1996 онд Монгол Улсын Ерөнхий сайд хараа хяналтгүй, гудамжинд амьдардаг хүүхдүүдэд туслахыг олон улсын байгууллагуудад уриаллаа.

Энэхүү уриалгыг ХИС хүлээн авч, тэр даруй Улаанбаатар хотод 10, хөдөө орон нутагт 4 хүүхэд хамгаалал, хөгжлийн “Хот айл” төвийг байгуулсан юм. Тэдгээр төвүүдэд гэр орноосоо дайжсан хүүхдүүдийг амьдрах орон байраар хангаж, сургуульдаа сурах, мэргэжлийн ур чадвар эзэмших боломжийг олгохын зэрэгцээ ганцаарчилсан зөвлөгөө, кэйс менежмент, гэр бүлд нь эргэн нэгтгэх, зөвлөн туслах, гэр бүлд түшиглэсэн хувилбарт үйлчилгээ зэргийг нэвтрүүлсэн нь Монголын нөхцөлд тохирсон үр дүнтэй шийдэл болжээ.

ХИС-гийн энэхүү туршлага 1990-2000 онд хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдтэй ажилладаг төрийн болон бусад байгууллагын үйл ажиллагаанд жишиг загвар болсон билээ.



■ Хот айл төвийн хүүхдүүд 1990-ээд оны сүүлээр



■ Хот айл төвийн хүүхдүүд Гачуурт зусланд амарч байна. 1998 он



■ Хот Айл төвөөс гарсан анхны оюутан Э.Баярмаа гэр бүлийн хамт, 2019 он

л... Тэгэхэд манайд нэг хүүхэд (одоо 30 хүрч яваа том залуу) байсан юм. Ерөөсөө хүрдээ цээжилдэггүй. Арван хэдүүлээ үзээд барахгүй. Бүтэн хоёр өдөр 2-ын хүрдийг цээжлүүлэх гээд чадаагүй бууж өгсөн хөгтэй явдал болж байсан. Бид зундаа Гачуурт руу зусланд гардаг байв. Зусланд гарахыг хоног тоолон хүлээдэг байлаа. Ер нь олон сайхан сайхан дурсамж бидэнд бий.

Би төвдөө амьдарч байхдаа хэд хэдэн мэргэжилтэй болсон. Тогооч болж үзсэн, сүлжигч ч болж үзсэн. Сүүлд 2002 онд 10-р ангиа төгсөөд, их сургуульд орсон. Хот айл төслөөс анх оюутан болсон хүүхэд нь би. Сурлага сайтай болохоор барилгын инженер архитектурын ангийн урилга авч байв. Одоо нөхөртэйгөө хамт барилгын компани ажиллуулдаг. Бид одоо тансаг зэрэглэлийн хотхоны төсөл дээр ажиллаж байгаа. Манайх дөрвөн хүүхэдтэй, өнөр олуулаа сайхан амьдарч байна. Гадуур Хүүхдийг Ивээх Сангийн лого ч юм уу, бичгийг харахаар надад их дотно, сайхан санагддаг. Монгол хүүхдүүдийн төлөө та бүгдийн хийж байгаа ажлуудаар бахархаж явдаг шүү.”

“Намайг Эрдэнэ-Очирын Баярмаа гэдэг. 2003 онд аав, ээж маань бурхан болоод, би 4 дүүтэйгээ өнчирч үлдсэн. Тэр үед Хүүхдийг Ивээх Сангийн “Хот айл” төслийн “Улаан сарнай” төвд ирж, дүү нартайгаа дөрвөн жил амьдарсан. Тэр төвөөс миний ажил амьдрал, өөрчлөлтийн гараа эхэлж дээ.

Анх төвдөө 25-уулаа байсан юм. Том хүүхдүүд нь жижигчүүлээ асардаг, хооллож ундалж, хувцас хунарыг нь угаадаг, хичээл номыг нь давтуулдаг. Тэр дундаа би хамгийн том нь байсан. Хүний өөрийн ялгалгүй тэд нарынхаа эцэг эхийн хуралд нь сууна, хичээлийг нь хийлгэж хүрдийг нь цээжлүүлнэ гээд





## 1996 - 1999 ОН: “ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ХҮҮХЭД” ХӨТӨЛБӨР

1996 оны байдлаар 1500 орчим хүүхэд гудамжинд байнга амьдарч, 3500 орчим хүүхэд гудамжинд олон цагаар ажиллаж олсон багахан мөнгөө өгөхөөр гэр орондоо алдаг оног очдог байв. Мөнгө олохын тулд олон хүүхэд, ялангуяа хөвгүүд зах дээр ачаа зөөх, гутал цэвэрлэх, машин угаах, гудамжинд жижиг худалдаа хийх, хаягдал шил, лааз, яс түүх, вагонд явж дуу дуулах, гуйлга гуйх, халаас суйлах, биеэ үнэлэх зэрэг янз бүрийн, заримдаа хууль бус үйл ажиллагаанд оролцох нь элбэг байлаа.<sup>1</sup> Ийм нөхцөлд эдгээр хүүхэд рүү чиглэсэн, үр дүнтэй, урьдчилан сэргийлэх болон нөхөн сэргээх арга хэмжээ авахгүй бол гудамжинд амьдарч байгаа хараа хяналтгүй хүүхдийн тоо богино хугацаанд эрс нэмэгдэх эрсдэл өндөр байлаа.

Нийгмийн байдлыг харгалзан ХИС 1996 онд “Хөдөлмөр эрхлэгч хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн юм. Хөтөлбөрийн хүрээнд ХИС-гаас хэрэгжүүлсэн олон жижиг төсөл нь хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг хүнд, хортой ажлаас хөндийрүүлэх, хөдөлмөрийн багаж зэвсэг олгож, тэдний хөдөлмөрийг хөнгөвчлөх, сурах болон хөгжих боломжийг нь нэмэгдүүлэх, хүүхдүүдэд ажил, сургуулиа хослуулах боломжийг олгоход чиглэж байв.

Насанд хүрэгчид болон “үе тэнгийн сургагч” нараар дамжуулан хэрэгжүүлсэн ХИС-гийн амьдрах ухааны сургалтууд нь өндөр эрсдэлтэй орчинд ажиллаж, амьдарч байгаа хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд болон хараа хяналтгүй хүүхдүүдэд бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх мэдлэг, мэдээллийг олгоход онцгойлон анхаарч байлаа. ХИС мэргэжлийн боловсролын сургуулиуд болон фермерүүдийн нийгэмлэгтэй хамтран ажилласны үр дүнд хөдөлмөр эрхэлж

<sup>1</sup> ХИС, “Хараа хяналтгүй хүүхдийн нөхөн сэргээлт” төслийн баримт бичиг, 1996/97



байсан өсвөр насны 850 хүүхдийг мэргэжлийн ур чадвар олгох сургалтад хамруулж, төгссөнийх нь дараа төрийн болон хувийн хэвшлийн ажлын байрт зуучилсан юм.

ХИС 2002 онд “Хараа хяналтгүй” хүүхдүүдэд чиглэсэн хөтөлбөрийнхөө үнэлгээг хийж, тэдгээр хүүхдэд үзүүлэх үйлчилгээний уялдаа холбоог сайжруулж, тэдэнд чиглэсэн боловсролын болон мэргэжил олгох сургалтуудаа эрчимжүүлсэн юм.

ХИС-гийн олон жилийн уйгагүй чармайлтын үр дүнд амьдралын эрхээр хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх тогтолцоо Монгол Улсад төлөвшөөд байна.

2002 оноос Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр (2002-2010) хэрэгжиж эхлэв. Мөн онд Монгол Улс ОУХБ-ын “Хүүхдийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай” 138 дугаар конвенцод нэгдэв.

2012-2016 онд “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн.

Гэхдээ хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо нэмэгдэж<sup>1</sup> АНУ-ын Төрийн Департаментаас жил бүр гаргадаг хүүхдийн хөдөлмөр шингэсэн бүтээгдэхүүний жагсаалтад (2014) Монголын нүүрс, алт, жоншийг оруулсан байгаа, НҮБ-ын “Дэлхийн хүний наймааны төлөв байдал 2014”<sup>2</sup>, АНУ-ын Засгийн газрын “Хүний наймаа 2014”<sup>3</sup> илтгэл, ЭКПАТ олон улсын байгууллагын “Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн эсрэг үйл ажиллагааны байдал Дэлхийн хяналт 2011”<sup>4</sup> илтгэлүүдэд Монголд охидыг худалдах, бэлгийн мөлжлөгт ашиглах, хүүхдээр албадан хөдөлмөр хийлгэх зэрэг хүүхдийн эрхийн зөрчлүүд байгааг дурдсан байна.

Иймд ХНХЯ-ны сайд 2016 онд А/36 тоот тушаал гаргаж “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг шинэчлэн баталсан.

1 ХТГ-ын дарга И.Нарантуяа <http://vip76.mn/content/25423> сайтад өгсөн ярилцлага. 2016.06.13

2 [www.unodc.org/documents/data-and-analysis/glotip/GLOTIP\\_2014\\_full\\_report.pdf](http://www.unodc.org/documents/data-and-analysis/glotip/GLOTIP_2014_full_report.pdf)

3 [http://www.state.gov/j/tip/rls/tiprpt/2014/index.html?utm\\_source](http://www.state.gov/j/tip/rls/tiprpt/2014/index.html?utm_source)

4 [http://www.ecpat.et/sites/default/files/a4a\\_v2\\_eap\\_mongolia\\_1.pdf](http://www.ecpat.et/sites/default/files/a4a_v2_eap_mongolia_1.pdf)



*Тухайн үед нийгэмд ядуурал, хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн их байснаас олон хүүхэд сургуулиас завсардаж, гэр бүлээ тэжээхийн тулд хөдөлмөр эрхлэх болсон байв. ХИС-гийн “Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд” төсөл тэдгээр хүүхдэд төрөл бүрийн дэмжлэг үзүүлж, үзэл бодлоо илэрхийлэх, дуу хоолойгоо нэгтгэх, хамтран ажиллах ур чадвар олоход нь тусалдаг байсан. Энэ төсөл олон хүүхдэд итгэл найдварыг өгсөн. Д.Алтансүх бол тэдний нэг юм. Найман настайгаасаа зах дээр ажил хийж байсан тэр хүү сургуульд огт суралцаж байгаагүй. Манай төсөлд хамрагдсанаар Алтансүх албан бус сургалтыг дүүргэж, видео төсөлд хамрагдан, мөн өөрөө бие даан англи хэл сурсан юм.*

*Хожим нь тэр хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн үүсгэн байгуулсан “Мандах холбоо”-ны тэргүүн болсон.*

*Х.Мөнхзул ХИС-гийн “Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд” төслийн нийгмийн ажилтан  
(2001- 2003)*



*Тэр үед нийгэмд хараа, хяналтгүй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах үзэл хүчтэй байсан. Тиймээс анх хараа хяналтгүй хүүхдүүдтэй уулзаж, харилцаа тогтооход хэцүү байсныг санаж байна. Бид хүүхдүүдтэй байгаа газар нь орон сууцны орц, траншейд очиж уулздаг байсан. Хүүхдүүд биднийг үнэн сэтгэлээсээ хандаж байгаа эсэхийг шалгахын тулд траншейнаасаа хорхой шавьж шидэх, хувцас халтартуулах зэрэг үйлдэл хийдэг байсан хэдий ч бид сайн сэтгэлийн үүднээс ирсэн гэдгээ харуулж, тэдэнд итгэл төрүүлэхийг хичээдэг байлаа.*

*Ж.Лхагвадулам ХИС-гийн Хараа, хяналтгүй хүүхдийн төвийн менежер  
(1995- 2003)*



■ Нийгэмшүүлэх Цирк төсөл 2000 оноос хойш хэрэгжихдээ 9000 гаруй хүүхдэд авьяасаа нээж хөгжүүлэх, нийгэмшихэд тусалсан билээ. Хүүхдүүд циркийн үзүүлбэрт бэлдэж байгаа нь. Гачуурт, 2000 он

**25 дэвшил: №12**

**Хүүхэд төвтэй,  
хүүхэд удирдсан  
хөгжлийн үйл  
ажиллагааг  
дэлгэрүүлэв.**

### **1999 ОНООС ХОЙШ: “НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК” ТӨСӨЛ**

Оролцоо, шударга ёс, тэгш байдал нь “Нийгэмшүүлэх цирк”-ийн үндсэн тулгуур юм. Цирк хэмээх гайхамшигт урлагаар дамжуулан хүүхэд залууст итгэл найдвар өгч, нийгэмшүүлэх зорилготой энэ онцгой хөтөлбөр 1995 оноос гараагаа эхлэн, өдгөө дэлхийн 56 оронд амжилттай хэрэгжиж байна. “Нийгэмшүүлэх цирк” нь циркийн урлагт суурилсан хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих аргагүй бөгөөд хүүхэд, залуучууд болон олон нийтэд эерэг өөрчлөлт гаргах асар их боломж юм. ХИС 1999 оноос дэлхийд алдартай Канадын “Нарны цирк” корпорацтай хамтран ажиллаж, энэхүү хөтөлбөрийг хүнд нөхцөлд амьдардаг хүүхэд, залуусын хувь хүний болон нийгмийн хөгжлийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж ирсэн.

■ Нийгэмшүүлэх Цирк төсөл 20 жилийн ойгоо циркчин хүүхдүүд, сургагч багш нар, хамтрагч байгууллагуудын хамт сонирхолтой үзүүлбэрүүдээр тэмдэглэв. Улаанбаатар хот, 2019 оны 12 дугаар сарын 13





### “НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК” ТӨСӨЛ НЬ:

- ХИС-гийн халамжийн төвүүд;
- ХИС-гийн Олон нийтэд түшиглэсэн хүүхэд, хөгжил, хамгааллын төвүүд;
- ХИС-гийн “Хүүхэд” төв;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 411-р анги;
- Төрөөс санхүүжилттэй халамж, асрамжийн төвүүд;
- Хөдөлмөр эрхлэгч хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг “Хүүхэд залуучуудын хөгжил, хамгаалал” төрийн бус байгууллага;
- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв;
- Насан туршийн боловсролын үндэсний төвийн харьяа Албан бус Насан туршийн боловсролын төвүүд;
- Ерөнхий боловсролын 29 дүгээр бүрэн дунд сургууль зэрэг байгууллагуудын хүүхэд хамгааллын чадавхыг бэхжүүлэх, хүүхэд төвтэй аргазүйг хөгжүүлэхээр ажилласан.

Дасгалжуулагч багш болон нийгмийн ажилтан хамтран ажиллаж хослон заах өвөрмөц аргазүй бүхий уг хөтөлбөрийг ХИС 2004 онд Дорнод дахь салбараараа дамжуулан хөдөө орон нутагт түгээн дэлгэрүүлж, Дорнод аймгийн төвийн болон Баянтүмэн, Сэргэлэн, Цагаан-Овоо зэрэг сумдын сургуулийн дотуур байрны малчин өрхийн хүүхдүүд хамрагдаж байжээ.

Хүүхэд залуус энэхүү сургалтад оролцсоноор циркийн арга техникт суралцаад зогсохгүй, нийгмийн харилцааны эерэг дадал, чадваруудыг эзэмшдэг. Түүнчлэн хүүхдүүд бүлгээр ажиллахын давуу талыг мэдрэх, тэсвэр хатуужилтай болох, бусдыг сонсох, хүндлэх, өөртөө итгэх, бусдад итгэх итгэлээ нэмэгдүүлэх замаар нийгмийн амьдралд оролцох боломжийг нь дээшлүүлдэг юм. Төслийн хүрээнд:

- “Нийгэмшүүлэх цирк” хөтөлбөрийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх боловсон хүчнийг бэлтгэхээр Хүүхдийг Ивээх Сан “Нарны цирк” корпораттай хамтран 2001-2013 онуудад “Нийгэмшүүлэх цирк” сургалтыг зохион байгуулах дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудыг бэлтгэх, чадавхжуулах олон улсын сургалтыг Монголд 4 удаа зохион байгуулж 30 гаруй байгууллагын 70 орчим ажилтнуудыг сурган бэлтгэсэн байна.
- Бэлтгэгдсэн ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр Хүүхдийг Ивээх Сан ажлын байран дахь аргазүйн зөвлөгөөг дагуулан сургах хэлбэрээр өгч байна.
- Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан бэлтгэх 40 цагийн агуулгыг багтаасан сургалтын хөтөлбөр, “Нийгэмшүүлэх дасгал, тоглоом” эмхэтгэл, “Нийгэмшүүлэх цирк” сургалт зохион байгуулах аргазүйн гарын авлагыг боловсруулж хэвлэн түгээв.
- Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд “Social circus” фейсбүүк группээр дамжуулан мэдээлэл солилцох, туршлагаа хуваалцаж хүүхэдтэй ажиллах аргазүйгээ баяжуулж байна.
- 2000 оноос эхэлсэн тус хөтөлбөрт нийт 9,000 гаруй хүүхэд, залуус хамрагджээ. Сургалтад



*Нийгэмшүүлэх циркийн сургалтад 2015 оны 4-р сараас явж эхэлсэн, миний хамгийн дуртай сургалт. Өмнө нь жонглёрын бөмбөгийг ердөө барьж үзээгүй, багшаар жонглёрдохыг заалгаад сурахад их хэцүү байсан ч дахин дахин оролдсоор байгаад одоо жонглёрын 3 бөмбөгөөр 200 удаа жонглёрдож чадна. Би өөртөө заавал хийж сурна даа гэж зорилго тавьсан.*

*Циркээр хичээллэхээр тэвчээртэй байхыг шаарддаг юм билээ. Өөрөө хичээвэл юмыг сурч чадах юм байна гэдгийг ойлгосон.*

*Б. Буянхишиг. БГД-ийн АБНТБТөвийн сурагч*



хамрагдсан хүүхдүүдийн биеийн өсөлт хөгжил, хөдөлгөөний эвсэл сайжран өөртөө итгэх итгэл, бусдад итгэх итгэл нь нэмэгдэж, өмнөө зорилго тавих, хатуужил тэвчээрт суралцан, бүтээлчээр сэтгэх, бие даах, амьдрах ухаанд сурган багаар ажиллах зэрэг хувь болон нийгмийн чадваруудад эерэг өөрчлөлтүүд гарсаар байгааг олон баримтаар нотолж байна. Хүүхдэд чиглэсэн сургалтыг зохион байгуулаад зогсохгүй тэдний эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхэдтэйгээ харилцах, тэдний давуу тал, ур чадвараар бахархах, хүүхдэдээ гарч буй эерэг өөрчлөлтийг мэдрэх боломжийг бүрдүүлэх үүднээс хүүхэд, насанд хүрэгчдийн хамтарсан сургалт хийх, уулзалт зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна.

- Эрх нь зөрчигдсөн, нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай хүүхдийг илрүүлэн нийгмийн ажлын ганцаарчилсан уулзалт хийх, гэр бүлд нийгмийн ажлын нөхцөл байдлын үнэлгээг хийж асуудлыг тодруулах, ганцаарчилсан уулзалт, зөвлөгөө өгөх, нийгмийн суурь үйлчилгээнүүдэд холбон зуучлах зэргээр хамгааллын үйлчилгээг хамтарсан багаар үзүүлэхэд нь дэмжлэг үзүүлснээр хамтрагч байгууллагуудын хүүхдэд хамгааллын чадавх бэхжиж байна.
- Хүүхдийн нийгэмшлийг дэмжих нэмэлт үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зуны сургалт хөтөлбөрт хамруулах, хүүхдийн оролцоотойгоор нийгэмшүүлэх циркийн аргазүйг олон нийтэд сурталчлах нөлөөллийн ажиллагаануудыг зохион байгуулж байна.

2015 оноос хойш уг төслийн гол хамтрагч Насан туршийн боловсролын үндэсний төв нь “Нийгэмшүүлэх цирк” хөтөлбөрийн зарчим, аргазүйгээр дамжуулан хүүхдэд боловсролын болон хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын ажилтнуудын хүүхэд хамгааллын чадавхыг бэхжүүлэх, насан туршийн боловсролыг дэмжих боломжийг эрэлхийлж байна.



■ Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш Б.Эрдэнэцэцэг дасгал сургуулилтын үеэр. Улаанбаатар хот, 2019 он



*Манай төвд сургалтад хамрагдсан хүүхдүүд сургалтын явцад хэмнэл, хэмжээ, орон зайн баримжаатай болох, өөртөө итгэх, өөрийгөө илэрхийлэн бусадтай харилцах чадвартай болж байна. Хүүхдүүдийн гэр бүл, эцэг эхтэй уулзан хүүхдэд гарч байгаа эерэг өөрчлөлтийн талаар ярилцан, юуг анхааран харилцах, яаж дэмжих талаар зөвлөснөөр зарим эцэг эх хүүхдээ сургалтад хамрагдахыг дэмжиж, хүүхдэдээ анхаарал тавих нь нэмэгдсэн. Энэ нь багштай тогтмол харилцах, төвийн үйл ажиллагаанд оролцох байдал сайжирсан зэргээс харагдаж байна. Нийгэмшүүлэх циркийн сургалт нь миний хувьд хүүхдүүдтэй итгэлтэй сайхан харилцаа тогтооход тус болсон.*

*Н. Мөнгөннавч. БГД-ийн АБГТБТөвийн дасгалжуулагч багш.*



*Би 2005 оноос “Нийгэмшүүлэх цирк” төслийн дасгалжуулагч багшаар ажиллаж байна. Анх хүүхдэд зөвхөн циркийн арга техник заана гэж бодож байсан. Гэтэл энэ төсөл маань хүүхдийг ойлгох, багаар ажиллах чадвар, хүүхдийн эрхийг дээдэлсэн сургалтын арга барил зэрэг олон зүйлийг шаардсан ажил байсан. Энэ олон зүйлийг хамтрагч багш, нийгмийн ажилтнууд, төслийн багийнхан маань зааж өгсөн.*

*Манай төслийн зорилго нь мэргэжлийн циркчин болгохдоо биш, циркийн урлагаар дамжуулаад хүүхдэд тэсвэр хатуужил, зорилгынхоо төлөө тэмцэх тэвчээр, хувийн сахилга бат гээд зөндөө олон зүйлд*

сургадаг. Тэр болгоныг хүүхдүүддээ сургахын төлөө ямар ч саад бэрхшээл, хэцүү зүйлийг бид хамтдаа даван гарч, ажиллаж ирсэн.

Хүүхдүүд маань урлаг, спортоор үргэлжлүүлэн хичээллэж, амжилт гаргаж байгаа. Жишээ нь, манай нийгэмшүүлэх цирк төслөөс мэргэжлийн циркийн 2 жүжигчин төрөн гарсан. Нэг нь Монгол Улсын Соёлын Тэргүүний Ажилтан Пүрэвсамбуу. Одоо олон улсын тэмцээнд тоглож байгаа. Циркийн олон ч тэмцээнээс олон шагнал авсан. Нөгөө нь Ганцэцэг гэдэг хүүхэд морины циркээр Хятад улсад тоглолтоор явж байна.

Бид “Нийгэмшүүлэх цирк” төслийнхөө 10 жилийн ойгоор Улсын циркт том тоглолт хийсэн. Гэрэл, хөгжим, тоглолт гээд бүх юм нь их гоё, багш, эцэг эхчүүд нь жижигхэн сандлууд дээр тойроод суучихсан. Тэнд байсан манай хүүхдүүдийн нүднээс ямар их баяр баясал, өөрсдөөрөө бахархсан сэтгэл цацарч байсан гээч. Тэр үед хүүхдүүдээ харахад үнэн гоё байсан. Тэр хэзээ ч мартагдахгүй дурсамжтай гоё тоглолт болсон. Цирк байгаа газар инээд баяр хөөр үргэлж цуг байдаг юм.

“Нийгэмшүүлэх цирк” төслийн сургагч багш Б.Эрдэнэцэцэг

## 2005 - 2009 ОН: “ХҮҮХЭД БА ДУРАН” ГЭРЭЛ ЗУРГИЙН ХӨТӨЛБӨР

ХИС хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, нийгмийн харилцааг дэмжин хөгжүүлэх “Хүүхэд ба дуран” гэрэл зургийн хөтөлбөрийг Монголын Урлагийн Зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэв. Зорилтот сургуулийн хүүхдүүдэд чөлөөт цагаар нь мэргэжлийн багшаар гэрэл зургийн онол, дадлагын хичээл заалгаж, бүтээл хийх боломжийг бүрдүүлсэн энэ төсөлд 70 гаруй хүүхэд хамрагдсан бөгөөд Монголын гэрэл зургийн салбарын залуу үеийн төлөөлөл болон олон уран бүтээлч төрсөн билээ. Тэдний нэг нь 2017 оны “Азийн шилдэг гэрэл зурагчин” Д.Давааням юм.



■ 2017 оны Азийн шилдэг гэрэл зурагчин Д. Давааням



Намайг Дэлгэржаргалын Давааням гэдэг. Би гэрэл зургийн Гамма агентлагт гэрэл зурагчин, СУИС-ийн Радио Телевиз Медиа урлагийн сургуульд гэрэл зургийн багш, Баримтат гэрэл зургийн Батзориг сангийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. 2005 онд 9-р ангид байхдаа Хүүхдийг Ивээх Сангаас Хайлаастанд хэрэгжүүлсэн “Хүүхэд ба дуран” төслийн анхны сурагчдын нэг болсон.

“Хүүхэд ба дуран” төсөл нь гэрэл зургаар дамжуулж өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлэхэд хүүхдүүдэд туслах зорилготой байсан. Хар цагаан гэрэл зургийн лаборатори байгуулж, жил бүр нэг бүлгийн 10 хүүхдийг сургадаг байв. Хар цагаан хальс, цаас, лабораторийн хэрэглэл, сурах материал гээд бүх зүйл нь бэлэн байсан учир хүүхдүүдэд, ялангуяа гэр хороололд амьдардаг хүүхдүүдэд маш том боломж байсан. Манай төслийн хүүхдүүд гэрэл зургийн 70 жилийн ойн баяраар анхны гэрэл зургийн үзэсгэлэнгээ гаргасан. Зургаа үзэсгэлэнгийн хэмжээнд гаргаж, хүмүүст үзүүлнэ гэдэг бол тасарчихсан гоё мэдрэмж шүү дээ. Швейцарын Хөгжлийн агентлаг, Монголын Урлагийн Зөвлөл, Хүүхдийг Ивээх Сантай хамтран хэрэгжүүлсэн энэ төсөл 6 жил хэрэгжихдээ 80 гаруй хүүхдийг төгсгөсөн, их амжилттай төсөл болсон.

## **Гэр бүлд түшиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээний стандартын төслийг боловсруулав.**

### **2009 - 2014 ОН: ГЭР БҮЛД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭ**

ХИС “хүүхэд бүр өөрийн гэр бүлд, эсвэл гэр бүлтэй дүйцэх орчин нөхцөлд амьдрах ёстой, халамж, асрамжийн газар бол эцсийн хувилбар” гэсэн зарчмыг баримтлан ажилладаг билээ. Иймээс олон улсад болон Монгол Улсад ажилласан туршлагадаа тулгуурлан 2009 оноос гэр бүлд түшиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээний үзэл баримтлалыг Монгол Улсад танилцуулах, хөгжүүлэх үйл ажиллагаанд анхаарч эхэлсэн юм.


Энэ ажлынхаа хүрээнд хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдэд халамжийн хувилбарт үйлчилгээний стандарт, заавар зөвлөмж, стратегийг танилцуулсан.

Мөн ХИС нь хүүхдэд шууд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын ажилтнуудад эцэг эхийн анхаарал халамжаас гадуур, хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдэд чиглэсэн хамгааллын бодлогыг танилцуулсан юм. Энэ ажлын хүрээнд 2009-2011 онд Улаанбаатар болон Дорнод аймаг дахь халамжийн байгууллагууд, Дорнод аймгийн дотуур байртай сургуулиуд, хорих төв, ХТҮГ-ын Хүүхэд гэр бүл хөгжлийн “Өнөр бүл төв” зэрэг байгууллагуудын удирдлага болон ажилтнуудад хүүхдийн эрхэд суурилсан чиг баримжаа олгох сургалтууд зохион байгуулав.

2010 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтарч Гэр бүлд түшиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээний стандартын төслийг Монгол Улсын нөхцөлд тохируулан боловсруулсан. “Гэр бүлд түшиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээний гарын авлага”-ыг хэвлэж, холбогдох байгууллагуудад түгээв.







2012 онд УИХ Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаална” гэж хуульчлан зааснаас гадна асаргааны тэтгэмж болох 48,000 төгрөгийг сар бүр улсаас олгох болсонд ХИС-гийн гүйцэтгэсэн үүрэг их бий.

2017 оны 12-р сард Монгол Улсын Засгийн газар, Стандарт хэмжилзүйн газрын хамтарсан тушаалаар “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандарт” батлагдан гарсан нь ХИС-гийн санаачлан хэрэгжүүлсэн үйл ажиллагааны түүхэн амжилт байлаа.



**25 дэвшил: №14**

**Хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалахын төлөө тэмцэж, өвөл, хаврын морин уралдааныг зогсоов.**

### **2017 ОН: ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛ**

ХИС 2017-2018 онд Хурдан морины өвөл, хаврын уралдаанд хүүхдийг оролцуулан, хүүхдийн амь нас, эрүүл мэндэд эрсдэл учруулан, сурч боловсрох эрхийг нь эдлүүлэхгүй байгаа нөхцөлийн эсрэг үндэсний ТББ-ууд болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг санаачлан эхлүүлж, Өмгөөллийн “ИЭлСи” ХХН хуулийн фирмтэй хамтран ажиллалаа.

ТББ-ууд хүүхдийн эрхийн асуудлаар анх удаа шүүхэд хандаж:

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 2-р сарын 22-ны өдрийн 63-р тогтоолыг хүчингүй болохыг тогтоолгох,
- Уг тогтоолын дагуу 2017 оны 3-р сарын 5-ны өдөр Төв аймгийн Аргалант суманд зохион байгуулагдсан Дүнжингарав уралдаан хууль бус байсан болохыг тогтоох,
- Засгийн газарт жил бүрийн 10-р сарын 1-ний өдрөөс 5-р сарын 1-ний өдөр хүртэл улс, аймаг, сумын хэмжээний хурдан морины уралдааны бэлтгэл шат болон уралдааны явцад хүүхдээр морь унуулах, аливаа хэлбэрийн морин уралдаан зохион байгуулахыг





хориглосон улс даяар дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт гаргахыг даалгах тухай нэхэмжлэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан.

Захиргааны хэргийн Анхан, Давж заалдах, Хяналтын шатны шүүхээс дээрх үндэслэлээр Засгийн газрыг хууль бус шийдвэр гаргаж байна гэж тогтоон шийдвэрлэсэн болно.

Засгийн газар шүүхийн шийдвэрийг хүлээж аван, 2019 оны 1-р сарын 30-ны өдөр Засгийн газрын 57 дугаар тогтоол гаргаж, жил бүрийн 11-р сарын 1-ний өдрөөс 5-р сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглож шийдвэрлэсэн. Уг тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосон юм.





# БОЛОВСРОЛ





### ХИС боловсролын салбарт:

- Бага насны хүүхдийн халамж, хөгжил буюу сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)
- Суурь боловсрол
- Хөгжлийг бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах боловсрол
- Хүүхэд, залуучуудыг чадавхжуулах боловсрол
- Гамшиг, онцгой байдлын үе дэх боловсрол гэсэн таван үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, чанартай боловсрол эзэмших хүүхдийн эрхийг баталгаажуулахад анхааран ажилласаар ирлээ.

ХИС нь хүүхэд бүр оршин суугаа газар, хүйс, яс үндэс, нийгмийн байдлаасаа үл хамааран чанартай боловсрол хүртэх эрхтэй гэж үздэг билээ.

Гэвч сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй, сургуульд хамрагдсан хэдий ч боловсролын үйлчилгээний чанараас шалтгаалан хэрэгцээт суурь мэдлэгийг авч чадахгүй хүүхэд олон байна.<sup>1</sup> Дэлхийн хүүхдүүдийн ойролцоогоор 20 хувь нь сургуульд огт хамрагдаж чадахгүй, эсвэл бага ангиасаа сургууль завсарддаг ажээ. Үүний шалтгаан нь ядуурал, нийгмийн гарал үүсэл, эрүүл мэнд, хүйсийн болон яс үндсээр ялгаварлан гадуурхалт зэргээс үүдэлтэй. Сургуульд сурдаг ч шаардлагатай суурь мэдлэгийг авч чадахгүй хүүхэд мөн 20 хувийг эзэлж байна.<sup>2</sup>

Боловсрол хүүхдэд өөрт нь, гэр бүлд, нийгэмд бүхэлд нь олон төрлийн тогтвортой эерэг үр дүнг авчирдаг. Боловсрол эзэмшсэнээр хүний орлогын хэмжээ нэмэгдэж, ядуурлын түвшин буурдаг хандлагатай. Үүнээс гадна хувь хүний болон гэр бүлийн эрүүл мэнд, хоол хүнсний тэжээллэг байдал боловсролын түвшинтэй шууд холбоотой байдаг. Түүнчлэн боловсрол нь ардчилсан нийгмийг бэхжүүлэх, энх тайван, аюулгүй байдлыг хангахад нөлөөлдөг хүчин зүйл юм.

Тиймээс ХИС боловсролын тогтолцоог хүүхдийн эрхэд суурилсан, хүүхдийн оролцоог хангасан, тэгш хамрагдах эрхийг нь хэрэгжүүлдэг чанартай боловсролын хүрээнд авч үздэг.

<sup>1</sup> Хүүхдийг Ивээх Сангийн 2015 он хүртэлх Боловсролын олон улсын стратеги

<sup>2</sup> Бүх нийтийн боловсролын олон улсын мониторингийн тайлан, ЮНЕСКО, 2012



# 1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

25 дэвшил: №15

**Сургуулийн өмнөх боловсролын салбарт хувилбарт сургалтыг нэвтрүүлж, үндэсний онцлогт нийцсэн явуулын “Гэр цэцэрлэг”-ийн үйлчилгээг санаачлав.**



## 1994 - 2000 ОН: “СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-1”

1994 онд ХИС-гаас санаачлан БСШУЯ, ХТҮТ-тэй хамтран үндэсний хэмжээний судалгааг хийж, Монголын СӨБ-ын чанар, хүртээмж, ялангуяа эмзэг бүлгийн хүүхдийн боловсролд хамрагдаж буй байдлыг шинжлэн дүгнэсэн билээ. Энэхүү судалгааны дүгнэлт, зөвлөмжид “Сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (СӨБХҮХ)-1” (1995-2000) үндэслэсэн юм.

Уг хөтөлбөрийн хэрэгжилтийн бүхий л үе шатанд ХИС нь Засгийн газрын гол хамтрагч байж, СӨБ-ын чанар, хүртээмжийг сайжруулах замаар тус салбарыг өөрчлөн шинэчлэх, СӨБ-ын үйлчилгээний зардлыг бууруулах, эмзэг бүлгийн хүүхдүүдэд үйлчилгээг хүргэх, ялангуяа хүүхэд төвтэй сургалтын аргазүйг СӨБ-д нэвтрүүлэхийн төлөө идэвхийлэн ажилласан юм.

СӨБ-д хүүхэд төвтэй арга зүйг нэвтрүүлэх ХИС-гийн туршилтын төсөл 1996 онд Улаанбаатар хотын 2 цэцэрлэгт эхэлж, 1998 онд Дархан-Уул, Дундговь, Орхон аймагт өргөжин хэрэгжив.

1996 - 1998 онд СӨБ-ын салбарын 20 багш, цэцэрлэгийн эрхлэгч, мэргэжилтнүүд ХИС-гийн дэмжлэгтэйгээр Сингапур улс дахь Зүүн өмнөд Азийн бүсийн Бага насны хүүхдийн боловсролын сургалт судалгааны төвд хүүхэд төвт аргазүйн сургалтад суралцлаа.

ХИС СӨБХҮХ-1 хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд БСШУЯ-ны Бодлогын төлөвлөлт, зохицуулалтын алба болон Боловсролын судлалын хүрээлэнгийн СӨБ-ын сургалт,







■ 2007 оны зун Завхан, Баянхонгор, Хөвсгөл, Дорнод аймгуудад 16 “гэр цэцэрлэг” ажиллуулж нийт 1025 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдлаа. Малчин өрхийн хүүхдүүд Хүүхдийг Ивээх Сангийн байгуулсан гэр цэцэрлэгт. Дорнод аймаг, 2007 он

■ Малчин өрхийн хүүхдүүд Хүүхдийг Ивээх Сангийн байгуулсан гэр цэцэрлэгт. Хөвсгөл аймаг, 2007 он

судалгааны төв, Цэцэрлэгийн багшийн коллеж зэрэг байгууллагуудад олон талт дэмжлэг үзүүлэв. ХИС-гийн арга зүй, санхүүгийн дэмжлэгтэй байгуулсан “СӨБ-ын сургалт- судалгааны төв” нь багш мэргэжилтнүүдэд нэн шаардлагатай гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж, практикт нэвтрүүлэхийн зэрэгцээ үндэсний болон орон нутгийн сургалт-семинаруудыг зохион байгуулж, СӨБ-ын салбарын хүний нөөцийг чадавхжуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.



СӨБ-ын салбарыг шинэчлэх, бэхжүүлэх орон нутгийн санаачилгыг идэвхжүүлэхийн тулд ХИС жижиг төслийг дэмжих туршлагыг бий болгов. Үүгээр дамжуулан алслагдсан орон нутгийн болон эмзэг бүлгийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд СӨБ олгох, хөдөөгийн цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд эцэг, эх, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, олон нийт болон цэцэрлэгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үүсгэл санаачилгыг дэлгэрүүлсэн билээ.



ХИС-гийн санаачилгаар ЯБҮХ-ийн Орон нутгийн хөгжлийн сангийн дор байгуулсан “Сургуулийн өмнөх боловсролыг дэмжих дэд сан” Завхан, Говь-Алтай, Булган, Төв, Ховд, Дундговь аймагт цэцэрлэгүүдийн барилгыг засварлах, явуулын<sup>1</sup> Гэр цэцэрлэг<sup>2</sup> байгуулах, эмзэг бүлгийн болон алслагдсан хөдөөгийн хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг хүргэх олон шинэлэг арга, үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Үндэсний онцлогт тохирсон дээрх шинэлэг арга хэлбэрүүдийг улсын хэмжээнд туршиж, “сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт” хэмээн нэрлэн, амьдралд нэвтрүүлсэн билээ.



Хүүхдээ ердийн цэцэрлэгт явуулах эдийн засгийн боломжгүй өрхийн хүүхдүүдэд цагийн, хагас өдрийн сургалтуудыг зохион байгуулах, цэцэрлэгийн хоолны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэмжээг авав.

1 Малчин өрхийн хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулахын тулд гэр цэцэрлэгүүд нь малчдад ойр байрлаж, явуулын үйл ажиллагаа явуулдаг.  
2 Монгол гэрт үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэг



*Сургуулийн өмнөх боловсролын салбарын хамгийн хүнд үед буюу 1990-ээд оны дундуур ХИС тус салбарт ажиллах болсон нь Монгол Улсын хөгжилд үнэлж баршгүй хувь нэмэр болсон.*

*Тухайн үед ХИС бага насны хүүхдийн боловсролын чиглэлийг сонгож ажиллаагүйсэн бол хожим нь биднээс хувь хүний болоод улс орны хөгжил, дэвшилд онцгой чухал үүрэгтэй сургуулийн өмнөх боловсролын салбарыг дахин сэргээхэд маш их цаг хугацаа, хөрөнгө, хүчин чармайлт шаардагдах байлаа.*

*Т.Цэндсүрэн, ХИС-гийн Боловсролын хөтөлбөрийн ажилтан (1997-2006)*

## **2000 - 2005 ОН: СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТӨВҮҮД**

2000- 2005 онд ХИС үйл ажиллагаагаа Ховд, Дорнод, Баян-Өлгий, Баянхонгор, Дундговь аймаг, Улаанбаатар хотын зарим дүүрэгт төвлөрүүлж, хүүхэд төвтэй арга зүйг нэвтрүүлэх, хүүхдийн сурч хөгжих нөхцөлийг сайжруулахад анхаарч, дөрвөн аймгийн Боловсрол, соёлын газар дээр СӨБ-ын төвийг нээн, хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохирсон тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан юм.



■ Хүүхдийг Ивээх Сангийн дэмжлэгтэйгээр сургуулийн өмнөх боловсролын сургалтын материал, хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон тоглоом болон бусад сурах хэрэгслийн хангамж сайжирлаа. 2007 он

## **2000 - 2010 ОН: ХУВИЛБАРТ СУРГАЛТ**

ХИС орон нутагт СӨБ -ын хувилбарт сургалтуудыг дэмжин ажилласнаар зөвхөн 2004 онд гэхэд 5200 хүүхэд уг сургалтад хамрагджээ. Хувилбарт сургалтын чанарыг сайжруулах зорилгоор “Гэр цэцэрлэг”-ийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, холимог бүлгийн сургалтын болон явуулын багшийн сургалтын хөтөлбөрийг боловсруулжээ.

ХИС-гаас санаачилсан явуулын Гэр цэцэрлэгийн загвар нь Монгол Улсын боловсролын тогтолцооны салшгүй хэсэг, үндэсний хэмжээний хөтөлбөр болж, алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдийн гуравны нэгээс илүүд хүрч, СӨБ олгох “хувилбарт сургалт”-ын үйлчилгээ бий болов.

## **2011 - 2014 ОН: “ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЦЭЦЭРЛЭГ”**

2011 оноос ХИС улсын цэцэрлэгийн тогтолцоонд бага насны хүүхдийн халамж, хөгжлийн цогц үйлчилгээг эцэг эхийн оролцоотойгоор хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Энэхүү санаачилгын хүрээнд хэрэгжсэн хоёр том төслийн нэг нь Япон улсын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төсөл юм.

**25 дэвшил: №16**

**“Хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-ийн загварыг Монгол Улсад шинээр танилцуулав.**



■ Япон улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр хэрэгжсэн “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төсөл (2011-2014)-ийн оролцогч талууд 2014 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо тус төсөлд эцсийн үнэлгээ өгч төслийн хаалтыг хийв. Улаанбаатар хот, 2014 оны 5 дугаар сар

Энэхүү төслийн үр дүнд “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-ийн үзэл баримтлал, үнэлгээний аргачлалыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бодлого, эрх зүйн орчин бүрдсэн билээ.

ХИС 2011-2013 онд МУБИС-ийн СӨБ-ын сургууль, Сэтгэл судлалын тэнхим, “Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг”, “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төв” зэрэг байгууллагуудтай хамтран, цэцэрлэгийн багш, туслах багш, эмч, эрхлэгч, арга зүйч нарыг мэргэжил дээшлүүлэх, давтан сургах 7 модулийг “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-ийн аргачлал дээр үндэслэн боловсруулж, гарын авлага гаргасан.

Хүүхдийн эрхэд суурилсан эдгээр сургалт болон арга зүй нь хүүхдийн эрүүл хооллолт, хөгжил, оролцоонд анхаарч, хүүхдийг учирч болзошгүй аливаа хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөгжлийн үе шатад тулгуурлан суралцах боломжоор хангаж, бие даах чадвар, өөртөө итгэх итгэл, үр дүнг хөхиүлэн дэмжиж, хүүхдийн цогц хөгжлийг хангахад чиглэдэг.<sup>1</sup> Дээрх 7 модулийг БШУЯ магадлан итгэмжилж, 3 нь үндэсний хэмжээний мэргэжлийн СӨБ-ын давтан сургалтын хөтөлбөрт орсон билээ.

### 2012-2014 ОНД УЛААНБААТАР ХОТЫН ЧИНГЭЛТЭЙ, ХАН-УУЛ, СОНГИНОХАЙРХАН, БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 58 ЦЭЦЭРЛЭГИЙГ ХАМРУУЛСАН УГ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД:



1,318 багш, ажилтныг мэргэжил дээшлүүлэх болон мэргэжлийн давтан сургалтад хамруулав.



38 цэцэрлэг хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн шалгуур үзүүлэлтийн дагуу байгууллагын өөрийн үнэлгээ, дотоод хяналтыг хийж хэвшлээ.



Зорилтот бүх цэцэрлэгт хүүхэд, багш, эцэг эхийн боловсролыг дэмжих номын сангууд тогтвортой ажиллаж байна.



Төслийн үр дүнд сонгосон цэцэрлэгүүдийн ойр орчмын автозам дээр “Цэцэрлэг” гэсэн анхааруулах тэмдэг, хурд сааруулагч, гэрлэн дохио байршуулж, хүүхдийг аюулаас урьдчилан сэргийлэх тодорхой ажлуудыг хийсэн юм. Түүнчлэн “Аюулгүйн дүрэм” боловсруулж, орчныхоо аюулгүйн зураглалыг жил бүр шинэчилж байхаар дүрэмдээ тусгасан цэцэрлэгүүдийн сайн туршлага бий болсон юм.

1 “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төслийн баримт бичиг, Хүүхдийг Ивээх Сан



## Гэр бүлд түшиглэн хүүхдийг сургуульд бэлтгэх сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэв.

### 2012 - 2017 ОН: “БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ГЭР БҮЛИЙН ОРЧИНД ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР”

ХИС Дэлхийн Банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн хөгжлийн сангийн 2,5 сая ам.долларын санхүүжилтээр “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийг хэрэгжүүлсэн юм. Дэлхийн Банкны түүхэнд анх удаа олон улсын байгууллагад шууд санхүүжилт өгч, хэрэгжүүлсэн энэ төсөлд 4 аймгийн 30 сум хамрагдав. Энэ төслийн хүрээнд СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдэд чиглэсэн “Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр”-ийг Монголд анх удаа боловсруулан туршсан юм. 120 өдрийн энэхүү хөтөлбөр алслагдсан хөдөөгийн 5-6 насны хүүхдүүдийн сурах сонирхлыг өдөөж, сургуульд амжилттай бэлтгэх, сургууль завсардахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн. Энэхүү өвөрмөц хөтөлбөрийг явуулын “Ном, тоглоомын багц”-аар дамжуулан хүүхдийг хөгжүүлэх шинэлэг аргазүйгээр хэрэгжүүлсэн юм. Хөтөлбөрийг тусгайлан боловсруулсан гарын авлагын дагуу эцэг эх биечлэн гүйцэтгэж, сумын сургуулийн номын санч, аргазүйч нар туслан дэмжих үүрэгтэй оролцдог нь хүүхдийн боловсролд бүх талын оролцоог хангаснаараа онцлог юм. Уг хөтөлбөрийн үр дүнд Архангай, Дорнод, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн алслагдсан 30 сумын 5-6 насны 1,545 хүүхэд сургуульд амжилттай бэлтгэгдсэн билээ.

Нийт 8,000 гаруй хүүхдэд үр өгөөжөө өгсөн энэ төсөлд нийт 20,000 багш, эцэг эх, албан хаагч оролцсон. Өнөөг хүртэл МУБИС СӨБ-ын багш бэлтгэх сургалтын агуулгадаа уг хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх арга зүйн талаар оруулан багш болохоор бэлтгэгдэж буй оюутнуудад зааж байна.

■ Эмээ, 5 настай ач хүүгээ сургуулийн бэлтгэл хангахад туслаж байна. Хотонт сум, Архангай аймаг, 2014 он



“Одоо би 4 дэх багцаа үзэж байгаа. Би Балхүүгийн цувралд дуртай. 5 бас 10 дахь багцууд их гоё гэж сонссон. Тэр багцаас би өнгө ялгаж сурна, тоо бодож сурна.

Шинэ багц аваад гэртээ хичээл хийх ёстой гоё. Багц авдаг болсноос хойш би зурах дуртай болсон. Номоо харж байгаад аав, ээждээ утгыг нь ярьж өгдөг. Би сургуульд ороод заавал онц сурна.”

Б.Бямба-Очир (5 настай, хүү)

## НОМ, ТОГЛООМЫН БАГЦ

Энэ бол хүүхэд төвтэй сургалтын аргазүйд тулгуурласан цоо шинэ аргачлал юм. Хүүхдийг хөгжүүлэх, тэдний суралцах сэдэл, тэмүүллийг бадраах, чадвар чадамж, өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэх зорилготой ном, тоглоомын багцад хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон 105 нэр төрлийн ном, 35 төрлийн тоглоом орно.

“Миний номын өргөө” нэртэй ном, тоглоомын багц дотроо 10 багцтай, нэг зэрэг 30 хүүхэд 10-14 хоногийн хугацаатай гэртээ хэрэглэдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 180 багцыг бэлтгэж, зорилтот сум бүрд 6 тусгай багцыг хүргэснээр хараа, сонсгол, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд 36 ном, 34 тоглоомоор гэртээ хичээллэх боломж бүрдсэн юм.

Хөтөлбөрийн аргачлалыг ХИС үндэсний мэргэжилтнүүдийн туслалцаатай боловсруулж, орон нутгийн боловсролын мэргэжилтнүүд хэрэгжүүлсэн.



■ Ном тоглоомын багц



*ХИС доноруудын дэмжлэгтэйгээр олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг болохоор өөрийн гэсэн худалдан авалтын нарийн бодлого, санхүүгийн журамтай. Төсөл хөтөлбөрийн хурал, уулзалт, сургалт, семинар, сургалтын хэрэглэгдэхүүний худалдан авалтыг хийхдээ бидний баримталдаг зарчим бол донорын өгч байгаа санхүүжилтээр зорилтот бүлгийнхээ хэрэгцээнд тохирсон, хамгийн сайн чанарын бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн боломжийн үнээр худалдан авах юм.*

*“Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр”-өөр тараасан ном, тоглоомын багцыг сонгохын тулд БСШУЯ дээр комисс байгуулагдсан. Хүүхдүүдэд тараах номыг яамнаас гаргасан заавал унших номын жагсаалтаас шүүн сонгож, худалдан авч цэцэрлэгийн багш нарт уншуулж, тоглоомуудаар тоглуулж үзээд, 10 суманд туршилтын байдлаар тарааж, санал авсан. Ирүүлсэн саналын үндсэн дээр багцын сонголтыг сайжруулж, зорилтот 30 сумандаа авч өгсөн.*

*Тоглоомын багцад тусгай 29 дүгээр сургуулийн багш нарын хийсэн модон тоглоомыг оруулсан нь тун онцлог байсан.*

*ХИС-гийн Худалдан авалт хариуцсан мэргэжилтэн О.Наран*



■ “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслөөс боловсруулсан ном, тоглоомын багц хөтөлбөрөөр сургуульд ороход бэлтгэгдсэн сурагч О дөрөвдэх жилдээ онц сурч байна. Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум, 2020 он



“Манайх ам бүл долуулаа. Аав, ээж хоёр маань мал малладаг. Манай гэр сумын төвөөс хол болохоор ах, эгч нар маань цэцэрлэгт явж үзэлгүй сургуульд шууд орж байсан. Харин би их азтай. Сургуульд орохоос өмнө би гэртээ ном, тоглоомын багцаас олон зүйл сурсан. Дотроо зөндөө олон үлгэрийн ном, буддаг ном, янз бүрийн тоглоомтой гоё хайрцгийг би сайн санадаг. Аав, ээж маань дасгалаа хийхэд тусалдаг, бас өөр багцаар сольж өгдөг байсан. Би сургуульдаа сайн уншиж сураад орсон. Одоо би дөрөвдүгээр ангид суралцдаг. Би хичээлдээ явах үнэхээр дуртай. Миний мөрөөдөл бол том болоод сайн эмч болж, хүн ардыг эмчлэх. Бас ээж, аавдаа тус болно.”

О, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагч



“Миний дунд охин О энэ ном, тоглоомын багцаар суралцаж, нэгдүгээр ангидаа их сайн бэлдээд орж байсан. Онц сурсан гээд сүүлийн гурван шинэ жилээр өвлийн өвгөнөөс бэлэг авсан. Би охиныхоо сурлагын амжилтаар маш их бахархдаг. Манайхны дундаас анх удаа амжилттай сурч, намайг баярлуулж байгаа хүн дээ. Бидэн шиг төвөөс 50-60 километр хол нутагладаг малчин хүмүүс тэр бүр хүүхдээ цэцэрлэгт зөөж чадахгүй шүү дээ. Үр хүүхдэд минь ийм сайхан боломж олгосон та бүхэнд их баярлаж явдаг шүү. Одоо энэ төсөл дууссан ч багц нь суман дээр байна гээд манай эхнэр гуйгаад аваад ирсэн. Одоо бид хоёр бага охиноо сургаж байна.”

О-гийн аав малчин Б, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум, 2020 он







■ “Бага насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих нь” Үндэсний чуулган, 2015 оны 5 дугаар сар, Дорнод аймаг, Чойбалсан хот



### “БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ГЭР БҮЛИЙН ОРЧИНД ДЭМЖИХ НЬ” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН

“Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд ХИС БСШУЯ-тай хамтран 2015 оны 5-р сарын 5-8-нд төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагууд, бүх аймаг, зорилтот 30 сумын төлөөлөл 110 хүн оролцсон үндэсний чуулганыг Дорнод аймгийн төвд зохион байгуулсан. Чуулганаас гэр бүлийн орчинд хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эх, асран хамгаалагчийн чадварыг дээшлүүлэх, энэ чиглэлээр хийж буй үйл ажиллагааны сайн туршлагаас суралцах, төслийн санаачилгыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, хууль, эрх зүйн орчныг шинэчлэх арга замыг тодорхойлох, зөвлөмж боловсруулах зэрэг хэд хэдэн томоохон зорилгыг дэвшүүлээ.



### “ГЭР БҮЛИЙН ОРЧИНД СУРГУУЛЬД БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРИЙН САЙН ТУРШЛАГЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ НЬ” ҮНДЭСНИЙ СУРГАЛТ

Уг сургалтыг ХИС-гаас санаачлан бүх аймгийн Боловсрол, соёлын газар (БСГ)-ын Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ) хариуцсан арга зүйч нарт зориулан БСШУЯ-тай хамтран Улаанбаатар хотод 2015 оны 12-р сарын 9-10-нд зохион байгуулсан. Сургалтад нийт 44 мэргэжилтэн оролцсон ба төслийн санаачилга, сайн туршлагыг өөр өөрийн аймагт түгээн дэлгэрүүлэхэд дэмжин ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлжээ.



### “ДАСГАЛ АЖЛЫН ДЭВТЭР”

“Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд ХИС-гаас БСШУЯ-тай хамтран “Дасгал ажлын дэвтэр”-ийг боловсруулж, хөтөлбөрт хамрагдсан 5 настай бүх хүүхдэд хүргүүлсэн.

ХИС-гаас санаачилсан энэхүү ажлын үр дүнд 2018 онд БСШУС-ын сайд А/487 тоот тушаал гаргаж, “Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан юм.

## 2. БАГА БОЛОВСРОЛ

25 дэвшил: №18

### Нэгдүгээр ангийн хүүхдүүдийг дэмжих, бага боловсролыг нөхөн олгох загвар туршлагыг бий болгов.

#### 2003 - 2006 ОН: “МАЛЧИН ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ” ТӨСӨЛ

2003 онд ХИС Дорнод аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран малчин хүүхдүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулснаар тус аймагт 2003- 2006 онд хэрэгжсэн “Малчин хүүхдийн боловсрол” төслийн эхлэл тавигджээ. Уулзалтад амьдралын эрхээр айлын мал маллаж, ам бүлийнхээ амьжиргаанд нэмэр болдог малчин хүүхдүүд оролцож, тэдний дунд бага ангиас завсардсан, сургуульд огт явж үзээгүй хүүхэд олон байсан нь зохион байгуулагчдын анхаарлыг нэн татжээ. Тэдгээр хүүхдүүдийн санал хүсэлт дээр үндэслэн ХИС хамгийн олон хүүхэд сургуулиас завсардсан Дорнод аймгийн Цагаан-Овоо, Матад суманд Европын Холбооны санхүүжилтээр “Малчин хүүхдийн боловсрол” төслийг хэрэгжүүлж, сурагчдын улирлын амралтын үеэр суларсан анги танхим болон дотуур байрыг ашиглан, 10 хоногийн албан бус боловсролын сургалтыг 3 шатлалтайгаар зохион байгуулсан юм.

#### 2006 - 2009 ОН: “СУРГУУЛИЙН ӨМНӨХ БА БАГА БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

2005- 2006 оны хичээлийн жилээс эхлэн сургуульд суралцах насыг хоёр үе шаттай бууруулснаар 2008-2009 оны хичээлийн жилээс Монгол Улсын ерөнхий боловсролын тогтолцоо 12 жилийн сургалтад шилжсэн билээ. Сургуульд элсэн сурах нас 6 болсон нь эцэг эх, цэцэрлэгийн болон бага ангийн багш нараас шинэ үүрэг хариуцлага, ур чадварыг шаардав.

ХИС-гийн “Сургуулийн өмнөх ба Бага боловсролын чанарыг сайжруулах төсөл” Монгол Улс ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоонд шилжих үетэй давхцан амжилттай хэрэгжсэн.



*“Сургалт эхлэхийн өмнө ХИС болон орон нутгийн засаг захиргааны хамтарсан урилгыг сургалтын хөтөлбөртэй цуг хүүхэд бүрд хүргүүлсэн. Уригдсан хүүхдүүдийн 90 хувь нь эхний сургалтад хүрэлцэн ирснийг харахад үнэхээр сайхан байсан. Сургалтад хамрагдах хугацаанд нь хүүхдүүдийг Сумын Засаг дарга хүлээн авч, сумын хэмжээнд ажиллаж байгаа бүх байгууллагын ажилтай танилцуулж, тэдний сонирхлыг татсан уралдаан тэмцээн зохиосон.*

*Үе тэнгийн сургагч бэлтгэх ажлаа ч бид давхар хийж байлаа. Эхний жилийн туршлага дээр үндэслэн 2004- 2006 онд орон нутгийн боловсролын байгууллагууд төслийн үйл ажиллагааг нийт 7 суманд өргөжүүлэн хэрэгжүүлсэн юм.*

*Эдгээр сургалтын үр дүнд сургуулиас завсардсан болон огт сургуульд сурч байгаагүй 400 гаруй малчин хүүхэд суурь боловсролтой болж, дийлэнх нь албан бус боловсролын сургалтаас ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцсан юм. Энэ төсөл нь эдгээр хүүхдүүдийн сурч, боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлсэн төдийгүй сургуулийн гадна үлдсэн хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэхэд орон нутаг, сургуулийн удирдлагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж чадсан билээ”.*

*Б.Эрдэнэчимэг, ХИС-гийн Дорнод аймаг дахь орон нутгийн салбарын зохицуулагч (2003- 2007)*



■ Европын Холбооны Комиссын санхүүжилттэй “Сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах нь” багц төслийн хүрээнд хөдөө орон нутагт ажиллах “гэр цэцэрлэг”-үүдэд гэр олгож мөн хот, хөдөөгийн нийт 71 цэцэрлэгт 84 сая төгрөгийн тоглоом наадгайг хүлээлгэн өгсөн.

Европын Холбооны 1,3 сая еврогийн санхүүжилттэй энэхүү төсөл дотроо 12 дэд төсөлтэй, тэдгээрийн 3 нь үндэсний хэмжээний, 2 нь БСШУЯ-тай хамтарсан төсөл байлаа.

- “Чанартай суурь боловсрол” дэд төсөл нь боловсролын салбарын шинэчлэлийг дэмжин, сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах, ялангуяа эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, эцэг эх, олон нийт, иргэний нийгмийн оролцоог боловсролын үйлчилгээ, менежментэд нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв.
- Баянхонгор, Завхан, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар аймаг, Улаанбаатар хотын Чингэлтэй, Хан-Уул дүүргийн цэцэрлэг, сургуулийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ үндэсний түвшинд боловсролын төлөвлөлт, удирдлагын чадавхыг бэхжүүлэх ажлыг дэмжин ажиллав.
- Төслийн хүрээнд СӨБ-ын явуулын багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулан, 2 жилийн хугацаанд хөдөөгийн малчдын 3, 4, 5 настай 2000 хүүхдэд СӨБ олгон, бага сургуульд амжилттай суралцах суурийг нь тавьсан билээ.
- СӨБ болон бага боловсролын залгамж холбоо, I ба II ангийн сурах бичгийн үнэлгээ, хүүхэд төвтэй заах арга зүйн асуудлуудад тусгайлан анхаарсан судалгааны ажлуудыг ХИС-гаас санаачлан хийлгэсэн нь сургуулийн өмнөх болон бага боловсролын бодлогыг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулсан юм.
- Төслийн хүрээнд нийт 131,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон тоглоом, сургалтын хэрэгсэл авахад зориулснаар 7000 гаруй хүүхдэд үйлчилдэг 96 цэцэрлэгийн сурах орчин сайжирсан.





## 2012 - 2017 ОН: “АЛСЛАГДСАН ХӨДӨӨГИЙН МАЛЧДЫН ХҮҮХДҮҮДИЙН БАГА БОЛОВСРОЛЫН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

Боловсролын тогтолцооны өөрчлөлтөөр хүүхдүүд 6 настайдаа сургуульд элсэх болсон нь хөдөөгийн малчин гэр бүлүүдэд шинэ бэрхшээлийг дагуулсан юм. Алслагдсан хөдөө нутагт 6 настай хүүхдүүдийн дийлэнх нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдалгүйгээр шууд сургуульд элссэн нь сурлагын ахиц гараагүйд нөлөөлсөн байдаг.<sup>1</sup> Түүнчлэн бага насны хүүхдүүд гэр бүлээсээ хол амьдрах болсноор зохистой асаргаа, халамж авч чадахгүйд хүрч, нийгэмшихүйн болон сэтгэлзүйн бэрхшээлтэй тулгарсан билээ.

Дэлхийн Банкны санхүүжилттэй төслийн өөр нэгэн зорилго нь эмзэг бүлгийн болон малчин өрхийн хүүхдүүдэд бага боловсролыг нөхөн олгох, хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр, зайны сургалтын хөтөлбөрийн хүртээмж, чанар, менежментийг сайжруулахад оршиж байв.



<sup>1</sup> Хүүхдийг Ивээх Сан, Дэлхийн Банкны Японы Нийгмийн хөгжлийн сангийн төслийн баримт бичиг, 2010

Энэхүү зорилгын хүрээнд сургууль завсардах эрсдэл өндөртэй, завсардсан хүүхдүүдийн боловсролд анхаарч бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг хэрэгжүүлсэн юм.

Бага ангиас сургууль завсардсан хүүхдэд гэрээр Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн агуулга нь БШУЯ-ны бага боловсролын албан ёсны хөтөлбөрт суурилсан бөгөөд 1-3 дугаар ангийн хүүхдүүдэд зориулсан тоо болон монгол хэлний 18 модулиас бүрддэг. Мөн хүүхэд болон эцэг эхэд ойлгомжтой, хэрэглэхэд хялбар төдийгүй сурах бичиг, дасгалын ном, аудио-видео материал, эцэг эхийн гарын авлага бүхий сургалтын иж бүрэн материалтай.





## “ХИЧЭЭЛИЙН БУС ЦАГИЙН НЭМЭЛТ ХӨТӨЛБӨР”

Энэ нь “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийн хүрээнд хэрэгжүүлсэн өөр нэг хөтөлбөр юм. ХИС 2013 оноос уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ гэр бүлээсээ тусдаа, айлд болон сургуулийн дотуур байранд амьдарч буй 6-10 насны хүүхдүүдийн суралцах чадварыг сайжруулж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэхийг зорьсон юм.

Дэлхийн Банкны дэмжсэн уг төслийн хүрээнд 4 аймгийн зорилтот 30 сумын сургуулийн дотуур байрыг түшиглэн Хүүхэд хөгжлийн танхимуудыг байгуулж, хүүхдүүдийн сурлагад ахиц гаргахад туслах, чөлөөт цагийг идэвхтэй өнгөрөөх ая тухтай орчинг бүрдүүлж өгсөн.

Хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, бусадтай харилцах чадвар, хувийн зохион байгуулалт сайжирч, бусад хүүхдүүддээ туслах, ариун цэврийн дадалд суралцах гэх мэт олон эерэг өөрчлөлт гарчээ.

Төсөл хэрэгжиж дуусах үед буюу 2017 оны байдлаар нийт 3,808 хүүхэд Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрт хамрагдсан байна.



*“Би хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр”-т хамрагдсанаар машин хийж, шүлэг бичиж, зураг зурж, өөрийгөө танилцуулж, санал бодлоо илэрхийлж сурсан. “Хүүхэд хөгжлийн танхим”-д бид сэтгэгдлээ бичицгээдэг. Энэ үед би юу сурснаа, бусдад яаж тусалснаа бичдэг. Бичсэн сэтгэгдлээ хүүхдүүдийн өмнө заримдаа би, заримдаа багш уншиж өгдөг. Манай багш бусадтай харилцахдаа их тэвчээртэй, тэднийг сайн сонсдог байх хэрэгтэй гэж заадаг.*

*Хөтөлбөрт хамтрагдахаас өмнө би хүүхдүүдтэй дандаа зодолддог байсан бол одоо олон найзтай болсон. Хичээлийн хоёрдугаар улиралд би Монгол хэлэндээ 75 хувьтай байсан бол хичээлийн жилийн төгсгөлд 85%, математиктаа 90% болж өссөн.”*

*Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын сургуулийн  
4-р ангийн сурагч Б.Базардарь*

■ Архангай аймгийн Хотонт сумын сургуулийн дотуур байранд амьдарч буй хүүхдүүд хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрт хамрагдаж байгаа нь. 2014 оны 5 дугаар сар







## “ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРАНД АМЬДАРЧ БУЙ БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ҮНДЭСНИЙ СУРГАЛТ

Дотуур байранд амьдарч буй бага насны хүүхдүүдэд хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн арга, хуримтлуулсан туршлагадаа тулгуурлан ХИС “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч буй бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” сэдэвт үндэсний сургалтыг БСШУЯ-тай хамтран 2015 оны 1-р сарын 28-30-нд Улаанбаатар хотод зохион байгуулсан.

Сургалтад аймаг бүрээс бага анги болон дотуур байр хариуцсан арга зүйч, мэргэжилтэн нийт 39 хүн оролцож, “Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр”-ийг өөр өөрийн аймагт дэмжин ажиллах үүрэг хүлээжээ. Түүнчлэн уг хөтөлбөрийн гарын авлагыг Монгол Улсын бүх аймаг, сумдад хүргүүлсэн болно.

ХИС энэхүү шинэлэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ Олон нийтийн боловсролын зөвлөлүүдийг (ОНБЗ) байгуулан тэдгээрээр дамжуулан боловсрол дахь орон нутаг, олон нийтийн оролцоог нэмэгдүүлсэн юм. (ОНБЗ-ийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Боловсрол дахь олон нийтийн оролцоо” хэсгээс авна уу.)



“2013 онд нийгмийн ажилтан, дотуур байрын багш багийн айлуудаар явж байгаад манайхаар ирсэн. Аавыг охиныгоо сургуульд суулгаач гэжэд би маргаашаас нь л сургуульд орж, дотуур байранд суух болсон. Дотуур байр гоё, одоо улам гоё болж, олон тоглоом, номтой болсон учраас би байрандаа байх дуртай. Одоо би минутад 24 үг уншиж, 20-ын дотор нэмж хасаж чадна, 5 шүлэг мэднэ, Төрийн дууллаа бас мэднэ. Ангидаа дотнын 3, байрандаа бас дотны 3 найзтай болсон. Бусад хүүхдүүд ч гэсэн миний найзууд. Хүүхэд хөгжлийн танхимд байгаа тоглоомуудыг тоглож сурсан. Тэр дундаа би хоёр төрлийн рубик шоог 20 секундэд эвлүүлж сурсан. Үлгэрийн ном, сургамжит өгүүллэгүүдийг уншсан. Даам, өнгө шахах, загас шүүрэх зэрэг олон тоглоомыг төвөггүй тоглож чадна. Би сургуульд эргэж ирсэндээ баяртай байна. Намайг сургуульд суулгасан багш нартаа, аавдаа, ээждээ баярлалаа. Бас төслийн хүмүүст баярлалаа.”

Г.Оюунцэцэг (Сүхбаатар аймаг,  
Уулбаян сум)



### **2015 - 2018 ОН: “НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХЭД ЧИГЛЭСЭН СУРГУУЛИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ**

Нэгдүгээр ангийн сурагчид, ялангуяа СӨБ-д хамрагдалгүй сургуульд элсэн орсон, нийслэлийн захын хороололд хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн сургуульд дасан зохицох, суралцах чадвартай холбоотой бэрхшээлүүдэд үндэслэсэн энэхүү төслийг Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчийн сургуулиудад хэрэгжүүлсэн юм.

Япон улсын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй уг төсөл нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэх, сургуулийн чадавхыг бэхжүүлэхэд анхаарч, цогц үйл ажиллагаа хэрэгжүүлснээр ерөнхий боловсролын сургуулиудад загвар туршлагыг бий болгосон. Үүнд, багшийн арга зүйг сайжруулах, нэгдүгээр ангийнханд чиглэсэн сургуулийн бодлогыг боловсруулах, багш, сургууль, эцэг эх хоорондын харилцаа, хамтын ажиллагаанд “Харилцах дэвтэр” зэрэг шинэлэг арга зүйг нэвтрүүлэх, олон нийтийн оролцоог хангах талаар сургалт, сурталчилгааны олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн юм.





Түүнчлэн үндэсний түвшинд бодлого боловсруулагчидтай хамтран ажилласны үр дүнд “Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийн дасгалын ном”-ыг сайжруулан, тухайн мэдээллийг ЕБС-д үзэх сурах бичгийн жагсаалтад орууллаа.

Мөн хүүхдийн хөгжлийн мэдээллийг цуглуулж, сургалтын үйл ажиллагаанд ашиглах зааварчилгааг боловсруулан боловсролын мэдээллийн санд хүүхдийн хөгжлийн ахицын талаарх тодорхой асуултуудыг нэмж оруулсан юм.

Багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт, нэгдүгээр ангийн хүүхдүүдэд багшийн зүгээс үзүүлэх дэмжлэг, энэхүү чиглэлээр багшийн ур чадвар, арга зүйг сайжруулах агуулгыг тусгасан.



*“Багш нарын хичээлд сууж байхад болон сургалтад оролцож байгаа багш нартай ярилцаж үзэхэд багш нар хичээл заах олон шинэ аргад суралцсан байна.*

*Төслийн сургалтууд 1-т багшийн хандлагыг өөрчилж, 2-т сургуулийн менежер, бусад ажилтнууд болон эцэг эхийн нэгдүгээр ангийнханд тавих анхаарал халамжийг нэмэгдүүлж, 3-т сургуулийн орчинд эерэг өөрчлөлт авчирч, 4-т эцэг эхчүүдэд өгөх мэдээлэл, сургалтыг сайжруулсан.”*

*Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Ж. Байгаль*



*“Төслийн санааг ойлгоход анхандаа жаахан хүндрэлтэй санагдаж байсан. Харин төслийн уулзалт, сургалтуудад оролцох явцдаа төслийн ач холбогдлыг илүү ойлгосон бөгөөд надад 2008 онд анх нэгдүгээр ангид 6 настай хүүхдүүдийг авч эхэлсэн үе өөрийн эрхгүй эргэн санагдлаа. Тэр үед бид одоо энэ төслийн гол санаа болох нэгдүгээр ангийнхныг дэмжих талаар бараг ойлголцгүй байжээ.*

*Хүүхдийн талаарх мэдээллийг цуглуулах, ашиглах аргазүй нь маш үр дүнтэй, хэрэгтэй бөгөөд хүүхдийн хөгжил, эрүүл мэндийн гэх мэтчилэн 17 төрлийн мэдээлэл цуглуулдаг юм байна. Энэ аргазүйг бид юун түүрүүнд ажилдаа хэрэгжүүлнэ гэж төлөвлөөд байна. Одоогийн байдлаар нэгдүгээр ангид суралцагсдын цусны бүлгийн талаар мэдээллийг эцэг эхийн оролцоотойгоор цуглуулаад байна. Мөн манай сургуульд 5-р ангийнхан 1-р ангийн дүү нартаа хөтөч хийж тусалж байгааг харахад сайхан байна.*

*Баянзүрх дүүргийн 87-р сургуулийн Бага ангийн сургалтын менежер Ж. Гантуяа*



### 3. СУУРЬ БОЛОВСРОЛ

Энэ хүрээнд ХИС оролцоонд тулгуурласан боловсрол нөхөн олгох хөтөлбөрүүдээр дамжуулан эмзэг бүлгийн болон сургууль завсардсан хүүхдүүдийн сургалтын үр дүнг дээшлүүлэх, сургуулийн болон дотуур байрны хүүхэд амьдрах орчинг сайжруулснаар аюулгүй байдлыг хангах, үр дүнтэй сургалт, олон нийтийн оролцоог бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй болон үндэстний цөөнхийн хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах сургалтын хөтөлбөр болон чанарыг дээшлүүлэх, загвар хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, нөлөөлөх замаар үндэстний болон орон нутгийн түвшинд суурь боловсролын бодлогыг сайжруулахад анхаарч байна.



**25 дэвшил: №19**

**Тусгай хэрэгцээтэй хүүхдийн боловсрол эзэмших эрхийг дэмжин, тэгш хамруулах боловсролын үзэл санааг Монголд түгээн дэлгэрүүлэв.**

#### **ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ**

ХИС тэгш хамруулан сургах боловсролын тухай үзэл баримтлалыг Монгол Улсад эрчимтэй түгээн дэлгэрүүлж, энэхүү ойлголтыг боловсролын салбарын мэргэжилтнүүдэд хүргэж, бодлогын түвшинд дэмжлэг үзүүлж, багш, сургуулийн удирдлага, эцэг эх, олон нийтэд нөлөөлсөөр байна.

1997 оны байдлаар Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох 2 тусгай цэцэрлэг, 5 тусгай сургууль үйл ажиллагаа явуулж байсныг эс тооцвол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагдах боломж хязгаарлагдмал байлаа.

Анх ХИС 1998 онд Архангай, Булган аймаг, Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг СӨБ-д хамруулах туршилтын төсөл хэрэгжүүлсэн юм.



■ БСШУЯ, Хүүхдийг Ивээх Сангаас хамтран зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах бодлого” олон улсын семинар. Улаанбаатар хот, 2003 он



■ “Тэгш хамрах боловсрол” сургалтад Хөвсгөл, Дорнод, Завхан, Сэлэнгэ аймгуудаас нийт 120 хүн оролцсон юм. 2008 он

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИС-ГААС ХИЙСЭН ГОЛ АЖЛУУД НЬ:



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлсэн нь эцэг эхчүүд, орон нутгийн хүмүүс болон сургууль, цэцэрлэгүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхдаг үзэгдлийг бууруулахад нөлөөлсөн.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих, нийгэмшүүлэх нөхөн сэргээх төвүүдийг байгуулж, олон нийтэд суурилсан нөхөн сэргээх үйлчилгээг бий болгохын сацуу хууль эрхзүйн болон бодлогын шинэчлэл хийхэд чиглэж байлаа.



Багшлах боловсон хүчнийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга барилд сурган бэлтгэлээ.

ХИС-гийн тусламжтайгаар холбогдох байгууллага, мэргэжилтнүүд, эцэг эхчүүдийг бусад орны туршлагаас суралцах аялал, олон улсын семинарт оролцох боломжоор хангасан юм. Мөн цэцэрлэгийн багш, эрхлэгч нарт зориулсан сургалтуудыг үе шаттай явуулсны зэрэгцээ ном, гарын авлага, сургалтын загваруудыг бий болгох, дэлгэрүүлэх ажлуудыг дэмжин ажилласан билээ.

2002-2006 онд ХИС-гийн дэмжлэгтэйгээр боловсролын үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 1,000-аас 8,000 болтлоо өссөн юм. Улсын хэмжээнд 69 сургууль, 13 цэцэрлэгийн хаалга, шатыг тэргэнцэртэй хүүхэд орох, гарахад тохиромжтой болгон засварлах ажлыг ХИС төслүүдийнхээ хүрээнд дэмжсэн юм.

ХИС-гийн арга зүй, санхүүгийн тусламжтайгаар БСШУЯ-нд “Тэгш хамруулах боловсролын нэгж”-ийг байгуулсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжих бодлогыг тодруулах, холбогдох баримт бичигт тусгах, Засгийн газрын бодлогод нөлөөлөх боломжийг нэмэгдүүлсэн юм.

## **2002 - 2008 ОН: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН НӨХӨН СЭРГЭЭХ ТӨВҮҮД**

ХИС олон улсын болон орон нутгийн санхүүгийн нөөцийг дайчлах замаар нийт 14 цэцэрлэгийн барилгыг шинээр барьж, олон нийтийн оролцоонд суурилсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төвийг Дорнод, Ховд, Баянхонгор, Баян-Өлгий аймаг болон Улаанбаатар хотод байгуулсан.

ХИС хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ СӨБ-ын сургууль, Удирдлагын хөгжлийн академи, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, ХБХЭЭХ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийттэй нягт хамтран ажилласан юм.

2003 оны 12-р сард “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр” батлагдсанаар энэ асуудал Засгийн газрын албан ёсны бодлого болсон.



*“2003 оны үед Дорнод аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх статистикийн найдвартай тоо баримт байхгүй байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн оролцоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг олж тогтоох, мэдээлэл цуглуулах ажлыг ХИС эхэлж, зөвхөн аймгийн төвд 900 гаруй хүүхэд байгааг тогтоосон нь эдгээр хүүхдүүдэд зориулсан нөхөн сэргээх үйлчилгээний асар их хэрэгцээ байгааг харуулсан юм.*

*ХИС болон орон нутгийн засаг захиргаа, эцэг эхчүүдийн хичээл зүтгэл, хүчин чармайлтын үндсэн дээр бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нөхөн сэргээх төвийг 2003 оны 5-р сард ашиглалтад орууллаа. ХБХЭЭХ энэ төв дээр байрлах болсноор хүүхдүүд тэдний эцэг эх, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй ойр ажиллах боломж нэмэгдлээ.*

*Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийг эмчилгээ, үйлчилгээнд хамруулж эхэлснээс хойш хагас жилийн дараагаас эхний үр дүнгүүд гарч эхэллээ. Огт явж чаддаггүй, хайрцагт суудаг байсан гурван настай хүүхэд анх удаагаа алхлаа. Тус төвөөр зөвхөн аймгийн төвийн төдийгүй сумын хүүхдүүд ч ирж үйлчлүүлдэг боллоо. Хүүхдээ авчирч төвийн үйлчилгээнд хамруулах боломжгүй айлын хүүхдүүдэд хүрч үйлчлэх “гэрийн сургагч” нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ээж нарын дундаас бэлтгэлээ. Сургагчаар бэлтгэгдсэн 15 ээж, нөхөн сэргээх төвийн эмч, сувилагч нартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айлуудаар явж, гэрийн нөхцөлд хүүхдээ хэрхэн асарч сувилах, нөхөн сэргээх дасгалыг хэрхэн хийх аргуудыг эцэг эхчүүдэд зааж зөвлөж эхэллээ.*

*Энэ ажлын сургаар сургуульд явах боломжгүй оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд бидэнд хандаж хүүхдүүдээ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг хүссэн юм. Бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байсан туршлагатай 5 багшийг сонгон “Гэрийн багш” болгон бэлтгэсэн юм. Багш нар маань гэртээ байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн гэрээр нь очиж, хүүхэд нэг бүрийн хөгжлийн түвшин, хэрэгцээнд тохирсон сургалтуудыг явуулахаас гадна нөхөн сэргээх төвөөр үйлчлүүлж байгаа, сургуульд явдаггүй хүүхдүүдэд зориулсан сургалтуудыг явуулж эхэлсэн юм. Энэ бүх үйл ажиллагааг амжилттай болоход орон нутгийн удирдлагын байнгын дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэсэн.*





■ Энэ хүү Хүүхдийг Ивээх Сангийг Чингэлтэй дүүрэг дэх Олон нийтэд түшиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төвийн үйлчилгээнд хамрагдаж өөрөө зогсч, явж чаддаг болжээ. 2008 он




■ Олон нийтэд түшиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төвийн үйлчилгээнд хамрагддаг 40 гаруй хүүхэд, тэдний ар гэрт нэн шаардлагатай боловч орон нутагтаа авч чаддаггүй байсан нөхөн сэргээх, хамгаалах үйлчилгээ үзүүлээ. Олон нийтэд түшиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төвийн нэг жилийн ойн үеэр. 2007 оны 9 дүгээр сар.

Нөхөн сэргээх төв нь одоо хүүхдүүд төдийгүй тэдний эцэг эхчүүдийн ирэх дуртай газар нэгэнт болжээ. Төв дээр хүүхдүүд нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдахаас гадна нийгэмших, тоглох, сурч хөгжих боломжоор хангагддаг. Нөхөн сэргээх төв нь хөгжлийн бэрхшээлтэй олон хүүхдийн амьдралыг илүү гэгээтэй, баяр баясгалантай болгосон билээ. Бидний дэмжиж эхлүүлсэн ажил орон нутгийн удирдлага, иргэдийн санаачилга, хүчин чармайлтаар ийнхүү тогтвортой үргэлжилж байгааг харахад их бахархалтай байдаг”.

Б.Эрдэнэчимэг, ХИС-гийн Дорнод аймаг дахь орон нутгийн салбарын зохицуулагч (2003- 2007)

■ “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийг хэрэгжүүлэх санамж бичигт Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Масато Такаока, Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн захирал Мицуаки Тоёода нар гарын үсэг зурав. 2018 оны 3 дугаар сарын 9-ний өдөр.



## 2018- 2021 ОН: “МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

Япон улсын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй, 3 жилийн хугацаатай энэ төсөл Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг, Ховд, Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын 16 сургууль, Насан туршийн боловсролын 16 төвд хэрэгжиж байна.

Төслийн зорилго нь олон төрлийн шалтгаан, нөхцөл байдлын улмаас сургуульд сурч чадахгүй байгаа хүүхдүүдэд хүрч ажиллах, тэдний сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх, хүлээн авч буй сургуулийн тэгш хамруулах боловсролын тогтолцоог бэхжүүлснээр хүүхэд бүрийн сурах эрхийг хангахад хувь нэмэр оруулах юм. Төслийн үр дүнд зорилтот ЕБС-ийн бага ангийн багш нар, Насан туршийн боловсролын төвийн дүйцсэн хөтөлбөрийн багш нар тусгай хэрэгцээт хүүхдийн талаарх мэдлэг, аргазүйд суралцаж, хүүхэд бүрийн хөгжлийн онцлогт тохируулан заах ур чадвар эзэмшиж байна.

**Үндэстний цөөнхийн  
хүүхдүүдийн  
чанартай  
боловсролыг хос  
хэлээр эзэмших  
эрхийг дэмжив.**

**ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХИЙН ХҮҮХДИЙН  
БОЛОВСРОЛ**

Казах үндэстэн оршин суудаг Баян-Өлгий аймаг боловсролын үзүүлэлтээрээ улсад доогуур ордог, сургууль завсардалтын түвшин хамгийн өндөр байдаг. Монгол Улсын нийт хүүхдийн 5 хувийг эзэлдэг казах хүүхдийн боловсролын асуудалд ХИС онцгой анхаарсаар ирсэн юм.

ХИС 1998- 2000 онд Баян-Өлгий аймагт төсөл хэрэгжүүлэхдээ олон хүүхэдтэй ядуу өрхийн орлого нэмэгдүүлэх, тэдний хүүхдийн сургууль цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлэхийг зорьж байлаа. Улмаар Баян-Өлгий аймгийн СӨБ-д хамрагдалт улсын хэмжээнд хамгийн бага байгааг анхаарч, Баян-Өлгий аймгийн цэцэрлэгийн багш нарт чадавхжуулах сургалт, Улаанбаатар хотын тэргүүний цэцэрлэгүүдээс туршлага судлуулах ажлыг зохион байгуулж, 2002 онд 30 гэр цэцэрлэгийг тус аймагт байгуулж ажиллуулсан билээ.



2003 онд Монголд анх удаа казах цагаан толгойн сурах бичгийг боловсруулж хэвлүүлснээр казах хүүхдүүд үндэсний хэл дээрээ сурах боломж бүрдсэн юм.

2005- 2006 онд ХИС үндэстний цөөнхийн хүүхдийн боловсролын нөхцөл байдалд судалгаа хийж, “Хос хэлээр сурах боловсролын тогтолцоо Монгол Улсад байхгүй байгаа нь казах хүүхдийн сурах үйл явцад сөргөөр нөлөөлж байна” гэсэн дүгнэлтээ төрийн болон бусад холбогдох байгууллагад хүргэлээ.

НҮБ-ын Арьс өнгөөр алагчлахыг устгах хороо уг судалгааны үр дүнг хүлээн авч, Монгол Улсын Засгийн газарт “...Үндэстний цөөнхийн хүүхдүүдэд өөрсдийн эх хэлээр сурах боломжоос гадна улсын албан ёсны хэлийг сурах боломжийг бүрдүүлж, хос хэлээр сурах тогтолцоог бий болгон хөгжүүлэх”-ийг албан ёсоор зөвлөсөн юм.

2007-2009 онд ХИС казах хүүхдүүдэд хос хэлээр боловсрол эзэмшүүлэх олон бичил төслийг дэмжин, казах хүүхдүүдэд зориулсан монгол хэлний 2, 3, 5 дугаар ангийн сурах бичгүүдийг боловсруулж, 9900 ширхгийг хэвлэн тараасан билээ.

2008- 2012 онд ХИС-гийн арга зүйн дэмжлэгтэйгээр боловсруулсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр”-ийг БСШУЯ-наас хэрэгжүүлсэн нь казах хэлээр сургалт явуулдаг сургалтын төлөвлөгөө, агуулга, хөтөлбөрийг шинжлэх ухааны үндэстэй судлан тогтоох, хос хэлээр сурах, сургах аргазүйг хөгжүүлэх, үндэстний цөөнхийн хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг тэгш тохиромжтой байдлаар хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.





## 4. ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ БОЛОВСРОЛЫН ОРЧИН

**25 дэвшил: №21**

**Монгол Улсын  
боловсролын  
салбарт хүүхэд  
төвт сургалтын  
аргазүй,  
хүмүүжлийн  
ээрэг аргыг  
анх удаа  
танилцууллаа.**

Чанартай боловсролын талаарх ХИС-гийн ойлголт, арга барил нь цаг хугацааны явцад баяжин, хүүхдийн хөгжлийг дэмжих боловсрол, аюулгүй хамгаалагдсан сурах орчинг бий болгоход онцгой анхаарах болсон юм. Хүүхдийн эрүүл, аюулгүй, сурч хөгжихөд таатай орчныг бий болгоход дэмжлэг үзүүлэх нь ХИС-гийн нэгэн чухал зорилт юм. Тиймээс хүүхдэд ээлтэй боловсролын орчинг бүрдүүлэх, хүүхэд төвтэй сургалтын аргазүйг бататгах, сургалтад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарт хүмүүжлийн эерэг аргыг эзэмшүүлэх зэрэгт онцгойлон анхаарч ажиллаж байна.

### **2008 - 2011 ОН: “БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖИХ, УДИРДЛАГА ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ**

УИХ 2006 оны 12-р сард Боловсролын хуульд өөрчлөлт оруулж, боловсролын салбарт бүх төрлийн хүчирхийлэл, дарамтыг хориглож, сургууль дээр хууль бус мөнгө хураадаг байдлыг хориглох, багш нарын мэргэжлийн ёс зүйн дүрмийг бий болгон мөрдөх, хүүхдийн оролцоог дэмжих заалтуудыг хуульчлан баталсан юм.

Хэдийгээр хуулиар хориглосон боловч ХИС-гаас 2009 онд хийсэн судалгаагаар сургууль дээр хүүхдийн хүчирхийлэл түгээмэл хэвээр байгаа нь харагдсан юм. Судалгаанд хамрагдсан 16 сургуулийн багш нарын 88% нь Боловсролын тухай хуульд суралцагчийн бие махбодод халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэхийг хориглосон нэмэлт өөрчлөлт орсон тухай мэдээгүй байлаа. Судалгаанд хамрагдсан багш болон хүүхдүүдийн 80% нь “хууль бус төлбөр авдаг”, хүүхдүүдийн 63% нь “багш сурлагын амжилт, гаднах төрх, ар гэрийн амьдрал зэргээс үүдэн хүүхдүүдийг ялгаварлан гадуурхдаг” гэж хариулжээ.<sup>1</sup>

Иймд ХИС 2008-2011 онд ЖАЙКА-гийн санхүүжилтээр хүүхдийн бие махбод, сэтгэл санааны шийтгэлийг хориглосон Боловсролын хуулийн хэрэгжилтийг хянах практикийг суурьшуулах, боловсролын орчинд сайн засаглалыг бэхжүүлэх зорилгоор Сурагчдын зөвлөл, эцэг эх, багш нарын загвар холбоодыг байгуулах, чадавхжуулах төслийг Улаанбаатар хот болон Дорнод аймгийн төрийн өмчийн нийт 16 дунд сургуульд хэрэгжүүллээ.

Энэ ажлын хүрээнд МХЕГ-тай хамтран Боловсролын хуулийн нэмэлт өөрчлөлтөд үндэслэсэн Сургуулийн бодлогын гарын авлагыг боловсруулав. Уг гарын авлага нь сургуулиудад Боловсролын хуулийг хэрэгжүүлэх дотоод удирдамж болж өгсөн юм. МХЕГ-ын боловсролын байцаагч нар хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сургалтад хамрагдаж, хуулийн хэрэгжилтэд

<sup>1</sup> “ЕБС-д суралцагчдын бие махбодод халдах, хуульд заагаагүй төлбөр хураамж авах, ялгаварлан гадуурхалтын байдал” суурь судалгаа, Хүүхдийг Ивээх Сан, 2009



■ 39 дүгээр сургуулийн багш нар “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” номыг хүлээн авч байна. Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 2009 он



■ Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын сургуулийн Иргэний хяналтын баг (нийгмийн ажилтан, багш, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн) санал хүсэлтийн хайрцгаар авсан мэдээлэлд үнэлгээ хийж байна. 2010 он

хяналт тавин ажиллав. Мөн Эцэг эхийн зөвлөл, сургуулийн ажилтнаас бүрдсэн Иргэний хяналтын баг 16 сургууль дээр ажиллаж хүүхдийн эрхийн зөрчлийг хянасан.

Сургуулийн орчинд эрх нь зөрчигдсөн хүүхдүүдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгоход ХИС хувь нэмрээ оруулж, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран зорилтот сургуулиудад “Залуу хуульчдын клуб” байгуулж, хүүхдийн эрхийн зөрчлийг арилгах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн юм. “Залуу хуульчдын клуб” нь ХИС-гийн дэмжлэгтэйгээр хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар гарын авлага боловсруулсан нь төрийн өмчийн сургуулиудад хүүхдийн эрхийг зөрчсөн бодит жишээнүүд дээр тулгуурласан билээ.

ХИС-гийн хичээл зүтгэлийн үр дүнд төслийн зорилтот 16 сургуулийн багш нарын зан үйлд эерэг өөрчлөлт гарч, хүүхдэд бие махбод, сэтгэл санааны шийтгэл хэрэглэх нь эрс буурсан байна. 2011 онд хийсэн үнэлгээгээр, багш нарын 88% нь өөрсдийн заах аргыг “хүчирхийллийн бус” гэж тодорхойлсон байна. Үүнээс гадна хүүхдүүд ч шийтгэлийг хүлээн зөвшөөрөх нь багасаж, шийтгэлийг хүмүүжлийн арга гэж үздэг хүүхдийн тоо 30 хувиар буурсан байв<sup>1</sup>. Мөн бие махбодын шийтгэлд өртсөн хүүхдүүд нийгмийн ажилтанд хандах нь нэмэгдсэн байна.

Сургуулийн сайн засаглалын механизмыг идэвхжүүлж, илүү нээлттэй, хариуцлагатай болгосноор Эцэг эхийн зөвлөлүүд сургуулийн засаглал, ялангуяа хууль бус төлбөр авахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн төсвийн зарцуулалтын хяналтад эцэг эхийг татан оролцуулж чадсан билээ. Энэ бүхний үр дүнд сургуулийн захиргаа нь сургуулийн төсөв, үйл ажиллагаа, эцэг эхийн оролцоо зэрэг асуудлаар Эцэг эхийн зөвлөлүүдтэй санал солилцдог, хамтарсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг, тайлагнадаг шинэлэг практик тогтлоо.

Сурагчдын зөвлөл нь сурагчдын эрх ашгийг сургуульдаа идэвхтэй төлөөлдөг болсноор багш, сурагчийн хооронд үүссэн үл ойлголцол, зөрчлийг маргааны бус замаар шийдвэрлэдэг сайн туршлагауд гарч ирсэн юм. Тухайлбал, сургуулийн орчин дахь бие махбодын шийтгэл хэрэглэх дадал зуршлыг өөрчлөх зорилго бүхий удаа дараагийн кампанит ажлыг зорилтот сургуулийн Сурагчдын зөвлөлүүд бүгд зохион байгуулж байв. Зорилтот 16 сургууль ил тод засаглалын дадал зуршлыг нэвтрүүлснээр 24,000 гаруй сурагч илүү ээлтэй, шударга орчинд суралцах боломж бүрдсэн нь энэхүү төслийн хамгийн том үр дүн байлаа.

<sup>1</sup> “Боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг дэмжих, удирдлага хяналтын тогтолцоог сайжруулах нь” ЖАЙКА-гийн санхүүжилттэй төслийн үнэлгээ, Хүүхдийг Ивээх Сан, 2011 он





## 2008 - 2011 ОН: ХҮМҮҮЖЛИЙН ЭЭРЭГ АРГА

“Эцэг эх нь хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхдээ тусламж, зөвлөгөө авах эрхтэй” гэж Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 18, 19-р зүйлд заасан байдаг. ХИС нь конвенцын энэ заалтыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын орчин нөхцөлд тохирсон, хүлээн зөвшөөрөгдөхүйц, хэрэглэхэд хялбар, хэрэгжүүлэхэд үр дүнтэй аргачлал дээр үндэслэсэн эцэг эхийн боловсролыг дэмжих сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.

2008 оны судалгаагаар Монгол Улсын боловсролын системд социализмын үеийн боловсролын тогтолцоо давамгайлсан хэвээр байсан ба сургуулийн орчинд хүүхэд төвтэй арга зүйг төдийлөн хэрэгжүүлж дадаагүй байв. Үүний зэрэгцээ тухайн үеийн заах аргачлал, багшийн мэргэжлийн ур чадвар дийлэнхдээ хангалтгүй гэж дүгнэгдэж байв<sup>1</sup>.

Иймд ХИС-гаас хүүхэд төвтэй сургалтын аргазүйг нэвтрүүлэхэд анхаарч, 2008-2011 онд ЖАЙКА-гийн санхүүжилтээр сургуулийн өмнөх болон бага сургуулийн боловсролын түвшинд тохируулан Хүүхдийг эерэг аргаар (ХЭА) хүмүүжүүлэх арга зүй, Эцэг эхэд хүмүүжлийн эерэг аргыг заах сургалтын модулиудыг боловсрууллаа.

Хүмүүжлийн эерэг арга бол хүүхдүүд, сурагчдад амжилттай суралцахад шаардлагатай чадвар, хувийн

<sup>1</sup> Боловсролын салбарын нөхцөл байдлын түргэвчилсэн үнэлгээ. Азийн Хөгжлийн Банк, 2008





сахилга батыг бэхжүүлэхэд өндөр ач холбогдолтой. Олон улсын энэхүү аргачлалыг ХИС-гийн Монгол дахь хөтөлбөрийн ажилтнууд Монгол улсын нөхцөл байдалд тохируулан боловсруулж, “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хэмээх багш нарт зориулсан шинэ гарын авлагыг хэвлүүлээ.

Монгол ёс заншил, монгол хүний сэтгэхүй, зан байдлын онцлог тохирсон гарын авлагыг хүмүүжлийн эерэг аргын суурь ойлголттой холбосон, дэлгэрэнгүй аргачлалтай уг гарын авлага багш нарт ХЭА боловсролын орчинд хэрхэн хэрэглэх талаар цогц зааварчилгаа болсон юм.

ХЭА-уудыг хэрэглэснээр хүүхэд багшаасаа айх, ялгаварлан гадуурхагдах, өөртөө итгэлгүй байдал багасаж хүүхдийн зан үйлд эерэг өөрчлөлт гарч буй нь үнэлгээний дүнгээс харагддаг. Хүмүүжлийн ийм эерэг аргаар хүүхдийн хөгжил, боловсрол, сэтгэл санаанд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийг багасгах боломжтой юм.

Хамгийн чухал нь энэхүү аргачлалыг багш өөрийн өдөр тутмын ажилдаа, тусгайлан цаг гаргалгүйгээр хэрэглэх боломжтой нь нотлогдсон юм.

ХИС хүмүүжлийн эерэг арга, түүний аргачлалыг Монгол Улсын боловсролын салбарт анх удаа ийнхүү танилцуулсныг ЕБС-ийн багш нар, боловсролын салбарын мэргэжилтнүүд, бодлого тодорхойлогчдын зүгээс өндрөөр үнэлж сайшаасан болно.

2013 оноос Хүмүүжлийн эерэг арга нь СӨБ-ын багш нарт зориулсан, салбарын яамаар магадлан итгэмжлэгдсэн, мэргэжил дээшлүүлэх сургалтын салшгүй хэсэг болов.



*“Шаардах хуудас” ба “Талархлын захидал”*

*“Өмнө нь би шавь нараа ямар нэгэн алдаа гаргаж буруу зүйл хийхэд нь загнаж буруутгахаас гадна эцэг эх рүү нь “Шаардах хуудас” илгээдэг байлаа. “Шаардах хуудас” авсан эцэг эхчүүд хүүхдээ дагуулан уулзахаар ирэхэд би хүүхдийнх нь аль болохгүй бүхнийг тоочин хэлдэг байв. Эцэг эхчүүд ч надтай санаа нэгдэнэ.*

*Харин тийм, энэ хүүхэд сүүлийн үед гэрийн даалгавар хийхгүй, гадуур их тоглодог гээд л ам нэгдэн муулж гарна. Энэ үед хөөрхий шавь минь царайд нь гэрэлтэн байдаг цог жавхаа алга болж зүггүйтэн гялалздаг нүдэнд нь уйтгар гуниг хуралдан, хошуугаа унжуулан, хуруу гараараа оролдон хажууд зогсоно. Энэхүү үйлдлээ эцэг эхчүүд болон багш бид хүүхдээ “муу хүн” болгохоос сэргийлж “тэдний тусын тулд” хийж буй хэрэг мэтээр ойлгодог байлаа.*

*Хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамрагдаад би энэ арга барилаа өөрчлөхөөр сэтгэл шулуудсан юм. Энэ үед “Талархлын хуудас” гэсэн санаа толгойд бодогдон хүүхдийнхээ хийж буй зөв зүйтэй алхам бүрийг урамшуулья гэсэн санаагаа талархлын хуудсаар дамжуулан түгээлээ. Өдөр бүр сайн үйл хийсэн, найздаа тусалсан, шинийг санаачилсан, эелдэг найрсаг зан гаргасан, хувцсаа зөв цэвэр өмссөн гээд л сурагчдынхаа сайн үйл бүхнийг “Талархлын хуудсан” дээрээ бичиж баяр хүргэн гардуулдаг болов. Сурагчид өнгө өнгийн тэр жижигхэн хуудсаар шагнуулах тун дуртай. Түүнийг авахаар аав ээждээ үзүүлэх гэж яардаг болов. Тэр ч бүү хэл аав ээж нь тэднийг талархлын хуудас аваад очихоор шагнадаг, урамшуулдаг болсон тухай хүүхдүүд ярилаа. Хуудас цаасан дээр талархлын хуудсуудаа эгнүүлэн наагаад хэн хэдийг авснаараа хоорондоо өрсөлддөг болов. Би ч энэ ажлаа үргэлжлүүлсээр байв.*

*Гэтэл нэг өдөр манай ангийн нэг сурагчийн ээж надтай уулзаж нэлээд ярилцлаа. Тэр ээжийн ярианаас би талархлын хуудсаар шагнуулсан хүүхэд гэртээ баяр хөөртэй ирж түүнийгээ үзүүлдэг тухай, түүнийг нь уншаад эх хүний хувьд сэтгэл нь тэнийж баярладаг тухай, мөн ангийн багш надтай ирж уулзахдаа сэтгэл түгших зүйлгүй болсонд баяртай байгаагаа хэлэхэд би үнэхээр өөрийгөө, бас шавь нараа эерэг аргаар өөрчлөөд зогсохгүй эцэг эхчүүдийг ч өөрчлөх зөв, шинэ ажлын эхлэлийг тавьснаа ойлгосон доо”.*

*ХИС-гаас ЖАЙКА-гийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн боловсролын төсөлд хамрагдсан Нийслэлийн 23 дугаар дунд сургуулийн бага ангийн багш Б.Оюун-Эрдэнэ*

## 5. БОЛОВСРОЛ ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

25 дэвшил: №22

**Боловсрол дахь эцэг эх, олон нийтийн оролцооны загварыг хөгжүүлэв.**



■ Улаанбаатар хотын цэцэрлэгүүдэд “Багш-эцэг эхийн харилцах дэвтэр”-ийг хэрэглэж байгаа нь. 2014 он

### “ЭЦЭГ ЭХТЭЙ ХАРИЛЦАХ ДЭВТЭР”

Хүүхдийн хөгжил, боловсролд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд ХИС-гийн Монгол дахь Хөтөлбөр анх байгуулагдсан цагаасаа анхааран ажиллаж байна.

2011 оноос Япон улсын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төслийн хүрээнд Хүүхдийг Ивээх Сан хүүхдийн хөгжил, сургалтын харилцаанд эцэг эх, цэцэрлэгийн хамтын ажиллагааг сайжруулахад туслалцаа үзүүлсэн. Энэхүү олон талт үйл ажиллагааны үр дүнд 2012-2014 онд зорилтот 58 цэцэрлэгийн Эцэг эхийн зөвлөл баяр тэмдэглэдэг “уламжлалт” оролцоог өөрчилж, цэцэрлэгийг хүүхдэд ээлтэй болгох үйл ажиллагаанд эцэг эхчүүдийг татан оролцуулдаг болов.

15,000 гаруй эцэг эхийн хүүхдийн эрх, хамгаалал, бага насны хүүхдийн халамж хөгжлийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдэж, хүүхдийн хөгжилд оролцох байдал, хүүхдээ ойлгон дэмжих хандлага сайжрав.

Эцэг эхийн зөвлөлүүд цэцэрлэгийн номын сан, эцэг эхтэй харилцах дэвтэр, орчны аюулгүйн зураглал зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоноос гадна ном бүтээх, хэвлэл мэдээлэлтэй харилцах, хүүхдүүдтэй хамтран жүжиг тавих гэх мэт шинэлэг ажлуудыг өөрсдөө санаачлан хэрэгжүүлсэн юм. Цэцэрлэгүүд дээр хийгдсэн үнэлгээгээр цэцэрлэгийн менежментэд эцэг эхийн зөвлөлүүд бодитой







■ 163 дугаар цэцэрлэгийн хүүхдүүдийн эмээ, өвөө нар үлгэрийн цагт оролцож буй нь. Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 2013 он

хувь нэмэр оруулсан гэж 90 хувь нь үзсэн ба тэдний дэвшүүлсэн санал санаачилга цэцэрлэгийн менежментэд тусгалаа олсон байна. Төслийн үр дүнд бага насны хүүхдийн халамж, хөгжил дэх эцэг эхийн оролцоо өмнө байсантай харьцуулбал 30 хувиар нэмэгдсэн дүн гарчээ.

Бага насны хүүхдийн халамж, хөгжилд багш, эцэг эх хамтран ажиллах боломжийг бүрдүүлж өгч буй “Эцэг эхтэй харилцах дэвтэр”-ийг Нийслэлийн боловсролын газраас СӨБ-ын шилдэг туршлагауудын нэг гэж үнэлэн, нийслэлийн бүх цэцэрлэгт түгээн дэлгэрүүлэхээр шийдвэрлэсэн юм. Иймд ХИС 2012-2014 онд нийт 61,000 ширхэг Эцэг эхтэй харилцах дэвтрийг хэвлэж, Улаанбаатар хотын 58 цэцэрлэгт түгээсэн нь жил бүр 20,000 гаруй хүүхдэд үр шимээ хүртээсэн юм.

2014 онд өмнө нь ХИС-д ажиллаж байсан хүмүүс болон 19 цэцэрлэгийн Эцэг эхийн зөвлөл нийлж “Эцэг эх, багш нарын холбоо” ТББ байгуулсан нь цэцэрлэг, сургуулийн Эцэг эхийн зөвлөлүүдийн хамтын ажиллагааны суурь болон ажиллаж байна.



*“Хүүхдийнхээ ололт, амжилт болон оюунд анхаарах ёстойгоо мэдэх шаардлага эцэг эх бүхэнд байдаг. Түүнчлэн багш ч мөн эцэг эхэд мэдээлэл, зөвлөгөө өгөх үүрэгтэй. Гэтэл аль алинд нь цаг хомс байдаг. Энэ асуудлыг цогцоор нь шийдэх нэг арга бол “Эцэг эхтэй харилцах дэвтэр” юм.*

*Энэ дэвтэрт эцэг эхэд хэрэгтэй мэдээлэл их бий. 0-5 насны хүүхдийн хөгжлийн талаар, бие бялдрын хувьд ямар байх, оюун ухаан, нийгэмшихүйн байдал нь аль үедээ ямар байх вэ гэдгийг товчлон хүснэгтэлж үзүүлсэн. Багш өдөр бүхэн хүүхэд бүрийн эцэг эхтэй уулзаж, ганцаарчлан ажиллах цаг бололцоо хомс байдаг учир энэ харилцах дэвтрээр дамжуулан эцэг эхэд хүүхдийнх нь талаар мэдээлэл, санал, зөвлөгөө өгөх боломжтой.*

*Дэвтрийг багш, эцэг эх, хүүхэд гэсэн гурвалсан холбоогоор ашиглаж болдгоороо онцлогтой. Эцэг эхчүүд хүүхдийнхээ талаар мэдэхийг хүссэн асуудлаа харилцах дэвтрийн “Тэмдэглэгээ” гэсэн хэсэгт бичиж багшаас харцулт авна. Хүүхдүүд ч цэцэрлэгтээ ирснийгээ дардас ашиглан тэмдэглэгээ хийдэг юм”.*





■ Дорнод аймгийн Матад сумын ОНБЗ-ийн гишүүд 2014 оны 1 дүгээр сард зохион байгуулагдсан Олон Нийтийн Боловсролын Зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтад оролцож байгаа нь.

## ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛЫН ЗӨВЛӨЛ

2012 оноос ХИС-гийн аргазүй, санхүүгийн дэмжлэгтэйгээр Архангай, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар аймгийн зорилтот 30 суманд Олон нийтийн боловсролын зөвлөл (ОНБЗ) ажиллаж байна. ОНБЗ нь сургуулийн өмнөх болон суурь боловсролын үйл ажиллагаанд орон нутгийн оролцоог хангах, боловсролын үр дүнг сайжруулахад орон нутгийн захиргаа, ард иргэдийн нөөц бололцоог дайчлахад чиглэсэн олон нийтийн оролцооны шинэ механизм юм.

ОНБЗ нь 7-11 гишүүнтэй бөгөөд эцэг эх, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, багш, дотуур байрны багш, албан бус боловсролын мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан, баг/сумын тамгын газрын ажилтнууд болон иргэдийн төлөөллөөс бүрддэг. Олон нийтийн оролцооны энэхүү шинэ механизмыг зөв нутагшуулж, бүтэц болон чадавхыг нь бий болгоход ХИС бүхий л боломж бололцоогоо дайчлан анхаарч, сургалт, танилцах аялал, уулзалт хийж, арга зүй, гарын авлагаар ханган ажилласан юм.

Байгуулагдсан даруйдаа ОНБЗ-үүд орон нутгийнхаа олон нийтийг идэвхжүүлэх, тэдний санал санаачилгыг дэмжих ажлуудыг хийж эхэлсэн билээ. Алслагдсан орон нутагт байгаа хүүхдүүдийн боловсролын асуудлыг

шийдвэрлэх, олон нийтийн хүрээнд сургуульд бэлтгэх олон нийтийн санаачилгыг дэмжихийн тулд ХИС үр дүнд чиглэсэн жижиг тэтгэлгийг олгосон.


Жишээлбэл, Архангай аймагт 14,8 сая төгрөгийн тэтгэлэг бүхий 10 бичил төсөл хэрэгжиж, 324 хүүхэд, 686 эцэг эх, сумын сургуулийн бага ангийн болон цэцэрлэгийн багш нар үр шимийг нь хүртжээ. Олон нийтээс гаргасан санаачилгыг орон нутгийн удирдлага ч мөн дэмжиж байна. Жишээ нь, Архангай аймгийн удирдлага ОНБЗ-ийн гаргасан санаачилгад 15 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Мөн Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын ЗДТГ “Сум хөгжүүлэх сан”-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр сумандаа “Хүүхэд хөгжлийн төв” 2-ыг байгуулах, ном, тоглоомын 8 багц авахад зориулан 2,9 сая төгрөг зарцуулав.

Дорнод аймгийн Халхгол сумын Ахмадын холбоо сумынхаа “Хүүхэд хөгжлийн төв”-д тоглоом хандивлажээ.







# ХҮҮХДИЙН ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ

**25 дэвшил:** №23

**“Ядуурлыг  
бууруулах Үндэсний  
хөтөлбөр”-т  
идэвхтэй оролцож,  
эмзэг бүлгийн  
хүүхдүүдэд  
хөгжих, нийгэмших  
боломжийг олгов.**

Хүүхдийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн зорилго нь зорилтот бүлгийн өрхийн гишүүдэд хүүхдийнхээ эрүүл байх, тэжээллэг хоол хүнс хэрэглэх, боловсрол эзэмших, хамгаалагдах үндсэн хэрэгцээг нь хангахад шаардлагатай эдийн засгийн боломж, ур чадварыг олгоход оршино.

ХИС Монголд ажиллагаагаа эхлүүлэх үед Монгол Улсын хүн амын 36,3 хувь нь ядуу амьдралтай байлаа<sup>1</sup>. Өрхийн түвшин дэх ядуурал хүүхдэд хүндээр тусч байв. Ядуурлыг бууруулах нь шилжилтийн үед эмзэг бүлгийн хүүхдүүдийн өмнө тулгарч байсан олон асуудлыг бүрэн шийдвэрлэхгүй ч өрхийн түвшинд ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа нь хүүхдийн амьдралын чанарыг богино хугацаанд бодитой өөрчилнө гэж ХИС үзсэн билээ.

Иймээс ядуурлыг бууруулах асуудлыг ХИС өөрийн стратегийн нэг хэсэг болгон авч, энэ талаарх зөв ойлголтыг олон нийтэд түгээхэд онцгой анхаарч, ядуурлыг бууруулахын төлөө олон улсад хуримтлуулсан арвин туршлагаасаа Монголын онцлогт тохируулан хэрэгжүүлсэн билээ.

<sup>1</sup> Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр Монгол Улсын Статистикийн Үндэсний газраас хийсэн “Амьжиргааны түвшин тогтоох судалгаа”, 1995



**1996 - 2000 ОН: “ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”**

1996 онд хэрэгжиж эхэлсэн “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр” (ЯБҮХ)-ийн үйл ажиллагаанд оролцох нь ХИС-гийн хувьд чухал сонголт байлаа. Тухайн үеийн санхүүгийн хязгаарлагдмал нөөцөөр Монголын хүүхдүүдийн өмнө тулгарч байсан олон асуудлыг шийдэх боломжгүй байсан тул ХИС хөрөнгийн чадвартай доноруудын үйл ажиллагааг эмзэг бүлгийн хүүхдэд чиглүүлэхэд гол анхаарлаа хандуулсан юм.

- ЯБҮХ-ийн үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад ХИС идэвхтэй оролцож, ЯБҮХ-ийн хэрэгжилтэд төвлөрлийг сааруулсан арга зүйг нэвтрүүлэхэд бодитой үүрэг гүйцэтгэсэн.
- ЯБҮХ-ийн төслийн баримт бичигт хүүхдийн асуудал бага туссан байсныг өөрчилж, сургуулийн өмнөх боловсролын асуудлыг ЯБҮХ-ийн нэг үндсэн хэсэг болгон оруулсан юм. ЯБҮХ-ийн Орон нутгийн хөгжлийн сангийн дор СӨБ-ын дэд сан бий болгон байршуулснаар СӨБ олгох орон нутгийн үйл ажиллагааг дэмжих боломж бүрдсэн билээ.
- Орон нутгийн байгууллагын чадавхыг дээшлүүлэхийн тулд ХИС-гийн санаачилгаар ЯБҮХ-ийг гардан хэрэгжүүлэх орон нутгийн ажилтнуудад нийгмийн хөгжлийн чадавх бэхжүүлэх сургалтуудыг хийсэн.
- Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд Архангай аймагт хэрэгжүүлсэн “Малжуулах төсөл”-д орон нутгийн хэрэгцээг үнэлэх, үйл ажиллагааг төлөвлөх, шийдвэр гаргах олон нийтийн оролцооны аргуудыг амжилттай хэрэгжүүлсэн.
- АХБ-ны санхүүжилтээр ХИС нь Нийгмийн хөгжлийн төвтэй хамтран ЯБҮХ-ийг бэхжүүлэх техник туслалцааны төслийг хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлж, нэн ядуу иргэдийн эн тэргүүний хэрэгцээг хангахад зориулж, санхүүгийн туслалцаа үзүүлэх санг Монгол Улсад анх удаа бий болгож, ажилтнуудыг нь сургасан билээ.
- ХИС нь ЯБҮХ-ийн хүрээнд дорвитой дэмжигдэх боломжгүй байсан хүн амын зарим бүлэг, тухайлбал, өрх толгойлсон, олон хүүхэдтэй эмэгтэйчүүд болон хөдөөгийн малчин өрхүүдийг дэмжих тусгай төсөл, хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлсэн.

Өмнөговь, Сүхбаатар, Дорнод, Дархан-Уул аймгийн олон хүүхэдтэй өрх толгойлсон 250 эмэгтэйд орлогоо нэмэгдүүлэх үйл ажиллагаа эрхлэх, хүүхдийнх нь сургууль, цэцэрлэгт явах боломжийг дэмжсэн жижиг зээл олгосон билээ. Баян-Өлгий, Хөвсгөл, Баянхонгор, Дорнод аймагт хүүхдээ сургуульд тасралтгүй хамруулах болзолтойгоор 450 зорилтот бүлгийн малчин өрхийг төслөөр малжуулав.

Хөдөөгийн орлого багатай, зорилтот бүлгийн иргэдийн дунд малжуулах төсөл амжилттай хэрэгжих боломжтойг нотолсон ХИС-гийн туршлага дээр суурилан ЯБҮХ-өөс 2000 онд 5 аймгийн 33 суманд хөдөөгийн малчдыг дэмжсэн малжуулах төсөлд 1,3 сая ам.долларын санхүүжилтийг хуваарилсан юм.



### **2015 - 2017 ОН: ӨСВӨР ҮЕИЙНХЭНД БИЗНЕСИЙН БОЛОВСРОЛ, ЭНТРЕПЕНЕР УР ЧАДВАР ОЛГОХ BEST ТӨСӨЛ**

ХИС нь ядуурлыг бууруулах үйл ажиллагааны гол цөмд хүүхэд, өсвөр үеийнхнийг тавьж, тэднийг эсэн мэнд амьдрахад шаардлагатай ур чадвар, орлогыг нэмэгдүүлэх, хувьсан өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээл, ирээдүйн ажил мэргэжилд бэлэн байх, энэ чиглэлээр суралцахад нь дэмжлэг үзүүлэхээр зорин ажиллаж байна.

### **2015 - 2016 ОН: ОРОН НУТАГТ АМЬДАРЧ БУЙ ӨСВӨР ҮЕИЙНХЭНД БИЗНЕС БОЛОН ЭНТРЕПЕНЕР УР ЧАДВАР ОЛГОХ БОЛОВСРОЛЫН ХЭРЭГЦЭЭГ ТОДРУУЛАХ СУДАЛГАА:**

Өвөрхангай, Сүхбаатар аймгийн ЕБС-ийн 9-12-р ангийн сурагч, багш нартай уулзаж, мэдээлэл цуглуулан, орон нутгийн удирдлагууд, статистикийн хэлтэс, бизнес эрхлэгч нартай санал солилцож ажиллав.

### **2017 ОН: ӨСВӨРИЙН ЭНТРЕПЕНЕРҮҮДИЙН АНХДУГААР УРАЛДААН:**

2017 оны 3-р сарын 11-нээс 4-р сарын 1 хүртэл Улаанбаатар хотын 4 сургуулийн 38 хүүхдэд бизнес болон энтрепренершип сургалтыг “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран явууллаа. Судалгаанаас үзэхэд бүх оролцогч уг сургалтыг маш хэрэгтэй, сонирхолтой, өгөөжтэй сургалт болсон гэж үнэлсэн байна. Сургалтын дараа оролцогчдын дунд Энтрепренершип тэмцээн зохион байгуулахад 3 баг шалгарч “Олон Улсын Залуу энтрепренершип” тэмцээнд орох эрхээ авсан юм. Үүнээс хойш уг арга хэмжээг жил бүр уламжлах болгон зохион байгуулж байгаа бөгөөд жил ирэх бүр оролцогчдын тоо, хамрах цар хүрээ улам өргөжиж байна.

### **2018 ОН: ӨСВӨРИЙН ЭНТРЕПЕНЕРҮҮДИЙН ХОЁРДУГААР УРАЛДААН:**

2018 оны 3-5 дугаар сард ХИС-гаас хоёр дахь жилдээ “Өсвөрийн энтрепренерүүдийн уралдаан”-ыг ерөнхий боловсролын 6 сургуулийн ахлах ангийн 64 сурагчийг хамруулан, монгол, англи хэл дээр амжилттай зохион байгуулав.



*“Бизнесийн чиглэлийн тэмцээнд анх удаа оролцож байна. Өөрсдийгөө туршаад үзье гэж бодсон. Нийгэмд өдөр болгон тулгамддаг зүйлийг зүгээр хараад суух биш, өөрсдөө шийдэх гээд үзвэл яасан юм бэ гээд энэ сургалтад хамт явдаг найзуудтайгаа хамт орсон.*

*Тэмцээний өмнө хийсэн сургалтын үеэр бид гол чиг баримжаагаа авч чадсан. Өмнө нь бизнес эрхлэх тухай огт өөрөөр ойлгож байжээ. Бидэнд бизнес эрхлэх үндсэн шат дараалал, бизнес төлөвлөгөө бичих тухай, бизнес загвараа яаж хийвэл зүгээр вэ, багаар хамтарч ажиллах, үүрэг даалгавраа тодорхойлох зэрэг олон зүйлийг сургасан учраас үр дүнтэй байсан”.*

*“Өсвөрийн Энтрепренерууд- 2019” уралдааны оролцогч М.Мөнхцэцэг*

**2018 ОН: “МОНГОЛ ЭНТЕРПРАЙЗИНГ ЭРЭЛ”:** 2018 онд ХИС өсвөр үе, залуучуудад чиглэсэн хөтөлбөрийн хамтын ажиллагааг нэмэгдүүлж бэхжүүлсний нэг нь 2018 оны 10-р сард НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Монгол Энтерпрайзинг Эрэл”-ийг Монголд анх удаа амжилттай зохион байгууллаа.

Уг төсөл нь залуучуудын шинэ санаагаа бодитоор хэрэгжүүлэх чадварыг нэмэгдүүлэх зорилготой шинэлэг хэлбэрийн буюу өртөөчилсөн сургалт үйл ажиллагаанаас бүрдсэн төсөл юм. “Тууштай байдал, эрмэлзэл”, “Бүтээлч хандлага”, “Бие даах чадвар”, “Эрсдэл хүлээх чадвар”, “Амжилтад хүрэх хэрэгцээ” гэх таван өртөөнөөс ХИС нь “Бие даах өртөө”-г хариуцаж, нийт 350 залуучуудаас шалгарсан 48 залууг хамруулж, бие даан шийдвэр гаргахын ач холбогдол болон эрсдэлийн талаар ярилцаж, сургалтыг сонирхолтой хэлбэрээр явуулсан. Төслийн үнэлгээнээс харахад залуучуудын ихэнх нь бусдаас хэт хамааралгүйгээр бие даан шийдвэр гаргахын ач холбогдлыг ойлгож, бие даан шийдвэр гаргах үр чадвараа ахиулсан гэж хариулсан байна.

**2019 ОН: ӨСВӨРИЙН ЭНТРЕПРЕНЕРҮҮДИЙН ГУРАВДУГААР УРАЛДААН:**

2019 оны 3-5 дугаар сард уламжлал болгон зохион байгуулдаг уг уралдаанд нийслэлийн 9 сургуулийн ахлах ангийн 64 сурагч баг болон оролцлоо. Хагас шигшээ тэмцээнд сурагчид “Хүнсний аюулгүй байдал” сэдвийн дагуу 12 цагийн дотор шинэ санаа, бүтээгдэхүүн боловсруулан, бизнес төлөвлөгөө, туршилтын загваруудаа 5 минутын дотор англи хэл дээр танилцуулах даалгаврыг гүйцэтгэсэн. Тэмцээний эхний гурван байранд “Шинэ Монгол Коосэн”, “Монгол Тэмүүлэл”, “Шинэ эхлэл” сургуулийн багууд шалгарлаа. Улмаар эдгээр багууд 2019 оны 5-р сарын 12-нд онлайнаар зохион байгуулагдсан “Өсвөрийн Энтрепренерууд 2019 уралдаан”-ы олон улсын түвшинд амжилттай оролцож, 20 багаас шилдэг 4-т шалгарсан юм.



**ЭРҮҮЛ МЭНД**



НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод “Хүүхэд бүр эрүүл байхын үүднээс эрүүл мэндийн чанартай үйлчилгээ, ундны цэвэр ус, тэжээллэг хоол хүнсээр хангагдах эрхтэй. Хөгжингүй орнууд үүнд хөгжиж буй орнуудад туслалцаа дэмжлэг үзүүлбэл зохино”<sup>1</sup> гэж заасан билээ.

Хүүхдийг эрүүл өсөж, бойжих боломжоор хангах нь ХИС-гийн эрхэм зорилгуудын нэг юм. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэх үүднээс ХИС дэлхий даяар хүний амь нас, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалан дэмжихэд чиглэсэн:

- Нярайн эрүүл мэнд
- Хүүхдийн эрүүл мэнд
- Эхийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд
- Өсвөр насныхны бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд
- Хоол тэжээл
- Ус, эрүүл ахуй, ариун цэвэр
- Яаралтай тусламж ба хоол тэжээл гэсэн 7 салбарт хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад эрүүл мэндийн анхан шатны тусламж нэн чухал. Амьжиргааны түвшин, амьдралын нөхцөл байдлаас үл хамааран хүн бүр эрүүл мэндийн анхан шатны тусламж авах эрхээр хангагдах учиртай. Анхан шатны тусламж бүх эх, хүүхдэд хүрч чадвал өвчин, эндэгдлээс урьдчилан сэргийлээд зогсохгүй, сая сая хүний амь аврагдах юм. Үүнийг биелүүлэх цорын ганц арга бол иж бүрэн, төрийн удирдлагатай, зохих санхүүжилт ба боловсон хүчнээр хангагдсан эрүүл мэндийн тусламжийн тогтолцоо билээ. Иймээс ХИС үйл ажиллагаа явуулж буй улс орнуудынхаа эрүүл мэндийн тогтолцоонд анхаарсаар ирсэн юм.

ХИС-гийн Монгол дахь хөтөлбөр нь эх, хүүхдийн эрүүл мэндэд чиглэсэн тусламжаа “Боловсрол”, “Хүүхэд хамгаалал”, “Хүмүүнлэг”, Хүүхдийн эрхийн засаглал” зэрэг өргөн цар хүрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад хөтөлбөртэйгөө уялдуулах замаар үзүүлж байна.

Жишээлбэл, Боловсролын хөтөлбөрийн хүрээнд гэртээ болон улсын цэцэрлэгүүдэд өсөн бойжиж буй 2-5 насны хүүхдүүд, тэр дундаа захын хорооллын хүүхдүүдийн эрүүл мэнд, хөгжлийн байдалд анхаарч, тэдэнд эрүүл мэнд, хоол тэжээлийн тусламж үзүүлсэн бол Хүүхэд хамгааллын үйл ажиллагаандаа хүүхдийн эрх зөрчигдөх үед хариу арга хэмжээ авахад эрүүл мэндийн салбарын нөлөөг нэмэгдүүлэхийн төлөө анхааран ажиллаж байна.

1 НҮБ-ын ХЭК, 24-р зүйл

## 2008 ОН: 50,000 НЯРАЙД 50,000 ДУЛААН МАЛГАЙ

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад өрнөсөн “Нэгийг нэхээд нэгийг авар” аяны хүрээнд сайхан сэтгэлт британичуудын гараараа нэхсэн 50000 ноосон малгайг ХИС хүлээн авч, 2008 оны 11-р сард дөнгөж төрсөн нярай хүүхдүүдэд түгээлээ.

Их Британийн олон нийт, сайн дурынхны нэхсэн 50,000 ширхэг малгайг Улаанбаатар хотын I, II, III амаржих газарт түгээхийн өмнө зохион байгуулсан ёслолд Эрүүл мэндийн дэд сайд Ж. Цолмон, ЭМЯ-ны Хүүхдийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Г. Соёлгэрэл нар оролцсон.

## 2010 ОН: “ХҮҮХЭД ХАМГААЛАЛ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР



2010 онд ХИС Монгол Улс дахь ИБУИНВУ-ын Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр хүүхэд хамгааллын асуудлыг эрүүл мэндийн салбартай уялдуулах ажлыг эхлүүлэхдээ “Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хүүхдийн эсрэг хүчирхийллийг оношлох, эмчлэх мэдлэг чадавхыг дээшлүүлснээр хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлэх, эмчлэх, нийгмийн ажлын үйлчилгээнд холбон зуучлах, нөхөн сэргээх дараагийн үйлчилгээг үзүүлэхэд маш чухал” гэж үзсэн юм. Тэрхүү зорилтынхоо хүрээнд ЭМЯ, ЭМШУИС (одоогийн АШУҮИС), Шүүх эмнэлэгтэй хамтран анагаах ухааны их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан “Хүүхэд хамгаалал”-ын хичээлийн хөтөлбөрийг анх удаа боловсруулж, гарын авлага хэвлүүлжээ.

Хичээлийн агуулгад Хүүхэд хамгааллын үндсэн ойлголт, хүчирхийлэл дарамтын шинж тэмдэг, хүчирхийлэл дарамтад өртсөн хүүхэдтэй ажиллах арга барил, хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд эрүүл мэндийн ажилтнууд хэрхэн оролцох арга замыг тодорхойлон оруулсан бөгөөд энэхүү хичээлийг ЭМШУИС үндсэн сургалтын хөтөлбөртөө оруулж баталсан болно.

## 2011 ОН: ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ

ХИС-гаас Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулсан цуврал сургалтад Улаанбаатар хотын бүх дүүргийн өрхийн 128 эмч, дүүргийн эмнэлгүүдийн өрх хариуцсан 28 дэд дарга, 40 гаруй эмч, эрүүл мэндийн ажилтан, ЭМЯ, ЭМШУИС, Шүүх эмнэлэг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын 25 албан хаагч хамрагдаж, Хүүхэд хамгааллын үйлчилгээн дэх эрүүл мэндийн ажилтны үүрэг, хариуцлагын талаар мэдлэгээ дээшлүүлсэн юм.





### **2011 - 2014 ОН: “ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ”**

Сургалтын орчин, ялангуяа ахуйн ариун цэврийн орчин хүүхдэд ээлтэй байх нь тэдний эрүүл мэнд, өдөр тутмын зөв дадал хэвшилд суралцах, бие даах чадварт нөлөөлөх чухал үндэс суурь болдог. Энэ үзэл санаа болон Монгол Улсын онцлогт нийцсэн жишиг загваруудыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ХИС Монгол Улсад хэрэгжүүлж буй Боловсролын хөтөлбөрийнхөө хүрээнд 2011- 2014 онд сургууль, цэцэрлэгийн ус, эрүүл ахуй, ариун цэврийн асуудалд анхаарч, “Хүүхдэд ээлтэй ариун цэврийн өрөө”-ний үзэл баримтлалыг боловсруулсан юм.

ХИС тэрхүү үзэл баримтлалын дагуу нийслэлийн 6 цэцэрлэгийн 18 бүлгийн ариун цэврийн өрөөг загварчлан зассан бөгөөд боловсролын болон барилгын мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага, зөвлөмж, богино хэмжээний кино бүтээж, Улаанбаатар хотын боловсролын газруудад сургалт хийж, сурталчилсан билээ. Энэ загварын дагуу нийслэлийн 31 цэцэрлэг өөрсдийн санаачилгаар ариун цэврийн өрөөнүүдээ засварлан тохижуулсан. Ийнхүү хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх үзэл санаа, зарчим сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд, мэргэжилтнүүд болон бусад олон хамтрагчдад жишиг загвар болж хүлээн зөвшөөрөгдлөө.

Улсын төсвийн 6 цэцэрлэгт бүтээсэн хүүхдэд ээлтэй ариун цэврийн өрөөний загваруудаараа ХИС Японы “Усны форум”-аас тусгай шагнал хүртсэн юм. Уг шагналыг олгохдоо зардал багатай, зөв хэрэглээтэй, хүүхдэд ээлтэй ариун цэврийн өрөөний загваруудыг амьдралд нэвтрүүлэхдээ мэргэжлийн байгууллагууд, хувь хүмүүс, төрийн байгууллагуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулж, бусад цэцэрлэгүүдэд энэхүү шинэлэг үзэл санааг таниулж чадсаныг нь өндрөөр үнэлсэн билээ.

ХИС-гийн “Хүүхдэд ээлтэй ариун цэврийн өрөө байгуулах зөвлөмж”-ийн үзэл санаа 2014 оны 7-р сард БШУЯ, ЭМЯ, СЯ-ны сайд нарын хамтарсан тушаалаар “Сургууль, цэцэрлэг, дотуур байрны ус, ариун цэврийн байгууламжийн наад захын шаардлага” баримт бичигт тусгагдан батлагдсанаар үндэсний хэмжээнд түгээн дэлгэрсэн.



■ 2013 онд Чингэлтэй дүүргийн 124 дүгээр цэцэрлэгт Хүүхдэд ээлтэй загвар ариун цэврийн өрөө байгуулсан нь, Улаанбаатар хот

## ТӨСЛИЙН ӨМНӨ

Манай цэцэрлэг барилгынхаа байдалд үнэлгээ хийхээр хуралдсан. Бидний ерөнхий дүгнэлтээр хүүхдэд тохирсон байгууламж тоноглол байхгүйн улмаас багш нар хүүхдэд маш их туслах хэрэг гардаг байна. Тухайлбал дараах зүйлс дутагдаж байна:



- Суултуур нь насанд хүрэгсдэд зориулсан том хэмжээтэй. Багш нь 2 настай хүүхдийг ийм суултуур дээр суухад нь туслах хэрэгтэй болдог. Эсвэл хуванцар хөтөвчид бие засуулаад багш нь тухай бүрд нь угаах гэж их ажил гардаг.
- Суултуурын ус татуурга ажиллагаагүй тул хүүхдүүд усаа татах боломжгүй. Багш нь тухай бүрд нь хувингаар ус хийх болдог.
- Суултуур нь томдоод хөл нь газар хүрдэггүй учраас хүүхдүүд суултуурын ирмэг дээр гараараа тулж суудаг.



- Угаалтуурын крантны хэлбэр, хийц хүүхдэд тохироогүй учраас хүүхэд онгойлгож чаддаггүй.
- Угаалтуурт хүүхдүүд халуун, хүйтэн усыг тохируулж хэрэглэж чаддаггүй эсвэл халуун үгүй бол хүйтэн ус хэрэглэдэг.

## ТӨСЛИЙН ЯВЦАД

Манай 22-р цэцэрлэг 2014 онд хүүхдүүдийн гэр бүлд эрүүл ахуйн нөхцөл ямар байгааг судалсан юм. Судалгаагаар гэр бүлүүдийн 70 % нь гар угаахад хувин хэрэглэдэг байв. Энэ нь нийт гэр бүлийн 70% орон сууцанд амьдардаггүй гэсэн үг юм. 58% нь хуванцар хөтөвч ба хувин, 42% нь насанд хүрэгсдийн суултуур хэрэглэдэг, хүүхдүүдийн 91% нь өөрийн алчуургүй, гэрийнхэн дундаа алчуураа хэрэглэдэг байлаа.

Судалгаанаас үүдэн эцэг эхэд сургалт хэрэгтэйг ойлгосон юм. Ингээд эцэг эхчүүдийн дунд “амлалтын өдөр” зохион байгуулан, эцэг эхэд хүүхэд цэцэрлэгт хэрхэн суралцсаныг гэрт нь давтуулдаг болгож байна. Эцэг эх, хүүхдийг нэг удаа ирэхдээ нэг эрүүл ахуйн дадал эзэмшиж ирэх амлалт авдаг. Эцэг эх нь багштай хамтран хүүхдийнхээ гараа угаах, шүдээ угаах, хувцас эвхэх, хооллох, бие засах, тоглоомоо хураах гэсэн 5 дадал хэвшлийг өдрийн турш ажиглан тэмдэглэл хөтөлнө. Эцэг эхэд хэрхэн зааж сургахыг хамтран үзүүлдэг. 14 хоногийн хугацаанд эцэг эх амлалт аван, хүүхдэдээ зааж сургасны дараа дахин хамтран үнэлж, цаашдын хөтөлбөрөө зохиож, хүүхдэдээ эрүүл ахуйн өдөр тутмын дадал хэвшлийг хэвшүүлж байна.

## 2013 ОН: “ЭСЭН МЭНД АМЬДРАХУЙН ТӨЛӨӨ” ӨДӨРЛӨГ, ГҮЙЛТ

“Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийн төлөөх дэлхийн өдөр”-ийг тохиолдуулж, 2013 оны 10-р сарын 23-нд ХИС-гийн олон улсын эвслээс нялхсын эндэгдэлд олны анхаарлыг хандуулах зорилготой зохион байгуулсан “Эсэн мэнд амьдрахуйн төлөө” өдөрлөгийн гүйлтэд 67 орны 50,000 орчим хүүхэд оролцов.



■ “Урьдчилан сэргийлж болох шалтгаанаар хүүхэд гэмтэх, эндэх ёсгүй” уриан дор зохион байгуулсан хэвлэлийн бага хурлын үеэр. Улаанбаатар хот, 2013 оны 10 дугаар сарын 23

ХИС-гийн Монгол дахь хөтөлбөр уг аяны хүрээнд “Урьдчилан сэргийлж болох шалтгаанаар хүүхэд гэмтэх, эндэх ёсгүй” уриан дор хүүхдүүд болон УИХ-ын эмэгтэй гишүүдийн бүлэгтэй хамтран ажилласан. Монголын 18 телевиз, өдөр тутмын 3 том сонины сэтгүүлчид оролцсон хэвлэлийн бага хурал хийж, Монгол орон даяар 10 минутын баримтат киног цацсан юм.

Монгол Улсад 5-аас доош насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлт тутамд 16,3 байдаг<sup>1</sup> бол хөдөө орон нутагт энэ тоо хот суурин газрынхаас 2 дахин их байгаа юм.

Бага насны хүүхдүүд байнга бэртэж гэмтэж байгаа нь Монгол Улсын хувьд онцгой анхаарууштай асуудал билээ. ҮСХ-ны Олон хэмжүүрт кластерийн судалгаа (2010)-ны IV тайлангаар, хот суурин газрын хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлтэй болох магадлал 12% байхад хөдөө, орон нутагт 15% байна. Монгол хүүхдүүдийн гэмтэл бэртлийн 60 гаруй хувь нь гэрийн нөхцөлд, асран хамгаалагчдын хайхрамжгүй байдал, асрамж халамж муугаас үүдэлтэй нь тогтоогджээ.

1 <http://data.worldbank.org/indicator/SH.DYN.MORT>



“Томчууд түгээмэл тохиолддог бүх төрлийн гэмтэл бэртлээс хүүхэд бүрийг сэргийлэх боломжтой гэж хүүхдүүд, өсвөр үеийнхэн бид үзэж байна. Гэвч үнэн хэрэгтээ бага насны хүүхдүүд эрсдэлтэй орчинд амьдарч байна. Хүүхдүүд ямар ч нөхцөлд хамгаалагдах ёстой, энэ нь бүх том хүмүүсийн үүрэг. Томчуудад хүргэх бидний уриалга энэ”.

Б.Э (13 настай)



“Томчууд бид худалдааны төв дээр гарсан түймэр зэрэг ослуудад их анхаарал хандуулдаг. Үүний оронд харин гэртээ хараа хяналтгүй эсвэл түгжиж орхисон хүүхдийнхээ төлөө илүү санаа тавих ёстой юм. Бүх насанд хүрсэн хүмүүс, асран хамгаалагчдад энэ аян зүйтэй сануулга болж байна”.

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч Г.Золжаргал



“УИХ дахь эмэгтэйчүүдийн бүлэг сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулсан асран хамгааллын хувилбарт үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулсан. УИХ хэлэлцээд энэ хуулийг баталбал цэцэрлэгийн хүрэлцээгүй байдлыг шийдвэрлэх чухал арга хэмжээ болох юм. Амжилттай батлагдсан тохиолдолд 80 мянга гаруй хүүхдийг бэртэл, гэмтлээс сэргийлж, хамгаалах боломжтой”.

УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг



## 2012 ОНООС ХОЙШ: ДЕНАН ТӨСӨЛ

2011 онд АНУ-д төвтэй “Денан прожект” байгууллагын төлөөлөгчид Монголд ирж, 10,000 ба түүнээс дээш хүн амтай, үйлчилгээний хүрээ нь 100 км-ийн радиустай, алслагдсан орон нутгийн эмнэлэгт ХИС-гаар дамжуулан дэмжлэг үзүүлэхээр судалсан юм. Судалгааны дүнд 5 сумын нийт 15,600 км<sup>2</sup> нутагт 15,000 гаруй хүнд хүрч үйлчилдэг Архангай аймгийн Тариат сумын Сум дундын эмнэлэг шалгарсан. Тус байгууллага төслийн хэрэгжүүлэгчээр Хүүхдийг Ивээх Санг сонгосон ба “Денан” төслийн Монгол Улс дахь үйл ажиллагааг манай байгууллага төсөл эхэлсэн цагаас нь хойш удирдан зохион байгуулж байна.

Денан төслөөс Архангай аймгийн Тариат сумын Сум дундын эмнэлгийн үйлчилгээг сайжруулж, улмаар аймгийн жишиг эмнэлэг болгох зорилго тавьж, төслийн эхний жилүүдэд шаардлагатай эм тариа, лабораторийн урвалж бодис, тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл болон эмнэлгийн халаалтад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Үүний хажуугаар уг эмнэлгийн хүүхдийн эмч, дотрын эмч, мэдээгүйжүүлэгч эмч, уламжлалт анагаах ухааны эмч, шүдний эмч, мэс заслын сувилагч, рентген техникчийг нарийн мэргэжлээр сургажээ.

Орон нутгийн удирдлага, Тариат сумын эмнэлгийн хүсэлтийн дагуу Денан төслөөс 2015 онд 18,000 ам.доллараар түргэн тусламжийн машин худалдан авч өгснөөр иргэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй авах нөхцөл бүрдсэн билээ.

Тариат сумын эмнэлэгт шүдний иж бүрэн тоног төхөөрөмж бүхий кабинет байгуулж, шүдний иж бүрэн суудал, компрессор, шүдний рентген аппарат, шүдний багаж ариутгах шүүгээ, ариутгасан багаж савлагч төхөөрөмж, зөөврийн бор машин зэргээр тохижуулж, шаардлагатай эмийн материалаар хангасан ба төслийн хүрээнд сумаасаа АУШУИС-д шүдний эмчээр суралцсан эмч сургуулиа төгсөж, эмнэлэгтээ ажиллах болсон. Ингэснээр эмнэлэг ломбо, сувгийн эмчилгээ, шүдний рентген, түрхлэг, шүдний тулгуур эдийн эмчилгээ, шүд авах, болон бусад жижиг мэс ажилбарыг хийх нөхцөл бүрдэж, өдөрт дунджаар 18 хүнд шүдний эмчилгээ, үйлчилгээ үзүүлж, энэ хугацаанд хамран үйлчлэх тойргийн 9937 хүнд амны хөндийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлээд байна.

■ Багийн эмч сар бүрийн нярайн үзлэг хийж байгаа нь. Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хан-Өндөр баг, 2019 он



■ Денан төслийн зүгээс малчин өрхүүдэд эм тариа өгч буй нь. Архангай аймаг, 2013 он





■ Архангай аймгийн Тариат сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Эмч клуб” нь Денан төслийн хүрээнд байгуулагдсан ба 8-12 дугаар ангийн 20 сурагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Клубийн гишүүд фейсбүүк сүлжээнд “Тариат эмч клуб” нэртэй групп хуудас нээж, олон нийтэд эрүүл мэндийн чиглэлийн мэдээлэл хүргэж эхэлжээ. Архангай аймаг, 2020 он

## **ДЕНАН ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГАЛТЫН БОЛОН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ДУРДВАЛ:**



Бруцеллэз өвчнөөс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд Тариат сумын 1611 хүнд шинжилгээ хийж, 720 хүн (шинжилгээнд хамрагдсан хүмүүсийн 44,6%) бруцеллэзын халдвартай байгааг илрүүлсэн. Архангай аймгийн Эрүүл мэндийн газар, Тариат сумын эмнэлэг хамтран 7 багийн 220 хүнд бруцеллэзын илрүүлэг шинжилгээний 2 дахь шатны үйл ажиллагааг зохион байгуулж, энэ өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар 120 хүнд сургалт явуулан, давхардсан тоогоор 7280 хүнд гарын авлага, тараах материал, баримтат нэвтрүүлгээр дамжуулан мэдээлэл хүргэжээ. Тариат сумын эмнэлгийн 3 эмч бруцеллэз өвчнийг оношлох сургалтад хамрагдсан байна.



Төслийн дэмжлэгтэйгээр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг тогтмол хийж байна.



Нийгмийн эрүүл мэндийн мэдлэг, мэдээллийг сайжруулах зорилгоор эрүүл, зөв хооллолт, архи, тамхины хэрэглээ, бэлгийн замын халдварт өвчин, нөхөн үржихүйн эрүүл мэнд, ханиад томуунаас урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эрүүл мэнд, эмийн зохистой хэрэглээ, ус, ариун цэвэр, амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр хүүхэд, залуучууд, олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлуудыг үе шаттай зохион байгуулжээ.



Дээрх сэдвээр гарын авлага, брошюр, мэдээллийн хуудас тогтмол бэлтгэн, түгээж байна.



6-10 дугаар ангийн 22 хүүхдээс бүрдсэн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүүхдийн оролцооны бүлгийг байгуулан ажиллуулж байна. Тус бүлгийн хүүхдүүд сургуулийн эмч, эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан, бусад эмч нараас тогтмол сургалт авч, сурч мэдсэнээ сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд, гэр бүлийнхэн, найз нөхдөдөө зааж, орон нутагтаа эрүүл амьдралын хэвшлийг бий болгоход гар бие оролцож байна.

2017 оноос Дэнэн төсөл хүрээгээ тэлж, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын эмнэлэгт хэрэгжих боллоо. Тухайн жилд Эрдэнэмандал сумын эмнэлгийн шүдний кабинетыг шаардлагатай материалуудаар хангаснаар одоогийн байдлаар нийт 2176 хүнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлжээ. Эрдэнэмандал сумын хоёр эмчийг дотрын болон мэдээгүйжүүлэгч эмчээр мэргэшүүлэн сургав. Эрдэнэмандал сумын эмнэлгийг мэс заслын ор болон өвчтөний мониторингоор хангаснаар 156 удаагийн хагалгааг амжилттай хийж гүйцэтгэжээ.

2018 оноос Тариат сумын эмч нар орчин үеийн тоног төхөөрөмжөөр зөөврийн оношилгоо хийж эхэлснээр 2000 орчим хүнд үзлэг, оношилгоо хийв. Зөөврийн оношилгоог суманд нэвтрүүлснээр ард иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт оношлох, ялангуяа эмнэлэгт хандах нь цөөн байдаг алслагдсан хөдөөгийн малчид, иргэд, эрүүл мэнддээ анхаарал тавих нь бага байдаг залуучуудын хувьд үр өгөөжөө өгч байна.

Хоёр сумын нийт 13 багийн эмчид сар бүр шатахууны дэмжлэг үзүүлснээр жирэмсэн болон төрсөн эхчүүд, нярай болон 0-5 насны хүүхдүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эргэх, хянах боломж бүрдлээ.







*Хүүхдийг Ивээх Сантай олон жилийн турш хамтран ажиллаж, бүх талын тусламж дэмжлэг авч байгаадаа манай эмнэлгийн хамт олон, нутгийн ард иргэд маш их талархаж байна.*

*Дутагдалтай байгаа боловсон хүчин, хүний нөөцийг бэлтгэж, шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, машин техникээр хангаж, ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл, боломжийг бүрдүүлж байгаад бид бүгдийн зүгээс сэтгэл өндөр байдаг.*

*Төслийн үр дүнд Архангай аймгийн сум дундын эмнэлгүүдийн үйлчилгээ сайжирч, алслагдмал багуудад хүртэл урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тогтмол хийгддэг болсноор хэвтэн эмчлүүлэгчдийн тоо жилээс жилд буурч байна.*

*Архангай аймгийн Тариат сумын Сум дундын эмнэлгийн ерөнхий эмч Т.Гэрэлтуяа*



*“Би клубтээ гурван жил явж байна. Энэ хугацаанд багаар ажиллах, бусдад өөрийгөө ойлгуулах, хүлээцтэй хандах, мэдсэн, сурснаа бусдад хүргэх чадвар эзэмшсэн. Бид энэ жил шинэ корона вирусын аюул, түүнээс хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл хүргэх, клубийнхээ гишүүд болон сурагчдад дархлаагаа эрүүл, эерэг аргаар хэрхэн дэмжих талаар таниулах зорилготой байгаа. Өмнөх жилүүдэд сургуулийнхаа зургаанаас дээш ангийнханд хеликобактери, архи, тамхины хор уршгийн талаарх мэдээллийг нэгдсэн журмаар өгсөн. Хүүхдүүд эергээр*

*ойлгон, хүлээж авна. Дараа нь эргэж асуухад сурагч бүр цаашаа 1-2 хүнд нөлөөлсөн байдаг юм. Би зуныхаа амралтаар хөдөө гэр бүл, хот айлынхандаа өөрийн сурсан мэдлэгээ хүргэдэг. Ирээдүйд мэс заслын эмч болох хүсэлтэй.”*

*Архангай аймгийн Тариат сумын ЕБС-ийн 11-р ангийн сурагч, “Эмч клуб”-ын ахлагч Ц.Дэлгэрмөрөн, 2020 он*

# ХҮМҮҮНЛЭГИЙН ХӨТӨЛБӨР

■ Хүүхдийг Ивээх Сангийн хүмүүнлэгийн хөтөлбөр нь гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, боловсролын тасалдалгүй байдалд онцгой анхаардаг. Ховд аймгийн малчин хүн амд үзүүлсэн хүмүүнлэгийн тусламж, 2019 он



## Гамшгийн үеийн тусламж үзүүлэхдээ ХИС дараах зарчмуудыг баримталдаг:



Аливаа гамшгийн үед зайлшгүй хэрэгцээ шаардлагыг судалсны үндсэн дээр хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохион байгуулах;



Гамшиг, хямралд өртсөн хүн ам, хүүхдэд шаардлагатай, хэрэгцээнд нь суурилсан хүмүүнлэгийн тусламжийг хүргэх;



Тухайн улс орны Засгийн газрууд, хүмүүнлэгийн холбогдох байгууллагуудтай нягт холбоотой ажиллах;



Байгалийн гамшигт өртсөн хүүхдүүд, айл өрхүүдийн 10-25 хувьд нь хүрч туслах;



Гамшгийн үед хүүхдийн эмзэг байдал, онцлог хэрэгцээг онцгойлох анхаарах

ХИС-гийн хувьд байгуулагдсан цагаасаа хойш хүмүүнлэгийн үйл ажиллагаанд манлайлан оролцож, гамшиг, хямралд өртсөн хүүхэд, хүн амд тусламжийн гараа сунгасаар байна.

Байгалийн ба хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй аливаа гамшиг, хямралын сөрөг нөлөө насанд хүрэгчидтэй харьцуулахад хүүхдэд илүү хүндээр тусдаг. Тиймээс өргөн хүрээг хамарсан онцгой нөхцөл байдлын үед ХИС газар дээр нь ажиллаж, гамшигт өртсөн хүүхдүүдийг аварч, эмнэлгийн тусламж, орон байр, ус, хүнсээр шуурхай хангахын зэрэгцээ гэр бүлийн гишүүдээ олж уулзах, хямралын байдлаас ангижрахад нь хүүхдүүдэд туслан, сурч мэдэх, тоглох аюулгүй орчныг бүрдүүлж өгдөг.

Өнөөдөр ХИС нь гамшиг, хямралын үед Засгийн газартай хамтарч, хүмүүнлэгийн нэгдсэн арга хэмжээ авах зорилго бүхий Монгол Улс дахь Хүмүүнлэгийн багийн идэвхтэй гишүүнээр ажиллахын зэрэгцээ НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамт Хүмүүнлэгийн багийн Боловсролын бүлгийг ахалж байна.

ХИС-гийн Монгол дахь хөтөлбөр байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол оронд тохиолдсон зуд, үер зэрэг байгалийн гамшигт өртсөн хүн ам, хүүхдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхийн зэрэгцээ, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ), аймаг дүүргийн Онцгой байдлын газар, хэлтэс болон бусад холбогдох талууд, тэр дундаа Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрууд, НҮБ-ын Хүүхдийн Сан, “Дэлхийн Зөн Монгол” ОУБ, Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг, ХААН банк зэрэг байгууллагуудтай нягт хамтран ажиллаж ирлээ.

Ийнхүү ажиллахад Английн Хүүхдийг Ивээх Сан, Японы Хүүхдийг Ивээх Сан, Солонгосын Хүүхдийг Ивээх Сан, СТАРТ Сүлжээ, Онцгой байдлын үед зарцуулах НҮБ-ын Нэгдсэн Сан (CERF), Япон Платформ Сан, Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Газар зэрэг санхүүжүүлэгчдийн дэмжлэг ихээхэн чухал байсан.



# 1. ХҮМҮҮНЛЭГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

**25 дэвшил: №24**

**Зудад өртсөн айл өрх, хүүхдүүдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлж, гамшгийн үед шуурхай ажиллах Хүмүүнлэгийн баг (НСТ)-ийн механизмыг Монгол Улсад бий болгоход оролцов.**

## 1999-2001 ОНЫ ЗУД

1999-2001 онд хоёр жил дараалан болсон зуд<sup>1</sup>-д нийт 450 мянган малчин (Монголын хүн амын тавны нэг) нэрвэгдэж, 3 сая мал (улсын нийт малын 10%) хорогдоход ХИС нь Европын холбооны хүмүүнлэгийн тусламжийн байгууллага, Олон улсын хөгжлийн нийгэмлэг болон Английн Бруки эмнэлгийн дэмжлэгтэйгээр хүмүүнлэгийн тусламжийн төсөл хэрэгжүүлсэн юм. Үүнд:

- Баянхонгор аймгийн 6 сумын зорилтот бүлгийн 420 малчин өрхөд 187 сая төгрөгийн дөрвөн сар хэрэглэх хүнс, 5 хүртэлх насны 3000 хүүхэд, 2000 жирэмсэн эмэгтэйд нэмэлт хүнс, амин дэм, сургуулийн дотуур байр, цэцэрлэг, эмнэлэгт хүнс, ногооны үр хандивлаж, хүлэмж барихад нь дэмжлэг үзүүлсэн юм.<sup>2</sup>
- Ховд аймгийн 3 сумын 856 өрхөд 115 тн малын тэжээл, 699 өрхөд 227 тн хүнс, 12 цэцэрлэг, эмнэлэг, сургуулийн дотуур байранд 14 тн хүнс, 76 машин нүүрс, түлээ, 1540 дулаан хөнжил, гудсыг шуурхай хүргэж ажилласан.<sup>3</sup>



■ Хүүхдийг Ивээх Сан зудад нэрвэгдсэн хүн амд тусламж үзүүллээ. Дундговь аймаг, Адаацаг сум, 2003 он

1 Монголын нэр томъёогоор зун ган болоход өвөл нь маш их цас орж, мал бэлчээргүй болж өлсөж даарснаас олноороо үхдэг, Wikipedia, 2010

2 Баянхонгор аймагт хэрэгжүүлсэн гамшгийн тусламжийн төслийн баримт бичиг, ХИС, 2000

3 Ховд аймагт хэрэгжүүлсэн гамшгийн тусламжийн төслийн баримт бичиг, ХИС, 2000

## 2001 ОНЫ ГАР, ХӨЛ АМНЫ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТ

2001 онд Дорнод аймагт гар, хөл, амны өвчин гарч, хорио цээр тогтооход ХИС-гаас 310 өрх, сургуулийн дотуур байранд 10,3 сая төгрөгийн хүнс, 950 өрхөд халдваргүйжүүлэлт, ариутгалын дэмжлэг үзүүлж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр уг өвчний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн хараа хяналтгүй 40 хүүхдэд амьдрах байр, бусад шаардлагатай зүйлийн тусламж үзүүлэв.<sup>1</sup>

## 2003 ОНЫ ЗУД

Зудын нөхцөлд байсан Дундговь аймгийн Адаацаг, Эрдэнэдалай сумын 3 ба түүнээс дээш хүүхэдтэй, зорилтот бүлгийн 370 өрхөд 36 тн хүнсний бүтээгдэхүүн, 530 өрхөд малын тэжээл хүргэж, сумын цэцэрлэг, дотуур байр, эмнэлэгт түлээ, нүүрс, дулаан хөнжил гудас, хүнсний нийт 31 сая төгрөгийн тусламж үзүүлсэн.

Хүмүүнлэгийн тусламжийн хяналт, үнэлгээний тайлангаас харахад эдгээр тусламж нь сургуулиас завсардах, сэтгэл санаагаар хямрах, санаа зовох зэрэг зудаас үүдэлтэйгээр малчдын хүүхдэд тусах сөрөг үр дагаврыг багасгахад тусалсан байна.<sup>2</sup>

## 2009 - 2010 ОНЫ ЗУД

2009-2010 оны өвөл Монгол Улсын зарим бүс нутагт агаарын температур - 30 -аас -40 хэм хүртэл хүрч хүйтрэн, ОБЕГ-ын мэдээлснээр 21 аймгийн 15 нь зудад өртөж, улмаар 2010 оны 1-р сард Монгол Улсын Засгийн газар албан ёсоор гамшгийн байдал зарласан билээ. Уг зудад нийт 9,7 орчим сая толгой мал (улсын нийт малын 10 орчим хувь) хорогдож, 769 мянган хүн (Монголын хүн амын 28 хувь) зудын хүндрэлтэй нүүр тулсан<sup>3</sup> үед ХИС орон нутагт ажиллаж, боловсролын салбарт зудын үзүүлж буй нөлөөг тодруулах түргэвчилсэн үнэлгээ хийж, үр дүнг нь холбогдох талуудад хүргэв.

<sup>1</sup> Дорнод аймагт хэрэгжүүлсэн гамшгийн тусламжийн төслийн баримт бичиг, ХИС, 2001

<sup>2</sup> Дундговь аймагт хэрэгжүүлсэн гамшгийн тусламжийн төслийн баримт бичиг, ХИС, 2003

<sup>3</sup> 2009-2010 оны зудын гамшгийн учруулсан хохирлын тухай тайлан, ХИС, 2010

■ Цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдэд хүмүүнлэгийн тусламж хүргэлээ.  
Говь-Алтай аймгийн Шарга сум, 2010 он



Мөн Жерсийн Олон улсын тусламжийн хороо, Мэнний арлын Засгийн газар, Европын тусламжийн сан зэрэг байгууллагуудаас санхүүжилт босгон хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн. Үүнд:

- Завхан, Говь-Алтай, Дорнод аймгийн 24 сургууль, дотуур байр, 19 цэцэрлэгийн 2272 хүүхдэд хүнс тэжээл<sup>1</sup>, ариун цэврийн хэрэгсэл, хөнжил, гутал зэрэг нэн хэрэгцээт зүйлсийг хүргэж, сургууль, дотуур байрны халаалтад дэмжлэг үзүүлж, түлш<sup>2</sup> авч өгсөн.
- Архангай, Говь-Алтай, Дундговь аймгийн 13 сумын 750 малчин өрхөд хүнсний тусламж, 120 өрхөд түлш болон 1678 хүүхдэд хөнжил, гутал олгосон.
- Дундговь, Говь-Алтай, Завхан аймгийн 5,000 хүүхдэд хичээлийн хэрэгсэл<sup>3</sup> хүлээлгэн өгсөн. Мөн эдгээр аймгийн 34 сургуульд ус, эрүүл ахуй, ариун цэврийн материал<sup>4</sup> хүргэж, цэвэр ус, эрүүл ахуйн байгууламжаас тусгаарлагдсан нөхцөлд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, гар угаах, хувийн ариун цэвэр сахиулах чиглэлээр боловсролын байгууллагын 67 ажилтныг сургалтад хамруулсан.

## 2011 ОНЫ ЯПОН УЛСАД БОЛСОН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ТУСЛАМЖ

Япон улсын зүүн хойд эрэг орчмын нутагт 2011 оны 3-р сард болсон хүчтэй газар хөдлөлтөд өртсөн хүн амд зориулж ХИС-гийн Монгол дахь хөтөлбөр Монголын иргэний нийгмийн болон орон нутгийн 12 байгууллага, 10 орчим хувь хүний хандив, тусламжийг хүлээн авч, Японы Хүүхдийг Ивээх Санд дамжууав.

## 2012 - 2013 ОНЫ ӨВӨЛ

2013 оны 1-р сард ОБЕГ-аас 15 аймгийн 55 сум өвөлжилт хүндрэх магадлалтай байгааг анхааруулсны дагуу ХИС нь Өвөрхангай, Архангай, Дорнод аймагт малчин өрхийн амьжиргаа, хүүхэд хамгааллын нөхцөлд байдалд түргэвчилсэн үнэлгээ хийсэн.

Уг судалгаагаар цаг агаарын байдал харьцангуй сайжирсан, түүнчлэн малчин өрхүүд хувийн бэлтгэлээ базааж, засаг захиргааны зүгээс өвөлжилтийн бэлтгэлийг шуурхай хангасны хүчинд мал сүргийн тоо ноцтой хорогдоогүй гэсэн дүн гарсан. Гэсэн хэдий ч өрхийн амьжиргаа, хүнсний аюулгүй байдал, хүүхэд хамгааллын чиглэлээр түлхүү анхаарч ажиллах шаардлагатай нь харагдсан билээ. Иймд ХИС-гаас холбогдох төрийн болон олон улсын байгууллагууд, бусад талуудад цөөн малтай зорилтот бүлгийн малчин өрхийн мал сүргийг хамгаалах, хүүхэд хамгаалал болон хүүхдийн боловсролын асуудлыг хөндсөн урт ба богино хугацааны зөвлөмж хүргүүлж, эдгээр асуудлыг ХИС-гийн урт хугацааны хөгжлийн төслүүддээ анхаарч ажиллалаа.

1 Буудайн гурил, будаа, элсэн чихэр, ургамлын тос, хуурай сүү, жимсний шүүс, үзэм зэрэг 4 долоо хоногийн хэрэгцээг хангахуйц хүнсний тусламж

2 2-3 долоо хоногийн түлшний нөөц

3 Тараагдсан багц бүрт сурагчийн цүнх, номын хавтас, дэвтэр, зургийн самбар, үзэг, харандаа, өнгийн харандаа, шугам, цаасны цавуу, баллуур, харандаа үзүүрлэгч, ор хөнжлийн даавуу, углааш, нүүрний алчуур, ванны алчуур, сам, вазелин, гарын саван, савангийн тавиур, угаалгын нунтаг, нойтон салфетка, шүдний оо, сойз, шампунь, сэнжтэй аяга, хоолны аяга, дотуур хувцас, оймс, бохир хувцас хийх сагс, ариун цэврийн цаас зэрэг хичээлийн болон ахуйн хэрэглээний зүйлс багтсан болно.

4 Ариун цэврийн багцад усны сав, түмпэн, хогийн сав, шүүр, тосгуур, цайруулагч шингэн, хувцасны сойз, хувин, ус шүүгч, гар угаахад зориулсан усны сав, гал тогооны алчуур, жорлонгийн сойз, алчуур, цэвэрлэгээний резинэн бээлий зэрэг ахуйн хэрэглээний зүйлс багтсан болно.





## 2015 - 2016 ОНЫ ЗУД

2015-2016 оны өвөл болсон зудын үеэр ХИС нь цөөн тооны малтай, хүнд нөхцөлд амьдарч буй малчин өрхийн амьжиргааг хамгаалах, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авахад нь дэмжих, малчдын хүүхдийн боловсролыг тасалдалгүй үргэлжлүүлэх болон хүүхэд хамгааллын чиглэлээр донор байгууллагуудаас 1,2 сая ам.долларын санхүүжилт босгож, 5 аймгийн 29 суманд хүмүүнлэгийн яаралтай тусламжийн 6 төсөл хэрэгжүүлж, нийт 24,7 мянган хүн амд (үүнээс 10,1 мянган хүүхэд) хүрч ажилласан.

ХИС нь НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран Хүмүүнлэгийн багийн боловсролын бүлгийг удирддагийн хувьд болон хүүхдийн эрхийг хангах үндсэн чиг үүргийнхээ дагуу хүмүүнлэгийн тусламжийн томхон хувийг боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн.



**ӨРХИЙН АМЬЖИРГААГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР:** Архангай, Сүхбаатар аймгийн 10 сумын 1,374 малчин өрхөд хивэг, 637 малчин өрхөд мөнгөн тусламж, Сүхбаатар аймгийн 7 сумын зорилтот 783 малчин өрхөд “Малын сувиллын багц”<sup>1</sup> өгч, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон, Түвшинширээ, Наран сумын малаа ихээр алдсан, бага орлоготой 70 өрхийн 297 хүн амыг малжуулах хөтөлбөрт хамруулан 1,870 толгой мал буюу нэг өрхөд дунджаар 27 толгой малыг буцалтгүй тусламжаар өгөв. Малжуулах хөтөлбөрт хамрагдсан эдгээр өрхөд мал сүргээ хариулах, өрхийн амьжиргаандаа зарцуулахад нь зориулж 3 удаагийн мөнгөн тусламжийг үе шаттайгаар үзүүлсэн.



**МАЛЧДАД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:** Архангай, Сүхбаатар аймгийн 10 сумын эрүүл мэндийн төвүүдийг яаралтай тусламжийн багц, нярайн даралт хэмжигч зэрэг багаж хэрэгслээр хангаж, алслагдсан

<sup>1</sup> Мультивитамин, загасны тос, амин тун, эрдэст долооц, зүү, тариур, малчдад зориулсан гарын авлагаас бүрдсэн тусламжийн багц

багаар тойрч, малчин өрхийн хүн амд урьдчилан сэргийлэх үзлэг, жирэмсэн эмэгтэйчүүдэд хяналтын үзлэг хийх, бага насны хүүхдийг вакцинжуулахад нь зориулж шатахуун, томилолтын зардлын дэмжлэг үзүүлснээр нийт 10,245 малчин иргэд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг гэрээсээ цаг алдалгүй авч чадав.



#### **МАЛЧДЫН ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

- Архангай аймгийн 5 сумын 7 сургуульд 280 тн нүүрс авч өгснөөр өвөл хаврын нөхцөлд 2,894 сурагчид, 315 багш, ажилчид ая тухтай, дулаан ангид хичээллэх боломжийг бүрдүүлж ажиллав.
- Архангай, Өвөрхангай аймгийн 10 сумын 15 сургуулийн дотуур байрны 1198 сурагчид дулаан хөнжил, цагаан хэрэглэл, ариун цэврийн багц, бага ангийн 319 хүүхдэд өвлийн гутал, ороолт малгай бээлий, өсвөр насны 509 охидод ариун цэврийн хэрэглэл гэх мэт шаардлагатай эд зүйлсийн дэмжлэг үзүүлэв.
- Архангай, Өвөрхангай аймгийн дээрх сумдын сургуулиудад зудын нөхцөл байдал, мал төллөлтөөс болж хичээлдээ ирж чадалгүй завсардсан, тасалсан болон хичээлийн хоцрогдолтой 2,430 хүүхдэд зориулж боловсрол нөхөн олгох нэмэлт хичээлийг зохион байгуулав. Эдгээр сургуулиудад хүүхэд хөгжлийн өрөөг тохижуулахад нь буйдан, ширээ, сандал, номын тавиур, ном, тоглоом, гитар болон бусад хэрэгцээт зүйлсийн (усны сав, ус халаагч) дэмжлэг үзүүлэв.
- Архангай, Өвөрхангай аймгийн 10 сумын амьжиргааны түвшин доогуур 646 өрхийн 1,063 хүүхдэд сургуулийн дүрэмт хувцас, биеийн тамирын хувцас, хичээлийн хэрэгсэл, өвлийн хувцас, сургуульд ирэх тээврийн зардал зэрэг боловсролын хэрэгцээнд зориулан нийт 208,8 сая төгрөгийн мөнгөн тусламж үзүүлэв.



**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:** Архангай, Өвөрхангай, Сүхбаатар, Дорнод аймгийн 19 сумын 25 сургуулийн 563 багш ажилчид, 2,637 хүүхдэд сургалт зохион байгуулж, хүүхдэд сэтгэлзүйн анхан шатны тусламж үзүүлэх арга зүйг эзэмшүүлсэн. Дээрх сумдын сургуулийн дотуур байранд суурин утас байрлуулж, эцэг эх, асран хамгаалагчтайгаа чөлөөтэй холбогдох боломжийг бүрдүүлэв.



**БАЙГАЛЬ ОРЧИН, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:** Архангай, Сүхбаатар аймгийн 10 сумын захиргаанд зудын улмаас хорогдсон малын сэг, зэм устгахад нь зориулж ариутгалын материал, шатахууны болон сайн дурынхан ажиллуулах зардлын дэмжлэг үзүүлж, хорогдсон 46,603 толгой малын сэг зэмийг зохих шаардлагын дагуу устгаж, ариутгав.

#### **2016 - 2017 ОНЫ ЗУД**

2016-2017 оны өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар Монголд үйл ажиллагаа явуулдаг хүмүүнлэгийн байгууллагуудаас зудад өртсөн малчин өрхүүдэд тусламж үзүүлэхийг хүссэн юм.

НҮБ-ын мэдээлснээр нийт 17 аймгийн 153 сумын 65,000 малчин өрхийн 265,000 хүн зудад өртсөн байна. ХИС нь 2017 оны 1-р сард зудын нөхцөл

байдалд түргэвчилсэн үнэлгээг хийхэд хүнд нөхцөлд буй малчин өрхүүд жил дараалан тохиолдсон зудад өртсөнөөр амьжиргаагаа залгуулахад ихээхэн хүндрэл үүссэн төдийгүй зуд нь малчдын хүүхдүүдийн сэтгэлзүй, боловсрол эзэмшихэд нь сөргөөр нөлөөлж буй нь харагдсан. Тиймээс ХИС 863.5 мянган ам.долларын хөрөнгө босгож, малчин өрхийн амьжиргааг хамгаалах, цаг алдалгүй эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, малчдын хүүхдүүдийн сэтгэлзүйн, эрүүл мэндийн болон боловсролын хэрэгцээг хангах чиглэлээр 3 төсөл хэрэгжүүлж, нийт 18,9 мянган хүн амд (үүнээс 9,5 мянган хүүхэд) хүрч ажиллалаа.



**ӨРХИЙН АМЬЖИРГААГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР:** Завхан аймгийн 7 сумын 672 малчин өрхөд малын тэжээлтэй сувиллын багц, мөнгөн тусламж үзүүлэв. НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагатай хамтран Архангай аймгийн 8 сумын 1072 малчин өрхөд малын тэжээлийн багц олгов.



**МАЛЧДАД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:** Архангай, Баян-Өлгий аймгийн өвөлжилт хүндэрсэн 5 сумын алслагдсан хөдөөгийн 10.5 мянган хүнд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлэв.



**МАЛЧДЫН ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

- Архангай, Өвөрхангай аймгийн 646 өрхийн 1063 хүүхдийг мөнгөн тусламжийн хөтөлбөрт хамруулснаар дүрэмт хувцас, биеийн тамирын хувцас, хичээлийн хэрэгсэл, өвлийн хувцас, сургуульд ирэх тээврийн зардал гэх мэт сурахад шаардлагатай эд зүйлсээ худалдан авсан.
- Архангай, Өвөрхангай аймгийн өвөлжилтийн хүндрэлээс болж хичээлдээ ирж чадаагүй, хичээлийн хоцрогдолтой 15 сургуулийн 2101 хүүхдийг тасалдсан хичээлээ нөхөх сургалтад хамруулав.



**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:** Дорнод, Сүхбаатар аймгийн 10 сургуулийн дотуур байранд суурин утас (G-мобайл, юнител) байрлуулж, 487 хүүхэд эцэг эхтэйгээ чөлөөтэй ярих боломжтой болсон.



*Би 2017 оны 3-р сард Архангай аймгийн Хотонт, Түвшрүүлэх суманд зудын тусламжаар явсан. Шагайгаар татсан их цастай, малчдын амьдрал үнэхээр хүнд хэцүү байсан.*

*Зудад нэрвэгдсэн айлуудад малын тэжээл, малын сувиллын багц тараахад хүмүүс их баярлаж байлаа. Манайх хүмүүнлэгийн тусламж үзүүлэхдээ хамгийн эхлээд бага насны хүүхэдтэй айл, олон хүүхэдтэй айлуудыг хамруулдаг.*

*2019 оны 1-р сард Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Баяннуур суманд ажилласан. Гэхдээ өмнөхөөс ялгаатай нь зуд болсны дараа биш харин өмнө нь тусламж үзүүлсэн.*

*Зудын зураглалын дагуу өвөлжилт хүндэрч болзошгүй сумуудад эрсдэлээс сэргийлж, урьдчилан тусламж хүргэх нь их үр дүнтэй болох нь тэндээс харагдсан.*

*ХИС-гийн захиргааны туслах ажилтан Ч.Гэрлээ*



## 2018 ОНЫ ҮЕР

2018 оны 7-8-р сард орсон усархаг аадар бороо, мөндрийн улмаас 11 аймаг, нийслэлийн зарим дүүрэгт үер бууж, нийт 8 иргэн нас барж, 72 иргэн бэртэж гэмтэн цахилгаан шугам сүлжээ, автозамд эвдрэл гэмтэл гарч ихээхэн хэмжээний хохирол учирсан.

ХИС 2018 оны 8 дугаар сард үерт хамгийн их өртсөн 4 аймгийг хамруулан НҮБ-ын Хүүхдийн Сан, БСШУСЯ-тай хамтран боловсролын бүлгийн хүрээнд түргэвчилсэн үнэлгээ боловсруулж, үнэлгээнээс гарсан зөвлөмжийн дагуу ажилласан.

- 2018 оны 7-9-р сард Баян-Өлгий, Ховд, Булган, Архангай аймгийн хүүхэдтэй ажилладаг 80 орчим ажилтан, албан хаагчдад “Хүүхдэд үзүүлэх сэтгэлзүйн анхны тусламж” сургалтыг зохион байгуулав. Гэр Бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газартай хамтран Баян-Өлгий аймгийн үерт өртсөн, хүнд нөхцөлд амьдарч буй 4 өрхөд гэр, гэрийн хэрэглэл хандивлан, дэмжлэг үзүүлээ.
- Баян-Өлгий, Ховд аймгийн 4 сумын үерт өртсөн гэр бүл, хүүхдэд сэтгэлзүйн болон боловсролын дэмжлэг үзүүлэх, 125 мянган ам.долларын төсөвтэй төслийг 2018 оны 11-р сараас 2019 оны 3-р сар хүртэл хэрэгжүүлж, 515 өрх, 970 хүүхэд, 2 аймгийн Онцгой комиссын 140 гишүүнийг хамруулав. Үүнд:
  - Хоёр аймгийн 15 сургуулийн нийт 50 багш, нийгмийн ажилтан, ОБГ-ын мэргэжилтэнг “хүүхдэд зориулсан сэтгэлзүйн анхны тусламжийн сургалт”-ын сургагч багшаар, 81 хүүхдийг “үе тэнгийн сургагч”-аар бэлтгэв. Нийт 855 хүүхдэд сэтгэлзүйн анхны тусламжийн талаарх мэдээлэл, сургалтыг зохион байгуулсан.
  - Үерт өртсөн зорилтот бүлгийн 515 өрхийн 970 хүүхдийн боловсролын хэрэгцээнд нь зориулан 201 сая орчим төгрөгийн мөнгөн тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлэв.
  - Хоёр аймгийн Онцгой комиссын гишүүд болон холбогдох мэргэжилтэн, албан хаагчдад гамшгаас хамгаалах сургалтыг аймгийн ОБГ-тай хамтран зохион байгуулж, үерийн цагийн байдалд ширээний дадлага хийлээ.

## 2018 - 2019 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ

2018 оны 11-р сард Ус, Цаг уур, Орчны Шинжилгээний Газраас гаргасан зудын эрсдэлийн зураглалыг үндэслэн, эрсдэл хамгийн өндөр байх магадлалтай Баян-Өлгий, Ховд аймгийн 7 суманд өвөлжилтийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эрт тусламж хүргэх 125 мянган ам.долларын санхүүжилт бүхий төслийг 2018 оны 12-р сараас 2019 оны 2-р сар хүртэл хэрэгжүүлж, 3,270 хүн амд (үүнээс 1,428 нь хүүхэд) хүрч ажилласан.

- Зудын эрсдэлд өртөх эрсдэл ихтэй, бага малтай, зорилтот бүлгийн 839 өрх тус бүрд 8 шуудай малын тэжээл, хивэг, өрхийн хэрэгцээнд зориулж 155 мянган төгрөгийн мөнгөн тусламжийг Хаан болон Төрийн банкаар дамжуулан өгөв.
- Зудын нөхцөлд малчдын хүүхдийн боловсрол, эрүүл мэнд орхигдохоос сэргийлэх болон ядарч доройтсон мал сүргийг сувилахад хэрэгтэй мэдээлэл бүхий гарын авлагыг казак, монгол хэлээр хэвлэж тараав.



Тусламж авсан 265 өрх (нийт өрхийн 30%)-өөс санамсаргүй түүврийн аргаар сонгон хяналт, үнэлгээ хийхэд: Төсөл хэрэгжсэн цаг хугацаа буюу “1-р сард тусламж авсан нь үр дүнтэй байсан” гэж 97,7%, “хивэг болон мөнгөн тусламж нь малын хорогдол үүсэх, мал сүрэг доройтохоос сэргийлж чадсан” гэж 99% нь хариулсан байна.

### **2011 - 2019 ОН: ХИС- ХҮМҮҮНЛЭГИЙН БАГИЙН ГИШҮҮН**

2009-2010 оны зудын гамшгийн сургамж, туршлагыг дүгнээд Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, олон улсын байгууллагууд хүмүүнлэгийн томоохон хямралын үед илүү үр дүнтэй ажиллах чиглэлээр хамтын ажиллагааны боловсронгуй арга тогтолцоог бий болгохоор 2011 оны 1-р сард Хүмүүнлэгийн багийг байгуулах үйл явцад ХИС идэвхтэй оролцсон юм.

Өнөөдөр ХИС Хүмүүнлэгийн багийн дэргэдэх Боловсролын бүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран удирдаж, Хүүхэд хамгааллын дэд бүлгийн гишүүнээр ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд Боловсролын бүлгийг тэргүүлж ажиллахдаа Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж, тогтмол тодотгол хийн, 2018 оны 7-р сард болсон үерийн нөхцөл байдалд түргэвчилсэн үнэлгээ хийж, үнэлгээний зөвлөмжийн дагуу тусламжийн ажиллагааг өрнүүлсэн. Мөн Хүмүүнлэгийн багийн Хүүхэд хамгааллын дэд бүлгийн идэвхтэй гишүүний хувьд уг бүлгийн хүүхэд хамгааллын болон гамшиг, эрсдэлийн төлөвлөлтийн чиглэлээрх ажлын удирдамжийг боловсруулахад хувь нэмэр орууллаа.



## 2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ БУЙ АЖЛУУД

25 дэвшил: №25

Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудалд мэргэжлийн байгууллагуудын анхаарлыг хандуулж, Монгол улсад анх удаа Ерөнхий боловсролын сургуулийн цогц аюулгүй байдлын суурь судалгаа, олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийв.





## **2011 - 2016 ОН: “ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕ ДЭХ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ХҮҮХЭД ТӨВТЭЙ БЭЛЭН БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”**

Солонгосын ХИС-гийн 380 мянган ам.долларын санхүүжилтийн дэмжлэгээр энэхүү төслийг ХИС ОБЕГ-тай хамтран 3 үе шаттай хэрэгжүүлэв.

### **ХИС БОДЛОГЫН ТҮВШИНД ХТҮГ БОЛОН ОБЕГ-ТАЙ НИЯГ ХАМТРАН АЖИЛЛАСНЫ ҮР ДҮНД:**



2014 оны 9-р сарын 23-нд ОБЕГ нь гамшгийн өмнө, гамшгийн үеэр болон түүний дараа хүүхдийн аюулгүй байдал, хүүхэд хамгаалал ба хүүхдийн оролцоог хангасан Хүүхэд хамгааллын чиглэлийг батлав.



ХТҮГ нь гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын зарчмуудыг тусгасан байгууллагын бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж, орон нутаг дахь салбар төвүүд нь уг бодлогыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллав.



Нийт 3,500 хүүхэд гэр болон байгууллагын орчинд гамшиг тохиосон нөхцөлд өөрийгөө болон бусдыг хамгаалах ур чадвараа дээшлүүлж, Улаанбаатар хотын 37, 200 гаруй хүүхэд гамшгийн үеийн нөхцөл байдалд үзүүлэх хариу үйлдлийн тухай анхан шатны ойлголт авсан.



Сургууль, хүүхдийн халамжийн төв зэрэг 18 байгууллага гамшиг, онцгой байдлын үе дэх бэлэн байдлын төлөвлөгөөтэй болсноор 5,000 орчим хүүхдийн аюулгүй байдал хангагдсан.



Төрийн албан хаагч болон үйлчилгээ үзүүлэгч 850 мэргэжилтэн хүүхдийн эрх болон гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх ойлголтоо сайжруулав.





## 2016-2019 ОН: СУРГУУЛИЙН ОРЧНЫ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2016 онд Архангай, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар аймгийн 19 сумын 25 сургуулийн 437 багш ажилтан, 585 сурагч гамшгийн эрсдэлийг бууруулах болон хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх сургалтад хамрагдсан. 25 сургуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах бичил төслийг ХИС 25 сая төгрөгөөр санхүүжүүлэв.
- 2017 оны 3-р сараас 2018 оны 3-р сар хүртэл 5 аймгийн 32 сумын дунд сургуульд “Сургуулийн орчны гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл”- ийг амжилттай хэрэгжүүлэв. Дорнод аймгийн Засаг Даргын Тамгын Газраас тус төслийн үйл ажиллагааг нутагшуулахаар төсөл хэрэгжээгүй сумын сургуулиудад “Сургуулийн цогц аюулгүй байдлын удирдлага” ажлыг санаачлан 10 сая төгрөгийг хуваарилсан нь төслийн тогтвортой байдлыг хангасан сайн туршлага боллоо.



*Хүүхдэд зориулсан гамшиг, онцгой байдлын сургалтаар янз бүрийн гамшгийн үед өөрийгөө болон бусад хүүхдэд яаж туслах талаар мэдэж авсан. Манай бүлгийн хүүхдүүд аймгийнхаа Онцгой байдлын газрын ах, эгч нараар бүлэгтээ сургалт явуулж, мэдсэн зүйлээ сургуулийн бусад хүүхдүүд, багш нар, эцэг эхчүүдэд заасан нь их сонирхолтой байсан.*

*Сургалт хийхийн тулд манай бүлгийн хүүхдүүд маш их хичээсэн. Жишээ нь хүүхдүүдийн өмнө сандрахгүй байх, юмаа ойлгуулах, самбар гаргаж мэдээлэл тавих гээд ажил их байсан. Үзүүлэх сургалтын үеэр манай бүлгийн хүүхдүүд багш нартай хамтраад хүүхдүүдийг зохион байгуулсан. Энэ нь надад их хариуцлагатай ажил оногдуулж том хүн болсон юм шиг л санагдаж байсан. Энэ үеэр анх удаа галын хор барьж гал унтраах дадлага хийсэн нь үнэхээр сонирхолтой байлаа.*

*Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын 1 дүгээр сургуулийн “Онцгойгийн охид залуус” бүлгийн гишүүн, 8г ангийн сурагч  
С.Батсайхан*

## 2016-2019 ОН: ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ СЭТГЭЛЗҮЙН АНХНЫ ТУСЛАМЖ

2016 оноос хойш ХИС хүүхдэд үзүүлэх сэтгэлзүйн анхны тусламжид чиглэсэн ажлыг нэвтрүүлж, МУЗН-ийн дунд шатны хороодын ажилтан, сайн дурынхныг чадавхжуулах, Нийслэлийн ОБГ-ын аврагч, эмч-сэтгэлзүйч, 8 аймгийн боловсрол, хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийг энэ чиглэлээр сургаж бэлтгэлээ. Түүнчлэн Архангай, Өвөрхангай, Ховд, Баян-Өлгий аймгийн сургуулиудад 776 үе тэнгийн сургагчийг “Хүүхдээс Хүүхдэд” аргаар бэлтгэж, сэтгэлзүйн анхны тусламж хүргэх ажлыг түгээн дэлгэрүүллээ.



## 2017 ОН: ЕБС-ИЙН ЦОГЦ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУУРЬ СУДАЛГАА

Монгол Улсад анх удаа үндэсний түвшинд гүйцэтгэсэн уг судалгаанд газар зүйн байршил, өөр өөр гамшгийн эрсдэлд өртөх магадлалыг харгалзан дөрвөн бүсчлэлийн 7 аймаг болон Улаанбаатар хотын 8 дүүргийн төрийн өмчит 96 ЕБС-ийг хамруулсан.

Энэхүү судалгааг НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын хэрэгжүүлж буй “Сургуулийн аюулгүй байдал” төслийн хүрээнд гүйцэтгэсэн юм. Судалгааны зорилго нь сургуулийн байшин барилгын аюулгүй байдал, гамшгийн менежмент, онцгой байдлын үед боловсролын үйлчилгээг тасралтгүй үргэлжлүүлэх нөхцөл, гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх боловсрол ямар түвшинд байгааг тодорхойлох явдал байлаа. Түүнчлэн, хүүхдийн аюулгүй, эрсдэлгүй орчинд сурч боловсрох, хамгаалагдах эрхийг хангахын тулд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний суурь нотолгоо болсноороо ач холбогдолтой.







■ Гамшгийн Эрсдэлийг Бууруулах Азийн Сайд нарын Бага хурал. Зургийн голд НҮБ-ын Гамшгийн Эрсдэлийг Бууруулах Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч ба тусгай төлөөлөгч хатагтай Мами Мизутори. 2018 оны 7 дугаар сар

## 2018 ОН: ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АЗИЙН САЙД НАРЫН БАГА ХУРАЛ

Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хуралд ХИС нь чухал үүрэгтэйгээр оролцов. Тухайлбал, тус хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтад ХИС нь ОБЕГ-т хүний нөөцийн дэмжлэг үзүүлэн ажиллав. Түүнчлэн бага хурлыг угтсан хүүхэд залуусын үндэсний зөвлөгөөнийг 2018 оны 5-р сард НҮБ-ын Хүүхдийн Сан, Дэлхийн Зөн Монгол ОУБ, МУЗН-тэй хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд оролцогчдоос Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хуралд Монгол Улсаа төлөөлөх хүүхэд, залуусыг сонгож, тэд 2018 оны 7-р сард Улаанбаатар хотноо болсон хурлын үеэр тэдгээр төлөөлөгчид салбар хуралдаанд илтгэл тавьсан.

Бага хурлын үеэр ХИС нь “Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, хүүхдэд үзүүлэх сэтгэлзүйн дэмжлэг” сэдэвт салбар хуралдааныг удирдан зохион байгуулсан. Ийнхүү ажилласны үр дүнд гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхэд, залуучуудын оролцоо, гамшгийн үед боловсролын тасралтгүй байдлыг хангах, гамшгийн дараах хямралд нийгэм сэтгэлзүйн тусламж үзүүлэх зэрэг чухал асуудлыг Бага хурлаас гарсан хүүхэд, залуучуудын илтгэл болон хурлын бичиг баримтад тусгуулж чадсан юм.



## 2018-2019 ОН: ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН ДАДЛАГА СУРГУУЛИЛТ

2018, 2019 онд Улаанбаатар хотын хэмжээнд зохион байгуулагдсан гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтад Дэлхийн Зөн Монгол ОУБ-тай хамтран хүүхдэд ээлтэй орон зай байгуулж, гамшгийн нөхцөлд, аюулгүй орчинд хүүхдэд зориулсан үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав.



## 2007-2019 ОН: ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ГАРГАСАН СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛУУД

Өнгөрсөн хугацаанд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр ХИС-гаас бэлтгэн гаргасан гарын авлага, видео хичээлүүдийг дурдвал:

- “Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал” гарын авлага - 2007, 2012, 2017, 2019
- “Хүүхдэд сэтгэлзүйн анхны тусламж үзүүлэх” гарын авлага 2016, 2018
- “Хүүхдэд сэтгэлзүйн анхны тусламж үзүүлэх” хүүхдэд зориулсан ажлын дэвтэр
- “Сэтгэлийн зовуурьтай хүүхдэд туслах багш нарт зориулсан зөвлөмж”
- “Гамшгаас ангид боловсрол” богино хэмжээний видео
- Сургуулийн орчинд гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөмж, багц материал
- Хүүхдүүдийн дунд гамшгаас хамгаалах мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Хууль Сахиулахын Их Сургуультай хамтран манай улсад хамгийн түгээмэл тохиолддог 8 төрлийн аюулт үзэгдлээр “Гамшигт бэлэн байцгаая” видео хичээл боловсруулж, зурагт хуудас бэлтгэн НОБГ-тай хамтран түгээв. Эдгээр хичээлийг казах хэл рүү орчуулан Баян-Өлгий аймгийн үндэсний цөөнх хүүхдэд хүргэж ажиллав.
- Газар хөдлөлт, ахуйн осол гэмтэл, үер усны аюул, ой хээрийн түймэр, хүчтэй цасан болон шороон шуурганаас хэрхэн урьдчилан сэргийлэх, тухайн нөхцөл байдалд өртвөл өөрийгөө хэрхэн хамгаалах талаарх мэдээллийг багтаасан номын хавчуурга төрөл бүрээр 2,000, хүүхдүүд зайлшгүй мэдэж байх утасны дугааруудыг багтаасан хичээлийн хуваарийг 8,000 хувь хэвлэж, холбогдох байгууллагуудад хүргэлээ.







## 2019 ОН: ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ТОЙМ СУДАЛГАА

ХИС нь “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ОБЕГ, Гамшиг судлалын хүрээлэнтэй хамтран 2019 оны 7-р сард Баян-Өлгий аймагт ажиллаж

- 1 Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх индикаторын
- 2 Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн тойм судалгааны гэсэн аргачлалаар Баян-Өлгий аймгийн 13 сумыг хамруулан зохион байгуулав.

Үүний үр дүнд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 2, 3, 4, 11, 12, 13-р багийн дарга, нийгмийн ажилтан, өндөр настан, хүүхэд, иргэдийн төлөөлөл багийнхаа нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй аюулын төрлийг тодруулж, эмзэг байдал, эрсдэлийн түвшнийг тодорхойлж, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, холбогдох байгууллага, орон нутгийн удирдлагуудад танилцуулсан.



*Би дотуур байранд эрэгтэй дүүтэйгээ хамт амьдардаг. Хүүхдийг Ивээх Сангаас зохион байгуулсан сэтгэлзүйн анхны тусламжийн сургалтад хамрагдаж олон шинэ зүйл сурч мэдсэн. Надад их таалагдсан. Манай дотуур байрны найзууд маань заримдаа гэрээ санах, уйтгарлах, сэтгэл нь зовох, тавгүйтэх үе гардаг. Өмнө нь яаж тэднийг тайвшруулах, тэдэнд юу хэрэгтэй байгааг мэддэггүй, яаж харьцахаа мэддэггүй байсан бол одоо тэдэнтэй хэрхэн харьцах, яаж тусламж хүргэхээ мэддэг болсон. Манай найзууд бас намайг сайн ярьж харилцаж чаддаг болсон байна гэсэн. Би сурсан зүйлээрээ найзууддаа тусалж чадаж байгаадаа сэтгэл өндөр байгаа.*

Ц.Л, 15 настай



## ХИС-ГИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ХАНДИВЛАГЧИД:

### Хүүхдийг Ивээх Сангийн гишүүд:

- Хүүхдийг Ивээх Сан (Австрали)
- Хүүхдийг Ивээх Сан (АНУ)
- Хүүхдийг Ивээх Сан (Их Британи)
- Хүүхдийг Ивээх Сан (Нидерланд)
- Хүүхдийг Ивээх Сан (Норвеги)
- Хүүхдийг Ивээх Сан (БНСУ)
- Хүүхдийг Ивээх Сан (Хүүхдийн Төлөөх Онцгой Байдлын Сан)
- Хүүхдийг Ивээх Сан (Швед)
- Хүүхдийг Ивээх Сан (Япон)

### Засгийн газрын болон олон улсын байгууллага:

- Айсл оф Мэний Засгийн газар
- Азийн Хөгжлийн Банк (ADB)
- Австралийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг (AusAID)
- Бээжин дэх Нидерландын Вант Улсын Элчин сайдын яам
- Гуэрнсийн Олон Улсын Тусламжийн Хороо (GOAC)
- Дэлхийн Банк (Японы Нийгмийн Хөгжлийн Сангийн болон бусад тусламжууд)
- Европын Холбоо
- Европын Холбооны Хүмүүнлэгийн Тусламжийн Байгууллага
- Европын Холбооны Техникийн Тусалцааны Байгууллага (TACIS)
- Жерсигийн Олон Улсын Тусламжийн Хороо (JOAC)
- Их Британи, Умард Ирландын Вант Улсын Олон Улсын Хөгжлийн Яам (DFID)
- Монгол Улс дахь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Элчин сайдын яам
- Монгол Улс дахь Канад Улсын Элчин Сайдын Яам (Канад Сан)
- НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (ЮНЕСКО)
- НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)
- Олон Улсын Хөгжлийн Газар (Их Британийн Засгийн газар)
- Финляндын Сан
- Швейцарын Хөгжлийн Агентлаг (SDC)
- Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг
- Япон Улсын Гадаад Хэргийн Яам
- Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (ЖАЙКА)
- Японы Шуудангийн Хадгаламж Эзэмшигчдийн Олон Улсын Сайн Дурын Тусламжийн Сан
- Японы Хилийн Чанад Дахь Сайн Дурынхны Байгууллага (JOCV)

### Хүмүүнлэгийн сангууд ба ТББ-ууд:

- Гөү Хэлп (Их Британи)
- Гэрлийн Үр Сан (Хонг Конг)
- Денан Төсөл (АНУ)
- Дюфресне Готьерийн Сан (Канад)
- Жон Лайн Хүмүүнлэгийн Сан (Их Британи)
- Каритас Чех Републик ОУБ
- Морис Ба Хилда Лэйний Нэрэмжит Буяны Сан (Их Британи)
- Оак Сан (Их Британи)
- СТАРТ Сан (Их Британи)
- Энх Тайвны Салхи (Япон)
- Япон Платформ Сан

### Бусад байгууллага, компаниуд:

- Аксенчер (Япон)
- Арт Венчер (Сингапур)
- Аштан Траст (Австрали)
- Блаклигийн гэр бүл
- Брүүк Амьтны Эмнэлэг (Их Британи)
- Глобал Ситизен Сан (Япон)
- Д. Жонс (Их Британи)
- Дэнцу Судалгааны Институт (Япон)
- Динос Сесиль (Япон)
- Михира Шокай Корпораци (Япон)
- Мкс Мани Казуо Шино (Япон)
- Нарны Цирк (Канад)
- Соня Чанарын Баталгаа (Япон)
- Остин Ба Хоуп Пилкингтон Сан (Их Британи)
- Такасү Клиник (Япон)
- Уэно Файн Химийн Үйлдвэр (Япон)
- Фамили Март (Япон)
- Фрито-Лэй (Япон)
- Фэллсисомогийн Глобал Тосгон Сан (Япон)
- Хаан Банк Сан (Монгол)

### Сайн дурын мэргэжилтнээ илгээсэн болон Про Боно үйлчилгээ үзүүлсэн дэмжигч байгууллагууд:

- Австралийн Хөгжлийн Төлөөх Залуу Элч Хөтөлбөр
- Дюфресне Готьерийн Сан (Канад)
- Жэй Эс Кэй Компани (Япон)
- Хоган Лоуэльд хуулийн фирм (Их Британи)
- Сайн Дурынхны VSO Байгууллага
- Сингапурын Үндэсний Их Сургууль
- Олон Улсын Хөгжлийн Төлөөх Австралийн Сайн Дурын Ажилтан Хөтөлбөр (AVID)
- Өмгөөллийн ИЭлСи ХХН
- Хүүхдийг Ивээх Сан (Солонгос)
- Скоп Глобал (Австрали)
- Хилийн Чанад Дахь Сайн Дурын Алба (Их Британи)
- Энх Тайвны Корпус (АНУ)

# МОНГОЛ ДАХЬ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ХАНДИВЛАГЧДЫН САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ (1994-2019)

Хүүхдийг Ивээх Сан (Их Британи)

		(фунт)	(фунт)	(фунт)	(фунт)	(фунт)	(фунт)	(фунт)	(фунт)	(фунт)	(фунт)	(фунт)	(фунт)	
		1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006
ХИС-ИЙН ГИШҮҮД	Хандивлагчид													
	1 Хүүхдийг Ивээх Сан (Их Британи)	100,000	159,000	242,000	414,000	197,530	173,492	163,601	167,826	205,187	268,678	232,896	265,991	307,383
	2 Хүүхдийг Ивээх Сан - Хүүхдийн төлөөх Онцгой байдлын Сан						5,097	8,545	1,800	517				
	3 Хүүхдийг Ивээх Сан (Япон)								35,649	26,751				
	4 Хүүхдийг Ивээх Сан (Солонгос)													
	5 Хүүхдийг Ивээх Сан (Нидерланд)													
ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД	6 Хүүхдийг Ивээх Сан (Швед)													6,422
	6 Олон Улсын Хүүхдийг Ивээх Сан													
	7 Австралийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг (AusAID)						12,620	1,144	108					
	8 Монгол дахь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын ЭСЯ					213,012	221,292	216,989	194,746	179,676	160,681	160,557	201,029	138,613
	9 Олон Улсын Хөгжлийн Газар (Их Британийн Засгийн Газар)							73,596	70,503					
	10 Жерсигийн Олон Улсын Тусламжийн Хороо								11,520				65,000	9,568
	11 Гүэрнсийн Олон Улсын Тусламжийн Хороо								7,680					
	12 АЙСЛ оф Мэнийн Засгийн Газар													
	13 Монгол дахь Канадын ЭСЯ (Канад Сан)							12,631	36,103	24,886	21,309	9,360	18,918	7,409
	14 Финляндын Сан					4,301								
	15 Бээжин дахь Нидерландын Вант Улсын ЭСЯ									19,976	31,478	2,562	3,941	5,831
	16 Европын холбоо								-					144,860
	17 Европын холбооны Хүмүүнлэгийн тусламжийн байгууллага							61,687						
	18 Европын холбооны Техникийн туслалцааны байгууллага (TACIS)									9,297	35,138	19,661		1,706
	19 Шведын Олон Улсын Хөгжлийн Хамтын ажиллагааны байгууллага (SIDA)													
	20 Японы шуудангийн хадгаламж эзэмшигчдийн олон улсын сайн дурын тусламжийн сан													
	21 Японы гадаад хэргийн яам													
	22 Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA)													
	23 Япон платформ													
	24 Азийн Хөгжлийн Банк					25,217	22,692							
25 Дэлхийн Банк (Японы Нийгмийн Хөгжлийн Сан)														
26 НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага					19,729	1,424	9,430	665	4,033					
27 НҮБ-ын Хүүхдийн Сан								6,928						
28 НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага														
БУЯНЫ САН БА ТББ-УУД	29 Артвенче													
	30 Аштан траст							6,641	3,359					
	31 Амьтдын Брук эмнэлэг							68,395	418					
	32 Каритас Чех													
	33 Клара И Бургес Буяны Сан													
	34 Дюфресне ба Готьерийн Сан								15,144	27,176	28,226	28,734	46,579	33,801
	35 Дэлхийн Иргэн Сан													
	36 Гоү хелп													
	37 МКС Мани Казуо Шино (Япон)								9,823					
	38 Оак Траст Сан													
	39 Энх Тайвны Салхи (Япон)					8,882	9,308	8,044	746					
	40 Гэрлийн Үр Сан (Хонг Конг)					22,868	13,587	8,476	627					
	41 Остин ба Хоп Пилкингтон Траст Сан													
	42 Денан төсөл													
43 Морис ба Хилда Лейнгийн нэрэмжит буяны сан														
44 Бизнесийн байгууллагууд														
БУСАД	45 Хувь хүмүүсийн хандив, тусламж, бусад санхүүжилт					4,461	-	26,403	13,573	18,842	7,073	19,156	15,450	22,110
	46 Д.Жонс													
	47 Японы газар хөдлөлтөд нэрвэгдэгсдэд тусласан (Монголчуудын хандив)													
Нийт дүн (фунтаар)		£100,000	£159,000	£242,000	£414,000	£496,000	£459,512	£665,582	£577,217	£516,340	£552,582	£472,926	£616,908	£677,705
Нийт дүн (ам.доллараар)		\$164,520	\$261,587	\$398,138	\$693,036	\$800,693	\$731,635	\$942,664	\$822,823	\$815,353	\$1,017,193	\$893,026	\$1,072,557	\$1,333,927

**Хүүхдийг Ивээх Сан (Япон)**

(фунт)	(фунт)	(фунт)	(фунт)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)	(ам. доллар)
2007	2008	2009 (4-7сар)	Нийт	2009 (8-12сар)	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	Нийт	Нийтдүн (1994-2019)	
323,036	263,592	127,536	3,611,749								255,506	80,250		141,480	477,236	6,617,824	
			15,959		234,616			75,086							309,702	333,302	
11,346	55,339	26,346	155,431	66,350	123,886	144,799	185,658	160,786	253,779	204,248	167,902	345,627	417,404	393,957	2,464,396	2,703,114	
			-			21,650	71,204	69,561	21,537	124,516	23,947				332,415	332,415	
11,544	22,107		33,651	1,466	8,566										10,032	64,562	
6,975	4,869	9,808	28,074	7,664	31,710	10,239					1,893	7,572	8,602	223	67,903	117,741	
			-									4,345	549		4,894	4,894	
	33,605	210	47,686	20,824	26,924										47,749	118,008	
56,554	44,258	21,094	1,808,499		58,285	45,676	41,011	64,058	39,541						248,571	3,245,557	
			144,099												-	204,736	
57,492	56,923		200,503		38,181										38,181	381,995	
3,598	32,720		43,998												-	64,870	
	5,218	16,558	21,776		36,536										36,536	71,658	
1,706	8,270	(1,651)	138,941												-	225,478	
			4,301												-	6,943	
			63,788												-	112,656	
125,337	417,228	(33,834)	653,592												-	1,073,983	
			61,687		400,415	636									401,051	488,418	
			65,802												-	119,847	
			-								223,960	362			224,322	224,322	
	52,001	14,457	66,458	53,873	12,460										66,333	164,826	
10,549	(1,144)		9,405			125,114	406,739	552,152	306,323	182,104	480,137	343,011	461,255	456,423	3,313,256	3,332,570	
	36,035	30,865	66,900	91,507	201,192	126,755				57,838	80,429	121,358	93,854	178,433	951,365	1,054,444	
											444,328	608,434	118,891	115,968	1,287,622	1,287,622	
			47,909		19,320										19,320	96,158	
							82,156	416,995	623,815	683,178	392,074	265,713	4,655	456,414	2,924,999	2,924,999	
			35,281												-	54,788	
			6,928						5,873	12,477	9,752				28,102	37,978	
			-									16,204			16,204	16,204	
1,204	(1,404)	2,109	1,909												-	3,908	
			10,000												-	14,194	
			68,813												-	97,463	
			-		1,480										1,480	1,480	
9,510	490		10,000												-	19,587	
31,765	42,736	1,570	255,730	22,944											22,944	467,973	
			-	2,741	6,652										9,393	9,393	
	21,088	(170)	20,918		37,056	29,668		11,444							78,168	108,032	
			9,823												-	14,003	
		2,000	2,000												-	3,341	
			26,980												-	41,615	
			45,558												-	71,447	
		3,000	3,000												-	5,012	
			-			6,682	22,386	29,256	39,732	50,358	8,522	23,571	27,523	21,327	229,358	229,358	
		7,123	7,123	5,393	14,407	15,782									35,582	47,481	
5,017	60,974	60,826	126,817	36,799	14,148	37,017	58,622	31,455	13,552	43,136	26,782	23,776	16,295	14,225	315,808	514,555	
32,435	22,202	2,267	183,972	10,427	447	2,001	2,547	6,327	42,718	30,987	90,994	4,070	14,096	4,020	208,633	521,843	
	13,525	15,873	29,397												-	45,852	
			-			6,043									6,043	6,043	
€688,067	€1,190,632	€305,986	€8,134,458														
\$1,366,433	\$1,702,127	\$511,181	\$13,526,892	\$319,988	\$1,266,282	\$572,062	\$870,323	\$1,417,120	\$1,346,868	\$1,388,840	\$2,206,228	\$1,844,293	\$1,163,124	\$1,782,470	\$14,177,597	\$27,704,489	



